

Агуулга

| | |
|--|-----|
| Хураангуй | i |
| Эдийн засаг, нийгмийн хөгжлийн сүүлийн 10 жилийн товч үнэлгээ | 8 |
| Танилцуулга..... | 8 |
| Бүлэг 1: МОНГОЛ УЛС ДАХЬ ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ | 1 |
| I. Макро эдийн засаг | 1 |
| II. Хүн ам зүйн хандлага, өрхийн орлого, зарлагын судалгаа..... | 5 |
| III. Ядуурлын өнөөгийн байдал..... | 11 |
| IV. Жендэрийн тэгш байдлыг хангах..... | 15 |
| V. Баталгаат бус байдал..... | 18 |
| VI. Ядуурал болон баталгаагүй байдлын үндсэн шалтгаан..... | 20 |
| VII. Ядуурлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ..... | 21 |
| VIII. Үр дүн ба сургамж..... | 23 |
| Бүлэг 2: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ | 25 |
| I. Засгийн газрын хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлүүд | 25 |
| II. Оролцоог өргөтгөх..... | 26 |
| III. Ядуурлыг бууруулахад чиглэсэн тогтвортой хөгжил, өсөлт..... | 28 |
| IV. Эдийн засгийн өсөлтийг түргэтгэх | 30 |
| Бүлэг 3: Макро эдийн засаг, төсөв санхүүгийн тогтвортой байдлыг хангах | 37 |
| I. Төсөв санхүү | 37 |
| II. Төрийн сангийн удирдлага | 54 |
| III. Төлбөрийн тэнцэл | 58 |
| IV. Мөнгөний бодлого..... | 68 |
| V. Эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлт | 71 |
| VI. Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, аудит..... | 73 |
| VII. Төрийн албаны шинэчлэл | 82 |
| Бүлэг 4: ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ | 85 |
| I. Бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх | 85 |
| II. Хууль эрхзүйн орчин | 86 |
| III. Дэд бүтэц | 90 |
| IV. Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих | 101 |
| V. Зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх | 102 |
| VI. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил | 111 |
| VII. Хүрээлэн буй орчин | 120 |
| Бүлэг 5: ХҮНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ | 123 |
| I. Боловсрол | 126 |
| II. Эрүүл мэнд | 131 |
| III. Хөдөлмөр эрхлэлт..... | 140 |
| IV. Нийгмийн хамгаалал..... | 147 |
| V. Жендэрийн тэгш байдал..... | 152 |
| Бүлэг 6: СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТ | 155 |
| I. Сайн засаглал..... | 155 |
| II. Хэрэгжилт ба үйл ажиллагааны удирдлага..... | 157 |
| III. Оролцоог өргөтгөх нь..... | 159 |
| IV. Мониторинг ба үнэлгээ | 160 |

ХУРААНГУЙ

Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжиж Ядуурлыг Бууруулах Стратеги нь Монгол Улсын Засгийн Газрын дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, ядуурлыг бууруулах чиглэлээр баримтлах бодлогын үндсэн чиглэлийг агуулсан стратегийн баримт бичиг юм.

Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт суурилсан, хүний эрхийг дээдэлсэн иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулах их үйлсийг эхэлж, улмаар нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэл хийж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг эргэлт буцалтгүй сонгосон билээ. Ардчилал, шинэчлэл, өөрчлөн байгуулалтын сүүлийн 10 гаруй жилд Монгол улс олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын дэмжлэг туслалцаатайгаар макро эдийн засгийн тогтвортой суурийг бүрдүүлж, хувийн хэвшилд тулгуурласан нээлттэй эдийн засгийн бүтцийг бий болгоход ихээхэн амжилт олсон. Дунд хугацааны эдийн засгийн өсөлтийг жилийн 5.5 хувьд хүргэхийг зорьж байгаа бөгөөд эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэн төрийн албаны шинэчлэл, төсвийн зарлагын удирдлагыг сайжруулж, нийгмийн халамжийн сүлжээг боловсронгуй болгон төрөөс үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилт тавьж байна.

Монгол улсын шилжилтийн үйл явц нь амьдралын бүхий л хүрээг хамарсан бөгөөд өнгөрсөн 10 жил нь Монгол улсад зах зээлийн эдийн засгийн харилцааны үндсийг бүрдүүлж, улмаар тогтвортой өсөлт, ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн он жилүүд байлаа. 2002 оны байдлаар эдийн засгийн өсөлт 4.0 хувьтай байсан бөгөөд энэ нь өнгөрсөн 3 жилтэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр хэмжээний өсөлт юм. Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох 1995 оны судалгаагаар Монголын хүн амын 36 хувь ядуу амьдралтай байна гэсэн дүн гарсан ба 1998 оны судалгаагаар нийт хүн амын 35.6 хувь, хот суурин газрын хүн амын 39.4 хувь, хөдөөгийн хүн амын 32.6 хувь нь ядуу амьдарч байна гэсэн дүн гарчээ. Сүүлийн жилүүдэд тохиолдсон байгалийн гамшигаас шалтгаалан хөдөөгийн хүн амын хот суурин газрууд руу шилжих хөдөлгөөн нь ихсэж, ингэснээр ядуурлын тархалтыг хөдөө орон нутгаас нийслэл хот болон бусад суурин газрууд руу төвлөрүүлсэн байна.

Сүүлийн гурван жилийн турш Монгол улсын Засгийн газраас ядуурлын үнэлгээ дээр үндэслэн ядууст чиглэсэн чиг баримжаатайгаар эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах бодлогын шинэчлэлүүдийг дэс дараатай хэрэгжүүлж ирлээ. Цаашид дунд хугацаанд Засгийн газар хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг түргэтгэж улмаар хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор макро эдийн засгийг тогтворжуулж, инфляцийг тогтвортой бөгөөд доогуур түвшинд байлгах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх, мөнгө зээл, татварын механизмыг оновчтой ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон баялгийг хүн амын дунд зохистой хуваарилах, ялангуяа ядууст чиглүүлэх нь ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилтын нэг юм. Гэхдээ энэхүү хуваарилалт нь ядуучуудад хөрөнгийг шууд хуваарилах арга замаар бус ядуучууд, ядуурлын ирмэгт ойрхон байгаа хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, тэдгээрийн өөрсдийнх нь идэвхи санаачлагыг дэмжих замаар амьжиргааны түвшинг нь дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж , ядуурлыг бууруулах

Улс төр, нийгмийн салбарын хүрээнд бүтцийн өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлсэн нь эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн хүчин зүйл болсон. Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих бас нэг хүчин зүйл юм. Хувийн хэвшлийн идэвхитэй оролцоо болон экспортод чиглэгдсэн гадаад худалдааны бодлогод тулгуурлан эдийн засгийн өндөр өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулахыг

Засгийн газар зорьж байна. Эдийн засгийн өсөлтийг бүсчилсэн хөгжил болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан хэрэгжүүлнэ.

Мөн эдийн засгийн өсөлт, хүний тогтвортой хөгжлийг хангахад макро эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалт, хүний хүчин зүйлийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ.

Түүнчлэн төсөв, санхүүгийн удирдлагын илүү үр ашигтай механизмыг хөгжүүлэх, улсын салбарын шинэчлэлийг хийх нь эдийн засгийн өсөлтийг хангах өөр нэг чухал бүрэлдэхүүн байх болно.

Хөгжлийн хүрээ

Монгол улсын хөгжлийн зорилтуудын хүрээнд ойрын жилүүдийн тэргүүлэх чиглэлүүдийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Макро эдийн засгийн тогтворжилтийг бататгах, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, хурдасгах
- Банк санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэн, төлөвшүүлэх
- Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах
- Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх
- Хүний хөгжлийг хангах нийгмийн тэгш орчинг бүрдүүлж, бүх шатны боловсролын чанар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх
- Тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны бодлогыг бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх
- Газрын шинэчлэлийг эрчимжүүлэх
- Томоохон хот, суурин газруудын агаар ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулах
- Хүний аюулгүй байдлыг хангах, сайн засаглалыг бүрдүүлэх
- Шүүх засаглалын хараат бус бие даасан байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах замаар иргэн бүрийн үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын тулгуур, зарчмыг баталгаатай хамгаалсан өндөр ёс суртахуун бүхий иргэний ардчилсан нийгмийн төлөвшүүлэх,
- Жэндэрийн тэгш байдлыг хангахын тулд ядуурлыг бууруулах үйл явцад жэндэрийн хэмжигдэхүүнүүдийг тусгах.

Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлт

Монгол Улсын Засгийн газар нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн хөгжлийг дэмжих үндсэн гурван арга замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ард иргэдийн амьжиргааны тогтвортой байдлыг бий болгох юм.

Засгийн газар нь Монгол Улсын хууль тогтоомжууд, тухайлбал ерөнхий тогтолцооны болон эдийн засгийн удирдлагын хуулиудыг 2004 он хүртэл сайжруулан боловсруулахад анхааран ажиллаж байна. Эдийн засгийн хууль тогтоомжид хийх шинэчлэл нь бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд бизнесийн таатай, өрсөлдөөнт орчныг бий болгох, шаардлагагүй лиценз болон бусад захиргааны саад, хүнд суртлыг арилгахад чиглэгдэж байна. Ялангуяа орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, жижиг дунд үйлдвэрлэгчдийн санхүүгийн эх үүсвэрт хүрэх боломжийг нь нэмэгдүүлнэ. Орон нутагт банк санхүүгийн үйлчилгээг нэмэгдүүлэх,

жигжиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааг тогтворжуулах, өргөжүүлэх замаар байгалийн гамшигт нэрвэгдсэн хүн амын хэсгийг дэмжихэд Засгийн газрын бодлого, арга хэмжээнүүд чиглүүлэх шаардлагатай байна.

Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхэд нэн тэргүүнд эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх явдал онцгой ач холбогдолтой. Бодлогын хувьд эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай орчинг бүрдүүлэх, тус салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах явдлыг дэмжих, тус салбарын төрийн өмчит хувьцаат компаниудыг арилжааны хэлбэрт шилжүүлж улмаар шат дараатай хувьчлахад тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна. Дунд хугацаанд тээврийн салбарын хөгжил нь орон нутгийн иргэдийн идэвхитэй оролцоотойгоор хөдөөгийн замын сүлжээг өргөжүүлэх, тээврийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, техникийн хүчин чадлыг сайжруулах, ачаа тээвэр болон дамжин өнгөрөх бололцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Одоо байгаа харилцаа холбооны технологийг сайжруулах замаар мэдээлэл холбооны салбарыг хөгжүүлэхэд доорхи 4 хүчин зүйлээр баталгаажуулах юм . Эдгээрт 1) зохистой бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын орчныг бий болгох 2) хэрэгцээг бүрэн хангахуйц, найдвартай харилцаа холбоог бий болгох мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх 3) мэдээлэл, харилцаа холбооны технологийг удирдлагын болон бусад хэрэгцээнд үр ашигтай ашиглах чиглэлээр эдийн засгийн болон бизнесийн орчинг бүрэлдүүлэх 4) мэдээлэл харилцаа холбооны технологийг үр ашигтайгаар ашиглаж чадахуйц хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг болно.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих өөр нэгэн хүчин зүйл бол гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, үүний дотор зохицуулалтын орчныг тогтвортой байлгах, бизнесийн лиценз олголтыг хялбаршуулах, олон улсын зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үр ашигтай механизмыг ашиглах, эрхээ хамгаалах, гадаад худалдааны бодлогыг дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн хандлагатай уялдуулан хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Дунд хугацааны бодлого нь эдийн засгийн өсөлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж, үүн дотроо Засгийн газар нь дотоодын түүхий эд материалд тулгуурлан боловсруулах аж үйлдвэр, уул уурхай , аялал жуулчлал, мэдээллийн технологи, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч байна.

Эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг бууруулахад Засгийн газар болон иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтыг нэмэгдүүлнэ.

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлого нь томоохон үнэ цэнэ бүхий аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, улмаар эдгээр аж ахуйн нэгж, байгууллагуудын эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх, шинэ технологи ноу-хау-г нэвтрүүлж экспортын шинэ зах зээлтэй холбож өгөхөд чиглэгдэж байна. Эрчим хүчний салбар дахь бүтцийн өөрчлөлт нь бие даасан зохицуулалтын механизмыг сайжруулах, эрчим хүчний зах зээлд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх мөн тэдгээрийн үйл ажиллагааны үр ашигтай байдал, бие даан үйл ажиллагаагаа явуулах чадварыг нь бэхжүүлэх замаар үргэлжилнэ. Газрын шинэчлэл нь газрыг орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох, газрын эзэмшил, өмчлөлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, эдийн засгийн үр ашигтай хөрөнгө болгоход чиглэгдэнэ. Нийгмийн салбарын бүтцийн өөрчлөлт, үүний дотор боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн салбарт хийгдэх өөрчлөлтийг төрөөс үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг муутгахгүйгээр удирдлагын гэрээ, хувьцааг борлуулах, түрээслүүлэх замаар удирдлагыг нь аажмаар шилжүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Шинэчлэлийн хөтөлбөрийн сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор ядууст чиглэсэн тодорхой арга хэмжээг давхар авч хэрэгжүүлнэ.

Төсвийн тогтвортой байдлыг хангах

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах нь төрийн албаны шинэчлэлийн гол үр дүн байх бөгөөд шинэчлэл нь төрийн сангийн удирдлага, төсөв, нягтлан бодох бүртгэл-тайлагналт, үр дүнд суурилсан удирдлага, бараа үйлчилгээ худалдан авах ажиллагаа, аудит гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжинэ. Энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн үндэс нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Нэгдсэн төсвийн тухай хууль болон эдгээр хуультай нийцсэн бусад эрхзүйн акт, хөтөлбөрүүд болно. Эдгээр хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төсвийн төлөвлөлтийг сайжруулан шинэ шатанд гаргаж төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, улмаар бага орлоготой иргэдэд зориулан төрөөс зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, ядуучуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх боломжийг бий болгоно. Дунд хугацаанд хэрэгжүүлэх улсын салбарын шинэчлэл нь төрийн албаны шинэчлэлийг өргөн хүрээнд хийхэд чиглэгдэж байна. Энэ нь төрийн албан хаагчдын хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх, үр дүнд үндэслэсэн удирдлага, хяналт үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэхэд оршино. Үнэт цаасны зах зээлийг олон улсын стандартын дагуу хөгжүүлж, оновчтой болгох, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, тэдгээрийн мэдлэгийг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана. Үнэт цаасны зах зээлийн шинэчлэлтэй уялдуулж Итгэлцлийн Сангийн хуулийг батлуулан хэрэгжүүлнэ. Даатгалын бодлого нь хууль эрх зүйн орчинг сайжруулах, даатгалын компаниудад тавих хяналтыг өргөжүүлэх, удирдлагыг нь оновчтой болгох, даатгалын үйлчилгээний хүрээг нэмэгдүүлж, төрлийг олшруулах, олон улсын стандартыг нэвтрүүлэхэд чиглэгдэнэ.

Хүний тогтвортой хөгжлийг хангах

Хүн амын тогтвортой амьжиргааг хангаж, ядуурлыг бууруулах зорилтууд нь эдийн засгийн өсөлтийн хүрсэн түвшингээс хамаарах боловч хүний тогтвортой хөгжлийг хангах, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, сайн засаглалыг бүрдүүлэх зорилттой нягт уялдаатай хэрэгжинэ. Эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах стратегийн хүний хөгжлийн асуудлууд нь ядуучуудад орлого нэмэгдүүлэх боломжийг өргөжүүлэх, тэднийг шийдвэр гаргахад оролцуулах, улмаар нийгмийн баталгаатай байдлыг хангахад чиглэгдэнэ. Нийгмийн салбарын бодлого нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийн салбаруудад голчлон чиглэгдэж, ядууст чиглэсэн наад захын үйлчилгээг сайжруулах, тэдгээрийг зөв чиглүүлэх, үйлчилгээ үзүүлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудыг аккредитчлах зэрэг асуудлыг хамааруулна. Эхийн болон нялхсын эрүүл мэндийг сайжруулах, санхүүжилтийн системийг оновчтой болгоход онцгой анхаарах болно. Нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэл нь тэтгэврийн тогтолцооны суурь шинэчлэлийг хийх, даатгалын системийн хяналтыг сайжруулж, хүрээг өргөжүүлэхэд чиглэгдэнэ. Мөн иргэдийн оролцоон дээр тулгуурласан үйлчилгээний зарчмыг баримтлах, үйлчилгээг зөв чиглүүлэх шалгуур үзүүлэлтүүдийн оновчтой системийг нэвтрүүлэх, өрхийн халамжийн шинэ төрлийг бий болгох замаар нийгмийн халамжийн удирдлагыг өөрчлөн зохион байгуулах юм.

Ажил эрхлэлтийг урамшуулах үйл ажиллагааг хүмүүсийн ур чадвар, чадавхийг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглүүлнэ.

Оролцоог өргөтгөх

ЯБСББ-н хэрэгжилтийг тасралтгүй хангах, тодорхой хугацааны дараа тус баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахад иргэний нийгмийн оролцоог хангана. Ялангуяа аймаг сумын түвшинд иргэний нийгэм, бизнесийн төлөөлөлийг оролцуулан ЯБС-н хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, хянах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллах болно. Мөн ЯБС-н хэрэгжилтийн үнэлгээ, хяналт шинжилгээний үйл ажиллагаанд ТББ-ыг оролцуулна.

Хэрэгжүүлэлт ба хяналт шинжилгээ

ЭЗӨДЯБС -ийн хэрэгжилт ба хяналтыг ерөнхийд нь Санхүү, Эдийн Засгийн Яам зохион байгуулна. Санхүү, Эдийн Засгийн яамны Ядуурлын Судалгааны Нэгж нь ЭЗӨДЯБС -н хэрэгжилт, хяналт ба тайлагнахад гол үүргийг гүйцэтгэнэ. Салбарын яамдууд уг зорилтын хүрээнд тодорхой хөтөлбөрүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, уг зорилтыг хангах үүргийг хүлээнэ. Түүнчлэн Ядуурлыг Бууруулах Стратегийн Завсрын Баримт Бичгийг тархаах үйл явцад орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн оролцоотой байгуулагдсан ажлын хэсгүүд нь ЭЗӨДЯБС-н хэрэгжилт, хяналт үнэлгээ хийхэд оролцоно. Явцын тайланг жил бүр бэлтгэх бөгөөд стратегийг гурван жил тутамд шинэчлэж хандивлагчдын тусламж, үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор хандивлагчдын зөвлөгөөнд танилцуулж байх юм.

Стратеги амжилттай хэрэгжих урьдчилсан нөхцөл нь үр ашигтай хяналт шинжилгээ ба үнэлгээг хоёр төрлийн аргаар хэрэгжүүлнэ. Үүнд Засгийн газраас тогтоосон хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд, иргэний нийгмийн зүгээс тавих хяналт орно. ЯБС-н хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх зорилгоор амьжиргааны түвшний статистик үзүүлэлтүүдийг тогтмол цуглуулж, хянах, хэвлэн нийтлэхэд тохирсон шалгуур үзүүлэлтүүд, арга хэрэгслийн системийг бий болгоно. Иргэний нийгэм буюу ТББ, хувийн хэвшил, УИХ гишүүд, иргэд, хандивлагч байгууллагуудын төлөөлөгчдийн зүгээс тавих хяналт нь хяналт шинжилгээ, үнэлгээний олон төрлийн аргачлалыг ашиглах бөгөөд холбогдох үнэлгээг хийх, хяналт шинжилгээ явуулах чадавхийг бий болгоход Засгийн газрын зүгээс туслалцаа үзүүлнэ.

Засгийн газрын дунд хугацааны бодлогын гол баримт бичгүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, салбарын баримт бичгүүд болон бусад бодлогын чанартай баримт бичгүүд, Олон Улсын агентлагуудтай байгуулсан гэрээнүүд болно. Түүнчлэн олон улсын туршлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар ЯБС-г боловсруулах үйл явц, Мянганы Хөгжлийн Зорилтийг хангах, Мянганы Сорилтын Данс мөн үндэсний бүх оролцогч талуудын идэвхитэй оролцоо, гадаад тусламжийн зохицуулалт зэрэгтэй уялдуулан ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хурдасгах чиглэлээр үндэсний хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн тусгай хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцож байна. Санхүү эдийн засгийн яам нь эдгээр хөтөлбөрүүдийг боловсруулах, батлах хэрэгжүүлэх болон хянахад гол үүргийг гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд бодлогын баримт бичгүүдийн нягт уялдаа, үйл явцын дэс дараалал, тайлагналт чухал ач холбогдолтой бөгөөд хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдсан төсвийн зарцуулалт нь ерөнхий макро эдийн засаг, салбарын удирдлагын хүрээнд чухал үүрэгтэй байна.

Санхүүгийн хэрэгцээ

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн хүрээн дэх бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд ойролцоогоор жил тутамд ДНБ-ий 40-45 хувьтай тэнцэх хэмжээний санхүүгийн нөөц шаардлагатай. Энэ тооцоог Дунд хугацааны төсвийн хүрээний тооцоонд орсон зорилтуудад үндэслэн хийсэн болно.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ТОВЧ ҮНЭЛГЭЭ

Танилцуулга

Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт суурилсан, хүний эрхийг дээдэлсэн иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулах их үйлсийг эхэлж, улмаар нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэл хийж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг эргэлт буцалтгүй сонгосон билээ. Ардчилал, шинэчлэл, өөрчлөн байгуулалтын сүүлийн 10 гаруй жилд Монгол улс олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын өргөн дэмжлэг туслалцаатайгаар макро эдийн засгийн тогтвортой үндэс суурийг бүрдүүлэх хувийн хэвшилд тулгуурласан нээлттэй эдийн засгийн бүтцийг бий болгоход ихээхэн ахиц олж, Монгол улсад зах зээлийн харилцааны суурь бүрдэж улмаар хөгжлийн урт хугацааны зорилт, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ. Зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1992 онд 21.7 мянган төгрөг байсан бол 1995 онд 187.1 мянга, 2002 онд 270.1 мянган төгрөг болж өсчээ¹. Монгол улс хүний хөгжлийн түвшингээрээ 2002 оны байдлаар дэлхийн 173 орнуудаас 113-т орж байна². Монголын хүн ам 2002 оны байдлаар 2442.5 мянга болсон бөгөөд 1 хавтгай дөрвөлжин километр нутагт 1.5 хүн, нийслэл хотдоо нийт хүн амын 1/3 нь оршин суудаг, эдийн засгийн үндсэн салбар нь нүүдлийн мал аж ахуй хэвээр байгаа бөгөөд нэг хүнд 10.1 толгой мал ногдож байна.

Монгол улсын засаг захиргаа нь 21 аймаг, 1 нийслэл хотоос бүрдэнэ. Нийслэл хот Улаанбаатар нь өөрийн бие даасан удирдлага, нутаг дэвсгэр, тусгай статустай, Монгол улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор заагдсан өөрийн захиргаа, ажил үүргийг хэрэгжүүлэх бие даасан төсөв бүхий эдийн засаг нийгмийн цогцолбор юм. Улаанбаатар хотын онцлог бол нийт хүн амын гуравны нэг, хот сууринд амьдардаг хүн амын 40-50 хувь, оршин суудаг нутаг дэвсгэрийн 0,3 хувийг эзэлдэг, Монгол Улсын хүн амын дундаж нягтшилаас 100-аар илүү, мөн бусад хотуудын хүн амаас 8-10 дахин илүү хүн оршин суудаг юм. Эдгээр хүчин зүйлүүд болон том хотын хөгжлөөс шалтгаалсан эерэг болон сөрөг үзэгдлүүд ажиглагдаж байна. Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлаас шалтгаалан хөдөө орон нутгаас нийслэл хот руу нүүх иргэдийн тоо хурдацтай өсч байна. Энэ нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээвэр болон эрчим хүчний хангамж, хүрэлцээ зэрэг эдийн засаг, нийгмийн асуудлуудыг зүй ёсоор гаргаж ирж байгаа юм.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ ШИЛЖИЛТИЙН ЯВЦ

I. Макро эдийн засаг

1.1 Хуучин ЗХУ-аас үзүүлж байсан тусламж зогсож, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагаа задарсан нь Монгол улсын эдийн засгийн байдалд 1990-ээд оны эхэн үед хүндээр туссан. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1990-1992 онд 20 гаруй хувиар буурсан байна. Үндэсний хуримтлалын хэмжээ эрс багасч 1990 оны байдлаар ДНБ-ий 35 орчим хувийг эзэлж байсан бол 1995 онд 26 хувь болов. Импортын хэмжээ 1990 онд 924 сая ам. доллар байснаа 1992 онд 388.4 сая ам. доллар болж эрс багассан байна. Инфляцийн жилийн түвшин 1992 онд хамгийн өндөр буюу 325.5 хувьд хүрсний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин өсч, ажил идэвхтэйгээр эрэлхийлж, Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 1992 онд 54.9 мянга болж байв. Хуучин ЗХУ-аас үзүүлдэг байсан олон сая шилжих рублийн зээл, тусламж 1991 онд үндсэндээ бүрэн зогссон байна.

¹ Статистикийн эмхтгэл, 1997, 2001

² Хүний хөгжлийн тайлан, НҮБ, 2002

1.2 Монгол Улсын Засгийн газраас хуучин тогтолцооны үед хатуу тогтоон мөрдөж байсан бараа, үйлчилгээний үнэ, тарифыг үе шаттайгаар чөлөөлөх, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, банкны хоёр шатлалтай тогтолцоонд шилжих, гадаад худалдааг либеральчлах, валютын хөвөх ханшны тогтолцоонд шилжих, инфляцийг бууруулахад чиглэсэн мөнгө, санхүүгийн хатуу бодлогыг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөн өрнүүлэх талаар холбогдох хууль тогтоомжийг гарган мөрдүүлэх, хувийн хэвшил хөгжих орчин бүрдүүлэх зэрэг шинэчлэлийн алхмуудыг 1991 оны эхнээс эрчимтэй авч эхэлсэн. Засгийн газраас хэрэгжүүлсэн эдгээр бодлого, арга хэмжээний үр дүнд 1993 оноос эхлэн эдийн засагт сэргэх хандлага ажиглагдах болсон байна.

Хүснэгт 1:1: Эдийн засгийн гол үзүүлэлтүүд

| | 1990 | 1992 | 1995 | 1997 | 1999 | 2000 | 2001 | 2002* |
|--|-------|-------|-------|-------|--------|--------|--------|--------|
| Эдийн засгийн өсөлт, хувиар | -2.5 | -9.5 | 6.3 | 4.0 | 3.2 | 1.1 | 1.0 | 3.9 |
| Инфляцийн түвшин, хувиар | | 325.5 | 53.1 | 20.5 | 10.0 | 8.1 | 8.0 | 1.6 |
| Төсвийн нийт тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | -43.3 | -13.5 | -5.2 | -7.8 | -10.6 | -7.7 | -4.1 | -6.0 |
| Төсвийн урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | -8.8 | -1.7 | 6.2 | 1.6 | -0.3 | 3.1 | 5.6 | 4.4 |
| Экспорт, сая ам. доллароор | | 368.0 | 473.3 | 451.5 | 452.4 | 535.8 | 521.5 | 524.0 |
| Импорт, сая ам. доллароор | | 400.0 | 415.3 | 468.3 | 512.8 | 614.5 | 637.7 | 690.7 |
| Ханш, 1 ам. доллар =төгрөг | | | 473.6 | 813.2 | 1072.4 | 1097.0 | 1102.0 | 1125.0 |
| Гадаад цэвэр албан нөөц, сая \$ | | 4.6 | 70.7 | 107.2 | 116.9 | 140.7 | 160.1 | 225.9 |
| Ажилгүйдлийн түвшин, хувиар | | 6.3 | 5.5 | 7.6 | 4.7 | 4.6 | 4.6 | 3.4 |

* урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн газар, Монгол банкны статистикийн эмхтгэл

1.3 Ийнхүү макро эдийн засгийн байдал аажмаар сайжирч, 2000-2002 онуудад тогтворжиж ирсэн нь эдийн засгийн өсөлтийг хангах үндсийг бүрдүүлэхийн зэрэгцээ ядуурлыг бууруулах боломжийг бий болгож байна.

1.4 **Эдийн засгийн өсөлт:** Сүүлийн арван жилд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буурсан боловч 1994 оноос эдийн засагт тогтворжих хандлагууд гарч эхлэв. ДНБ-ий хэмжээ 1992 онд 9.5 хувиар буурч байсан бол 1994 онд 2.3 хувиар нэмэгдэж, түүнээс хойш өсөх болсон байна. Ялангуяа аж үйлдвэрийн салбар, тэр дундаа уул уурхайн салбарын жилийн өсөлт 6 орчим хувьд хүрч, байнгын уналттай байсан боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа 2000 оноос сэргэн идэвхжиж 2002 онд 20 гаруй хувиар өссөн байна. Ингэснээр аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин нэмэгдэж 26.6 хувьд хүрчээ. Харин эдийн засгийн голлох салбар болох хөдөө аж ахуйд 1990-1998 онуудад ихээхэн өсөлт гарч байснаа, 1999-2002 оны өвөл, хавар байгаль, цаг уурын байдал өөрчлөгдөж, хур бороо багасч ган болох, цас их орж зуд нүүрлэснээс 2000 онд нийт малын 10.4 хувь буюу 3.5 сая толгой мал, 2001 онд 4.7 сая толгой мал хорогдож, эдгээр жилүүдэд 2.7-3.0 сая мал хээл хаяж, төл бойжилт буурсан байна. 1999 оны эцэст 33.6 сая гэж тоологдсон малын тоо 2001 онд 26.1 сая, 2002 онд 23.9 орчим сая болж буурав. Үүний уршгаар мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс буурч, улмаар эдийн засгийн өсөлтийн хурдцыг сааруулан олон зуун малчин өрх амьжиргааны эх үүсвэргүй болж ядууралд орсон байна. Монголын эдийн засгийн үндэс болох мал аж ахуй нь байгаль цаг агаарын эрхшээлд өртөмтгий хэвээр байгаа нь эдийн засаг, хүн амын амьдралд ихээхэн эрсдэлтэй гэдгийг харуулж байна. ДНБ-ий өсөлт 2001 онд 1.0 хувь болж, 2002 оны урьдчилсан байдлаар 3.9 орчим хувь байхаар байна. Хэрэв ган, зудын гамшгийн нөлөөллийг эс тооцвол эдийн засгийн өсөлт сүүлийн 2 жилд жил тутам 8.0-аас дээш хувиар өсөх боломжтой байсан байна.

1.5 Төвлөрсөн төлөвлөгөөтэй захиргаадгалтын эдийн засгийн тогтолцоотой байсан 1960-1990-иэд оны үед Монгол улс нь мал аж ахуй дээр суурилсан хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон байв. Энэ үед бараг 100 хувь улсын болон хоршоолын өмчтэй байсан. Харин шилжилтийн үед бүтцийн өөрчлөлт, өмч хувьчлал эрчимтэй явагдсантай холбоотойгоор аж ахуйн нэгжүүд задарч, тайлан бүртгэлийн хамрах хүрээ, аргачлал өөрчлөгдсөн юм. Хэдийгээр эдийн засгийн харилцаа улам нээлттэй болж, хөрөнгө, хүмүүн капитал, үүнтэй уялдан шинжлэх ухаан, техник, технологийн ололт амжилтууд үйлдвэрлэлд нэвтэрч байгаа боловч эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл бага буюу өсөлтийн зөвхөн 20 хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Энэхүү стратегийн баримт бичгийг боловсруулах явцад ДНБ-ий өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийн тойм судалгаа Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн юм. (Шигтгээ1.1)

Шигтгээ 1.1: Эдийн засгийн өсөлт: хүчин зүйлийн нөлөөлөл (эмпирик судалгаа)

Энэхүү судалгаа нь эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлсийн оруулж буй хувь нэмрийг үнэлэх зорилготой байв. Урьд өмнө нь манайд хийгдэж байсан өсөлтийн судалгаануудаас энэхүү судалгааны онцлог нь хүмүүн капиталыг тусдаа биеэ даасан хүчин зүйл болгож, үндсэн хөрөнгийг олон улсын стандартын дагуу үнэлсэнд оршино.

Эмпирик судалгааны үр дүн

Монгол Улсын эдийн засгийн 1980-2001 оны өгөгдлүүдийг ашиглан эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлийн тооцоог хийж дүгнэлтийг гаргасан юм. Судалгаа нь өгөгдлүүдийг боловсруулах болон эмпирик үнэлгээ хийх гэсэн 2 үе шаттай байлаа (бодлогын зөвлөмж боловсруулах гэсэн 2 үе шаттай). Манайд үндсэн хөрөнгийн болоод хүмүүн капиталыг төлөөлүүлэх өгөгдлүүд статистикийн тоо баримтын хувьд олдоц муутай байсан тул эдийн засгийн өсөлтийн онолын болоод эмпирик судалгаануудын туршлагад тулгуурлан эдгээр хүчин зүйлүүдийг тооцоолсон. Тооцооны үр дүнгээс харахад хөдөлмөр ба капиталын бүтээмж 1990-1992 онд эрс буураад 1993 оноос эргээд өссөн байна. Хөдөлмөрийн бүтээмж 1985 онд хамгийн өндөр түвшиндээ хүрээд түүнээс хойш байнга буурч ирсэн байхад капиталын бүтээмж 1980 оноос хойш буурах хандлагатай байжээ.

Эмпирик судалгааны үр дүнгээс харвал монголын эдийн засгийн өсөлтөнд үндсэн хөрөнгийн 1 хувийн өсөлтийн оруулах хувь нэмэр 0.56 буюу хамгийн их, хөдөлмөрийн 1 хувийн өсөлтийн хувь нэмэр 0.29 ба хүмүүн капиталын 1 хувийн өсөлтийн хувь нэмэр 0.15 байна. Эдгээр хүчин зүйлийн 6 жилийн дундаж өсөлтийг ашиглан өсөлтөнд оруулж буй хувь нэмрийг тооцож үзэхэд 0.1 хувийг үндсэн хөрөнгө, 0.4 хувийг хөдөлмөр, 0.2 хувийг хүмүүн капитал тус тус бий болгож байжээ. Эндээс Монгол улсын хувьд үндсэн хөрөнгөөс хамаарсан мэдрэмж хамгийн их боловч сүүлийн жилүүдэд өсөлтийн хурд огцом буурснаас шалтгаалан эдийн засгийн өсөлтөнд үзүүлж буй нөлөө нь эрс багассан байна. Хамгийн бага мэдрэмжтэй хүчин зүйл болох хүмүүн капитал үндсэн хөрөнгөөс 2 дахин их хувь нэмэр оруулсан судалгааны дүн гарсан байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд хүмүүн капитал хамгийн их нөлөөтэй хүчин зүйл байдаг. Гэтэл Монголд 0.15 байгаа нь тийм ч хангалттай өндөр түвшин биш юм. Монгол орны хувьд боловсролтой ажиллагчидын цалин бүтээмжээс нь доогуур түвшинд олгож буй явдал үнэлгээний дүнд нөлөөлсөн байж болзошгүй юм. Иймд боловсролын түвшинг дутуу үнэлэх нь эдийн засагт нөөц буруу хуваарилгагдах, улмаар эдийн засгийн өсөлт хүрч чадах түвшингээсээ бага байх зэрэг сөрөг үр нөлөөтэй байдгийг судалгааны дүн харуулж байна.

1.6 Гадаад эдийн засгийн хүчин зүйлүүд: Монгол улсын гадаад эдийн засгийн харилцаан дахь хамтын ажиллагаа, гадаад худалдааны хуучин тогтолцоо задарч, гадаад худалдааг либеральчилж нээлттэй бодлого явуулж байгаа боловч экспортын өрөөсгөл бүтэц болон дэлхийн зах зээл дээрхи бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарч гадаад худалдааны нөхцөл муудаж, Азийн орнуудад гарсан санхүүгийн хямрал зэрэг нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж байна. Гадаад худалдааны алдагдал 1992 онд 32.0 сая ам. доллартай тэнцэж байсан бол 1994 оноос гадаад худалдааны тэнцэл эерэг болж, 1995 онд гадаад худалдааны тэнцэл 102.6 сая ам. долларын ашигтай гарч байв. Харин 1996 оноос дахин дордож жилд дунджаар 110.0 сая ам. долларын алдагдалтай байх болов. 1997 онд гаалийн албан татварыг тэглэсэн нь импорт нэмэгдэхэд зохих нөлөө үзүүлсэн. 2001 онд гадаад худалдааны алдагдал 169.9 сая ам.долларт хүрч төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал ДНБ-ий 16.6 орчим хувь болсон. Энэ нь дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлттэй шууд холбоотой байв. Зэсийн орлого 1999 оны экспортын нийт орлогын 33 хувийг бүрдүүлж байв. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ 1995 онд нэг

тонн нь 3000 ам. долларт хүрч байсан бол 1999 онд 1480 ам.доллар болтлоо эрс буурсан. Зэсийн үнэ 2000 онд бага зэрэг өссөн боловч 2001 онд дахин унажээ. Үүний зэрэгцээ энэ хугацаанд алт, ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ ч бас буурлаа. Нөгөө талаас манай улсад тохиолдсон малын шүлхий өвчнөөс хамааран Хятад улс руу экспортлодог мал аж ахуйн гаралтай түүхий эдийн хэмжээ мөн буурсан байна. Ийнхүү экспортын бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл нь хүн амын орлого, ялангуяа малчдын орлогод нөлөөлж тэдний амьдралын түвшинд тодорхой нөлөө үзүүлсэн байна. Ер нь Монгол улс олон улсын чөлөөт зах зээлээс алслагдмал, далайд гарцгүй, өрсөлдөх чадвар султай, цөөн нэрийн бүтээгдэхүүн экспортолдог нь гадаад худалдааны нөхцөлд муугаар нөлөөлж байна.

1.7 Харин энэ үед алтны үнэ 2001 оны 9 дүгээр сараас хойш нэмэгдсэн нь сайнаар нөлөөлөв. Гадаад валютын албан нөөц 1992 онд 4.6 сая ам.доллартай тэнцэж байсан бол 1994 онд 40.0 сая ам.доллар, 2001 оны эцэст 160.1 сая ам. доллар болж өслөө. Шилжилтийн үед нээлттэй эдийн засгийн бодлогыг явуулснаар манай оронд үзүүлэх олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудын Засгийн газрын туслалцаа байнга өсч, нөгөө талаар Засгийн газрын гадаад өрийн үлдэгдлийн хэмжээ нэмэгдэж 2002 оны эцэст ДНБ-ий 84 орчим хувьд хүрэв. Монгол улс 1991 - 2001 оны хооронд 2.1 тэрбум ам.долларын албан ёсны зээл, тусламжийг авч ашигласны 48 хувь нь хөнгөлөлттэй зээл байна. Монгол улс гадаад эдийн засгийн харилцааны нээлттэй бодлого явуулж, гадаад худалдааг либеральчилснаар дэлхийн олон орон, олон улсын байгууллагатай харьцаж өнгөрсөн 10 жилд хандивлагчдын зөвлөлдөх уулзалтыг 9 удаа зохион байгуулжээ.

1.8 **Санхүү, мөнгөний зах зээл:** Инфляцийн түвшин 1993 оноос аажмаар саарч, 1994 онд 66.3 хувь, 1995-1999 онд дунджаар 27.0 хувь болсон бөгөөд 2000 онд 10 хувь, 2001 онд 8.0 хувь, 2002 онд 1.6 хувьд хүрч нэг оронтой тоонд шилжлээ. Сүүлийн 10 жилд нийт мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ нэмэгдэж түүний жилийн дундаж өсөлт 27 орчим хувьд хэлбэлзэж, зээлийн хүүгийн түвшин жилийн 35 орчим хувьтай байна. Хүүгийн түвшин өндөр байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээ, эдийн засгийн өсөлтийг дэмжихүйц түвшинд байж чадахгүй байна. Сүүлийн арван жилд төсвийн байдал нэлээд хүндрэлтэй, төсвийн алдагдлын санхүүжилтийн ихэнхи хэсгийг банкны болон гадаадын зээл, тусламжаар хаах хандлагатай явж ирлээ.

1.9 Төсөвт орох татварын орлого 1998 онд багассан нь гадаад худалдааны нөхцөл муудсанаас үүдэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон ногдол ашгийн орлогын хэмжээ эрс буурсантай зарим талаар холбоотой. Ийнхүү дэлхийн зах зээлийн үнийн уналтаас шалтгаалан төсвийн орлого эрс буурч байхад төсвийн зарлагыг хэмнэх тал дээр дорвитой арга хэмжээ аваагүйгээс улсын санхүүгийн чадавхи ихээхэн муудсан байна. Үүний зэрэгцээ санхүүгийн байдлыг хүндрүүлэх өөр нэг шалтгаан бол банкны салбар дахь хямрал юм. 1996 оноос хойш нийтдээ 12 арилжааны банк дампуурч эдгээрийн заримынх нь хохирлыг нөхөх зорилгоор гаргасан өрийн бичгийн хүүгийн төлбөрт жилд 9 хүртэл тэрбум төгрөг төсвөөс төлдөг байсан нь төсвийн ачааллыг улам нэмэгдүүлж байв. 1996-1999 онд арилжааны банкуудаас олгосон зээлийн 30 орчим хувь нь чанаргүй зээлийн ангилалд орж байлаа.

1.10 Дээр дурдсан гадаад худалдааны таагүй нөхцөл, банк санхүүгийн хямрал, төсвийн хэт өндөр ачааллаас шалтгаалан төсвийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь жил бүр нэмэгдэж 1996 онд 7.7 хувьтай байснаа 1998 онд 12.5 хувь, 1999 онд 10.6 хувьд хүрч байлаа. Өөрөөр хэлбэл, 1996-1999 онд төсвийн орлого байнга буурч, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн өртөг хэт өндөр байснаас хамааран ядуучуудад чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээний зардал улам багассан байна. Харин сүүлийн хоёр жилд төсвийн алдагдал буурч, санхүүгийн тогтвортой байдлын эхлэл тавигдлаа. 2002 оны урьдчилсан тооцоогоор ДНБ-ний өсөлт 4.4 хувьтай байхад нийт төсвийн алдагдал ДНБ-ний 6 хувьтай байсан байна.

II. Хүн ам зүйн хандлага, өрхийн орлого, зарлагын судалгаа

1.11 Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор, Монгол улсын суурин хүн ам 2373.5 мянгад хүрч, эдгээрийн 56.6 хувь нь хотод /нийт хүн амын 32 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод төвлөрч байна/, 43.4 хувь нь хөдөөд оршин сууж байна. Нийт хүн амын 50.4 хувь нь эмэгтэйчүүд, 49.6 хувь нь эрэгтэйчүүд бөгөөд хүн амын 35.8 хувь нь 0-14 насны хүүхэд байна. Нэг квадрат километр газар нутагт 1.5 хүн ногдож байгаа нь дэлхийд хамгийн сийрэг байршилтайд тооцогдож байна.

1.12 1990-иад оноос хойш хүн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувь болж, төрөлтийн нийлбэр коэффициент 2.1 байгаа бөгөөд шилжилтийн үеийн эдийн засаг, нийгмийн хүндрэл бэрхшээлээс үүдэлтэйгээр төрөлт ихээхэн багассан нь хүн амын өсөлт саарах шалтгаан болжээ. Гэхдээ төрөлтийн түвшин ядуу гэр бүлийн дотор харьцангуй өндөр байна. Тухайлбал, ядуу гэр бүлийн бүтэц харьцангуй залуу байгаа бөгөөд ядуу өрхийн гишүүдийн 45 хувийг 15-аас доош насны хүн ам эзэлж байхад чинээлэг өрхийн хувьд энэ үзүүлэлт 31 хувьтай байна.

1.13 Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнд үндэслэн хийсэн сэдэвчилсэн судалгаануудын дүнгээр ард түмний аж амьдралд зарим өөрчлөлтүүд гарсан гэсэн дүгнэлт гарчээ.

1.14 Тухайлбал, өндөр настны тоо, өсөлтийн хурд сүүлийн 20 гаруй жилд буюу сүүлийн 3 тооллогын хооронд нийт хүн амынхаас бага, нийт хүн амд өндөр настны эзлэх хувийн жин үргэлж буурч байсан нь судалгаанаас харагдаж байна. 1950-иад оноос хүн амын өсөлтөд таатай орчин бүрэлдэж, хүн амын өсөлт эрс хурдассан. Иймд 1950-иад оны сүүлч 1960-иад онд төрсөн хүмүүс 2015-2020 оны үед өндөр насанд шилжих тул тэр үеийн өндөр настны тоо өмнөх үеийнхээс эрс өсөхөөр байна. Хүн ам, орон сууцны 2000 оны хэтийн тооцооны дунд хувилбараас үзэхэд өндөр настны тоо 2005 онд 2000 оныхоос 16.2 хувь буюу 20.1 мянган хүнээр, 2010 онд 2000 оныхоос 28.7 хувь буюу 35.6 мянган хүнээр өсч байна. Энэ нь УИХ-аас 1996 онд баталсан “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого” болон “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай” хуулиуд, бусад хөтөлбөр, тогтоол, шийдвэрт ахмадуудын ахуй нөхцөлийг сайжруулах, ажиллах боломж нөхцөлөөр хангах, тэдэнд хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, уг хуульд ойрын ирээдүйн нөхцөл байдалтай уялдуулан зарим өөрчлөлт оруулах шаардлага гарч болзошгүйг судалж үзэх шаардлага гарч байна.

1.15 Монгол улсад ам бүлээрээ эсвэл садан төрлөөрөө хамтран нэг өрх болж амьдардаг уламжлалт хэв шинж хэвээр хадгалагдаж байгаа нь улсын хэмжээний болон өндөр настны өрхүүдийг өрхийн хэлбэрээр ангилсан үзүүлэлтүүдээс харагдаж байна. Нийт өндөр настны 59.7 хувь нь буюу 72.4 мянга нь өрхийн тэргүүлэгч байна. Өрхийн тэргүүлэгч эрэгтэйчүүдээс 4109 нь, эмэгтэйчүүдээс 8453 нь ганц биеэр амьдарч байгаа нь анхаарал татах асуудал юм. Өндөр настай 10 хүний нэг нь ганцаараа амьдарч байгаад тухайн орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тэдний нийгмийн асуудалд илүүтэй анхаарах шаардлагатайг харуулж байна.

1.16 Өндөр настны ажил эрхлэх, санхүүгийн болон нийгмийн идэвхи сонирхол нэлээд өндөр байгаагийн дотор 2000 оны тооллогын үеэр өндөр настай 9 хүний нэг нь ажил эрхэлж байлаа. Нийт өндөр настны 12.3 хувь буюу 15.3 мянган хүн нь эдийн засгийн идэвхитэй хүн амд хамаарч байна. Эдийн засгийн идэвхийн түвшин хөдөөд болон нийт хүн амд ч, өндөр настангуудад ч илүү байгаа нь монголын онцлог юм. Хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэлд өндөр настангууд илүү оролцож байна. Харин хот суурин газарт байнга оршин суудаг өндөр настангуудын ажиллах ажлын байр хүрэлцээгүй, аж ахуйн нэгж, байгууллагууд тэднийг авч ажиллуулах сонирхол бага байна. Монгол улсын өндөр настангууд ялангуяа 65 хүртэл настай хүмүүсийн боловсрол, мэргэжил, ажлын дадлага туршлага сайтай зэргийг харгалзан үзвэл тэднийг ажиллах нөхцөл боломжоор хангах, бэлтгэгдсэн нөөц, хүнийг хөгжүүлэх талаар урьд өмнө оруулсан хөрөнгө оруулалтын үр дүн, чадавхийг аль болох бүрэн ашиглах, “Ахмадууд ажил,

амьдралын баялаг туршлага, үндэсний уламжлалаа залуу үеийнхэнд өвлүүлэх, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах, идэвхитэй амьдрах үүсгэл санаачлагыг дэмжих, ахмад үеийнхэний хөдөлмөр, гавъяа зүтгэлийн үнэлгээг оновчтой болгох бодлого баримтлана” гэсэн төрөөс хүн амын талаар баримтлах бодлогод заасан зорилтыг төр, засгийн болон аж ахуйн нэгж, байгууллагууд нэгдмэл бодлого чиглэлтэй хэрэгжүүлэх арга хэмжээг авах нь чухал байна.

1.17 Хүн амын боловсролын байдал. Хүн ам, үүний дотор сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, суралцаж байгаа хүүхдийг сургуулиас завсардуулахгүйгээр зохих түвшний боловсрол эзэмшүүлэх талаар Монгол улсын төр, засгаас ихээхэн анхаарч тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үе шатны онцлогтой уялдуулан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, түүнийгээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байсны үр дүнд эдүүгээ тус улсын хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин хөгжсөн орнуудынхтай ойртож очсоныг Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнд үндэслэсэн судалгаа харуулж байна.

1.18 Сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа бүрэн бус дунд, бүрэн дунд боловсрол эзэмших наснаас эхлэн бүх түвшинд бага байгаа нь цаашид мэргэжлийн сургуулиудад суралцагчдын хүйсийн харьцаа ялгаатай байх үндсийг тавьж байна. Сургуульд хамралтын хувь, бага боловсрол эзэмших насны бүлгээс бүрэн бус дунд боловсрол эзэмших насны бүлэгт 9.2 пүнктээр буурч байна. Энэ нь тоон утгаараа 44.7 мянган хүүхэд бүрэн бус дунд боловсрол эзэмших насандаа сургуульд хамрагдахгүй байна гэсэн үг юм. Эдгээр хүүхдийн 64.0 хувь нь хөвгүүд байна. Энэ нь малыг хувьчилж, 1990-ээд оны дунд үе хүртэл малчин өрхийн эрэгтэй хүүхэд сургуулиас ихээхэн завсардаж байсантай холбоотой бөгөөд сүүлийн жилүүдэд буурч байгаа хэдий ч энэ байдал бүрэн арилахгүй байна. Нөгөө талаар тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж ядуурал газар авсантай холбоотойгоор ядуу, нэн ядуу өрхийн эрэгтэй хүүхдийг орлого олох янз бүрийн хөдөлмөрт татан оруулж байгаа нь хүүхэд сургуулиас завсардах нэг нөхцөл болж байна.

1.19 Сургууль завсардалт ялангуяа эрэгтэй хүүхэд олноороо сургууль завсардсанаар мэргэжлийн сургуулиудад суралцагчдын хүйсийн тэнцвэрт биш байдал улам гүнзгийрч, цаашдаа эдийн засгийн төрөл бүрийн салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчин ялангуяа ажил үйлдвэрлэлийн онцлог нь эрэгтэйчүүд голлон ажиллах аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчид хүрэлцэхгүй болох талтай байна.

1.20 15-19 насны хүүхэд, залуучуудын дотор бичиг үсэг үл мэдэгчийн эзлэх хувь 2000 онд 1989 оныхоос 2.2 пүнктээр өсчээ. 2002 онд 15-19 насны хүүхэд, залуучуудын 4.2 хувь буюу 8.4 мянган хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн 5.6 мянга нь эрэгтэйчүүд, 2.8 мянга нь эмэгтэйчүүд байна.

1.21 1989 онд 20-29 насны залуучуудын 1.8 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байсан бол 2000 онд 0.5 пүнктээр өсч, нийт 5.3 мянган хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн 60.4 хувь нь мөн л эрэгтэйчүүд байна.

1.22 Хүн амын орон сууцны нөхцөлийн талаар. Монгол улсын хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор нийт 541149 өрх тоологдсоны бараг тэн хагас нь буюу 51 хувь нь гэрт, 49 хувь нь байшинд амьдарч байна. Энэ нь 1989 оны тооллогын дүнтэй харьцуулбал гэрт суудаг өрх 9.3 хувиар багасч, байшинд суудаг өрх 9.3 хувиар өсчээ. Хотын өрхийн 72 хувь нь байшинд, хөдөөгийн өрхийн 78 хувь нь уламжлалт гэрт амьдарч байна.

1.23 1989 оны тооллогын дүнгээр байшинд суудаг нийт өрхийн 2.7 хувь нь нийтийн байранд амьдардаг байсан бол 2000 оны тооллогоор энэ үзүүлэлт 3.2 хувь болж, 0.5 пүнктээр өссөн бөгөөд байшинд суудаг нийт өрхийн 1.3 хувь нь сууцны бус байшинд, 0.3 хувь байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээ, ой мод, уул хад зэрэгт амьдарч байна.

1.24 Гэрт амьдардаг нийт өрхийн 56.9 хувь нь гэрэл цахилгаангүй, 69.9 хувь нь телефон утасгүй байгаа бөгөөд эдгээр үзүүлэлт хөдөөд хотынхоос өндөр, хөдөөгийн гэрт амьдардаг өрхийн 75.2 хувь нь гэрэл цахилгаангүй, 98.9 хувь нь телефон утасгүй байна.

1.25 Хүн амын шилжих хөдөлгөөн. 2000 оны эхэнд Монгол улсад байнга оршин суугаа бүх хүний 74.3 хувь нь төрсөн газартаа амьдарч байна. Харин 25.7 хувь нь төрсөн газраасаа өөр газарт шилжин суурьшсан, эдгээрээс 5.0 хувь нь төрсөн газраас шилжин явсан боловч буцаж ирээд байнга оршин сууж байв.

1.26 Сүүлийн 3 жилд шилжигчдийн 42.6 хувь нь зөвхөн сүүлийн нэг жилд шилжсэн байна. Эдгээрээс үзэхэд Монгол улсад зах зээлийн эдийн засаг руу шилжилт хийж эхэлсэн үеэс чөлөөтэй болсон шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд улам гүнзгийрч нэмэгдэх төлөвтэй байгаа нь харагдаж байна.

1.27 Бүс нутаг доторх шилжих хөдөлгөөн Хангайн бүс нутагт хамгийн өндөр, Баруун бүс нутагт хамгийн бага байна. Хангайн бүс нутгийн аймаг хоорондын шилжих хөдөлгөөнд орсон нийт хүний дөрөвний гурав нь Орхон аймагт шилжин ирж, Хангайн бүс нутаг дотроо шилжигчдийг хамгийн их татдаг болж байна. Сүүлийн үеийн статистикийн тоо баримтаас үзэхэд Улаанбаатар хотод 824.7 мянган байнгын оршин суугч болон байнгын бус оршин суугч, зочлон өнгөрөгч, ажиллагч, суралцагчидтай нийт нэг сая орчим хүн амьдардаг гэсэн тоо гарч байна. Сүүлийн 5 жилийг авч үзэхэд л 70 мянгаас илүү хүн нийслэл хот руу нүүн суурьшсан нь төлөвлөөгүй нийгмийн зарлага өсөх гол хүчин зүйл болж байна.

1.28 Төвийн бүс нутагт Дархан уул аймаг шилжигчдийг хамгийн их татдаг аймаг болоод байна. Төвийн бүс доторх шилжигчдийн ойролцоогоор гуравны нэг нь Дархан уул аймагт шилжин иржээ. Улаанбаатар хотын тав, түүнээс дээш насны хүн ам сүүлийн таван жилийн цэвэр шилжих хөдөлгөөний үр дүнд 10 илүү хувиар өссөн ажээ. Баруун бүсийн нутгаас бүх шилжин явагчдын 60.0 хувь нь Улаанбаатар хот, 22.5 хувь нь Төвийн бүсэд шилжин суурьшжээ. Улаанбаатар хотод, тооллогын үед байнга оршин сууж байсан тав, түүнээс дээш насны бүх хүн амын 13.7 хувь нь сүүлийн 5 жилд шилжин ирсэн хүмүүс байна. Шилжин ирэгчдийн дийлэнхи нь Төвийн болон Баруун бүс нутгаас шилжин ирж байна. Улаанбаатар хот руу сүүлийн таван жилд шилжин ирэгчдийн бараг 40.0 хувь нь 15-24 насныхан байна. Үүний 20.0 хувь нь 15-19 насныхан, үлдсэн 19.6 хувь нь 20-24 насныхан юм.

1.29 Сүүлийн нэг жилд найм, есөн настай шилжсэн хүүхдийн сургуульд хамрагдалт төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй ийм насны хүүхдүүдийнхээс доогуур байгааг тэмдэглэх нь чухал юм. Энэ нь шилжин ирж суурьшсан газарт сургууль дутагдалтай эсвэл шинээр шилжин ирэгчид бүртгүүлж чадахгүй байгаатай холбоотой байж болно. Улаанбаатар хот руу 1999 онд шилжсэн өрхийн гэрт амьдрах нь илүү байсан бол 1999 оноос өмнө шилжсэн өрх ийн байшинд амьдрах нь илүү байна. Улаанбаатар хот руу 1999 онд шилжсэн өрх 1999 оноос өмнө шилжсэн өрхтэй харьцуулахад цахилгаан хангамжаар тааруу байна. Үүнтэй нэг адил Улаанбаатар хот руу сүүлийн 1 жилд шилжсэн өрхийг 1999 оноос өмнө шилжсэн өрхтэй харьцуулахад телефон утасны хангамжаар муу байна. Улаанбаатар хот руу 1999 онд шилжсэн өрхийн сууцны бус байшинд амьдарч байгаа хэсэг нь 4.0 хувь байхад шилжих хөдөлгөөнд ороогүй өрхийнх 2.0-оос бага хувь байна.

1.30 Хүн амын шилжих хөдөлгөөн нь хүн амын газар зүйн байршилд нөлөөлж, хүн амын төвлөрлийг Улаанбаатар болон түүний захын дүүргүүд, төвийн районд нэмэгдүүлэх, нөгөө талаар зарим бүсэд хүн амын тархалтыг эрс бууруулж байгаа нь орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг хомсдуулж, эдийн засаг дахь эрэлт нийлүүлэлт, нийгмийн хөгжлийн тэнцвэртэй бус байдлыг бий болгож байна.

1.31 Гэрлэлтийн байдал. 15 ба түүнээс дээш насны огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 2000 оны тооллогоор 1979 оны эрэгтэйчүүдээс 8.9, эмэгтэйчүүдээс 11.2 пунктээр, харин 1989 оны эрэгтэйчүүдээс 7.4, эмэгтэйчүүдээс 8.3 пунктээр өссөн нь залуучууд тэр дундаа эрэгтэйчүүдийн гэрлэх нас хойшилж хожуу гэрлэдэг болсонтой холбоотой байна.

1.32 Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүмүүсийн эзлэх хувь өсч, бэлэвсэн хүн амын эзлэх хувь буурсан байна. Гэр бүлээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал өндөр байдаг бол 60, түүнээс дээш насны бүлэгт бэлэвсэн хүмүүсийн эзлэх хувь хамгийн их байгаа нь өндөр настаны бүлгүүдэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс урт насалж байгаагаар тайлбарлагдана.

1.33 1979, 1989 оны тооллогын хооронд гэрлэлтийн нас нэг жил хагас, харин 1989, 2000 оны тооллогын хооронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэрлэлтийн нас хоёр жил хагас болж өсчээ. Харин хотын эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд нь хөдөөгийнхөөс ойролцоогоор 1 насаар хожуу гэрлэж байна. Энэ байдлаас дүгнэхэд сүүлийн жилүүдэд эрэгтэйчүүд орой гэрлэж байгаа нь нэг талаас зах зээлийн өнөөгийн нөхцөлд гэр бүл болох бэлтгэл, эдийн засгийн боломжоо хангах, сурч боловсрох зэрэг олон шалтгаанаас хамаарч байж болох ба нөгөө талаас залуучуудын үүрэг хариуцлага, ухамсар, амьдрах ухаанд өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох юм.

1.34 Ийнхүү Монгол улсын хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний хүчин зүйлээс үүдэн гарч буй хүн ам зүйн бодлого өөрчлөлтүүдийг эрүүл мэнд, жендэр, боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон бусад салбарын бодлогоор дамжуулан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегид тусгаж эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигтэй нягт уялдуулав.

1.35 Өрхийн орлого, зарлага. Өрхийн орлого, зарлагад 1999-2002 онд гарсан өөрчлөлтүүдийг мөнгөн орлого, цалингийн орлого, дундаж цалин, мөнгөн зарлага, хадгаламж зэрэг үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэн авч үзвэл дараахь байдалтай байна. Үүнд нэг өрхийн мөнгөн орлого 2002 онд 1999 оныхоос 82 хувиар өссөн байна. Харин мөнгөн орлого бодит хэмжээгээр 54 хувиар өссөн байна. Судалгаанаас үзэхэд, дундаж цалин 1999 оноос 2002 онд 26 хувиар өссөн бөгөөд бодит өсөлт нь 6 хувь болсон байна. Өрхийн мөнгөн зарлага 1999 оныхоос 2002 онд 67 хувиар өссөн дүнтэй байгаа бөгөөд бодит өсөлт нь 41 хувь байна.

1.36 *Өрхийн зарлага.* Өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлтүүдийг илүү тодорхойлох боломж бүхий үзүүлэлтүүд нь өрхийн зарлагын үзүүлэлтүүд болон зарлагын зарцуулалтыг харуулсан бүтэц юм. 2000-2002 онуудын байдлаар нэг өрхийн сарын дундаж зарлагыг нэр төрлөөр нь бүтцээр нь авч үзвэл дараах байдалтай байна. (Хүснэгт 1.2) 2000-2002 онуудын хувьд улсын дунджаар өрхийн мөнгөн зарлагын нийт зарлагад эзлэх хувь буурч 93.9-өөс 78.9 хувь болсон байна. Энэ нь өрхүүдийн хэрэглээнд бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийн хэмжээ 1 хувиас 3.5 хувь хүртэл, өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн хүнсний зүйлсийн хэмжээ 5.1 хувиас 17.6 хувь хүртэл тус тус өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1:2: Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц, улсын дунджаар

| Зарлагын төрөл | 2000 он | 2001 он | 2002 ХБГ |
|--|----------------|----------------|-----------------|
| Өрхийн зарлага-Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| 1. Мөнгөн зарлага-бүгд | 93.9 | 91.9 | 78.9 |
| Хүнсний зүйлийн зарлага | 39.1 | 39.1 | 32.2 |
| Хүнсний бус барааны зарлага | 31.7 | 27.0 | 26.3 |
| Үйлчилгээний зарлага | 22.9 | 25.6 | 19.9 |
| Хадгаламжийн кассанд | 0.1 | 0.2 | 0.5 |
| 2. Бусдаас үнэгүй авсан-Бүгд | 1.0 | 1.8 | 3.5 |
| Хүнсний зүйлийн зарлага | 0.3 | 0.7 | 1.9 |
| Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага | 0.7 | 1.1 | 1.6 |
| 3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлс | 5.1 | 6.3 | 17.6 |

1.37 Өрхийн зарлагын бүтцийн өөрчлөлтийг хот, хөдөөгөөр дараах хүснэгтэд харуулав. (Хүснэгт 1.3) Энэ хүснэгтээс харахад 2000-2002 онд өрхийн нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь хот болон хөдөөд тус тус буурсан байхад өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлсийн хэмжээ өссөн байна.

Хүснэгт 1:3: Нэг өрхийн сарын дундаж нийт зарлагын бүтэц, хот

| Зарлагын төрөл | Хот | | | Хөдөө | | |
|--|--------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|
| | 2000 | 2001 | 2002ХБГ | 2000 | 2001 | 2002ХБГ |
| Өрхийн зарлага-Бүгд | 100.0 | 100. | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 1. Мөнгөн зарлага-бүгд | 98.4 | 97.6 | 92.8 | 87.8 | 82.0 | 68.2 |
| Хүнсний зүйлийн зарлага | 45.4 | 42.8 | 38.7 | 31.4 | 32.6 | 26.6 |
| Хүнсний бус барааны зарлага | 27.6 | 24.8 | 28.8 | 36.4 | 30.8 | 24.8 |
| Үйлчилгээний зарлага | 25.2 | 29.6 | 24.5 | 19.9 | 18.6 | 16.6 |
| Хадгаламжийн кассанд | 0.0 | 0.4 | 0.7 | 0.1 | 0.0 | 0.2 |
| 2. Бусдаас үнэгүй авсан-Бүгд | 1.2 | 2.0 | 4.4 | 0.8 | 1.5 | 2.9 |
| Хүнсний зүйлийн зарлага | 0.3 | 0.5 | 2.3 | 0.4 | 1.0 | 1.7 |
| Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага | 1.0 | 1.5 | 2.1 | 0.4 | 0.5 | 1.2 |
| 3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлс | 0.4 | 0.4 | 2.8 | 11.4 | 16.5 | 28.9 |

1.38 Мөн хүн амын амьжиргаанд гарч байгаа өөрчлөлтийг харуулах нэг гол үзүүлэлт нь нэг хүнд ногдох зарлагын үзүүлэлт юм. Судалгаанд хамрагдсан өрхүүдийг нэг хүнд ногдох нийт зарлагын хэмжээгээр нь багаас нь их рүү 5 тэнцүү бүлэгт хувааж, нэг хүнд ногдох зарлагын бүлэглэлтийг хийж үзэхэд 1999 он болон 2002 онд дараах байдалтай байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 1:4: Нэг хүнд ногдох зарлагын бүлэглэлт, суурьшлаар

| Бүлэг | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|-------|--------------|--------|-------|--------|-------|--------|
| | 1999 | 2002 | 1999 | 2002 | 1999 | 2002 |
| 1 | 6398 | 57822 | 5319 | 59158 | 7205 | 56502 |
| 2 | 11509 | 111376 | 10271 | 111348 | 12435 | 111414 |
| 3 | 17101 | 167662 | 15738 | 167893 | 18121 | 167611 |
| 4 | 30002 | 252798 | 23841 | 253102 | 34612 | 252901 |
| 5 | 47611 | 620786 | 52448 | 639294 | 43992 | 584648 |

1.39 1999 онд, 5-р бүлгийн нэг хүнд ногдох зарлагын хэмжээ, 1-р бүлгийнхээс 7.4 дахин их байсан бол 2002 онд 5-р бүлгийн нэг хүнд ногдох зарлагын хэмжээ 1-р бүлгийнхээсээ 137 дахин өссөн гарч байна. Энэ нь Монгол улсад өрхийн орлого хуваарилалтын жигд бус байдал ихсэж байгааг харуулж байгаа үзүүлэлт юм.

1.40 Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ. Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, илчлэг, найрлагын хэмжээг жишсэн дундаж нэг хүний сарын хэрэглээгээр тооцож гаргасан бөгөөд жишсэн дундаж нэг хүний сард хэрэглэвэл зохих зөвлөмж хэмжээтэй жишиж харуулав. (Хүснэгт 5) Зөвлөмж хэмжээг ЭМНХЯ-ны сайдын 1997 оны А/318 тоот тушаалаар батлагдсан “Хүн амын хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-нээс авав.

Хүснэгт 1:5: Жишсэн нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний хэрэглээ, улсын дунджаар

| Хүнсний бүтээгдэхүүн | Зөвлөмж хэмжээ | 1990 | 1995 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|-----------------------------|----------------|------|------|------|------|------|------|
| Мах, махан бүтээгдэхүүн | 6.9 | 8.1 | 8.1 | 9.4 | 10.0 | 8.1 | 8.6 |
| Маханд шилжүүлснээр | | | | | | | |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн | 10.2 | 9.8 | 10.5 | 12.2 | 10.9 | 8.4 | 10.5 |
| Сүүнд шилжүүлснээр | | | | | | | |
| Цөцгийн тос | 8.1 | 0.3 | 0.4 | 0.2 | 0.2 | 0.2 | 0.1 |
| Гурил, гурилан бүтээгдэхүүн | 11.4 | 8.1 | 7.9 | 8.3 | 9.0 | 9.2 | 9.7 |
| Гуриланд шилжүүлснээр | | | | | | | |
| Будаа | 1.35 | 1.1 | 0.7 | 0.8 | 1.2 | 1.3 | 1.5 |
| Чихэр, сахарын зүйл | 1.8 | 1.9 | 0.7 | 0.7 | 0.9 | 1.0 | 1.0 |
| Сахарт шилжүүлснээр | | | | | | | |
| Загас, загасан бүтээгдэхүүн | 0.12 | 0.1 | 0.1 | 0.0 | 0.0 | 0.2 | 0.1 |
| Өндөг, ширхэг | 0.21 | 2.4 | 0.2 | 0.3 | 0.7 | 1.2 | 1.3 |
| Төмс | 3.6 | 1.9 | 0.9 | 1.4 | 1.8 | 2.2 | 2.6 |
| Хүнсний ногоо | 6.0 | 1.7 | 0.7 | 1.0 | 1.0 | 1.4 | 1.7 |
| Жимс, жимсгэнэ | 8.4 | 0.8 | 0.0 | 0.2 | 0.3 | 0.3 | 0.4 |
| Ургамалын тос | 0.75 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.2 | 0.5 | 0.7 |

1.41 Хүснэгтээс харахад тооцоо хийсэн бүх онуудад мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад хүнсний бүтээгдэхүүний хувьд зөвлөмж хэмжээнээс доогуур байна. Сүүлийн жилүүдэд болж байгаа ган, зуд зэрэг байгалийн бэрхшээлийн улмаас мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 2002 онд 1999 оны хэмжээнээс буурсан байна. Харин гурил, гурилан бүтээгдэхүүн, будаа, өндөг, төмс, хүнсний ногооны хэрэглээ 1999-2002 онд өссөн байгаа боловч зөвлөмж хэмжээтэй харьцуулахад доогуур түвшинд байна. Ялангуяа төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ хэрэглэсэн хэмжээ, зөвлөмж хэмжээнээс нэлээд доогуур түвшинд байна.

Хүснэгт 1:6: Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэг, найрлага, улсын дунджаар

| | Зөвлөмж хэмжээ | 1990 | 1995 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|--------------|----------------|--------|-------|--------|--------|--------|--------|
| Илчлэг, ккал | 2731.18 | 2538.4 | 2277 | 2241.2 | 2462.3 | 2344.4 | 2697.0 |
| Уураг, гр | 104.85 | 99.2 | 95.5 | 99.2 | 105.4 | 93.6 | 107.5 |
| Өөх тос, гр | 76.23 | 85.3 | 87.1 | 83.6 | 90.1 | 78.4 | 98.2 |
| Нүүрс ус, гр | 406.74 | 326.2 | 262.5 | 257.7 | 290.7 | 300.1 | 327.9 |

1.42 Хоногт шаардлагатай илчлэгийн хэмжээ 1999-2001 онуудад зөвлөмж хэмжээнд хүрэхгүй байгаа боловч, 2002 онд өсч гарсан байна. (Хүснэгт 6) Энэ нь найрлага дахь илчлэгийн хэмжээ харьцангуй өндөр гурил, гурилан бүтээгдэхүүн, өндөг, төмс, хүнсний ногооны хэрэглээ өссөнтэй холбоотой. Мөн хүнсний зүйлийн найрлага дахь уураг, өөх тосны хэмжээ 2002 онд зөвлөмж хэмжээнээс өссөн байна.

III. Ядуурлын өнөөгийн байдал

1.43 *Тодорхойлолт.* Монгол улс дахь ядуурлын шугамыг амьжиргааны доод түвшингээр тодорхойлж байна. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуульд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшинг Үндэсний статистикийн газар бүс нутгийн ялгавартайгаар зарлаж байна. Амьжиргааны доод түвшинг 2000 оны 12 дугаар сарын эцсээр 19500-25300 төгрөг гэж зарласан дүнг ядуурлын үнэлгээ, бодлогын зөвлөмж боловсруулахад ашиглаж байна. Харин уг түвшингийн 40 хувиас доош орлоготой буюу

хүнснийхээ наад захын хэрэгцээг хангаж чадахгүй шахам байгаа өрхийг нэн ядуу өрх гэж тодорхойлдог.

Ядуурлын үнэлгээ. Монгол улс дахь ядуурлын байдлыг үнэлэх судалгаа, үзлэгийг Засгийн газраас олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэд хэдэн удаа зохион байгуулсан.

1.44 Монголд 1995-2000 онд хийгдсэн хүн амын амьжиргааны түвшний судалгаа, оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх хэд хэдэн судалгаанаас үзэхэд дараах таван бүлгийн хүмүүс (1) олон хүүхэдтэй, ганц бие өрх, (2) 100-аас доош малтай өрх (өрхийн гишүүдийн тоо болон бүтцээс хамаарч), (3) ажилгүйчүүд, (4) боловсролгүй (суурь боловсролгүй) хүмүүс, (5) эмзэг бүлгийнхэн (өндөр настан, тахир дутуу, гудамжны болон өнчин хүүхдүүд) ядууралд өртөх нь элбэг байна.

Хүснэгт 1:7: Ядуурлын үзүүлэлтүүд (хувиар)

| | Хамралтын хүрээ, P0 | | Гүнзгийрэлтийн индекс, P1 | | Ялгааны индекс, P2 | |
|------------|---------------------|------|---------------------------|------|--------------------|------|
| | 1995 | 1998 | 1995 | 1998 | 1995 | 1998 |
| Хот | 38.5 | 39.4 | 12.2 | 13.9 | 5.7 | 7.1 |
| Улаанбаата | 35.1 | 34.1 | 10.4 | 13 | 4.5 | 7.4 |
| р | | | | | | |
| Хөдөө | 33.1 | 32.6 | 8.9 | 9.8 | 3.6 | 4.4 |
| Улсын дүн | 36.3 | 35.6 | 10.9 | 11.7 | 4.8 | 5.6 |

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

1.45 Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох 1995 оны судалгаагаар Монголын хүн амын 36.3 хувь ядуу амьдралтай байна гэсэн дүн гарсан байхад 1998 оныхоор нийт хүн амын 35.6 хувь, хот суурин газрын хүн амын 39.4 хувь, хөдөөгийн хүн амын 32.6 хувь нь ядуу амьдарч байна гэсэн дүн гарчээ. Өөрөөр хэлбэл, 1995 оны судалгааны дүнтэй харьцуулахад 1998 онд ядуу хүн амын тоо Улаанбаатар хотод буурч, бусад хот, суурин газарт өссөн байна. Ялангуяа ядуурал аймгийн төв, хот, суурин газарт илүүтэй төвлөрч байгааг судалгааны дүн харууллаа. Дээрх 2 судалгааны аргачлалаас шалтгаалан үүнээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг газар зүй байршил болон хүн амын бүтцээр гаргахад хязгаарлагдмал юм.

Шигтгээ 1.2. Ядуурлын талаарх мэдээллийн эх үүсвэр

1. Хөдөлмөрийн яамнаас ядуурлын үзлэгийг 1995 онд анх удаа зохион байгуулсан бөгөөд Монголын нийт өрхийн 13.2 хувь, нийт хүн амын 14.1 хувь нь ядуу гэсэн дүн гарсан.

2. Монгол улсад Өрхийн орлого, зарлагын судалгааг 1966 оноос явуулж эхэлсэн. Өрхийн нийт тоо нэмэгдэхийн хэрээр түүвэрлэлтэд хамрах өрхийн тоо 1000-1500 өрх болж өргөжсөн юм. Уг судалгааны явцад зөвхөн орлого, зарлагын хэмжээг тодорхойлохоос гадна орлогын эх үүсвэр, хэрэглээний загвар, амьжиргааны түвшин, түүний доод хэмжээг тооцдог. Өрхийн орлого, зарлагын судалгаа нь ядуурлын түвшин, инфляци, үндэсний тооцоо зэрэг статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох суурь болдог учраас энэ судалгааны аргачлал, хамрах хүрээг оновчтой болгох шаардлагатай юм. Одоогоор Үндэсний статистикийн газар нь Дэлхийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр Өрхийн орлого, зарлагын судалгааны аргачлалыг шинэчлэн, хамрах хүрээг өргөжүүлэн, асуулгыг амьжиргааны түвшингийн үзүүлэлтээр баяжуулж, ядуурлын талаар дүгнэлт гаргах, суурь мэдээлэл болгох чиглэлээр ажиллаж, 2002 оны эхнээс Өрхийн орлого, зарлагын өргөтгөсөн судалгааг явуулж байна. Энэхүү судалгааг нь өрхийн орлого зарлагын өмнө хийгдэж байсан судалгаануудтай харьцуулах боломжгүй юм. УСГ өрхийн орлого зарлага болон амьжиргааны түвшингийн судалгааг шинэ аргачлалаар хийж байна. Өрхийн орлого зарлага болон амьжиргааны түвшингийн судалгаа нь

Өрхийн орлого зарлагын судалгаа (Сар тутмын)

Амьжиргааны түвшингийн судалгаа (3 Сар тутмын)

Нийтийн асуулга

Үнийн асуулгаас бүрдэнэ

Өрхийн орлого зарлагын судалгаанд жил бүр Улаанбаатар хот болон бусад 21 аймгаас 11232 гэр бүл, 3 сард 2808 гэр бүлийг хамрах хурдацтайгаар хамрагддаг юм. Өрхийн орлого зарлагын ба амьжиргааны түвшингийн нэгдмэл судалгаанд нэг жилд 3744 гэр бүл 3 сард өрхийн орлого зарлагын судалгаанд хамрагдсан 936 гэр бүлийг хамрах хурдацтайгаар солигдох аргачлалыг ашиглан явагдах юм.

Олон улсын байгууллагын тусламжтайгаар явагдаж байгаа өргөтгөсөн судалгаа бол нийгмийн салбарт хийх шинэчлэл болон эдийн засгийн хөгжил ядуурлыг бууруулах дэлгэрэнгүй бодлогын салшгүй хэсэг юм. Өрхийн орлого зарлагын судалгаа нь ядуурлын бууралт, МХЗ-ын биелэлт болон □□-ны шаардлагыг хянах үндсэн эх сурвалж болдог.

3. Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох анхны судалгааг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 1995 онд явуулсан юм. Уг судалгаанд Монгол улсын нийт өрхөөс 1500 өрхийг сонгон хамруулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн газраас 1998 онд явуулсан Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох хоёр дахь судалгааг гүйцэтгэсэн нь Монгол улс дахь ядуурлын талаарх албан ёсны статистик мэдээлэл болсон юм.

4. Ядуурлыг чанарын талаас нь үнэлэх зорилгоор Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгааг 2000 онд Дэлхийн банк болон бусад хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар явуулсан. Уг судалгаа нь Засгийн газарт ядуучуудын дуу хоолой, тэдний байдал, мөн чанар болон түүнийг сайжруулахаар баримталж буй бодлогын талаар ядуучуудын үнэлгээ, дүгнэлтийг сонсох боломжийг олгосон юм. Энэ судалгааны зорилго нь ядуурлын талаархи статистикийн тоо мэдээллийг чанарын үзүүлэлтүүдээр баяжуулах, өмнө нь 1995, 1998 онд хийгдсэн Ядуурлын үзлэг болон Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаанд нэмэлт мэдээлэл өгөхөд оршиж байв. Энэ нь үндэсний хэмжээнд оролцооны аргаар явуулсан анхны судалгаа байлаа.

1.46 Ядуурлын түвшин 1994-2000 оны хооронд эрс нэмэгдээгүй боловч, ядуурал гүнзгийрч, орлогын тэнцвэрт бус байдал улам алдагдсаар байна. Хүн амын тэр дундаа ядуучуудын орлогын ялгаа сүүлийн жилүүдэд нэмэгдэж буйг 1995 онд 0.31 хувь байснаа 1998 онд 0.35 хувь болсон Жини коэффициент илэрхийлж байна. Ядуу хүн амын хэрэглээний ялгааг илэрхийлдэг хэрэглээний гүнзгийрэлтийн индекс 10.9-11.7-д хүрч, ядуурлын ялгааны индекс 1995 оноос 0.8 нэгжээр өссөн байна. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаанаас харахад, 1992-1995 онд баян, ядуу хүмүүсийн ялгаа шинээр үүсэж, 1995-2000 оны хооронд баян, ядуугийн зөрүү улам нэмэгдсэн байна. Судалгаанаас үзэхэд хотын хүн амын нэлээд хэсгийг ядуу болон нэн ядуу хүмүүс эзэлж байна. Дундаж амьдралтай өрхийн тоо 1992-1995 онд багасч энэ хугацаанд ядуу болон нэн ядуу өрхийн тоо нэмэгдсэнийг судалгаа болон судалгаанд оролцогчдын дүгнэлт нотолж байна. Монгол дахь ядуурал нь орлогын хомсдолоос үүдэлтэй байна. Ядуучуудын дийлэнх нь гэрт амьдардаг бөгөөд 27-30 хувь нь хамгаалалтгүй худгаас ундны усны хэрэгцээгээ хангаж байна.

1.47 Ядуучууд ба хөдөлмөр эрхлэлт. Ядуурал нь ажилгүйдэлтэй шууд холбоотой байгаа бөгөөд хот, суурин газрын хөдөлмөрийн насны ядуу хүн амын 27.3-38.8 хувь нь ажил эрхлээгүй байхад хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажилгүйчүүдийн 60 шахам хувийг ядуучууд эзэлж байна. Энэ нь хүн амын орлогын түвшингийн үзүүлэлтээр илэрхийлэгдэж байна. Хүн амын орлогын гуравны нэг нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, 20 гаруй хувь нь хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэлийн орлого, 30 хувь нь өрхийн өөрийн хувийн аж ахуйн орлого, 10 хувь нь бусдаас үнэгүй авсан хэрэглээнээс бүрдэж байна. Энэ бүтэц нь өрхийн байршлаас ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, хот, суурин газрын хүн амын орлогын 40-60 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж эзэлж байхад хөдөөгийн хүн амын орлогын дөнгөж 7 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж, 60-аад хувийг өрхийн хувийн аж ахуйн орлого эзэлж байна. Гэвч сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, зудаас шалтгаалан хөдөөд 10 гаруй мянган малчин өрх огт малгүй болж, олон мянган өрх малынхаа дийлэнх хувийг хорогдуулж, тэдгээрийн гэр бүлийн гишүүд ядуучуудын эгнээд орж, нэлээд нь төв суурин газар бараадан шилжиж ажилгүйчүүдийн эгнээг нэмэгдүүллээ.

Хүснэгт 1:8: Хөдөлмөрийн насны хүн амын бүтэц, байршлаар, 1998 (хувиар)

| Орлогын бүлгээр | Ажиллагчид | Ажилгүйчүүд | Бусад | Бүгд |
|--------------------------|-------------------|--------------------|--------------|--------------|
| Хөдөө | | | | |
| 1. Нэн ядуу | 37.6 | 38.8 | 23.6 | 100.0 |
| 2. Ядуу | 48.3 | 27.3 | 24.4 | 100.0 |
| 3. Ядуу бус (бага зэрэг) | 49.9 | 19.3 | 30.8 | 100.0 |
| 4. Ядуу бус (дунд зэрэг) | 55.2 | 13.2 | 31.6 | 100.0 |
| 5. Ядуу бус (чинээлэг) | 58.6 | 9.0 | 32.4 | 100.0 |
| Бүгд | 49.8 | 21.4 | 28.8 | 100.0 |
| Хот | | | | |
| 1. Нэн ядуу | 58.4 | 26.5 | 15.1 | 100.0 |
| 2. Ядуу | 79.6 | 11.9 | 8.5 | 100.0 |
| 3. Ядуу бус (бага зэрэг) | 83.3 | 6.5 | 10.1 | 99.9 |
| 4. Ядуу бус (дунд зэрэг) | 81.3 | 7.2 | 11.5 | 100.0 |
| 5. Ядуу бус (чинээлэг) | 80.8 | 4.4 | 14.8 | 100.0 |
| Бүгд | 77.9 | 10.3 | 11.8 | 100.0 |
| Улсын дүн | 65.0 | 15.4 | 19.6 | 100.0 |

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

1.48 Ядуучуудын дийлэнхи нь хэдийгээр ажил эрхэлж байгаа ч гэсэн орлого багатайн улмаас өлмүүн зэлмүүн амьдарч байна. Өөрөөр хэлбэл, хувиараа арилжаа наймаа, гар урлал эрхлэгчид, төсвийн байгууллагын ажиллагчид байна. Нэн ядуучуудын олонхи нь мэргэжилгүй, хөдөлмөр эрхлээгүй хүмүүс байгаа бөгөөд өөрсдөө ажил эрхлэх сэтгэлгээ санаачилга дутмаг, хэн надад ажил өгөх бол гэсэн хуучны бэлэнчлэх сэтгэлгээтэй зарим нь хэвээрээ байгаа нь нөлөөлж байна.

Хүснэгт 1:9: Хэрэглээний бүлгээр дундаж орлогын хуваарилалт (хувиар)

| Ядуурлын бүлэглэл | | | | | | | | | | | | |
|-------------------|------|---------------|------------|------------|-------------|------------------|-------------------|------------|-----------------------|----------------------|-------------|------------|
| | Бүгд | Мөнгөн орлого | | | Биет орлого | а.а-н бус орлого | Хөдөө аж ахуйгаас | | Өөрийн үйлдвэр-лэлээс | Бус-даас авсан бэлэг | Бусад | |
| | | Бүгд | Цалин | Тэтгэвэр | | | Тэтгэмж | ХАА | | | | МАА |
| Улсын дүн | 10 | 50. | 36. | | | | | | | | | |
| Нэн ядуу | 0 | 6 | 0 | | | | | | | | | |
| Ядуу | 10 | 37. | 29. | | | | | | | | | |
| Ядуу бус (б) | 0 | 0 | 1 | 11.0 | 3.6 | 0.8 | 2.8 | 0.2 | 8.1 | 21.1 | 13.0 | 3.4 |
| Ядуу бус (д) | 10 | 32. | 26. | 6.7 | 1.3 | 0.5 | 5.4 | 0.2 | 12.8 | 32.4 | 8.7 | 2.9 |
| Ядуу бус (ч) | 0 | 1 | 4 | 4.9 | 0.7 | 0.4 | 4.0 | 0.3 | 16.5 | 34.1 | 8.2 | 4.5 |
| Ядуу бус (ч) | 10 | 32. | 27. | 4.5 | 0.4 | 0.2 | 9.9 | 0.2 | 16.1 | 29.8 | 7.7 | 3.5 |
| | 0 | 5 | 6 | 4.2 | 0.3 | 0.1 | 12.4 | 0.2 | 9.9 | 28.8 | 13.4 | 5.9 |
| Дундаж | 10 | 29. | 24. | | | | | | | | | |
| | 0 | 4 | 8 | 5.1 | 0.7 | 0.2 | 8.5 | 0.2 | 13.3 | 30.1 | 10.1 | 4.4 |
| | 10 | 33. | 27. | | | | | | | | | |
| | 0 | 0 | 2 | | | | | | | | | |
| Хот | | | | | | | | | | | | |
| Нэн ядуу | 10 | 71. | 52. | | | | | | | | | |
| Ядуу | 0 | 1 | 0 | | | | 4.9 | | | | | |
| Ядуу бус (б) | 10 | 61. | 50. | | | | 11. | | | | | |
| Ядуу бус (д) | 0 | 0 | 1 | 15.3 | 3.8 | 1.3 | 2 | 0.1 | 1.4 | 4.5 | 11.6 | 5.1 |
| Ядуу бус (ч) | 10 | 59. | 51. | 9.0 | 1.8 | 1.0 | 9.4 | 0.0 | 4.4 | 5.9 | 12.6 | 3.9 |
| Ядуу бус (ч) | 0 | 1 | 2 | 6.9 | 1.0 | 0.6 | 0.6 | 0.3 | 3.1 | 5.6 | 12.2 | 9.6 |
| Ядуу бус (ч) | 10 | 57. | 51. | 5.3 | 0.4 | 0.2 | 17. | | | | | |
| | 0 | 1 | 4 | 5.3 | 0.4 | 0.2 | 3 | 0.1 | 3.0 | 4.2 | 11.5 | 6.6 |
| Дундаж | | | | | | | | | | | | |
| | 10 | 45. | 40. | 4.2 | 0.3 | 0.1 | 22. | 0.2 | 1.2 | 3.8 | 17.2 | 10. |
| | 0 | 0 | 5 | 6.4 | 0.9 | 0.4 | 15. | 0.2 | 2.4 | 4.5 | 13.8 | 8.2 |
| | 10 | 54. | 47. | | | | 9 | | | | | |
| | 0 | 6 | 4 | | | | | | | | | |
| Хөдөө | | | | | | | | | | | | |
| Нэн ядуу | 10 | 25. | 16. | 5.8 | 3.4 | 0.2 | 0.3 | 0.2 | 16.2 | 41.3 | 14.7 | 1.2 |
| Ядуу | 0 | 8 | 6 | 4.6 | 0.8 | 0.1 | 0.4 | 0.4 | 20.2 | 56 | 5.3 | 2.0 |
| Ядуу бус (б) | 10 | 15. | 10. | 3.6 | 0.6 | 0.2 | 0.3 | 0.2 | 25.7 | 53.5 | 5.5 | 1.0 |
| Ядуу бус (д) | 0 | 7 | 3 | | | | | | | | | |
| Ядуу бус (д) | 10 | 13. | 9.5 | 3.9 | 0.5 | 0.2 | 4.5 | 0.4 | 25.6 | 48.4 | 4.9 | 1.2 |
| | 0 | 6 | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|-----------------|-----------------|------------------|------------------|------------|------------|------------|------------|------------|-------------|-------------|-------------|------------|
| Ядуу бус (ч) | 10 0 | 14. 8 | 10. 4 | 4.3 | 0.3 | 0.1 | 2.5 | 0.3 | 18.7 | 54.4 | 9.4 | 1.2 |
| Дундаж | 10 0 | 13. 3 | 8.8 | 4.1 | 0.6 | 0.2 | 2.3 | 0.3 | 22.6 | 51.7 | 7.00 | 1.2 |
| | 10 0 | 14. 8 | 10. 1 | | | | | | | | | |

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

1.49 **Ядуучууд ба нийгмийн үйлчилгээ.** Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний зардал ядуу айл өрхийн амьжиргаанд дарамт болж, эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээг хүртэж чадахгүй байдал байна. Тухайлбал, өрхийн орлогоос боловсролд зориулан зарцуулж байгаа зардал 1998 онд 1995 оныхоос 4-5 дахин нэмэгдэж, хүнсний бус зардалд эзлэх хувийн жин 9.3 нэгжээр өссөн байна. Нэг хүнд ногдох зарлагын түвшин бага байх тусам тухайн өрхийн нийт зарлагад хүнсний хэрэглээний эзлэх хувийн жин өсч байна. Тухайлбал, нэг хүнд ногдох зарлага нь 8.0 мянган төгрөгөөс доогуур өрхийн 72.6 хувь нь зарлагынхаа 70-аас дээш хувийг хүнсэндээ зарцуулж байхад нэг хүнд ногдох зарлагын түвшин нь 60.1 мянган төгрөгтэй өрхийн зөвхөн 22.6 хувь нь зарлагынхаа 70-аас дээш хувийг хүнсэндээ зарцуулж байна.³

1.50 Боловсролын суурь үйлчилгээний хувьд 8-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин 86.5 хувь (охид 89.6 хувь, хөвгүүд 83.4 хувь), сургууль завсардалт 2.8 хувь (охид 2.4 хувь, хөвгүүд 3.2 хувь) байна. Сургууль завсардалт хөдөөд 3.7 хувь, хотод 1.4 хувь байна. Сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн 43.8 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй байна. Ийнхүү сургууль завсардалт их байгаа нь ирээдүйн ядуучуудыг төрүүлэх үндэс болж байна.

1.51 Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг чинээлэг өрхүүд ядуу өрхүүдтэй харьцуулахад илүү хүртэж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний сарын дундаж зардлыг хэрэглээний түвшингээр авч үзвэл хамгийн өндөр орлоготой бүлгийн нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал нэн ядуу хэсгийнхний зардлаас 9 дахин их, ядуу хүний эмнэлгийн байгууллагад хандах давтамж ч буурсан байна. Ядуучууд эмнэлгийн үйлчилгээг дутуу хүртэж байгаа, хоол хүнсний дутагдлаас болж өвчин эмгэгт өртөх нь нэмэгдэж улмаар тахир дутуугийн группт орон нийгмийн халамжийн сангаас тэтгэлэг авах явдал байна.

IV. Жендэрийн тэгш байдлыг хангах.

“Жендэрийн тэгш бус байдал нь хөгжлийн бодлогын үр ашгийг үндсэндээ бууруулдаг.”

1.52 Монгол улс Үндсэн хуулиар эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг баталгаажуулж, Засгийн газар эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлын олон улсын янз бүрийн конвенциудад нэгдэн орж, Засгийн газрын дэргэд эмэгтэйчүүдийн бодлогыг хянах, дэмжих, жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Жендэрийн тэгш байдлын асуудлаарх үндэсний хороог 2001 онд байгуулсан зэрэг жендэрийн тэгш байдлыг дэмжих таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа билээ. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэгш байдлыг дэмжих иргэний нийгмийн байгууллагууд, хөдөлгөөнүүд идэвхтэй ажиллаж байна. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг 2002 оны 12 дугаар сард батлан мөрдөж байна. Нэгэнт үүсэн бий болсон эдгээр эерэг нөхцөл байдлын зэрэгцээ эдийн засгийн боломж, хүртээмж, төрийн үйлчилгээнээс хүртэх байдал, гэр бүл дотор хүчирхийлэлд өртөмтгий байдал болон эрх мэдлийн хүрээнд ядууралд нөлөөлж байгаа, түүнийг хэмжиж байгаа бүх үзүүлэлтүүдэд

³ Өрхийн орлого, зарлагын судалгаа, 2002 оны 2 дугаар улирал

жендэрийн тэгш бус байдал ажиглагдаж, зарим чиглэлээр улам нэмэгдэх байдал гарч байна.

1.53 Жендэрийн тэгш бус байдал нь хөгжлийн бодлого амжилттай хэрэгжихэд ихээхэн сөрөг нөлөөтэй тул түүнийг арилгах нь чухал бөгөөд эдийн засгийн өсөлтийг сайжруулах, ядуурлыг бууруулах ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг. Засгийн газар болон төрийн бус байгууллагууд, хөгжлийн агентлагууд хамтран жендэр ба ядуурлын чиглэлээр цуврал семинарыг зохион байгуулсан юм. Эдгээр семинар, чуулганы эцэст Монгол дахь жендэрийн асуудлыг дараах чиглэл, сэдвээр тодорхойлон гаргаж ирсэн юм.

1.54 Жендэр ба эдийн засгийн бололцоо, нөхцөл. Бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн бодлогыг жендэрийн өнцгөөс харж хийгээгүйгээс энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст янз бүрийн эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлсэн байна. Өнгөрсөн туршлагаас харахад сүүлийн 10 жилд хийгдсэн нийгэм, эдийн засгийн бодлогууд эмэгтэйчүүдэд илүүтэйгээр сөргөөр нөлөөлж, тэднийг ядууралд өртөхөд нөлөөлжээ. 1990-ээд оны бүтцийн өөрчлөлт, хувьчлалын явцад олон тооны эмэгтэйчүүд нэрвэгдэж үлдсэн юм. Аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллаж байсан олон эмэгтэйчүүд цомхотгогдож, ямарч баталгаагүй албан бус салбар уруу шилжихэд хүрсэн байна. Эмэгтэйчүүд өмч эзэмших эрхгүй хоцорсон нь цаашид тэдний хөрөнгө барьцаалан зээл авах, аж ахуй эрхлэхэд нь том саад болсон билээ.

1.55 Эмэгтэйчүүдэд ээлгүй зарим нэгэн хууль дүрмүүд батлагдаж гарсан байна. Тухайлбал, 1991 онд гарсан тэтгэврийн хуульд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүд тэтгэвэрт эрт гарч болохоор заалт орсон нь тэр үеийн харьцангуй залуу олон эмэгтэйчүүдийг ажилгүй болгосон байна. Саяхан батлагдсан Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар газрыг өрхөд өгнө гэж заасан нь Үндсэн хуулийн иргэн бүр газар өмчлөх эрхтэй гэж заасантай зөрчилдөж, ялгавар үүсгэж байна. Энэхүү хуулийн хэрэгжилт нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн тусах нь тодорхой бус байгаа юм.

1.56 Зээл авах, санхүүгийн үйлчилгээ, бизнесийн орчин эмэгтэйчүүдийн хувьд хязгаарлагдмал, хангалтгүй байна. Эмэгтэйчүүд гэрийн хөлсгүй ажилд олон цаг зарцуулдаг учраас эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхлэхэд бэрхшээл учирч байна. Хөлсгүй хөдөлмөрийг үнэлж, түүний оруулж байгаа хувь нэмрийг үндэсний тооцооны журамд тэр бүр тусгадаггүй байна. Ялангуяа хөдөөгийн нөхцөлд мал аж ахуйг хувьчилж, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэлийг өрхөд даатгаснаар хөлсгүй хөдөлмөр ихээхэн нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн эдийн засгийн шинэчлэлийн ихэнх сөрөг үр дагаврыг үүрч, харин ашгийн багахан хувийг хүртэж иржээ.

1.57 Ядуурлаас гарах гол хүчин зүйл болсон ажил эрхлэлт, орлого хуваарилалтад жендэрийн тэгш бус байдал ажиглагдаж байна. Эмэгтэйчүүдийг нас, хүйс, өнгө зүсээр нь ялгаварлаж үзэхээс гадна тэдний хүүхэд төрүүлэх, асран хүмүүжүүлэх хариуцлагаас нь болгоомжилж ажилд авахаас цааргалдаг явдал байсаар байна.

1.58 НХХЯ-наас 1992-1995 оныг хамруулан хийсэн судалгаагаар ажилгүйдэлд орсон эмэгтэйчүүд (63%) эрэгтэйчүүдээс (37%) илүү байсан байна. Эмэгтэйчүүд санхүү, зээлийн үйлчилгээнээс хүртэх хүртээмж, бизнес эрхлэх боломжууд нь эрэгтэйчүүдийг бодвол хязгаарлагдмал байна. Өмч хөрөнгө гол төлөв өрхийн тэргүүн эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэгдэж байна.

1.59 Жендэр болон төрийн үйлчилгээний хүртээмж. Монгол орны өргөн уудам нутаг дэвсгэрт хүн ам тархай бутархай суурьшдаг, дэд бүтцийн хөгжил муугаас төрийн үйлчилгээг ард түмэндээ хүртээхэд саад тотгор учирдаг байна. Ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа сурагчдын тоог 1990 онтой харьцуулахад маш бага байна. Ялангуяа ахлах ангид суралцагч эрэгтэй сурагчдын тоо үнэхээр бага байна. Эмэгтэйчүүдийн төрөлтийн нас баралт өндөр байгаа нь ялангуяа хөдөө орон нутагт нилээд байгаа нь хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй, чанарын түвшин муу байгаатай холбоотой юм. Энэ нь эмэгтэйчүүдэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Хөдөө

орон нутагт эрүүл мэндийн байгууллага хомсдолтой байгаа нь үйлчилгээний чанарт болон үйлчилгээний зардалд сөргөөр нөлөөлж байна. Үүний хажуугаар энэ байдал нь үйлчлэгч үйлчлүүлэгч хоёрын хоорондын зайг холдуулж асуудлыг улам хүндрүүлж байна.

1.60 Жендэр ба эмзэг байдал. Ажилгүйдэл, эдийн засгийн баталгаагүй байдлын улмаас нийгмийн дотор бухимдал, архидалт, гэмт хэрэг даамжирч, гэр бүлийн салалт, хүчирхийлэл нэмэгдэж байна. Тухайлбал, 2001 онд насанд хүрсэн 10000 хүн тутмын 156 нь нэг буюу хэд хэдэн төрлийн хүчирхийлэлд өртсөн байна. Хүчирхийллийн хүнлэг бус үйлдлүүд илэрхий гарсаар байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Улаанбаатар хот, 6 дүүрэгт хийсэн судалгаагаар хүчирхийлэлд эмэгтэйчүүд илүү өртдөг гэсэн дүгнэлт гарчээ. Хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн 30 хувь нь ажил хийх сонирхолгүй болдог гэсэн төдийгүй тал хувь нь өөртөө итгэх итгэл, нийгмийн байдалд нь сөргөөр нөлөөлдөг гэжээ. Гэр бүлийн хүчирхийлэл эмэгтэйчүүдийн бие мах бодь, сэтгэлзүйд хохирол учруулж байна.

1.61 Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн хувь өндөр байгаа болон албан бус салбарт ажиллаж амь зуулгаа залгуулж байгаа нь тэднийг нийгмийн хамгаалал болон тэтгэвэр тэтгэмжийн системд хамрагдах боломжгүй болгож байна. Гэр бүл толгойлсон эмэгтэйчүүдийн амьдрал туйлын ядуу байна. Жишээлбэл: Хэдийгээр нийт өрхийн 12-13 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байгаа боловч нэн ядуу өрхийн 24.6 хувь, ядуу өрхийн 18.3 хувийг тэд эзэлж байгаа юм.

Хүснэгт 1:10: Ядуу өрхийн тооны эзлэх хувийн жин өрхийн тэргүүлэгч ба орлогын бүлгээр (хувиар)

| | Эмэгтэй тэргүүн | Эрэгтэй тэргүүн |
|-------------------------|-----------------|-----------------|
| Нэн ядуу | 24.6 | 75.4 |
| Ядуу | 18.3 | 81.7 |
| Ядуу бус (бага зэргийн) | 11.6 | 88.4 |
| Ядуу бус (дунд зэргийн) | 13.5 | 86.5 |
| Ядуу бус | 12.7 | 87.3 |

Эх сурвалж: НҮБХХ/УСГ 1999

1.62 Ядуурал гүнзгийрэх тусам эмэгтэйчүүд толгойлсон өрхийн тоо олширч байгаа нь эдгээр өрх нь олон хүүхэдтэй, орлого олох боломжтой хүн цөөхөн байгаатай шууд холбоотой байна. Нөгөө талаар гэр бүл салалт нь эдийн засаг, сэтгэл санааны хувьд эмэгтэй хүнд илүү хүнд тусч байна. Эмэгтэй өрхийн тэргүүнтэй ядуу өрхүүд нь аймгийн төв, сумдад илүүтэй төвлөрч байгаа нь хөдөө орон нутагт бизнес эрхлэх болон томоохон төвлөрсөн хот суурин газар бараадах боломж тэдгээрт хязгаарлагдмал байгаатай холбоотой юм.

1.63 Эмэгтэйчүүдэд тэгш эрх олгох, тэдэнд илүү боломж олгоход чиглэсэн хандлага давамгайлж байсан үзэл баримтлалыг агуулгын хувьд өөрчилж, Монгол Улсад хүний эрхэд суурилсан жендэрийн тэгш байдлыг хангаж баталгаажуулах зарчмыг баримтлан эдийн засаг, нийгмийн хүрээний бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Орон нутагт 2002 оны 2-3 дугаар сард “Ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах нь” сэдэвт бүсчилэн зохион байгуулсан семинарт оролцогчдоос олон хүн “Ядуурлыг бууруулахад боловсрол чухал байна. Хүмүүсийг амьдрах ухаанд багаас нь сургах хэрэгтэй. Аливаа сургалтад эрэгтэйчүүд хамрагдаггүй” гэжээ. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сантай хамтран 2002 онд зохион байгуулсан Үндэсний чуулганаар Жендэрийн тэгш байдлын асуудлаарх үндэсний хөтөлбөрийн төслийг хэлэлцэв.

Хүснэгт 1:11: Ядуу өрхийн тоо, өрхийн тэргүүлэгч ба байршлаар, 1998 (хувиар)

| Өрхийн тэргүүлэгч, хүйсээр | Нийслэл | Аймгийн төв | Сум | Хөдөө |
|----------------------------|---------|-------------|------|-------|
| Эрэгтэй | 21.4 | 39.1 | 28.5 | 25.2 |
| Эмэгтэй | 43.8 | 53.2 | 51.7 | 23.6 |

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

1.64 *Жендэрийн тэгш эрхийг хангах үндэсний хөтөлбөр*: Монгол улсын Засгийн газрын чухал зорилтуудын нэг бол улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд жендэрийн тэгш эрхийг хангах орчинг бүрдүүлэх явдал юм. Энэ нь гэр бүл доторх жендэрийн ухамсар ухагдахууныг сайжруулснаар цаашид гэр бүлийн амьжиргааны түвшин ба иргэний хөгжлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн юм. Өмнө хийгдсэн судалгаануудаас авч үзэхэд монголд жендэрийн тэгш байдал тодорхой хэмжээгээр байгаа нь харагдсан юм. Тийм ч учраас Монгол улсын Засгийн газар Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг 2002 оны 12-р сард батлан гаргасан юм.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь жендэрийн асуудлыг зохицуулах болон шаардлагатай өөрчлөлт шинэчлэлтийг хийх, ажилгүйдэл дэх жендэрийн тэнцвэргүй байдлыг багасгах улмаар ядуурлыг багасгах, боловсрол, улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэгдэнэ. Мөн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэгдэж байна. Мөн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх эмэгтэйчүүдийн хөрөнгө эзэмшихийг дэмжих гэр бүл доторх хүчирхийллийг улс орны эдийн засаг, нийгэмтэй зохицуулан шийдвэрлэхэд хөтөлбөрийн зорилго чиглэгдэж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн зорилт, хийгдэх ажлууд:

- Гэр бүлийн хөгжил: Гэр бүлийн доторх харьцааг бататгах, хүүхэд өсгөхөд болон гэрийн ажилд тэгш оролцох, гэр бүл доторх хүчирхийллийг хуулиар болон гэр бүлийн гишүүдийн мэдлэгээр голлон зогсоох, гэр бүлийн өмчийн тухай шийдвэрийг эрх тэгштэйгээр гаргах болон эдгээрт зориулсан сургалт, арга боломжоор ядуу өрхийг хангах
- Эдийн засгийн харилцаа: жендэрийн асуудлыг хамарсан макро эдийн бодлогыг хэрэгжүүлэх, статистикийн аргаар хяналт тавих боловсон хүчин эрүүл мэнд, нийгмийн даатгалын судалгаа явуулах, дотоодын санхүү дэх эрх тэгш байдлыг хангах
- Хөдөө орон нутгийн хөгжил: Хөдөө орон нутаг дахь ерөнхий боловсролын сургуулийн насны ялангуяа эрэгтэй хүүхдүүдийг сургалтанд хамрагдуулах орон нутгийн хөгжилд хүмүүсийг идэвхтэйгээр оролцуулах, нярай хүүхэд болон эхийн эндэлтийг багасгах, бага оврийн бизнес болон ажиллагсдыг тэгш нөхцөлөөр хангах
- Шийдвэр гаргах эрх олгох сонгуулийг болон ажил хэргийн үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх орчныг бүрдүүлэх
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад үндэсний механизмыг сайжруулах (боловсруулах), үндэсний зөвлөл байгуулах, жендэрийн судалгаа хийх, жендэрийн асуудлыг хөтөлбөрт оруулах, санхүүжүүлэх, хөгжүүлэх, хянах, шалгах хэрэгтэй байна. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хөгжүүлэхэд зохих байгууллага болон ерөнхий аргачлал бодлого зайлшгүй хэрэгтэй байна.

V. Баталгаат бус байдал.

1.65 Ядуурал ба баталгаагүй эмзэг байдал харилцан уялдаатайг Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаанд хамрагдсан хүмүүс онцлон тэмдэглэсэн байлаа. Ялангуяа өрхийн эдийн засгийн баталгаагүй байдлаас гадна нийгэм, аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэндийн баталгаагүй байдлыг дурьджээ.

1.66 Эдийн засгийн баталгаагүй байдал нь хамгийн түрүүнд ажилгүйдэл, зах зээлээс алслагдмал байдлаар илэрхийлэгдэж байгаа бөгөөд үүнээс үүдэж олон өрхийн хувьд тэтгэвэр, тэтгэмж нь бэлэн мөнгөний тогтмол орлогын цорын ганц эх үүсвэр болж байна. Олон нийтийг хамарсан арга хэмжээ, орон нутгийн санаачилга дээр тулгуурласан хөрөнгө оруулалт нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, хөдөө аж ахуйн уналтыг бууруулахад чиглэгдэж байгаа нь хөдөө дэх ядуурлыг багасгах алхам болж байна. Ажлын байрны баталгаагүй байдал нь ядуурлыг улам бүр нэмэгдүүлж байна.

Хүснэгт 1:12: Ажил эрхлэлтийн түвшин, 1998 (хувиар)*

| | Нэн ядуу | Ядуу | Ядуу бус (бага зэрэг) | Ядуу бус (дунд зэрэг) | Ядуу бус (чинээлэг) |
|-------------------|----------|------|-----------------------|-----------------------|---------------------|
| Хот, суурин газар | | | | | |
| 1995 | 44.7 | 66.0 | 75.8 | 78.7 | 92.8 |
| 1998 | 49.2 | 63.9 | 72.2 | 80.7 | 86.8 |
| Хөдөө | | | | | |
| 1995 | 65.0 | 85.9 | 92.9 | 95.8 | 92.7 |
| 1998 | 68.0 | 87.0 | 92.7 | 91.8 | 94.8 |

*Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэж буй хүнийг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулав (1995 оны Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа)
Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

1.67 Байгаль орчны баталгаагүй байдал нь газар тариалан, мал аж ахуйд муугаар нөлөөлж улмаар хүн амын амьжиргаанд сөрөг үр дагавар авчирч ядуурлыг төрүүлж байна. 1990-иад оноос малчид болон малын тоо өссөн боловч нутаг бэлчээр сэлгэн нүүх, отор хийх нь багассанаас бэлчээрийг талхлахын зэрэгцээ байгалийн гамшиг, ган, зуд, ой хээрийн түймэр, хортон мэрэгчдийн хор нөлөө нь хөдөөгийн хүн амын амьжиргааны байдлыг улам дордуулж байна. Байгаль орчны эмзэг, баталгаагүй байдалд ялангуяа шинээр малчин болсон туршлагагүй хүмүүс илүүтэй өртөхийн зэрэгцээ үндэсний үйлдвэрүүдийн түүхий эдийн хангамж, экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ буурсанаас, хөдөөд ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн байна. Тухайлбал, улсын нийт мал сүрэг 1994-1999 онд тогтвортой өсч байснаа сүүлийн жилийн жилүүдэд болсон ган, зудын улмаас үлэмж тооны мал хорогдож, 2002 оны жилийн эцсийн байдлаар 24 сая толгой малтай болсон нь 1999 оныхоос 29 хувиар, 2000 оныхоос 20 хувиар тус тус буурчээ. Энэ хугацаанд зүй бусаар хорогдсон малын тоог зах зээлийн ханшаар үнэлбэл, нийтдээ 270 гаруй тэрбум төгрөг болж байна. Байгаль цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуй эдийн засгийн бааз суурь нь болсон Монгол орны хувьд байгаль орчны баталгаагүй байдал нь хүн амын амьдралд ихээхэн эрсдэлийг бий болгодог онцлогтой юм. Орон нутагт 2002 оны 2-3 дугаар сард бүсчилэн зохион байгуулсан "Ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах нь" сэдэвт семинар дээр байгаль цаг агаарын бэрхшээл, түүнээс хамгаалах талаар төр засгийн дэмжлэг бага байгаа тухай хүмүүс санал гаргаж байв.

1.68 Нийгмийн баталгаагүй байдал нь Монгол хүний уламжлалт зан заншил ёс зүй, садан төрлийн холбоонд муугаар нөлөөлж байна. Ер нь 1990-ээд оноос садан төрлийн холбоо суларч, айлууд хоорондоо хагас арилжааны маягтай харилцах нь нэмэгдсэн байна. Садан төрөл нь холдсон, нийгмийн сүлжээнд хамрагдаж чадахаа больсон өрхүүд хамгийн эмзэг, ядуу байдалтай байна. Үйлдвэр үйлчилгээ зогсож ажилгүйдэл бий болсноос хамт олны холбоо, нөхөрлөл байхгүй болсон.

1.69 Олон өрх, ялангуяа ядуу өрх эрүүл мэндийн баталгаагүй нөхцөлд орж байна. Ажилгүйдэл, эдийн засгийн баталгаагүй байдлын улмаас нийгмийн эмх цэгц алдагдаж, архидалт, гэмт хэрэг өсч, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт ихэсч байна. Энэ бүх

баталгаагүй байдал нэлээд өрхүүдэд том цохилт болж, дарамтад олон хүнийг оруулж, ядуурал руу хөтөлсөөр байна.

1.70 Эдийн засгийн уналт, нийгмийн тэгш бус байдал иргэний соёл, ёс заншлын доголдол ба бас бус нийгмийн сөрөг үзэгдлүүд “гудамжны хүүхэд” гэсэн шинэ, сэтгэл шимширмээр асуудлыг бий болгосон. Гудамжны хүүхдүүд жирийн хүний хэрэгцээт зүйлсээр дутаж, туйлын ядуу байдалд гуйланчлал хийж амьдарч байна. Энэ сэтгэл шимшрүүлсэн асуудал нь хүүхдийн үндсэн эрх ашигтай зөрчилдөж, нийгмийн хөгжилд сөрөг үр нөлөө үзүүлж, мөн олон улсын байгууллагуудын анхаарлыг татсан ноцтой асуудал болж байгаа юм. Гудамжны хүүхэд болж байгаа гол шалтгаанууд нь:

- Гэр бүлийн нөхцөл байдал муу
- Хүчирхийлэлд өртсөн
- Эцэг эхийн хайр халамж дутмаг
- Янз бүрийн өвчин эмгэгтэй
- Биеийн өсөлт торнилт муу
- Сургуулиас завсардсан болоод сургуульд сурч байгаагүй
- Зан аашийн доголдолтой

Гудамжны хүүхдийн асуудлыг шийдэхийн тулд нийслэл, хотын захиргаанаас тэдгээр хүүхдүүдийг гэр оронд нь буцааж хүргэж өгөх, асран хүмүүжүүлэгч байхгүй хүүхдүүдэд асран хүмүүжүүлэх орчныг бүрдүүлж байна. Тухайлбал:

- Асрагчгүй зан аашийн доголдолтой хүүхдүүдэд зориулсан байр байшин, багш ажилчдаар хангах, тэдний цалин хөлсөн дээр нэмэгдэл өгөх
- Хүүхдүүдээ асрагчгүй орхисон эцэг эхчүүдтэй хариуцлага тооцох тухай асуудалтай холбоотой хуулинд өөрчлөлт оруулах
- 1990-д оноос хойш гудамжинд өсч нас бие гүйцсэн хүмүүст зориулсан нарийвчилсан бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

VI. Ядуурал болон баталгаагүй байдлын үндсэн шалтгаан.

1.71 Монголын хүн амын гуравны нэг гаруй нь ядууралд орсон гол шалтгааныг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Зах зээлийн эдийн засагт тодорхой хөтөлбөртэй шилжээгүй, гэнэтийн огцом шилжилт хийсэнтэй холбогдуулж авсан бүтцийн өөрчлөлтийн явцад тус улсын үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын олонх нь үйл ажиллагаагаа зогсоож, олон мянган хүн ажилгүй болсон,

- Макро эдийн засгийн тогтворгүй байдлаас болж дотоодын болон импортын барааны үнэ өсч, гадны нөлөө ихсэж, банкны хямралууд үүсч, эдийн засгийн хөгжил саарч, улмаар орлого багассан,

- Мал сүргийг хувьчлах үед олон зуун шинэ малчид мал авсан боловч, мал маллагааны арга барил дутах, байгаль цаг агаарын бэрхшээлд бэлтгэлгүйгээсээ өртөж малаа хорогдуулсан зэргээс олон малчин өрх амьжиргааны эх үүсвэргүй болсон,

- Шилжилтийн эхний үед мал маллахаар олон хүүхэд сургуулиа орхисноос мэргэжил боловсролгүй хоцорч, ажил эрхлэх бололцоогүй болсон,

- 1990-ээд оноос өмнө төрөөс хүн амд үзүүлж байсан төрөл бүрийн бодит тэтгэлэг, тэтгэмжийн хэмжээ нийгмийн халамж, дэмжлэг ихээхэн буурсан,

- Хүн амын бодит орлого эрс буурсан зэрэг болно.

1.72 Дээрх үндсэн шалтгааныг Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх нь судалгаа болон 2002 оны эхний улиралд зохион байгуулагдсан “Ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах нь” бүсийн семинарт оролцогчид ч цохон тэмдэглэж байв.

Шигтгээ1.3. Баталгаагүй ба эмзэг байдал

"Аз жаргалтай сайн сайхан амьдрал гэдэг нь хувь хүн бие даан амьдралаа авч явах, гэр бүлийнхээ хэрэгцээг хангах, хэнээс ч хамаарахгүйгээр хувийн амьдралаа шийдвэрлэж чаддаг байх, үр хүүхдүүдээ боловсролтой болгож, эрүүл саруул амьдрахыг хэлнэ" гэж Хөвсгөл аймгийн Баянзүрх сумаас судалгаанд оролцсон хэсэг эмэгтэйчүүд тодорхойлжээ.

"Ажиллаж, эрүүл саруул, идэх хоолтой, өмсөх хувцастай, нийгэмтэйгээ хөл нийлүүлж алхаж чадаж байвал сайн амьдарч байна гэсэн үг" гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумаас судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлсон байна.

"Муу муухай амьдрал гэдэг нь хүүхэд, залуучууд нь боловсрол мэдлэггүй, өвчин зовлон нүүрлэсэн, бие бялдар оюун ухааны хэрэгцээгээ хангаж чадахгүй, ирээдүйдээ итгэлгүй амьдрахыг хэлнэ" гэж Төв аймгийн Жаргалант сумаас судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.

"Миний өр нэмэгдэж, түүнийг төлж чадахаа больж, хэмжээ нь тэнгэрт байгаа од шиг тоймгүй олон болсон доо " гэж Өмнөговь аймгийн Сэврэй сумын ядуу эмэгтэй хэлсэн байна.

Баталгаагүй байдлын дараах хэлбэр байна.

| | |
|---------------|---|
| Эдийн засаг | Ажилгүйдэл, зах зээлээс тусгаарлагдсан алслагдсан байдал, худалдаа, арилжаа наймааны таатай бус нөхцөл, үнийн тогтворгүй байдал, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгохгүй байх, бэлэн мөнгөний дутагдал, шинэ малчдын туршлагагүй байдал, үндсэн хөрөнгөө алдах болон өрөнд орох |
| Нийгэм | Нийгмээс тусгаарлагдах, хамт олон ураг төрлийн холбоо сулрах, итгэл алдрах, хамтран ажиллаж чадахгүй болох, гэр бүлийн хүчирхийлэл, хулгай, ялангуяа малын хулгай, |
| Байгаль орчин | Бэлчээрийн талхлалт, бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийн хомсдол, бэлчээр булаацалдах, зуд, ган, үер, шороон болон элсэн шуурга, тал хээрийн түймэр, хортон мэрэгчдийн хэт их тархалт, худаг усны болон өвөлжөөний хомсдол |
| Эрүүл мэнд | Архидалт, чанар муутай ундны ус, импортын хүнсний бараа, эм хэрэгсэл, ариун цэвэр, эрүүл ахуй муудаж, биеэ үнэлсэнээс эрүүл мэндийн эрсдэлд орох |

Эх сурвалж: Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа, 2000

VII. Ядуурлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

1.73 Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын банк санхүүгийн байгууллагууд, Монголыг дэмжигч орнуудтай хамтран 1994 оны 6 дугаар сард Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ЯБҮХ)-ийг боловсруулан баталж, 2000 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлсэн юм. Төвлөрлийг сааруулах, олон нийтийн оролцоог хангах зарчимд тулгуурлан олон салбарыг хамарсан уг хөтөлбөр нь хүн амын амьжиргааны түвшин буурах, хүний нөөцийн чадамж доройтох хандлагыг багасгах гол зорилготой байлаа. Хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт нийгмийн дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх замаар ажлын түр байр бий болгох, сургуулийн өмнөх болон суурь боловсролыг дэмжих, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн суурь үйлчилгээг сайжруулах, насанд хүрсэн хөдөлмөрлөх бололцоотой тахир дутуу иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тэднийг хамруулах болон тахир дутуу хүүхдэд боловсрол олгох зэрэг 13 мянга гаруй жижиг төслийг алслагдсан аймаг, сум, хороо, багт хэрэгжүүлэв. Эдгээр төслийг хэрэгжүүлэх үүсгэл санаачилга орон нутгаас гарч байсан нь онцлог юм.

1.74 Бусад хөтөлбөр, арга хэмжээ. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд, гадаад орнуудын дэмжлэг туслалцаатайгаар хүн амын амьжиргааны түвшинд шууд болон шууд бусаар нөлөөлөх цөөнгүй хөтөлбөр, төслийг эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, байгаль орчны салбарт хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, 1991-2001 онд авч ашигласан гадаадын зээл, тусламжийн 26 хувь буюу 287 сая ам. долларыг нийгмийн салбарт зарцуулсан байна.

1.75 Ажил эрхлэлт. ``Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай`` хууль батлагдсанаар хөдөлмөр эрхлэлтийн талаархи төрийн бодлого, зарчим, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой болж, үндэсний үйлдвэрийг сэргээж хөгжүүлэх, ажилгүйдлийг багасгахад чухал ач

холбогдолтой болсон юм. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрсөн төсвийн орлогын 0.3 хувь хүртэл хөрөнгийг жил тутам олгож байхаар хуульчлан тогтоов. Хуулийн энэ заалтын дагуу Улсын төвлөрсөн төсвөөс 2002 онд 200.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлэн зарцуулав. Мөн гадаад орнуудаас манай улсад ажиллаж байгаа иргэдийн ажлын байр эзэмшсэний төлбөрөөс 2002 онд 441.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн эдгээр гол 2 эх үүсвэрийн нийт 641.2 сая төгрөгөөс 400.0 сая орчим төгрөгийг аймаг, нийслэлийн дүүргүүдийн хөдөлмөр эрхлэлтийн 30 албадад хуваарилан мэргэжлийн сургалт зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих замаар ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч байна. 2002 онд нийт 4.6 мянган иргэн мэргэжил олгох сургалтад хамрагдаснаас 41 хувь нь амьжиргааны доод түвшингээс бага орлоготой хүмүүс байв. Нийтийг хамарсан ажлын түр байраар хангах бодлогын хүрээнд “Мянганы зам” төслийн зам барилгын зарим ажлын гар аргаар гүйцэтгүүлэн ажлын байраар хангах зорилгоор хөдөлмөр эрхлээгүй 260, цэргийн дүйцүүлэх албаны болон хөнгөн ялтай 240 хүнийг ажиллуулав.

1.76 Орлого нэмэгдүүлэх арга хэмжээ. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн үргэлжлэл болох Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг 2001 онд батлуулан хэрэгжүүлж эхлэв. Уг хөтөлбөрийн гол зорилго нь хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, нийгмийн зайлшгүй үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, ядуу бус бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэхэд оршиж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд зээлийн төслийн эхний үе шатны үйл ажиллагааг 2002 оны сүүлийн хагасаас Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхлээд байна.

1.77 Ядуурлын талаар хийсэн үнэлгээнд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд ядуу, эмзэг байдалд өртөх магадлал илүү байна гэсэн дүгнэлт гарсан тухай өмнө дурдсан. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх дэд төслийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх 2020 он хүртэлх үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас боловсруулан хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ 2002 оны 12-р сараас уг хөтөлбөрийг Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болгон өргөжүүлэв. Уг хөтөлбөрийн дагуу эхний шатанд /1996-2000/ жендэрийн талаарх судалгааг гүнзгийрүүлэх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах, хүн амын ажилгүйдэл, туйлын ядуурлыг арилгах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизмыг оновчтой тогтоогүй, санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан төдийлөн амжилтанд хүрээгүй гэсэн дүгнэлтийг хэрэгжилтийг дүгнэх үндэсний симпозиумаас гаргасан байна.

1.78 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр гадаад, дотоодын санхүүжилтээр нэлээд олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаагийн дотор Герман Улсын Засгийн газрын хөдөө дэх жижиг үйлдвэрлэлийг дэмжих төслүүд нэлээд үр дүнтэй болов.

1.79 Орлогын ядуурлыг бууруулах талаар тусгайлсан хөтөлбөр, төслийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас орлогын түвшингээрээ доогуур тооцогддог төрийн албан хаагчдын цалин, мөн тэтгэвэр, тэтгэмж авагчдийн тэтгэлэгийн хэмжээг удаа дараа нэмэгдүүлж ирсэн. Зөвхөн 2001-2002 онд тэтгэврийг дунджаар 41 хувь, төрийн албан хаагчдын цалинг дунджаар 23 хувиар нэмэгдүүлсэн байна.

VIII. Үр дүн ба сургамж

1.80 Хүрсэн үр дүн. Дээр дурьдсан арга хэмжээний дүнд манай улсын ядуурлын хурдац саарч, нэмэгдээгүй хэдий ч дорвитой буураагүйгээс ядуурал нь өнөөгийн тулгамдсан асуудал хэвээр байна. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс дараах үр дүн харагдаж байна. Үүнд:

- ◆ Хөтөлбөрийн хүрээнд орлого бий болгох төсөлд хүн амыг хамруулах болон нийтийг хамарсан түр ажлын байраар хангах замаар ядуу өрхийн 30 гаруй хувийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүллээ. Тэдний ихэнх нь ур чадвар, бизнесийн мэдлэг

шинээр эзэмшиж, өөрөө өөртөө итгэлтэй аж төрж, улмаар ядуурлаас гарч чадсан байна.

- ◆ Малчин ядуу өрхүүдийн амьжиргааны тогтвортой байдлыг хангах зорилгоор 2200 гаруй малчин өрхөд 107 орчим мянган толгой малыг гэрээгээр олголоо. Малжуулах төслийн зэрэгцээгээр малчин өрхийн зарим хэсэг нь газар тариалан давхар эрхэлж өөрсдийн ахуй амьдралаа дээшлүүлж байна.
- ◆ Ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд эмэгтэйчүүд ихээхэн хэмжээний ашиг хүртэж байна. Тухайлбал, орлого нэмэгдүүлэх төсөлд хамрагдаж байгаа нийт хүмүүсийн 65 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүний зэрэгцээ төрийн бус байгууллагуудаар дамжуулан төсөл боловсруулах болон төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслүүд, мөн хөдөөгийн эрүүл мэндийн төслүүд, нэн ялангуяа эхчүүдийн амрах байрыг тохижуулах төслөөс эмэгтэйчүүд илүү ашиг хүртэж байна.
- ◆ Нийтийг хамарсан ажлын түр байр бий болгох төслүүд нь орлого нэмэгдүүлэхээс гадна орон нутгийн эдийн засагт урт хугацааны туршид сайн үр нөлөө үзүүлэхээр байна. Зам гүүр, далан, усалтын суваг зэрэг нь удаан хугацааны туршид хөдөөгийн хүн амын тогтвортой амьжиргааг хангах нөхцөл болж байна. Түүнчлэн ундны усан хангамж, нийтийн халуун ус болон халаалтын сүлжээ, орчны ариун цэврийн төслүүд нь эрүүл энх, сайн сайхан байдлыг хангахад тодорхой хувь нэмэр орууллаа.
- ◆ Суурь болон сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх, хөдөөгийн эрүүл мэндийг сайжруулах төслүүдийг улсын хэмжээнд хэрэгжүүлснээр сургууль, цэцэрлэгт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг багасгах, эх няхлхсын эндэгдлийн түвшинг бууруулахад дэмжлэг болж байна.

1.81 Ядуурлыг бууруулахад чиглэсэн тодорхой төслүүдийг хэрэгжүүлж үр дүнд хүрэхийн зэрэгцээ зах зээлийн эдийн засагт шилжих явцад эдийн засаг, тэр дундаа макро эдийн засагт гарч буй нааштай алхмууд нь хүн амын тогтвортой амьжиргааг хангахад чухал нөлөө үзүүлж байна. Инфляци, үнэ, ханш тогтворжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, үндэсний үйлдвэрлэл сэргэж, улсын төсвийн удирдлага бэхжиж, гадаадын зээл, тусламжийн хэмжээ болон зохицуулалт сайжирснаар нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшилж, улмаар тэдгээрийг ядуучуудад чиглүүлэх боломж бүрдэж байна. Хүн ам, тэр дундаа хөдөөгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн дэд бүтцийг сайжруулах, шинжлэх ухаан, технологийн ололтыг амьдралд нэвтрүүлэх замаар эдийн засаг дахь бүтээмжийг дээшлүүлэх явдал Засгийн газрын үйл ажиллагааны нэг зорилт болж байна.

1.82 Эдийн засгийн хүрээнд хэрэгжиж буй бүтцийн өөрчлөлтийн үр дүнд эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, ДНБ-ий 70 гаруй хувийг үйлдвэрлэх болов. Монгол улсын эдийн засгийн нээлттэй байдал улам өргөжиж, иргэд амьдралаа өөрийн хүсэл эрмэлзлийн дагуу зохицуулж, зорилгодоо хүрэх эрх, эрх чөлөөгөөр хангагдан, чөлөөт өрсөлдөөний зарчмаар бизнес эрхлэх таатай орчин бүрдлээ.

1.83 *"Одоо бид ядуурал гэж юу вэ? гэдгийг ойлгож түүнд юу нөлөөлж байгаа, түүнтэй хэрхэн тэмцэх арга замуудыг мэдсэн. Ядууралд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил нөлөөлөхөөс гадна тухайн үеийн байгаль цаг уур, ядуу хүний өөрийнх нь арчаагүй байдал нөлөөлж, бидний өөрсдийн зохион байгуулалт хангалтгүй байна"* гэж Баянхонгор аймагт 2002 оны 3 дугаар сард зохион байгуулсан бүсийн семинарт оролцогчид дүгнэж байв.

1.84 *Сургаамж.* Ядуурлыг бууруулах болон нийгмийн чиглэлийн бусад хөтөлбөр, төслүүдийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг боловсронгуй

болгох зэрэг өргөн хүрээний бодлоготой уялдуулан цогцолбороор авч үзэж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн сургамж гарч байна. Өөрөөр хэлбэл ядуурлыг бууруулах хөтөлбөрийн ойлголт, зарчмууд нь хичнээн ул суурьтай байсан ч үүнийг эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулж, хүний хүчин зүйлсийн чадавхийг бэхжүүлэх болон ажлын байр ихээхэн нэмэгдүүлэх бодлого, өсөлтийн стратегитэй уялдуулахгүйгээр ядуурлыг дорвитой бууруулах боломжгүй гэдэг нь харагдсан болно.

1.85 Ядуурлыг бууруулах, хүн амын тогтвортой амьжиргааг хангах бодлого, түүний хэрэгжилтийг жинхэнэ ядуучуудад хүргэж хүртээх, хүн амын дунд бий болсон орлогын болон хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах нь Ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилго байхын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон хуримтлалыг ядуучуудад оновчтой хүргэх механизмыг бүрдүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

1.86 Цөөн нэр төрлийн түүхий эд голлосон экспортын өрөөсгөл бүтэц нь эдийн засгийн гадаад орчны нөлөөлөлд хэтэрхий өртөмтгий байдалд хүргэж байгаа бөгөөд дотоодын эрэлтийг одоогийн эдийн засгийн өсөлт тэр бүр хангахгүй байна.

1.87 Эдийн засагт чухал үүрэгтэй банкны тогтолцоо хэврэг хэвээрээ байгаа бөгөөд банкны систем хувийн хэвшилд шилжих үйл явц үндсэндээ дуусч байна. Нөгөө талаар банкны салбар дахь өрсөлдөөн сул байгаа нь зээлийн хүүг өндөр байлгаж, түүний олдцыг хязгаарлаж байна. Хувьчлагдсан аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны ашиг доогуур, хүний нөөц болон удирдлагын чадавх нь сул байна.

1.88 Сайн засаглалын бүрэлдэхүүн хэсэг болох төрийн зохицуулалт, удирдлага, хяналт, бодлогын ил тод байдал, иргэний нийгмийн оролцоог хангах зэрэг асуудал хангалтгүйгээс шалтгаалан боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээний чанар сул, нийгмийн халамжийн сүлжээний хүртээмж, чанар муу байна.

1.89 Ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд зөвхөн ядуучуудыг анхаарч үзэхийн зэрэгцээ ядууралд өртөж болзошгүй орлого багатай хүн амын давхаргыг урьдчилан сэргийлэх нь чухал болох нь өнгөрсөн практикаас харагдаж байна. Иймээс ядуучуудаас гадна дунд орлоготой хүн амын давхаргын ядууралд өртөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

I. Засгийн газрын хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлүүд

2.1 Монгол Улсын Засгийн газар зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн өнгөрсөн 10 гаруй жилийн байдалд дүгнэлт хийж эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн бодлогоо тодорхойлж байна. Шилжилтийн үеийн эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд хийсэн бүтцийн өөрчлөлт шинэчлэл нь тус улсын хөгжлийн шинэ үндэс суурь болох юм. Эдийн засагт хувийн хэвшил давамгайлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг хангах гол эх үүсвэр болж, ингэснээр ядуурлыг бууруулах зорилтыг тавьж байна. Хувийн хэвшилд тулгуурласан, экспортын баримжаатай эдийн засгийн өсөлтийг бий болгоно. Эдийн засгийн өсөлтийг бүсчилсэн хөгжил болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан хэрэгжүүлнэ.

2.2 Монгол улсын эдийн засгийн өсөлт нь өөрийн дотоод нөөц бололцоогоо дайчлан зохистой ашиглахын зэрэгцээ хүн төрөлхтөний үнэт зүйл, туслалцаа дэмжлэгт тулгуурлан байгаль орчныг хамгаалах нийгмийн хамгааллыг сайжруулах замаар ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны тогтвортой найдвартай эх үүсвэрийг бий болгоход чиглэгдэж байна. Эдийн засгийн өсөлтийг хангахад макро эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалт, хүний хүчин зүйлийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ.

2.3 Эдийн засгийн бүх салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөгжүүлэн дэмжих, орчныг нь бүрдүүлэх замаар техник технологийн шинэчлэл хийх, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, боловсруулах аж үйлдвэрийг бүрэн сэргээж, тогтвортой хөгжих нөхцөлийг хангах, хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгийг нэмэгдүүлж, хүний хөгжлийг хангах зэргээр эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.4 Эдийн засгийн өсөлтийг хангаснаар тус улсын ядуурлыг бууруулахын зэрэгцээ, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын салбарт авч хэрэгжүүлэх хүний хөгжлийг хангах бодлого нь эргээд эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг болно. Үүний зэрэгцээ төсөв, санхүүгийн механизмыг үр ашигтай байлгах, улсын салбарт шинэчлэл хийх нь эдийн засгийн өсөлтийг хангах нэг нөхцөл болно.

2.5 Монгол улсын хөгжлийн ерөнхий зорилтуудын хүрээнд ойрын жилүүдийн тэргүүлэх чиглэлүүдийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Макро эдийн засгийн тогтворжилтийг ханган шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх
2. Банк санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэн төлөвшүүлэх
3. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах
4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх
5. Хүний хөгжлийг хангах нийгмийн тэгш орчинг бүрдүүлж, бүх шатны боловсролын чанар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх
6. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх
7. Тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны бодлогыг бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх
8. Газрын шинэчлэлийг эрчимжүүлэх
9. Томоохон хот, суурин газруудын агаар ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулах
10. Засаглалын хямралыг арилгаж, хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг бүрдүүлэх
11. Шүүх засаглалын хараат бус бие даасан байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах замаар иргэн бүрийн үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын тулгуур, зарчмыг баталгаатай хамгаалсан өндөр ёс суртахуун бүхий иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлэх,
12. Ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангах эдгээр болно.

2.6 Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги нь тус улсын оролцоотой НҮБ-аас тунхагласан Мянганы хөгжлийн зорилтуудтай нягт уялдаж байгаа юм. Мянганы хөгжлийн зорилтуудыг хангахад Монгол улсад туслахаар Азийн хөгжлийн банк санаачилга гарган дунд хугацаанд хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулсан юм. Мянганы хөгжлийн зорилтуудын 2000-2002 оны хэрэгжилтийн талаар Монгол улсын Засгийн газар илтгэл бэлтгэж байна.

2.7 Монгол улсын Засгийн газар Мянганы хөгжлийн зорилтуудыг өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан 2005 онд нэн ядуу хүний тоог 25 хувиар, 2015 онд 50 хувиар бууруулах, амьжиргааны доод түвшингээс бага орлоготой хүний тоог 2005 онд 50 хувиар, 2015 онд дахин 25 хувиар бууруулах; 2005 онд нийт хүн амыг анхан шатны (бага) боловсрол эзэмшүүлэх, нярай болон 5-аас доош насны хүүхдийн эндэгдлийг 2000 оныхоос 2015 онд 50 хувиар бууруулах зэрэг мянганы хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн үзүүлэлтүүдийг хангах, жендэрийн тэгш байдлыг хангахын тулд ядуурлын хэмжигдэхүүнүүдэд жендэрийн асуудлыг тусгахад хүч чармайлт тавин ажиллаж байна.

2.8 Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийг (ЭЗӨДЯБС) мянганы хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн үзүүлэлттэй уялдуулав. Мянганы хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн ядуурлыг бууруулах, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг

багасгах, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, хөгжлийн макро түвшингийн зорилтуудыг ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигтэй уялдуулахын зэрэгцээ уг баримт бичгийн бодлогын матриц, мониторингийн үзүүлэлтүүдэд тодорхой тусгав.

II. Оролцоог өргөтгөх

2.9 ЭЗӨДЯБС-ыг боловсруулах явцад оролцооны аргыг үр нөлөөтэй ашигласан бөгөөд бүхий л талуудыг оролцуулсан. Засгийн газрын ажлын хэсэг уг стратегийг боловсруулахад гол зохицуулагчаар нь ажилласан юм. ЯБСЗББ болон түүн дээр хийгдсэн ОУВС, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн хамтарсан үнэлгээ, Монгол улсын Засгийн газар, УИХ, ба бусад доноруудын зөвлөмжийн дагуу техникийн ажлын хэсэг нь дотоодын болон гадаадын доноруудын санхүүжилттэй төслүүдийг зохицуулах, мөн зөвлөмж, санал оруулах маягаар салбараар нь чухалчилан бодлого тодорхойлох эрчимтэй үйл ажиллагааг эхлүүлсэн юм. Бэлтгэл үйл ажиллагааны хүрээнд Засгийн газар эрчим хүч, мэдээлэл холбооны технологи, эрүүл мэнд, нийгэм хамгааллын салбарууд болон хөдөө орон нутаг, Улаанбаатар хотын хөгжлийн талаар зэрэг салбарын бодлогын суурийг боловсруулах үүднээс зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. Түүнчлэн жендерийн асуудал, байгаль орчны бодлогын асуудлыг тусгасан засаглалын шинэчлэлийн хэлэлцүүлэг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хийгдсэн юм. Энэхүү үйл ажиллагааны эцсийн шатанд СЭЗЯ ЭЗӨДЯБС-ийн нэн тэргүүнд хийгдэх ажлууд болон хяналт, хэрэгжилтийн хугацааны талаар дугуй ширээний уулзалтыг Засгийн газар, УИХ-ын гишүүдийн дунд зохион байгуулсан юм. ЯБСЗББ-ын үйл ажиллагааг дэмжих тал дээр Засгийн газрын зохион байгуулалтаас гадна олон улсын байгууллагууд тэр дундаа Дэлхийн Банк оролцогч талуудын дунд эдийн засгийн хөгжил, худалдаа, ядуурал, ядуурлын бодлого, нийгмийн салбарын шинэчлэлийн талаар олон семинар зохион байгуулсан. НҮБ-ын Хүүхдийн сан Хөдөөгийн айл өрхийн нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг тусгасан хяналтын аргыг санаачлан ЭЗӨДЯБС-ийн зорилтуудыг хянах гол аргачлалуудын нэг болгохыг зорьж байна.

2.10 ТББ-уудын өргөн оролцоо нь тодорхой асуудал, салбарт судалгаа хийх, зөвлөлдөх ба бүсийн уулзалтуудад орох болон үндэсний Зохицуулах Зөвлөлийн дэд ажлын хэсэгт орох замаар хангагдсан болно. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 2500 орчим Төрийн бус байгууллага байдаг. 1996 онтой харьцуулахад ТББ-уудын тоо 4.2 дахин өсч, зөвхөн чанарын хувьд бус мөн ТББ-ууд санхүүгийн хувьд тогтворжиж, хүний чадамж болон байгууллагын чадавхийн хувьд сайжирсан юм. Хамгийн чухал нь эдгээр нь хөгжлийн явцад эрчимтэй хариуцлагатай оролцогчид болж чадсан явдал юм. ЯБСЗББ-ийн боловсруулах ажлын хэсэгт ТББ-ын 12 төлөөлөл оролцож, иргэний нийгмийн оролцогч болон бүхий л түвшингийн зөвлөлдөх үйл ажиллагаанд идэвхтэй оролцогчид болсон билээ.

2.11 Орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн оролцоог ЯБСЗББ-ийг боловсруулах үйл ажиллагаанд оролцуулах үүднээс Дэлхийн банк, олон улсын хөдөөгийн хөгжлийн байгууллагын тусламжтайгаар үндэсний анхны бүсийн зөвлөлдөх семинаруудыг 2002 оны эхний хагаст зохион байгуулсан юм. Семинаруудын үеэр оролцогчид ядуурлын талаар болон ядуурлыг бууруулах боломжит арга замуудыг хэлэлцсэн юм. Оролцогчид Монголд амьдралын түвшин буурч, орлогын ялгаа ихээр гарч байгааг цохон тэмдэглэсэн. Хэдийгээр Засгийн газар гадаадын доноруудын тусламжтайгаар нилээдгүй дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа боловч үр дүн нь хангалтгүй байна. Мөн оролцогчид ядуурлыг бууруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд ядуурлын тодорхойлолтыг тодруулж, ядуучуудыг амьдралын ухаанд сургаж, суурь нийгмийн үйлчилгээ болон ядуучуудыг дэмжих систем болон механизмыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн юм. Түүнчлэн боломжийн эх үүсвэр болон тодорхой бүсэд чиглэгдсэн санхүүгийн туслалцааг орон нутгийн үйлдвэр, ижил төстэй байгууллагууд болон зээл аван төлөх бололцоотой хүмүүст бизнес эрхлэхэд нь туслалцаа үзүүлэх шаардлагатайг онцолсон юм. Ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, орон нутгийг зах зээлтэй холбох, дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх болоод байгаль орчны болон гамшгийн удирдлагыг Засгийн газар нэн чухалчлах шаардлагатайг дурьдав. ТББ-ууд

семинарын оролцогчдийн гол хэсэг байсан ба бүсийн семинаруудыг бэлтгэх, зохион байгуулах ажлын гол идэвхтэй бүрэлдэхүүн болж чадсан юм. Уг семинаруудын оролцогчдын гуравны нэг нь иргэний нийгмийн төлөөлөл байсныг тэмдэглэхэд таатай байна. Түүнчлэн ажлын хэсэг нь Дэлхийн банкны институтын зохион байгуулсан Зайны сургалтын бүсийн цуврал семинаруудад оролцсон. ЯБСББ-ийг хэлэлцүүлэх явцад, хурлуудад уг стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болох “Замын зураг”-ыг хэлэлцсэн. Ийм байдлаар орон нутаг болон үндэсний түвшингийн байгууллагууд ЭЗӨДЯБС-ийг хэрэгжүүлэх шатны эхэнд гүнзгий оролцож ажилласан бөгөөд Засгийн газрын зарим үйл ажиллагаа, хэрэгжилтийн явцыг хянах үүрэг ролтой байсан .

2.12 Үндэсний хэмжээнд мөн цуврал зөвлөлдөх болоод бизнес уулзалтууд зохион байгуулагдсан. Эдгээр зөвлөлдөх уулзалтуудад Засгийн газар болоод УИХ-ын гишүүд, үндэсний болон орон нутгийн дээд албан тушаалтнууд, байгууллагуудын төлөөлөгчид, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд, иргэд, ядуу болоод эмзэг бүлгийн төлөөлөгчид оролцсон юм. Зарим оролцогчдын, яамдын сайдууд, ЯБСББ-ийн ажлын хэсгийн гишүүд санал туршлагаа Дэлхийн Банкны зохион байгуулсан видео болоод утсаар хийгдсэн уулзалтаар солилцож бусад орны туршлагаас суралцсан билээ. Иргэний нийгмийн төлөөлөгчид өөрсдийн ЯБСББ-ийн туршлагаа Дэлхийн Банкны Ерөнхийлөгчид танилцуулж, Монголын ядуурал, эдийн засгийн хөгжлийн талаар зөвлөлдсөн байна. Мөн Монголын төлөөлөгчид үндэсний ядуурлыг бууруулахад чиглэгдсэн олон улсын чуулга уулзалтуудад оролцон Монголд ЯБСББ боловсруулах үйл ажиллагааны талаар танилцуулж бусад орны туршлагаас судлан, Монголын ЯБСББ-д тусгалаа. Үүгээрээ ЯБСББ -ийг улам чанаржуулсан болно.

2.13 Ядуурлын Судалгааны Нэгж нь НҮБХХ-ын Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн дэргэд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд ЯБСЗББ болон түүн дээр хийгдсэн ОУВС, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн хамтарсан үнэлгээгээр илэрсэн мэдээллийн зөрөөг тодорхойлж судалгаа хийхэд дэмжлэг үзүүлж байна. Эдгээр судалгааны үр дүнд зарим бодлогын зөвлөмжүүдийг боловсруулан гаргасан. Судалгааны хүрээнд хувьчлалын анхны бодлогуудыг хянах, тэдгээрийн ядуучуудад үзүүлсэн нөлөө, дунд орлоготой бүлгийг эмзэг бүлэгт орохоос хамгаалах, байгалийн үзэгдлүүдийн байгаль орчин, малчдын орлогод үзүүлэх нөлөө зэргийг судлахаар судалгааны багуудтай гэрээ хийгдэн ажиллаж байна.

2.14 Оролцооны үйл ажиллагааг байгууллагын зохион байгуулалтанд нийцүүлэх хүрээнд хөдөөгийн хүүхдүүдийн сургуулиас өмнөх боловсролыг сайжруулах, оролцогч талуудын оролцоо болон суурь мэдлэгийг сайжруулах, малчдын хоршоог дэмжих зэрэг тодорхой төслийн саналууд Үндэсний Зөвлөл болон гол доноруудаар хэлэлцэгдэн ЯБСББ-ийн Итгэлцлийн Санд санал болгон тавигдсан.

III. Ядуурлыг бууруулахад чиглэсэн тогтвортой хөгжил, өсөлт

2.15 Монгол улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх зорилтыг ядуурлыг бууруулахад чиглүүлж байна. Ядууст боловсрол олгох, улмаар эрүүл мэндийг сайжруулах, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, бизнес эрхлэх орчныг бүрдүүлснээр эдийн засгийн өсөлтийг хангахад ядуучуудыг өөрсдийг нь оролцуулахад анхаарч байна. Иймээс ядуурлыг бууруулахад чиглэсэн эдийн засгийн өсөлтийг бий болгох явдлыг стратегийн гол зорилт болгож байна.

2.16 *Ядуучуудад чиглэсэн эдийн засгийн өсөлт.* Эдийн засгийн өсөлт нь ядуурлын түвшинг бууруулах, орлогын ялгааг багасгах, улмаар хүн амын тогтвортой амьжиргааг хангах угтвар нөхцөл гэж үзнэ. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 1995-1999 онд жилд дунджаар 3.5 хувь, сүүлийн 2 жилд 1 орчим хувь өсч байгаа нь ядуурлыг бууруулахад хангалтгүй юм. Ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилго нь эдийн засгийн бодит өсөлтийг дунд хугацаанд 5-6 хувьд хүргэж, ядуурлын түвшинг бууруулах явдал юм. Эдийн засгийн тогтвортой өндөр өсөлт нь хүн амын сурах, хөдөлмөрлөх, хөгжих боломжийг бүрдүүлэх бөгөөд түүнийг ядуучуудад чиглүүлэх, уг механизмыг

оновчтой болгох явдал нь төр засаг болон иргэний нийгмийн анхаарлын төвд байна. Улс орны хөгжилд иргэний нийгмийн оролцоог аль болох өргөжүүлэх зорилгоор иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх талаар Засгийн газраас онцгой анхаарч байна.

2.17 Дунд хугацаанд хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг түргэтгэж улмаар хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор макро эдийн засгийг тогтворжуулж, инфляцийг доогуур түвшинд байлгах, бизнес зах зээлийн шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх, мөнгө зээл, татварын механизмыг оновчтой ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.18 Макро эдийн засгийн түвшинд хэрэгжүүлж буй бодлогыг салбарын тэргүүлэх чиглэл, эдийн засаг, нийгмийн салбар дахь бүтцийн өөрчлөлттэй уялдуулснаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Судалгааны дүнгээс үзэхэд 1998 оны байдлаар ядуучуудын тархалт харилцан адилгүй байсан бөгөөд аймгийн төвд илүүтэй төвлөрч байсан бол сүүлийн 3 жилд тохиолдсон байгалийн гамшгаас үүдэн хөдөөд малчдын амьжиргааны түвшин эрс муудсан байна. Иймд хүн амын эдгээр бүлэгт илүү нөлөө үзүүлэх чиглэлээр хөдөө дэх санхүү, банкны үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх болон хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг тогтворжуулж, өргөжүүлэх нь чухал байна. Эдийн засгийн өсөлтийг хурдасгах бодлогыг хэрэгжүүлэх, хянах явцад төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг улам өргөжүүлнэ.

2.19 **Ядуучуудад чиглэсэн хуваарилалт.** Эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон баялгийг оновчтой хуваарилах, ялангуяа ядуучууд болон ядуурлын ирмэгт ойр байгаа хүн амд хүртээх нь ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилгын нэг юм. Гэхдээ энэхүү хуваарилалт нь ядуучуудад хөрөнгийг шууд хуваарилах арга замаар бус ядуучууд, ядуурлын ирмэгт ойрхон байгаа хүн амын хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг дээшлүүлэх, сурч боловсрох, эрүүл мэндээ сайжруулахад чиглэсэн тодорхой хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх замаар тэдэнд ногдох орлогыг нэмэгдүүлнэ. Мөн эдийн засгийн чадавхитай уялдуулан бүтцийн өөрчлөлт, тэр дундаа улсын салбарын шинэчлэл, төсвийн зарлага, нийгмийн хамгааллын тогтолцоог оновчтой болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.20 **Ядуурлыг бууруулах стратегийн цогц байдлыг хангах нь.** Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилтуудыг бодлогын урт хугацааны хөгжлийн баримт бичигт тусган уялдуулахын зэрэгцээ улс орны хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн жилийн Үндсэн чиглэл, төсөвт тусгаж хэрэгжүүлэх нь стратегийн хэрэгжилтийн цогц байдлыг хангах, түүний үр дүн, ил тод байдлыг дээшлүүлэх болно.

2.21 Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд макро эдийн засгийн оновчтой удирдлага, зохицуулалт чухал юм. Төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд нийцүүлэн макро эдийн засаг, салбарын бодлогын уялдааг хангасан “зорилтын санал”-ыг боловсруулах тогтолцоог нэвтрүүлнэ.

2.22 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөр нь одоогоор салбаруудын бодлогыг уялдуулан, төр болон иргэний нийгмийн зөвшилцлийн үндсэн дээр боловсрогдож байгаа бөгөөд үүний хэрэгжилтийг хангах гол механизмын нэг нь байгууллагуудын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө юм. Уг төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын арга хэмжээ нь тухайн салбарын хөгжлийн дунд хугацааны бодлоготой уялдсан байхын зэрэгцээ төсвийн дунд хугацааны хүрээгээр дамжин санхүүгийн эх үүсвэрээр баталгаажина. Ингэснээр Засгийн газраас баримталж буй бодлого нь ядуучуудад хандсан байх зарчим хангагдах болно. Дунд хугацааны бодлогод Эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах стратегийн гол агуулга тусгагдаж, хэрэгжүүлэх, хянах үндсэн механизм нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тухайн жилийн Үндсэн чиглэл байх болно.

IV. Эдийн засгийн өсөлтийг түргэтгэх

2.23 Ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд Монгол улсын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх зорилгоор макро эдийн засгийн тогтворжилтыг хангаж, зах зээлийн харилцааг улам чөлөөтэй болгох, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх асуудлыг тэргүүлэх чиглэлээ болгон тодорхойлж байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх бодлогын цөм нь макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах явдал гэж үзэж байна. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хүн амын орлогыг өсгөх үндэс юм. Эдийн засгийн өсөлтийн гол механизм нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн бүтцийг бүрдүүлэх явдал болно. Үүнтэй уялдаж үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжийн хувьчлалыг эрчимжүүлж бизнесийн орчин болон бизнесийн удирдлагыг сайжруулан, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж макро эдийн засгийн тогтвортой байдлыг батжуулна.


2.24 Засгийн газар нээлттэй эдийн засгийн бодлогыг цаашид үргэлжлүүлэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх бодлого баримтална. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих, орон нутагт бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн зөвшөөрөл олгодог тогтолцоог арилгах, хялбаршуулах арга хэмжээ авна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, техник технологийг шинэчлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, жижиг зээлийн үйлчилгээг өргөжүүлэх бодлого баримтална. Эдийн засгийн өсөлтийг түргэтгэхтэй уялдаж үйлчилгээний салбарын өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Ялангуяа аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарна.

2.25 ОУВС-тай тохиролцсон Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр нь төсвийн тогтвортой байдлыг хангаж, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжин, макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж улмаар эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон баялагийг хүний хөгжлийг хангах, ядуурлыг бууруулахад чиглүүлж байна. Иймд уг хөтөлбөрийн хүрээнд ДНБ-ий жилийн өсөлтийг 5.5-7 хувьд хүргэх зорилт тавьж байна. ЯБӨХ хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр тус улсын эдийн засгийн цаашдын хөгжлийн баттай үндэс бүрдэнэ гэж тооцож байгаа бөгөөд 2005-2008 онд эдийн засгийн өсөлт 6-аас дээш хувь байхаар төсөөлж байна. Мөн 2004 он гэхэд төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг ДНБ-ий 6 орчим хувь хүртэл бууруулж цаашид энэ түвшингээс хэтрүүлэхгүй байх бодлого баримтална.

2.26 Өргөн уудам газар нутагтай, онгон байгаль, байгалийн эрдэс, түүхий эд, нөөцөөр баялагтай, олон тулгуурт гадаад харилцаа өргөжсөн, хүний нөөц харьцангуй сайн хөгжсөн, хотжилтын үйл явц явагдсан Монгол орон нэг талаар хөгжлийн давуу талтай боловч цаг уур, гадаад орчны нөлөөнд хэтэрхий өртөмтгий, эмзэг юм. Эдийн засгийн өрөөсгөл бүтэц, далайд гарцгүй байршил, хүн ам цөөн, жижиг эдийн засагтай байдал нь манай орны хөгжилд сөргөөр нөлөөлсөөр байна. Энэ эмзэг байдлын гол илрэл нь дэлхийн зах зээлийн үнийн огцом өөрчлөлт болон хөдөө аж ахуйн салбарын сүүлийн 3 жилийн уналтаас харагдаж байна. Иймд дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг түргэтгэх эх үүсвэрүүдийг оновчтой тодорхойлох, тэдгээрийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхдээ эдгээр хүчин зүйлсийг нарийвчлан тооцож, түүнийг оновчтой удирдан зохицуулах замаар хэрэгжүүлэх болно.

2.27 *Монгол улсын эдийн засгийн өсөлтийн сүүлийн 10 жилийн байдал.* Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлсэн 1990 оноос хойшхи үед хөрөнгө оруулалт түр саатаж эдийн засаг уналтанд орж эхэлсэн. Хамгийн их уналттай жил 1992 он байсан бөгөөд бодит ДНБ өмнөх оныхоосоо 9.5 хувиар буурсан байна. Энэхүү уналт 1993 он хүртэл үргэлжилж 1993 оноос эдийн засгийн уналтын хурдац саарсан байна. /Зураг 2.1./

Зураг 2.1. Эдийн засгийн бодит өсөлт, 1989-2002 он



2.28 Эдийн засгийн өсөлтийн сүүлийн 10 жилийн хандлагыг 1993-1995, 1996-1999, 2000-2002 гэсэн цаг хугацааны 3 заагт хувааж үзэж болохоор байна.

Хүснэгт 2:1: Эдийн засгийн өсөлт

| | 1993-1995 | 1996-1999 | 2000-2002 |
|-----------------------------|-----------|-----------|-----------|
| Эдийн засгийн өсөлт, хувиар | 1.9 | 3.3 | 2.0 |

2.29 Эдийн засгийн бодит өсөлт 2000 онд 1.1, 2001 онд 1.0 хувь байсан бол урьдчилсан гүйцэтгэлээр 2002 онд 3.9 орчим хувь болохоор байна. Сүүлийн 10 гаруй жилд эдийн засагт гарсан бүтцийн өөрчлөлт, гадаад эдийн засгийн орчин нөхцөл, байгаль цаг уурын нөлөөллөөс шалтгаалан эдийн засаг дахь салбаруудын өсөлт тогтвортой байж чадсангүй. 1993-1999 онуудад анхдагч салбар МАА-н салбарт гарсан өсөлт эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болж, аж үйлдвэр, барилга, тээвэр холбооны салбарын өсөлт тогтвортой биш байлаа. Тухайлбал, 1993 онд 6.4 хувийн уналттай байсан аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт 1995 онд 14.8 хувь болтлоо нэмэгдсэн боловч, 1996 онд энэ салбарын үйлдвэрлэл 3.6 хувиар буурч 1997-1999 ондуудад дахин өсч эхэлсэн байна. Аж үйлдвэр тэр дундаа боловсруулах аж үйлдвэрлэлийн салбар 2000 оноос сэргэж эхэлсэн. 1993-1999 онуудад эрчимтэй өсч ДНБ-ний 36.8 хувийг эзлэх болсон МАА-н салбар байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл байдлаас болж дунджаар 18.5 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлт 2000-2002 онд дунджаар 2.0 хувь болоход голлон нөлөөлөв. Засгийн газар 2001 оныг дотоодын үйлдвэрлэлийг сэргээх жил болгон зарлаж, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжих бодлого явуулж гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авсан нь ихээхэн үр дүнтэй боллоо. Эдгээр арга хэмжээний үрээр боловсруулах аж үйлдвэрийн салбарт 1990 оноос хойш анх удаа 2001 онд 31.8 хувь, 2002 онд 22.1 хувийн өсөлт гарав. Гадаад худалдааны үйл ажиллагаанд Хятадын талаас тавьсан шаардлагын дагуу арьс шир, ноос ноолуур зэрэг тодорхой хэдэн төрлийн түүхийн эдийн бүтээгдэхүүнд Монголын үндэсний стандарт 4724:2001, Монголын үндэсний стандарт 3683:2001 зэрэг техникийн стандартуудыг тогтоосон байна.

2.30 Нийслэл Улаанбаатар хот нь улс орны эдийн засгийн хөгжилд голлох хувь нэмэр оруулах боллоо. Тус улсын ДНБ-ний 36 хувийг Улаанбаатарт үйлдвэрлэж байна. 2001 онд нийслэлийн ДНБ 20 хувиар өсч 426.9 тэрбум төгрөгт хүрчээ. ДНБ дотроос аж үйлдвэр, барилга, зочид буудал, хоолны газар, ресторан болон санхүүгийн үйлчилгээний салбар хурдацтайгаар хөгжиж байна. Нийслэлийн ДНБ-нд хувийн салбарын эзлэх хувь сүүлийн жилүүдэд 71.2 хувьд хүртлээ өсчээ. Үйлдвэрлэл нэмэгдснээр төсвийн орлого 2002 оны байдлаар өмнөх жилтэй харьцуулахад 5.5 тэрбум төгрөгөөр өсч, нэгдсэн төсвийн 13.5 хувийг эзлэх болсон байна.

2.31 **Дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газрын баримтлах бодлогын чиглэл.** 2004-2007 онуудад эдийн засгийн өндөр

өсөлтийг бий болгох зорилтын хүрээнд дотоодын түүхий эдэд түшиглэсэн боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн олборлох, аялал жуулчлал, мэдээллийн технологи, дэд бүтцийн салбарын хөгжилд түлхүү ач холбогдол өгч байна.

2.32 Боловсруулах салбарын хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах аж үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлж, энэ чиглэлийн аж ахуйн нэгжүүдийн экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих болон бүс нутгийн хөгжлийн зарчмуудтай уялдуулж, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарч байна. Үүнд ноолууран бүтээгдэхүүн, мах, арьс шир, үслэг эдлэл, гурилын үйлдвэрүүдийг хөгжүүлэх, газрын түүхий тос олборлох улмаар боловсруулж авто бензин, дизелийн түлш, мазут зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн шинэ салбарыг хөгжүүлнэ. Үүнтэй уялдаад газрын тос олборлолтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.33 Уул уурхайн үйлдвэрлэлийн хувьд Монгол улсын эрдэс түүхий эдийн баялагийг оновчтой зөв ашиглах үүднээс уул уурхайн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, тус салбарт бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Эрдэс түүхий эдийн шинэ ордуудыг нээх, ашиглах зорилгоор хайгуул судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, алт, зэс, нүүрс, газрын тос, цайр болон бусад нэр төрлийн эрдэс түүхий эдийн олборлолтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ оюуны багтаамж ихтэй эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд онцгой ач холбогдол өгч байна.

2.34 Мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх хүрээнд интернетийн үйлчилгээг өргөжүүлэх, электрон мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх, улмаар программ хангамжийг сайжруулах, боловсон хүчнээ чанартай бэлтгэх нөхцөлийг бий болгох, программ зохиож худалдах, электрон мэдээллийг боловсруулах чиглэлийн бизнесийг хөгжүүлж экспортлох зэргээр мэдээллийн технологийн салбарт тэргүүлэх ач холбогдол өгч эрчимтэй үйл ажиллагаа явуулна.

2.35 Аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэх зорилгоор Монголд аялал жуулчлал хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх, ялангуяа олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлж тав тухтай зорчих нөхцөлийг хангах үндсэн дээр гадаадаас ирэх жуулчдын тоог ихээхэн нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Гадаадын жуулчдыг тохьтой байлгах үүднээс зочид буудлуудын үйлчилгээг олон улсын стандартын түвшинд ойртуулах арга хэмжээ авна. Жуулчны баазуудын тохилог байдлыг хангах, жуулчид, аялагчдын үзэх харах, зугаацах зүйлийг бий болгох талаар анхаарна. Монголын аялал жуулчлалын зах зээлийн сурталчилгааг шинэ шатанд гаргаж өргөжүүлэх шаардлага гарч байна. 2003 оныг Монголд зочлох жил болгон зарлаж, олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлж байна.

2.36 Бүс нутаг, дэд бүтцийн салбарын хувьд бүс нутгийн хөгжлийг дэмжих хууль эрхзүйн орчин бүрдүүлж, жижиг дунд үйлдвэрийг орон нутагт түлхүү хөгжүүлэхийн хамт бизнес эрхлэх орчныг нь сайжруулах үүднээс хөдөө, орон нутагт тээвэр, харилцаа холбоо, зам, цахилгаан эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарыг эрчимтэй хөгжүүлнэ. Эдийн засгийн төлөвлөлтийг бүс нутгаар хийх тогтолцоонд аажмаар шилжин хот хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдлыг багасгах бодлогыг хэрэгжүүлнэ. Ингэснээр хөдөө, орон нутаг зах зээлийн харилцаанд идэвхитэй оролцож, хөдөөд зах зээл, бизнес эрчимтэй хөгжих таатай орчин бүрдэнэ гэж үзэж байна.

2.37 Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хувьд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эхлэлийг тавих, бэлчээрийн менежмент, усан хангамжийг сайжруулахын зэрэгцээ тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мал сүргийг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч, өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бий болгоно. Газар тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэл хийх, эргэлтийн хөрөнгийн дутагдлыг арилгахад дэмжлэг үзүүлнэ. Хөрс боловсруулах шинэ технологи нэвтрүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх бодлого явуулна.

2.38 *Дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөв байдал.* Өмнө дурдсан Засгийн газрын эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаатай уялдан 2003-2007 онуудад эдийн засгийн өсөлт ямар байх талаархи тооцоог 3 хувилбараар авч үзлээ.

2.39 2003 онд ДНБ-ий бодит өсөлтийг 5.2 хувь, дунд хугацаанд буюу 2004-2007 онд эдийн засгийн бодит өсөлтийн дээд хувилбарыг 6 хувьтай байхаар тооцож байна.

2.40 Энэ **дээд хувилбарт** байгаль цаг уурын нэн тааламжтай нөхцөлд МАА, Газар тариалангийн салбаруудын үйлдвэрлэл сэргэж үүнтэй холбоотой боловсруулах аж үйлдвэрлэлийн салбар, тухайлбал, хүнсний үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл өсөхөөр тооцлоо. 2004-2007 онуудад эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хүргэх тооцоонд ХАА-н салбарт дунджаар 4.2 хувь, уул, уурхайн олборлох салбарт 8.0 хувь, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарт 7.9- 8.0 хувь, зочид буудал, зоогийн газрын үйчилгээний салбарт 7.0 хувийн өсөлт гарахаар төлөвлөсөн нь эдийн засгийн өсөлтийн гол суурь болж байна.

Дээрх салбаруудаас гадна эдийн засгийн бусад салбарт 2004-2007 онуудад тогтвортой өсөлттэй байна гэж таамаглаж байна.

Хүснэгт 2:2: Эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хүргэх хувилбар

| | 1999 | 2000 | 2001 | 2002* | 2003** | 2004** | 2005** | 2006** | 2007** |
|--|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй | 4.2 | -14.9 | -18.5 | -10.5 | 4.0 | 4.2 | 4.2 | 4.2 | 4.2 |
| Уул уурхай, олзворлох үйлдвэр | 3.2 | 6.6 | 9.6 | -6.8 | 5.9 | 8.0 | 8.0 | 8.0 | 8.0 |
| Боловсруулах үйлдвэр | -2.8 | -3.3 | 31.8 | 22.1 | 7.3 | 8.1 | 7.9 | 7.9 | 8.0 |
| Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж | 4.6 | 0.4 | 3.5 | 4.0 | 4.0 | 4.1 | 4.3 | 4.3 | 4.3 |
| Барилга | 1.6 | -14.6 | 10.8 | 11.1 | 8.0 | 8.0 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар | 1.3 | 26.1 | 9.8 | 12.3 | 4.6 | 6.0 | 5.9 | 5.9 | 5.9 |
| Зочид буудал, ресторан | 8.7 | 13.2 | -6.9 | 0.5 | 7.0 | 7.0 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо | 6.1 | 25.2 | 14.9 | 17.1 | 6.7 | 6.9 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Санхүү, зээлийн байгууллага | 39.9 | 7.0 | 22.4 | 7.8 | 6.8 | 6.8 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйлчилгээ | -4.7 | 12.5 | 7.1 | 11.6 | 4.4 | 4.9 | 6.0 | 6.5 | 7.0 |
| Төрийн байгууллагын үйл ажиллагаа | 1.5 | 3.5 | -5.7 | 5.5 | 2.1 | 2.1 | 2.1 | 2.1 | 2.1 |
| Боловсрол | 4.6 | 3.2 | 1.3 | 0.8 | 4.5 | 4.5 | 4.5 | 4.5 | 4.5 |
| Эрүүл мэнд, нийгмийн халамж | 3.1 | -0.1 | 4.6 | 2.9 | 3.2 | 3.2 | 3.2 | 3.2 | 3.2 |
| Нийгмийн болон хувийн үйлчилгээ | 0.5 | 57.1 | 10.4 | 9.1 | 6.0 | 7.0 | 6.0 | 6.0 | 6.0 |
| Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ | 7.0 | 30.5 | 27.1 | -21.3 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| ДНБ / 1995 оны зэрэгцүүлэх үнээр/ | 3.2 | 1.1 | 1.0 | 3.9 | 5.2 | 6.0 | 6.0 | 6.0 | 6.1 |

*- Урьдчилсан гүйцэтгэл, **-Төсөөлөл

2.41 Дунд хугацаанд эдийн засгийн гадаад нөхцөл байдал мөн тааламжтай байхаар тооцлоо. Уул, уурхайн олборлох салбарт зарим орд газруудыг шинээр ашиглаж эхлэх, зарим эрдэс түүхий эдийн олборлолтыг нэмэгдүүлэхээр тооцсон болно.

Хүснэгт 2:3: Шинээр ашиглаж эхлэхээр төлөвлөж байгаа ордууд

| Үйлдвэр | Байршил | Ашиглалта д оруулах хугацаа | Бүтээг- дэхүүн | Жилийн хүчин чадал | Бүтээгдэхүүн й мөнгөн дүн, сая ам.доллар |
|---|--|-----------------------------------|-----------------------|--------------------------|---|
| Бороогийн үйлдвэр | алтны Сэлэнгэ аймаг Баянгол сум | 2005 | Алт | 1500 кг | 15.0 |
| Тосонгийн үйлдвэр | алтны Төв аймаг Заамар сум | 2003 | Алт | 800 кг | 8.0 |
| Тавтын үйлдвэр | алтны Булган аймаг Тэшиг сум | 2005 | Алт | 200-400 кг | 3.0 |
| Төмөртэй цайрын олборлон үйлдвэр | овооны Сүхбаатар хүдэр аймаг баяжуулах Баруун-Урт сум | 2004 | Цайрын баяжма л | 58000 тонн | 17.8 |

2.42 **Хоёрдугаар хувилбар** буюу ДНБ-ий өсөлтийг дунд хугацаанд 5.5 хувь байхаар тооцлоо. Энэхүү тооцоонд ХАА, уул, уурхай, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт нэгдүгээр хувилбараас арай бага байхаар авч үзлээ.

Нэгдүгээр хувилбарт газар тариалангийн салбарт дунджаар 4 хувь, МАА-н салбарт 4.3 хувь, хөдөө аж ахуйн салбарт бүхэлдээ 4.2 хувь, уул, уурхайн салбарт 8.0 хувь, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарт 8 хувийн өсөлт гарахаар тооцсон бол хоёрдугаар хувилбарт газар тариалангийн салбарт 4 хувь, МАА-н салбарт 3.8 хувь, ХАА-н салбарт бүхэлдээ 3.8 хувь, уул уурхайн салбарт 6.0-6.6 хувь, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарт 7.3-7.9 хувийн өсөлт гарахаар тооцсон нь хоёр хувилбарын гол ялгаа болж байна.

Хүснэгт 2:4: ДНБ-ий бодит өсөлтийн хоёрдугаар хувилбар

| | 1999 | 2000 | 2001 | 2002* | 2003** | 2004** | 2005** | 2006** | 2007** |
|--|------|-------|-------|-------|--------|--------|--------|--------|--------|
| Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй | 4.2 | -14.9 | -18.5 | -10.5 | 4.0 | 3.8 | 3.8 | 3.8 | 3.8 |
| Уул уурхай, олзворлох үйлдвэр | 3.2 | 6.6 | 9.6 | -6.8 | 5.9 | 6.0 | 6.6 | 6.6 | 6.6 |
| Боловсруулах үйлдвэр | -2.8 | -3.3 | 31.8 | 22.1 | 7.3 | 7.3 | 7.9 | 7.9 | 7.9 |
| Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж | 4.6 | 0.4 | 3.5 | 4.0 | 4.0 | 4.1 | 4.3 | 4.3 | 4.3 |
| Барилга | 1.6 | -14.6 | 10.8 | 11.1 | 8.0 | 8.0 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар | 1.3 | 26.1 | 9.8 | 12.3 | 4.6 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| Зочид буудал, ресторан | 8.7 | 13.2 | -6.9 | 0.5 | 7.0 | 7.0 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо | 6.1 | 25.2 | 14.9 | 17.1 | 6.7 | 6.9 | 7.0 | 7.0 | 7.0 |
| Санхүү, зээлийн байгууллага | 39.9 | 7.0 | 22.4 | 7.8 | 6.8 | 6.8 | 7.0 | 7.0 | 7.0 |

| | | | | | | | | | | |
|--|--|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйлчилгээ | | -4.7 | 12.5 | 7.1 | 11.6 | 4.4 | 4.9 | 6.0 | 6.5 | 7.0 |
| Төрийн байгууллагын үйл ажиллагаа | | 1.5 | 3.5 | -5.7 | 5.5 | 2.1 | 2.1 | 2.1 | 2.1 | 2.1 |
| Боловсрол | | 4.6 | 3.2 | 1.3 | 0.8 | 4.5 | 4.5 | 4.5 | 4.5 | 4.5 |
| Эрүүл мэнд, нийгмийн халамж | | 3.1 | -0.1 | 4.6 | 2.9 | 3.2 | 3.2 | 3.2 | 3.2 | 3.2 |
| Нийгмийн болон хувийн үйлчилгээ | | 0.5 | 57.1 | 10.4 | 9.1 | 6.0 | 6.0 | 6.0 | 6.0 | 6.0 |
| Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ | | 7.0 | 30.5 | 27.1 | -21.3 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| ДНБ / 1995 оны зэрэгцүүлэх үнээр/ | | 3.2 | 1.1 | 1.0 | 3.9 | 5.2 | 5.3 | 5.5 | 5.5 | 5.5 |

*- Урьдчилсан гүйцэтгэл, **-Төсөөлөл

2.43 Хоёрдугаар хувилбар нь уул, уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувьд нэгдүгээр хувилбарыг бодвол харьцангуй бага өсөлттэй байхаар тооцсон нь илүү бодит байдалд нийцсэн хувилбар байж болох юм. Энэ хувилбарт мал сүрэг хэвийн хорогдолтой, үр тариа, газар тариалангийн салбарт боломжийн ургац авна гэж тооцсон ба нэгдүгээр хувилбарыг бодвол ХАА-д учирч болох эрсдлийг тодорхой хэмжээгээр тооцсон хувилбар юм. Энэ хувилбарт гадаад нөхцөл байдлын хувьд 2000-2002 оныхтой ижил төстэй байхаар авч үзлээ.

2.44 Эдийн засгийн өсөлтийн төлөв байдалтай уялдаатайгаар дунд хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг дараах байдалтай байхаар тооцож байна.

Хүснэгт 2:5: Хөрөнгө оруулалт, оны үнээр тэрбум төгрөг

| | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|
| Нийт хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/ | 324.6 | 338.4 | 368.0 | 394.3 | 426.8 | 463.1 |
| Дотоод эх үүсвэр | 114.6 | 124.1 | 141.3 | 156.4 | 175.3 | 197.7 |
| <i>Үүнээс: Төсвийн</i> | 36.8 | 39.9 | 49.9 | 55.4 | 62.7 | 70.8 |
| Гадаад эх үүсвэр | 210.0 | 214.3 | 226.7 | 237.9 | 251.5 | 265.3 |
| Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь | | | | | | |
| Дотоод эх үүсвэр | 35.3 | 36.7 | 38.4 | 39.7 | 41.1 | 42.7 |
| <i>Үүнээс: Төсвийн</i> | 11.3 | 11.8 | 13.6 | 14.0 | 14.7 | 15.3 |
| Гадаад эх үүсвэр | 64.7 | 63.3 | 61.6 | 60.3 | 58.9 | 57.3 |
| ДНБ-нд нийт хөрөнгө оруулалтын эзлэх хувь | 23.0 | 23.3 | 23.7 | 23.9 | 23.8 | 23.9 |
| ДНБ-нд төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь | 2.6 | 2.7 | 3.2 | 3.4 | 3.5 | 3.6 |

2.45 Монгол улсын хэмжээнд дунд хугацаанд ДНБ-ий 24 орчим хувьтай тэнцэхүйц хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Энэхүү хөрөнгө оруулалтын 60 орчим хувийг гадаад эх үүсвэрээр хангахаар төлөвлөж байна. Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалт, хандивлагч орон, олон улсын байгууллагуудын зээл, тусламжийг боловсрол, эрүүл мэнд, бүс нутгийн хөгжил, дэд бүтцийн салбарт түлхүү хандуулж, уул, уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зочид буудал зоогийн газрын үйлчилгээ, худалдаа үйлчилгээний бусад салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангана.

2.46 **Гуравдугаар хувилбарт** эдийн засгийн гол салбарууд болох МАА, газар тариалангийн салбарт төдийлөн тааламжтай биш байхаар тооцсон нэлээд муу хувилбарыг авч үзлээ. Энэ хувилбарт ХАА-н салбарт эрсдэл үргэлжилж МАА-н салбарт жилд 5 хувь хүртэл, газар тариалангийн салбарт жилд 4 хувь хүртэл бууралт гарахаар тооцсон болно. Энэ хувилбараар эдийн засгийн өсөлт дунд хугацаанд 3.0-3.7 орчим хувьтай байхаар байна. Энэ хувилбарын хоёрдугаар хувилбараас ялгарах гол зүйл нь МАА-н салбарын зэрэгцээ боловсруулах аж үйлдвэрлэлийн салбар юм. ХАА-н салбарт уналт үргэлжилсэнтэй холбоотойгоор боловсруулах аж үйлдвэрлэлийн гол дэд салбар хүнсний үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэлд төдийлөн өндөр өсөлт гарахгүй гэж үзвэл боловсруулах аж үйлдвэрлэлийн салбар 4.8 орчим хувь өсөхөөр байна. Мөн гадаад нөхцөл байдлыг сайнгүй гэж үзлээ. Ойрхи дорнод дахь дайны хор уршиг ямар нэг байдлаар нөлөөлж болохыг үгүйсгээгүй болно.

2.47 Дээрх гурван хувилбараас дүгнэж үзэхэд эдийн засгийн өсөлт дунд хугацаанд гадаад болон дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалан 3-6 орчим хувь байхаар байна. Дээрх гурван хувилбарын хувьд ДНБ-ий үзүүлэлтүүд дараах байдалтай байхаар байна.

Хүснэгт 2:6: ДНБ-ий өсөлт, 2001-2007 он

| | | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|-------------------------------------|------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| ДНБ /оны үнээр, сая төгрөгөөр/ | Дээд | 1115641.4 | 1231330.2 | 1366089.3 | 1515894.5 | 1683093.6 | 1868921.7 | 2075343.8 |
| | Дунд | 1115641.4 | 1231330.2 | 1362239.5 | 1508014.0 | 1669664.8 | 1849164.6 | 2049104.7 |
| | Доод | 1115641.4 | 1231330.2 | 1362239.5 | 1477719.8 | 1606656.3 | 1749770.4 | 1909040.8 |
| ДНБ өсөлтийн хувь, оны үнээр | Дээд | 9.5 | 10.4 | 10.9 | 11.0 | 11.0 | 11.0 | 11.0 |
| | Дунд | 9.5 | 10.4 | 10.6 | 10.7 | 10.7 | 10.8 | 10.8 |
| | Доод | 10.1 | 9.5 | 10.4 | 10.6 | 8.5 | 8.7 | 8.9 |
| ДНБ /1995 оны үнээр, сая төгрөгөөр/ | Дээд | 639013.0 | 664252.5 | 699046.4 | 740641.4 | 784880.1 | 832346.9 | 883014.2 |
| | Дунд | 639013.0 | 664252.5 | 698614.4 | 735419.2 | 775553.2 | 818084.7 | 863152.4 |
| | Доод | 639013.0 | 664252.5 | 698614.4 | 719429.0 | 743280.5 | 769291.7 | 797538.5 |
| ДНБ бодит өсөлтийн хувь | Дээд | 1.0 | 3.9 | 5.2 | 6.0 | 6.0 | 6.0 | 6.0 |
| | Дунд | 1.0 | 3.9 | 5.2 | 5.3 | 5.5 | 5.5 | 5.5 |
| | Доод | 1.0 | 3.9 | 5.2 | 3.0 | 3.3 | 3.5 | 3.7 |

2.48 Дээрх гурван хувилбараас эдийн засгийн дунд хугацааны төлөвлөлтөд хоёрдугаар хувилбарыг /дунд/ авч ашиглах нь бодит байдалд илүү нийцсэн хувилбар гэж үзэж байна. Хоёрдугаар хувилбараар эдийн засгийн аль нэг салбарыг хэт товойлгон авч үзээгүй ба ХАА-н салбарт гарч болох эрсдэлийг тодорхой хэмжээгээр харгалзан үзэж МАА-н салбарын өсөлтийг хэвийн хорогдолтой, эрсдэлгүй байсан 1996-1999 онуудын дундаж өсөлтөөс 1.7 пунктээр бага байхаар авч тооцсон юм.

2.49 2 дугаар хувилбараар тооцсон дунд хугацааны эдийн засгийн бүтцийг гол салбараар авч үзье.

Хүснэгт 2:7: Эдийн засгийн бүтэц, гол салбараар

| | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|-------------------|------|------|------|------|------|------|
| Аж үйлдвэр | 21.4 | 21.6 | 21.8 | 22.1 | 22.3 | 22.5 |
| Хөдөө аж ахуй | 20.7 | 20.5 | 20.2 | 19.9 | 19.6 | 19.3 |
| Барилга | 2.1 | 2.2 | 2.2 | 2.3 | 2.3 | 2.3 |
| Тээвэр, холбоо | 14.0 | 14.1 | 14.2 | 14.3 | 14.5 | 14.6 |
| Худалдаа материал | 27.6 | 27.6 | 27.5 | 27.5 | 27.5 | 27.5 |
| техникийн хангамж | | | | | | |
| Үйлчилгээ | 14.2 | 14.1 | 14.0 | 14.0 | 13.9 | 13.8 |

2.50 Хоёрдугаар хувилбараар дунд хугацаанд эдийн засгийн бүтэц төдийлөн өөрчлөгдөхөөргүй байна. Уул, уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын өсөлттэй холбоотойгоор аж үйлдвэрлэлийн салбарын ДНБ-нд эзлэх хувь 1.5 пунктээр нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин 1.4 пунктээр буурахаар байна.

БҮЛЭГ 3. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

3.1 Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхний алхамуудыг эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн 1990-ээд оны эхний жилүүдэд макро эдийн засаг тогтворгүй, эдийн засгийн уналт нэлээд хугацаагаар үргэлжилсэн юм. 1995-1999 оны хооронд макро эдийн засаг тогтворжих хандлага аажмаар бий болсон. Гэвч Монгол улсын эдийн засагт Зүүн Өмнөд Азийн эдийн засаг, санхүүгийн хямрал, дэлхийн эдийн засгийн сааралт нь нөлөөлсөн төдийгүй, дотоод улс төрийн тогтворгүй байдал, бодлогын зарим арга хэмжээ сөргөөр нөлөөлж байлаа.

I. Төсөв санхүү

3.2 1990-ээд оны эхэнд ДНБ-нд төсвийн орлого 60 орчим хувийг эзэлж байсан бол Азийн бүс нутагт явагдсан эдийн засгийн хямралын улмаас 1995-1999 онуудад уг үзүүлэлт 23.4-33.6 хувь болж буурсан байна. Төсвийн орлогын энэхүү өөрчлөлтөд Монгол улсын татварын бодлого, хууль эрх зүйн орчны өөрчлөлт мөн нөлөөлжээ. Татварын шинэчлэлийн чиглэлээр 1997 -1999 онд хийгдсэн арга хэмжээ:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дөрвөн (15, 25, 35, 40 хувь) шатлалыг хоёр (15 ба 40 хувь) шатлалтай болгосон.
- Хүн амын орлогын албан татварын таван (2, 8, 15, 27, 40 хувь) шатлалыг гурван (10, 20, 40 хувь) шатлалд шилжүүлсэн.
- Согтууруулах ундааны импортод гаалийн 15 хувийн татвар ногдуулахаас бусад гаалийн импортын татварыг тэглэсэн.
- Гурил, хүнсний ногооны гаалийн татварын 15 хувийг улирлын хамааралтай болгосон.

3.3 2001 оноос НӨАТ-ын хувь хэмжээ 15.0 хувь болсон ба архи тамхины онцгой татвар 50 хувь болсон байна. Татварын зарим нөхцөлүүдийг төсвийн орлого нэмэгдүүлэхэд чиглүүлж өөрчлөв. Гаалийн татварыг тэглэсэн татварын хуулийг халж, гаалийн татварыг зонхилох импортод ногдуулах болсон. Үүний сацуу татвар хураалтыг сайжруулах арга хэмжээг Засгийн газар бодлогын түвшинд хэрэгжүүлсэнээр ДНБ-д төсвийн орлогын хувийн жин 2001- 2003 онд 36 хувь болж өсөв. 2000-2002 оны хооронд төсөв, санхүүгийн чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, эдийн засгийн сэргэлт нь макро эдийн засгийн тогтворжилтыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт нэлээд саарч 1 орчим хувь болсон. Энэхүү бага өсөлтөд мал аж ахуйн салбар дахь уналт голлон нөлөөлсөн байна. Хэдийгээр сүүлийн 3 жилд эдийн засгийн өсөлт саарч

байгаа ч энэ хугацаанд улсын салбар, тэр дундаа санхүүгийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Төсвийн нийт алдагдлын ДНБ-д эзлэх хувийн жин 10 гаруй хувьтай байсан үетэй харьцуулахад 2000-2002 онд алдагдлын түвшин 6-7 орчим хувь болж буурав. Төсвийн тэнцэл ийнхүү сайжирсан нь татвар хураалтыг сайжруулах, төсвийн эрүүл орчин бүрдүүлж, ялангуяа банкны салбарын хараат байдлаас гаргах, гадаад, дотоод өрийг барагдуулах, засаглал хоорондын төсвийн харилцааг боловсронгуй болгоход чиглэсэн бодлого баримталсны үр дүн юм. Төсвийн хуримтлагдсан дотоод өрийг 2000-2002 онд 60 орчим хувиар бууруулж, 2000 онтой харьцуулахад Засгийн газрын банкны системээс авсан зээлийн хэмжээ 2002 онд 2 дахин буурч, 32.4 тэрбум төгрөгийн цэвэр хадгаламжтай болсон байна.

3.4 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан татварын баазыг өргөтгөн татвар хураалтын үйл ажиллагааг сайжруулах, татвар ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, татварын өр барагдуулах удирдлагыг боловсронгуй болгон эрхзүйн зохицуулалтыг чангатгах, бага орлоготой иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр нэлээд арга хэмжээ авч хэрэгжүүлэн зохих үр дүнд хүрч байна.

3.5 Мөн иргэдийн мөнгөн хуримтлалыг нэмэгдүүлэх явдлыг урамшуулахад чиглүүлэн Монгол улсад байгаа байнга оршин суугчийн хувьцааны ноогдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого болон адилтгах бусад орлогоос татвар авч эхлэх хугацааг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл сунгаснаар иргэдийн бодит орлого жил бүр 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

3.6 Төсөв, санхүүгийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн дараагийн үе шатны арга хэмжээ нь төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулахад чиглүүлж богино хугацааны төлөвлөлтийн тогтолцооноос дунд хугацааны төсөв зохиолт, эдийн засаг, нийгмийн бодлогын тэргүүлэх чиглэлийг хөрөнгийн эх үүсвэртэй нягт уялдуулах, төсвийн норм, нормативыг оновчтой болгох, төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог нэвтрүүлэх, тайлагналтыг сайжруулах зэргээр төсвийн харилцааны ил тод, цогц байдлыг хангахад чиглэгдэж ирлээ. Цаашид дунд хугацаанд төсөв, татварын шинэчлэлийн талаар баримтлах бодлого нь макро эдийн засгийн тогтворжилтийг бататгах, төсвийн тэнцлийг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, санхүү, хөрөнгийг аль болох ядуучуудад оновчтой чиглүүлэхэд оршиж байна. Энэхүү шинэчлэлийн хууль эрх зүйн үндэс нь 2002 оын 6 дугаар сард УИХ-аар батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль /ТБУСХ/ юм. Ийнхүү УИХ-аас улсын төсвийн зарцуулалтын талаарх хууль эрхзүйн орчныг цоо шинээр бүрдүүлэх арга хэмжээ авснаар орон тоо, нэгэнт гарсан зардлыг санхүүжүүлэх замаар хэрэгжиж байсан төсвийн зарлагын бодлого нь тухайн байгууллагын тавьсан зорилт, түүнд чиглэгдсэн бодит үр дүнг санхүүжүүлж байх шинэ зарчимд шилжсэн. Үүнээс гадна УИХ-аас 2003 оны төсвийг хэлэлцэн батлахдаа дээр дурьдсан шинээр батлагдсан хуулиудын утга агуулгад нийцүүлэн төсвийг урьд өмнө мөрдөгдөж байснаас өөр, шинэ зарчмаар хэлэлцэн баталсан. Үүнд:

- Төсвөөс олгох санхүүжилт, бүтээгдэхүүний төлбөр нь тухайн төсөвт байгууллагыг, орон тоог нь, байрны зардлыг нь санхүүжүүлэхэд чиглэгдээгүй, төсөвт байгууллагуудад төрөөс өгсөн үүрэг, зорилтыг хэрхэн биелүүлж байгаа үр дүнтэй нь холбож санхүүжүүлэх зарчим баримталсан.
- Төсвийн зарлага, санхүүжилтийг зардлын зүйлээс гадна, төсвийн ерөнхийлөн захирагчдаар буюу тодорхой салбар хариуцсан сайд нарын хувьд ногдох төсвийг нь багцлах байдлаар хуваарилсан.
- Ирэх оноос төсвийн санхүүжилтийг олгохдоо бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн талаар байгуулсан гэрээний үндсэн дээр олгох зарчмыг мөрдөнө.
- Жилийн явцад төсөвт байгууллагаас гаргаж ирүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн тайланг үндэслэн төсвийн санхүүжилтэд өөрчлөлт оруулах нөхцөл боломж бүрдэнэ.
- Орон нутагт байршиж, зөвхөн тухайн нутаг дэвсгэрийн хүрээний бус нийт улс орон даяар хамаарах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг салбарын төсвийг орон

нутгийн төсвөөс улсын төвлөрсөн төсвөөс, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх зарчмаар хэрэгжихээр тооцсон болно.

3.7 Үүний зэрэгцээ төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцооны талаарх бүх шатны төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулахаар дээд боловсролын байгууллагуудын дунд тендер зарлаж, сургалт явуулах 3 байгууллагыг шалгаруулаад байна. Эдгээр байгууллагууд нь 2003 оны 5 сараас 7 сарыг хүртэлх хугацаанд 22 аймаг болон нийслэлийн бүх дүүргийн удирдах ажилтан, ерөнхий менежерүүд, санхүүгийн ажилтнуудад нийтдээ 8.0 мянга орчим хүнийг хамруулан шинэ тогтолцооны талаар иж бүрэн сургалтыг газар дээр нь зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгнө.

3.8 Ийнхүү орон нутагт сургалт явуулснаар Монгол улсын 2004 оны төсвийн төслийг боловсруулах үйл ажиллагааг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуульд тусгагдсан шаардлагын дагуу боловсруулах боловсон хүчний чадавхи бэлтгэгдэнэ.

3.9 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу 2003 оноос эхлэн төсвийг аймаг, орон нутаг, төсөвт байгууллагуудад хуваарилан олгохдоо бүх шатандаа Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, Үр дүнгийн гэрээ байгуулах замаар санхүүжилтийг олгох шинэ зарчмыг хэрэгжүүлж эхлээд байна. 2002 оны жилийн эцсийн байдлаар 14 мянга гаруй эдийн засгийн нэгжүүд нийслэлд үйл ажиллагаа явуулж, нийслэлийн төсвийн хөрөнгийн орлогыг бүрдүүлж байсан ба 51.1 тэрбум төгрөг цугларч боловсрол, эрүүл мэнд, соёл, мэдээлэл, нийтийн үйлчилгээ, аюулгүй байдлын үйл ажиллагаа явуулдаг 500 гаруй нэгжид 53.7 тэрбум төгрөг зарцуулагдан, нийт төсвийн алдагдал 73.9 сая төгрөг болсон байна. 2001 он хүртэл нийслэл хот зардлаа нөхөх орлогыг бүрдүүлдэг бие даасан төсөвтэй байсан боловч сүүлийн жилүүдэд СЭЗЯ төсвийн төслийг бэлдэх явцад нийслэлийн төсөвт зохих өөрчлөлтүүдийг хийсэн.

3.10 Шинэ хуулийн дагуу бүх шатны төсөвт байгууллагууд, аймаг, нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн хөрөнгөөр ямар ажил үйлчилгээг, чанарын ямар түвшинд, хэрхэн гүйцэтгэсэн талаарх Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг улирал, жилээр гаргаж тайлагнаж байх юм.

3.11 Монгол улс төсвийн удирдлагын шинэ зарчмыг саяхнаас хэрэгжүүлж эхэлж байгаа бөгөөд үүнд дараах зорилтуудыг тавьж байна:

- Эхний ээлжинд бүх шатанд боловсон хүчний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх замаар хуулийн агуулгыг бүрэн ойлгож, бүтээгдэхүүнээ зөв тодорхойлох, нийлүүлсэн бүтээгдэхүүнийг зөв зохистой шалгуур үзүүлэлтээр хэмждэг болох, тайлангаа цаг хугацаанд бүрэн агуулгаар нь гаргаж сурах.
- Дараагийн ээлжинд тухайн байгууллагын иргэдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээг аль болох хямд өртөг зардлаар, чанартай хүргэх боломжийг бүрэн дайчлах, бүтээгдэхүүн үйлчилгээний өртөгийг хямдруулах чиглэлээр тодорхой үр дүнд хүрэх явдал болно.
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаашид мөрдөгдвөл зохих зарим заавар, журам, Засгийн газрын тогтоол шийдвэрийг СЭЗЯ-аас боловсруулж, мөрдүүлэхээр бэлтгэж байна. Тухайлбал:
- Монгол улсын Нэгдсэн төсвийн тухай хуульд заасны дагуу Бүтээгдэхүүний ангийг тогтоож батлуулах,
- Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд тусгагдсан зорилтын хэрэгжилт, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлох,
- Засгийн газрын Болзошгүй эрсдэлийн сан, түүний хуваарилалт, зарцуулалтын талаарх хууль, тогтоомжийн төсөл,
- Төсвийн байгууллагын жилийн эцсийн төсвийн хэмнэлтийг хэрхэн зарцуулах, эрх олгох тухай журам зэрэг болно.

3.12 ТБУСХ нь улсын салбарын үйл ажиллагаа, удирдлагыг бэхжүүлэх, түүний үүрэг, эрх мэдэл, хариуцлагыг оновчтой хуваарилах, ил тод байдлыг хангах, улсын салбарын удирдлагыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх үндсэн зарчмуудыг тодорхойлсон юм. Энэхүү хуультай холбогдуулан 78 хууль, тогтоомжид зохих өөрчлөлтийг оруулав. Дээрх хууль, тогтоомж, зааврууд нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд суурь баримт бичгүүд болно.

3.13 Ойрын жилүүдэд гадаад хүчин зүйлийн эрс өөрчлөлт гарахгүй бол макро эдийн засаг тогтвортой байх дотоод нөхцөл байдал бүрдсэн болно. Ялангуяа төсөв санхүү, улсын салбарын шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх бодлого арга хэмжээ нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндэс болно. Улсын төсвийн макро түвшиний хүрээний гол үзүүлэлтүүдийн тэнцвэрийг 2004-2006 онд хангахад чиглүүлж татварын орлогын талаар дараах зорилт тавьж байна.Үүнд:

- Нэгдүгээрт, эдийн засгийн өсөлт ба төсвийн орлогын харилцан хамаарлыг оновчтой тодорхойлж, татвар ногдуулалт, хураалт, хяналтыг хуулийн хүрээнд улам эрчимжүүлж, төсвийн санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангаж байгаа сүүлийн жилүүдийн ахицыг улам бататгана.
- Хоёрдугаарт, төсвийн орлого, татварын харилцааг төрийн албаны шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, засгийн газрын нийгмийн бодлогын талаар дунд хугацаанд явуулах арга хэмжээтэй уялдуулж, төсвийн тэнцвэр, тогтвортой байдлыг хангахад чиглүүлнэ.
- Гуравдугаарт, улсын төсвийн зардлын өсөлтийг дагасан татварын бодлого баримтлахгүйгээр, эдийн засагт болон хүн амд үзүүлэх татварын ачааллыг боломжтой түвшинд бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.14 ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувийг 2004 онд 37.4 хувь, 2005-2006 онд 36.3 хувь болгон бууруулах чиглэл барина. Үүнтэй уялдуулан татварын талаар ирэх гурван жилд дараах арга хэмжээ авахаар төсвийн дунд хугацааны хүрээний төсөлд урьдчилан тооцож байна.

3.15 Тухайлбал: эдийн засагт татварын ачаалал 2002 оны гүйцэтгэлээр 29.2 хувь байгааг ирэх гурван жилд тогтвортой байлгах бодлого баримтална. Нийгмийн даатгалын шимтгэлийн хураамжийн орлогыг хүн амын бодит болон мөнгөн орлогын өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэхтэй уялдуулан тооцож 2004-2006 онд 2003 оныхоос жилд дундажаар 15 тэрбум төгрөгөөр буюу 27 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдүүлнэ. Тамхинд ногдуулах онцгой албан татварыг нэмэгдүүлж, үүний үр дүнд 2004 оноос татварын орлого 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэж тооцож байна. Газар хувьчлалын үйл ажиллагааг эхлүүлснээр газрын хураамж, төлбөрөөс бий болох орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлнэ. Аж ахуйн өндөр албан татварыг дахин хянах бодлого 2005 он гэхэд одоогийн зардлыг багасгаж чадсан нөхцөлд хийгдэнэ. Энэ нь аж ахуйн нэгжийн албан татварыг нэг шатлалтай болгох үйл явцын анхны алхам болно.

3.16 Нийгмийн секторыг өөрчлөн зохион байгуулах үйл явц УИХ-аас баталсан нийгмийн салбарыг хувьчлах, шинэчлэн зохион байгуулах ерөнхий удирдамжийн дагуу хийгдэнэ. Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас батлагдан гарах жагсаалтын дагуу дунд хугацаанд нийгмийн салбарын зарим байгууллагуудад өөрчлөлт, шинэчлэлт хийнэ.

3.17 **Төсвийн тогтвортой байдал.** Төсвийн тогтвортой байдал нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. 1997-1999 онуудад авч хэрэгжүүлсэн татварын бодлого, үйлдвэрийн уналт, эдийн засгийн гадаад орчин, Азийн эдийн засаг санхүүгийн хямрал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан төсвийн орлого муу төвлөрч байв. Цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, урсгал зарлагад тавих хяналт муудах зэргээс төсвийн зарлагын удирдлага суларсан. Ийнхүү төсвийн байдал бүхэлдээ муудаж


төсвийн алдагдал нэмэгдэн, тогтвортой байдал нь алдагдсан байна. ДНБ-д эзлэх төсвийн зарим үзүүлэлтийг үзүүлвэл:

Хүснэгт 3:1: Төсвийн үзүүлэлтүүд, 1993-2003 (ДНБ д эзлэх хувиар)

| | 1993 | 1994 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003 |
|------------------------------------|-------|-------|------|------|------|-------|-------|------|------|------|------|
| Төсвийн орлого | 30.2 | 31.1 | 25.6 | 24.8 | 25.5 | 27.6 | 27.2 | 33.6 | 38.9 | 38.8 | 36.3 |
| Төсвийн зарлага, цэвэр зээл | 28.3 | 26.8 | 31.5 | 32.7 | 34.5 | 41.9 | 39.4 | 41.1 | 43.3 | 44.8 | 42.6 |
| Урсгал зардал | 25.5 | 18.4 | 23.7 | 22.1 | 23.1 | 27.2 | 26.7 | 30.1 | 32.4 | 33.8 | 31.9 |
| Хүүгийн төлбөр | 1.2 | 0.6 | 0.4 | 0.7 | 2.5 | 1.4 | 1.9 | 1.7 | 1.5 | 1.6 | 1.5 |
| Урсгал төсвийн ашиг (+) | 1.9 | 2.9 | 6.2 | 4.0 | 1.6 | -0.7 | -0.2 | 3.1 | 5.6 | 4.4 | 3.8 |
| Нийт төсвийн алдагдал (-) | -14.6 | -19.8 | -5.9 | -7.9 | -9.1 | -14.3 | -12.1 | -7.5 | -4.5 | -6.0 | -6.2 |

*-төлөвлөгөө

3.18 Монгол улс төсвийн алдагдлыг бууруулах талаар сүүлийн 10 жилд зохих амжилтад хүрч байна. 1994 онд төсвийн алдагдал ДНБ-ний 19.8 хувийг эзэлж байсан бол түүнийг жил дараалан бууруулж 2002 онд ДНБ-ний 6.0 хувийг эзлэх түвшинд хүргэж чадсан. Төсвийн урсгал зардал үнэмлэхүй дүнгээр болон нийт зардалд эзлэх хувиар өсөж байгаа хэдий ч улсын салбарын үйлдвэрийн газарт олгох шууд татаас 1995-2002 онд 3 дахин буурсан байна.



3.19 2001 оноос Монгол улсын Засгийн Газар нь үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, ил тод байдал болон хариуцлага тооцох боломжийг дээшлүүлэхийн тулд төсвийн зарлагын удирдлагын тогтолцоонд бүтцийн өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн юм. Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн ажлын хүрээнд 2001-2002 оны хооронд макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч урсгал төсөв эерэг болж мөн зарлага, санхүүжилтийг хянах явц ч мөн дээшилсэн байна.

3.20 Төсвийн тогтвортой байдлыг хангах, татвар хураалтыг сайжруулах, татварын оновчтой бодлого явуулах талаар Засгийн газраас анхаарч олон чухал арга хэмжээг шуурхай авсны үр дүнд төсвийн тогтвортой байдал 2000 оны сүүлийн хагасаас сайжирч иргэдэд үзүүлэх үйлчилгээ хүртээмж нь дээшилсэн байна. 2000 оны 8 сард эмхлэн байгуулагдсан Засгийн газар юуны өмнө Монгол банкинд төлөх 12.0 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, татвар хураалтыг сайжруулах талаар далайцтай ажиллаж, гадаадын орны урсгал өрийн төлбөрийн хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээ авсны дүнд төсвийн орлогын төвлөрөлт сайжирч тулгамдсан зарим өрийг барагдуулж чадсан. Төсвийн зарлага

санхүүжилтийн хувьд хяналтыг сайжруулж тулгамдсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч эхэлсэн. Цалингийн 8.2 тэрбум төгрөгийн өрийг 2000 онд багтаан барагдуулсны зэрэгцээ, гадаад урсгал өрийн төлбөр, түлш цахилгаан, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өмнөх онуудын өрийг барагдуулах талаар ихээхэн ахиц гарсан. Үүний үр дүнд 21 аймгийн 16 нь 2002 оны эцэс гэхэд төсвийн ямар ч өргүй болсон байна. 2003 оны төсвийг ТБУС-ийн хуулийн дагуу боловсруулан батлуулж 2003 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлж эхэллээ. 2001 оны 1 сарын 1-ээс эхлэн нэмэгдсэн өртгийн албан татварын хувийг 2 нэгжээр нэмэгдүүлж 15.0 хувь, архи тамхины онцгой албан татварыг 50 хувь, гаалийн татварыг 2 нэгжээр нэмэгдүүлж 7.0 хувь болгон мөрдсөн. (Гаалийн татварыг зөвхөн нэг жилийн хугацаатай мөрдсөн).

3.21 Засаглал хоорондын төсвийн харилцааг шилжүүлэгийн шинэ загвараар удирдах болсон. Төсвийн орлого төвлөрүүлэлт хуваарилалт дээр шинэчлэлт хийж НӨАТ-ыг 80 хувь, онцгой албан татварын 50 хувийг төвлөрсөн төсөвт төвлөрүүлэн эргүүлж шилжүүлэх механизмыг нэвтрүүлэв.

2001 онд НӨАТ, 2002 онд ААН-ийн орлогын албан татвар, онцгой татварууд, 2003 онд ХАОАТ-уудыг улсын төсөвт төвлөрүүлдэг болж орлогын суурийг нь багасгасаар байгаа боловч сүүлийн 5 жилийн нийслэлийн төсвийн үндсэн үзүүлэлтүүд нь хүн амын болон ААН-ын орлогын албан татвар нэмэгдсээр байна. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар нийслэлийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь дараах үүргийг орон нутгийн санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ:

1. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, зам засвар
2. Усан хангамж, цэвэрлэх байгууламжийн жигд ажиллагааг хангах
3. Байгаль хамгаалал
4. Үерийн далан барих, хөрсний элэгдэлтэй тэмцэх
5. Нийгмийн эрүүл ахуйг хангаж, хог хаягдлыг цэвэрлэх устгах
6. Гал түймэртэй тэмцэх
7. Хортон мэрэгчидтэй тэмцэх
8. Малын өвчин болон малаас хүнд халддаг өвчинтэй тэмцэх

Боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хэв журмын үйлчилгээг Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр нийлүүлэх боловч нийслэлийн төсвийн орлого нь үл хөдлөх хөрөнгийн татвар, тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ус, рашаан, байгалийн баялаг ашигласны төлбөр зэрэг хязгаарлагдмал эх үүсвэрээс бүрдэж байна. Энэ байдал нь орлогын нэмэгдэл эх үүсвэрийг бий болгох, орлогын бааз суурийг өргөтгөх шаардлагатайг харуулж байна.

3.22 Төсвийн тогтвортой байдлыг хангах талаар 2001-2002 онд авч хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээний үр дүнд төсвийн макро үзүүлэлтүүд сайжирч урсгал төсөв ашигтай гарч зарлага санхүүжилтийн хяналт сайжирлаа. Төсвийн тогтвортой байдлыг хангах асуудлын хүрээнд төсвийн алдагдлын санхүүжилтийн асуудлыг 1997-2003 оноор авч үзье.

Хүснэгт 3:2: Төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)

| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 | 2003* оны төсөв |
|--------------------------------|------|-------|-------|------|------|------|-----------------------|
| Нийт төсвийн алдагдал | -9.1 | -14.3 | -11.9 | -7.5 | -4.5 | -6.0 | -6.2 |
| Төсвийн алдагдлын санхүүжилт | 9.1 | 14.3 | 11.9 | 7.5 | 4.5 | 6.0 | 6.2 |
| - Гадаад эх үүсвэр (цэвэр) | 10.5 | 8.9 | 10.1 | 6.4 | 6.4 | 6.7 | 7.3 |
| - төслийн зээл | 8.3 | 9.5 | 9.4 | 6.0 | 6.1 | 6.6 | 6.7 |
| - санхүүгийн зээл | 4.5 | 0.9 | 1.8 | 1.3 | 2.1 | 1.3 | 2.1 |
| -Үндсэн өрийн төлбөр | -2.2 | -1.5 | -1.1 | -0.9 | -1.7 | -1.2 | -1.5 |
| Дотоод эх үүсвэр (цэвэр) | -1.5 | 5.4 | 1.8 | 1.2 | -1.9 | -0.7 | -1.1 |
| - Хувьчлалын орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.7 | 0.5 | 1.4 | 1.1 |
| - Засгийн газрын гаргасан бонд | 0.0 | 0.0 | 0.0 | 0.2 | -1.3 | -1.1 | -0.8 |
| - Олон Улсын Валютын сан | 0.0 | 0.0 | 0.4 | 0.7 | 0.5 | -0.2 | 0.6 |
| - Банкны системийн | -1.5 | 5.4 | 1.3 | -0.5 | -1.5 | -0.8 | -2.0 |
| - Банкны бус системийн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | -0.2 | 0.0 | 0.0 |

* төлөвлөгөө

3.23 Хүснэгтээс харахад, төсвийн алдагдлыг 1997-1999 онуудад голлон гадаад эх үүсвэрээр, тэр дундаа санхүүгийн зээлээр нөхөж байснаас гадна Монголбанк, банкны системээс их хэмжээний зээл авч нөхөж байсан байна. Ийнхүү дотоод эх үүсвэрийг хэт дайчилснаас эдийн засагт очих хөрөнгө багассан байна. Харин 2000-2002 онд банкны систем дэх өрийг барагдуулж, дотоод эх үүсвэрийг багасгаж, сар улиралын чанартай түр санхүүжилтийг Засгийн газрын богино хугацаат бонд гарган хангаж байна. 2002 оны байдлаар төсвийн алдагдал нь үндсэндээ Засгийн газрын шугамаар гаднаас хөнгөлөлттэй нөхцлөөр авч ашиглаж байгаа төслийн зээлийн хөрөнгө байна.

3.24 ЯБӨХ хөтөлбөрийн хүрээнд ОУВС-тай урьдчилан зөвшилцсөний дагуу Монгол улс дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2004 онд 5.3 хувь, 2005-2006 онд 5.5 хувиар өсгөсөн нөхцөлд улсын төсвийн тэнцлийн гол үзүүлэлт дараах түвшинд хадгалагдахаар 2004-2006 оны төсвийн дунд хугацааны хүрээний тооцоонд тусгаж төлөвлөөд байна. Үүнд:

Хүснэгт 3:3: Төсвийн төлөвлөгөө (ДНБ-нд эзлэх хувиар)

| | 2002 | 2003* | 2003** | 2004*** | 2005*** | 2006*** |
|----------------------------------|------|-------|--------|---------|---------|---------|
| Нийт орлого, тусламж | 38.8 | 36.3 | 37.0 | 37.4 | 36.3 | 36.3 |
| татварын орлого | 29.2 | 27.4 | 28.7 | 29.4 | 28.4 | 28.5 |
| татварын бус орлого | 9.0 | 8.3 | 7.7 | 7.5 | 7.4 | 7.3 |
| Татаас | 0.6 | 0.6 | 0.6 | 0.5 | 0.5 | 0.5 |
| Нийт зардал ба цэвэр зээл | 44.8 | 42.6 | 43.0 | 43.3 | 41.8 | 40.8 |

| | | | | | | |
|--------------------------------|------|------|------|------|------|------|
| Урсгал зардал | 33.8 | 31.9 | 31.9 | 31.8 | 31.0 | 30.4 |
| Нийт бараа үйлчилгээний зардал | 23.2 | 21.3 | 21.1 | 21.5 | 21.1 | 20.9 |
| Цалин хөлс | 8.5 | 8.6 | 8.5 | 8.5 | 8.4 | 8.3 |
| Бараа үйлчилгээ | 14.7 | 12.7 | 12.7 | 13.0 | 12.7 | 12.6 |
| Зээлийн үйлчилгээ | 1.6 | 1.5 | 1.4 | 1.3 | 1.2 | 1.1 |
| Татаас, шилжүүлэг | 8.9 | 9.2 | 9.3 | 9.0 | 8.8 | 8.4 |
| Хөрөнгийн зардал | 5.5 | 4.8 | 4.8 | 5.1 | 4.9 | 5.3 |
| Цэвэр зээл | 5.5 | 5.9 | 6.3 | 6.3 | 5.9 | 5.1 |
| Урсгал төсвийн ашиг (+) | 4.4 | 3.8 | 4.5 | 5.0 | 4.7 | 5.4 |
| Нийт тэнцлийн алдагдал (-) | -6.0 | -6.2 | -6.0 | -5.9 | -5.5 | -4.5 |

** - төлөвлөгдөж буй

*** - ДХТХМ

3.25 Дунд хугацаанд ДНБ-нд төсвийн нийт зардал цэвэр зээлийн нийлбэр дүнгийн эзлэх хувийг харьцангуй бууруулах болно. Тухайлбал 2002 оны гүйцэтгэлээр нийт зардал ДНБ-нд 44.8 хувь эзэлж байгааг 2004 онд 43.3 хувь, 2005 онд 41.8 хувь болгон бууруулах зорилт тавьж байна. Үүний тулд:

- Боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын өөрийн орлогоор зардлаа нөхдөг зарим нэгжийг бие даалган улсын үйлдвэрийн газрын хэлбэрт шилжүүлэх, гэрээгээр үйлчилгээ гүйцэтгүүлэх, хувьчлах;
- Төрийн албаны бүтцийн өөрчлөлтийг үе шаттай явуулж Засгийн газрын зардлын өсөлтийг хязгаарлах, багасгах.
- Улсын үйлдвэрийн газруудад олгодог татаасыг бууруулах;
- Хандивлагч орнууд, олон улсын санхүүгийн байгууллагаас авч ашиглах зээлийн чиглэл, зориулалтыг оновчтой болгож, эдийн засгийн өсөлтийн нэг гол хүчин зүйл болгох, үүний тулд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн талаар одоо үйлчилж байгаа хуульд зарим нэмэлт өөрчлөлт оруулах замаар зээлийн өрийн өсөлтийг зохистой түвшинд байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.26 Урсгал төсвийн эерэг үлдэгдэл 2002 онд 4.4 хувь байгаа бөгөөд цаашид 2004-2006 онд төсвийн тэнцлийг 4.7-5.4 хувиас доошгүй байлгаж, дотоодын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх нэг эх үүсвэр болгоно. Улсын төсвийн нийт тэнцлийн алдагдлыг ДНБ-д 2004 онд 5.9 хувь, 2005-2006 онд 5.5-4.5 хувиас хэтрэхгүй байлгах бодлогыг баримталж байна.

3.27 Хөрөнгийн хуваарилалт. Бодлогын тэргүүлэх чиглэлийг төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөтэй аль хэр оновчтой уялдуулснаас Засгийн газрын бодлогын хэрэгжилт ихээхэн хамаарч байна. Иймд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дунд хугацаанд баримтлах бодлогын суурь болох бөгөөд эдгээр бодлогын чиглэлийг салбарууд өөрийн тэргүүлэх чиглэлийн стратеги, хөтөлбөр, төсөл болгон боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрээр баталгаажуулж байна. Улсын салбарын шинэчлэлийн нэг зангилаа асуудал бол бодлогын тэргүүлэх чиглэлийг төсвийн эх үүсвэртэй уялдуулах, ялангуяа ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг дэмжих явдал юм.

Хүснэгт 3:4. Нийгмийн салбарын төсвийн хувь хэмжээ

| | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|------|------|------|------|------|------|
| 1. ДНБ-д эзлэх хувь | | | | | | |
| Боловсрол | 5.6 | 7.1 | 7.0 | 8.1 | 9.0 | 8.5 |
| Эрүүл мэнд | 3.4 | 4.0 | 3.9 | 4.5 | 5.3 | 4.4 |
| Нийгмийн хамгаалал | 5.1 | 6.3 | 6.5 | 7.5 | 7.7 | 7.7 |
| 2. Төсвийн нийт зардалд эзлэх хувь | | | | | | |
| Боловсрол | 16.2 | 17.1 | 17.8 | 19.1 | 20.6 | 19.8 |
| Эрүүл мэнд | 9.9 | 9.6 | 9.8 | 10.7 | 12.2 | 10.3 |
| Нийгмийн хамгаалал | 14.9 | 15.1 | 16.4 | 17.7 | 17.7 | 17.9 |

3.28 Боловсролын салбарт 2000 оноос эхлэн нэлээд анхаарч ядуу болон малчин айл өрхийн нэг хүүхдийг дээд сургуульд сургах, дотуур байрны зардлыг төрөөс хариуцах болсон сургалтын орчинг сайжруулах арга хэмжээг авч эхэлсэнтэй холбогдож тус салбарт төсвөөс хуваарилагдах хөрөнгө сүүлийн 3 жилд нэмэгджээ. Боловсрол, эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь нэг суралцагч болон үйлчлүүлэгчид ногдох хувьсах зардлын нормативаар төлөвлөгдөж байгаа бөгөөд хүүхэд олонтой сургуулийн санхүүжилт нь хангалттай түвшинд байна. Нормативыг 1998 оноос эхлэн мөрдсөн бөгөөд үнийн өөрчлөлттэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэн мөрдөж байна. Хүүхэд цөөн, зах хязгаар нутгийн сургууль, хүн ам цөөнтэй сумын эмнэлэгүүдэд нормативт хуваарилагдсан зардал нь хүрэлцээ муутай, дутагдах явдал зарим газар гарч байна. Хөрөнгө мал ихтэй айлын хүүхдүүд ихэвчлэн аймаг, нийслэл бараадан сурч байхад хөрөнгө чинээ муутай ядуу, ядуувтар айлын хүүхдүүд сумандаа үлдэн сурч байна. Иймээс зардлын хуваарилалт дээр цаашид анхаарч боловсронгуй болгох, ядуу айлын хүүхдийн сурах бололцоо, ядуучуудад үзүүлэх эмнэлэгийн үйлчилгээг сайжруулна. ДНБ-д боловсрол, эрүүл мэндийн салбарын эзлэх хувь хэмжээг дунд хугацаанд бууруулахгүй бодлогыг тууштай баримтлана. Энэ нь хүн ам, ялангуяа эмзэг ядуу, дунд хэсгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг өсгөж улмаар ядуурлыг бууруулах үндэс болно гэж үзэж байна. Хэдийгээр тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх шаардлага байгаа боловч богино хугацаанд Засгийн газраас тэтгэвэрийг нэмэгдүүлэх ямар нэг амлалт авахгүй бөгөөд 2004 онд төсвийн зардлыг оновчтой тогтоох шийдлүүдийг судлан, тэтгэвэрийн хэмжээг инфляцийн түвшингээс хэтрэхгүй хэмжээгээр нэмэгдүүлнэ. Мөн Засгийн газар тэтгэвэрийн даатгалын бодлогоо тэтгэвэрийн шинэтгэл, ажил эрхлэлтийн өсөлттэй уялдуулан түүний хамралт, хүрээний тал дээрүргэлжлүүлэн явуулна. Мөн нэрийн дансны хуримтлалын эх үүсвэрээр хангах бодлого баримтлана. Дунд хугацаанд бодлого нь ядуучуудыг дэмжихэд илүүтэй чиглэгдэнэ. Түүнчлэн дунд хугацаанд бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдан боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

3.29 Улаанбаатар хотын санхүүгийн чадавхи хэдийгээр нэмэгдсэн ч нийтийн тээвэр, ахуйн үйлчилгээ, гэрэлтүүлэг, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн дэг журам сахиулах байгууллагуудын болон инженерийн байгууламжуудыг орчин үеийн болгон засч янзлах хөрөнгө бололцоо дутмаг байгаа бөгөөд эдгээр нь эдийн засаг, нийгэм, хотжилттой холбоотой олон асуудлуудыг бий болгож байна.

3.30 Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тогтвортой байдал нь тус салбарт төсвөөс хуваарилагдаж буй хөрөнгийн эх үүсвэрээс гадна Эрүүл мэндийн даатгалын тогтолцооноос нэлээд хамааралтай юм. Учир нь төрөөс ядуучууд, тахир дутуу иргэд, өндөр настан, хүүхэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн эрүүл мэндийн даатгалын хураамжийг хариуцаж байна. Харин эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээг оновчтой тогтоож, зөвхөн ядуу, эмзэг хэсэгт төсвөөр дамжуулан үзүүлж буй дэмжлэгийг сайжруулах нь чухал юм.

3.31 Нийгмийн даатгал, халамжийн тогтолцооноос өрхөд үзүүлж буй төрөл бүрийн тэтгэвэр, тэтгэмж нь удирдлага, хамрах хүрээний хувьд шинэчлэгдэх шаардлагатай тулгарч байна. Одоогийн байдлаар төсвийн нийт зардлын 18 хувь нь өрхөд тэтгэвэр, ямар нэгэн тэтгэмжийн хэлбэрээр хуваарилагдаж байна. Хэдийгээр нийт дүн нь их боловч хамрах хүрээ оновчгүй байгаагаас шалтгаалан нэг хүнд ногдож буй хэмжээ тун бага, тухайлбал, тэтгэврийн дундаж 22 орчим ам. доллар байхад тэтгэмж үүнээс хамаагүй бага байна. Иймд дунд хугацаанд тэтгэврийн шинэчлэл, төсвөөс хүн амд олгож буй шилжүүлэгийн өөрчлөлтийг өрхөд үзүүлэх дэмжлэг хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй юм.

3.32 Үүний зэрэгцээ ядуучуудад чиглэсэн хуваарилалтыг оновчтой болгох зорилгоор хүн амын орлогын албан татварын шатлалыг өөрчилсөн юм. Төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхдээ хүн амын бодит орлогыг нэмэгдүүлэх, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор орлогын шатлалын дагуу 36000 хүртэлх төгрөгийн орлогод татвар ногдуулахгүй байсныг 48000 хүртэл төгрөг болгож татвараас чөлөөлөгдөх шатлалыг ахиулав. Мөн хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, хадгаламжийн хүүгийн орлогоос авах татварыг 2005 оны 1-р сарын 1-н хүртэл ногдуулахгүй байхаар шийдвэрлэв.

3.33 Төсвийн тогтвортой тэнцвэртэй, ил тод байдал нь макро эдийн засгийн тогтворжилтыг бататгаж Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг хангах болон ядуурлыг бууруулах талаар дэвшүүлсэн зорилтуудад хүрэх гол нөхцөл болж байна. Төсвийн нийт алдагдлыг 2004 оноос 6 орчим хувь, түүнээс бага байлгах зорилт тавьж байна. Төсөв, татварын дунд хугацааны бодлого нь макро эдийн засаг, түүний дотор санхүүгийн тогтвортой байдал, хувийн хэвшлийг хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх, төсвийн тэнцлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэх, ядуучуудад чиглэсэн төсвийн зардлыг нэмэгдүүлж тогтвортой байлгахад чиглэгдэнэ. Төсвийн зарлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктэй хамтарч улсын салбарын шинэчлэлийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд суурь мэдээлэл нь Дэлхийн банкны төсвийн зардлын суурь судалгаа юм. Дунд хугацааны төсвийн шинэчлэлийг эрчимжүүлснээр төсвийн төлөвлөлтийг сайжруулж, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлж, улмаар бага орлоготой иргэдэд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.34 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах, нөгөө талаар төсвийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад төрийн албаны шинэчлэлийн гол агуулга чиглэгдэх бөгөөд шинэчлэлийг төрийн сангийн нэгдсэн удирдлага, төсөв, нягтлан бодох бүртгэл, тайлагналт, үр дүнгийн удирдлага, бараа үйлчилгээ худалдан авах ажиллагаа, аудит гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгээр хэрэгжүүлнэ. Энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн үндэс нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Нэгдсэн төсвийн тухай хууль болон эдгээр хуультай нийцсэн бусад эрхзүйн акт, хөтөлбөрүүд болно. Эдгээр хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төсвийн төлөвлөлтийг сайжруулан шинэ шатанд гаргаж төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, улмаар бага орлоготой иргэдэд зориулан төрөөс зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, бодлогыг ядуучуудад чиглүүлэх боломж бүрдэнэ. Дээр дурьдсан хууль тогтоомж, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага хандивлагчдын дэмжлэг туслалцаа ихээхэн ач холбогдолтой.

3.35 **Төсвийн шинэчлэл.** 1996-1999 оны хооронд төсвийн шинэчлэлийн талаар дорвитой өөрчлөлт хийж чадаагүй. 2000-2003 оны хооронд төсвийн шинэчлэлийн талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авлаа. Юуны өмнө төсвийн зарлага санхүүжилтийн ил тод байдал, тайлагналтыг хангах зорилгоор төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих туршилтуудыг 2001 оноос авч хэрэгжүүлээ. Тэг үлдэгдэлтэй дансны тогтолцоог 10 гаруй байгууллагад туршив. Төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэх цогцолбор хөтөлбөр боловсруулах ажлыг хийж байна. Үүний зэрэгцээ шинэчлэлийн зарим арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. 2003 оны 1 сарын 1-нээс туршилтын журмаар үр дүнгийн гэрээ байгуулан ашиглах хэлбэрт салбарын яамд шилжлээ. Төсвийн хариуцлага,

ил тод байдлыг хангах, нийгмийн даатгал, халамжийн тогтолцоог шинэчлэх замаар төсвийн ачааллыг бууруулах арга хэмжээ авна.

3.36 Төсвийн шинэтгэлийн үндсэн зорилт нь төсвийн төлөвлөлт, хяналт, хэрэгжилтийг сайжруулах, төрийн албаны шинэтгэлийг явуулах, ядуурлыг бууруулахад чиглэсэн үйлчилгээг сайжруулах, ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхүндсэн дээр үр ашиг багатай урсгал зардлыг бууруулахад оршино. Ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхийн тулд зам болон бусад томоохон дэд бүтцийн байгууламж барихад ашигт малтмалыг олзворлох эрхийн баталгаа гаргах зэрэг солилцоонд үндэслэсэн санхүүгийн гэрээ хийхээс татгалзана.

3.37 Татвар нь зөвхөн орлого бүрдүүлэх механизм байхын зэрэгцээ хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг урамшуулах, хэрэглээ ба хуримтлалын хоорондын зохистой харьцааг хангах гол хэрэгсэл байх болно. Ингэхдээ татварын суурийг өргөтгөж, татвар хураалтыг сайжруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгаж, татварын тэгш, шударга орчинг бүрдүүлэх замаар татварын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.38 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, улмаар хөдөөгийн хүн амын амьжиргааг дэмжих зорилгоор төв болон орон нутгийн төсвийн харилцааг улам боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарын талаарх орон нутгийн удирдлага, иргэдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

3.39 Төсвийн удирдлагын шинэ арга барилыг нэвтрүүлсэнээр Засгийн газар, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллагын төсөв зохиох, батлуулах, зарцуулах, тайлагнах талаар тэдгээрийн идэвх сонирхлыг татах өөрчлөлтүүд хийгдэх болно. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналт салбараар хийгдэж салбарын бодлого, үйл ажиллагаатай нягт уялдана. Ингэснээр ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн дэд бүтцийн салбаруудын санхүүжих эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах боломж нэмэгдэнэ.

3.40 Тайлагналтыг боловсронгуй болгох хүрээнд төсвийн сарын мэдээллийг Засгийн газрын санхүүгийн статистикийн аргачлалын дагуу гаргаж байна. Мөн Засгийн газрын бүртгэлийн иж бүрэн систем болох Засгийн газрын бүртгэлийн мэдээллийн системийн программыг суурилуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

3.41 Санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх замаар ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх аргуудын нэг бол төсвийн зарлагын дунд хугацааны хүрээ /ТЗДХХ/-г оновчтой тогтоох явдал юм. ТЗДХХ нь бодлогын тэргүүлэх чиглэлийг төсвийн хөрөнгө, түүний зарцуулалттай уялдуулах гол механизм мөн бөгөөд энэхүү хүрээг боловсруулах, үйл ажиллагаандаа мөрдөх нь хүний нөөцийн чадавхи, төсөв захиран зарцуулагч нарын хариуцлагатай үйл ажиллагаагааг шаардсан урт хугацааны үйл явц мөн билээ. Энэхүү хүрээг тодорхойлох эрх зүйн суурь нь ТБУСХ юм.

3.42 Хүрээг боловсруулах ажлын бүрэлдэхүүн хэсэг болох Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг Засгийн газар сүүлийн 2 жилд боловсруулж Улс төрийн түр хороогоор батлуулж байв. ТБУСХ-д төсвийн хүрээг УИХ-аар батлуулахаар заасан юм. Мөн ТЗДХХ-г оновчтой тогтоох нэг нөхцөл бол макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хэтийн тооцоог аль болох үнэн зөв хийх явдал юм. Тооцооны үндэслэл, зөв байдал нь бодлого боловсруулагчдын чадавхи, мэдээллийн чанар зэргээс шууд хамааралтай, мөн төсвийн хүрээг оновчтой мөрдөх нь бодлого боловсруулагчдын чадавхи, бодлогыг төсвийн хөрөнгөтэй уялдуулах чадвараас ихээхэн шалтгаална. Иймд ТЗДХХ-ийг боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд хандивлагчдын үйл ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй юм.

3.43 **Төсвийн зарлагын удирдлага.** Төсвийн зарлагын удирдлага нь Санхүү, эдийн засгийн яам, аймаг нийслэлийн Засаг даргын хүрээнд үндсэндээ явагдаж байсан бол төсвийн шинэчлэлийн хүрээнд 2003 оноос салбарын удирдлагын чиглэлээр явагдаж эхэллээ. Салбарын яамд газруудын сайд, дарга нар нь төсвийн ерөнхийлөн захирагчид

бас тухайн салбарынхаа төсвийг боловсруулах, зарцуулах эрх мэдэлтэй болж, Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан нийлүүлсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нь санхүүжүүлэх, бодлого хэрэгжүүлэх хэлбэрээр төсвийн зарлагын удирдлагад бүтцийн өөрчлөлт хийгдлээ. Төсвийн төлөвлөлт санхүүжилт салбараар хийгдэхтэй уялдаад гол гол яамдад санхүү эдийн засгийн алба 2003 оны 2 сараас байгуулагдав. Дунд хугацаанд ТБУСТХ-ийн дагуу СЭЗЯ болон төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн байгууллагын санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааг хянаж, үр дүнг үнэлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдний ажлын албыг бэхжүүлж, төлөвшүүлэх арга хэмжээг 2003-2005 онуудад хэрэгжүүлнэ.

3.44 Төрийн байгууллагын шинэтгэлийн хүрээнд дунд хугацаанд Засгийн газраас үр дүнд суурилсан үнэлгээнд үндэслэн төсвийн зарлагын удирдлага, үр ашгийг дээшлүүлнэ. Ингэхдээ төрийн албаны болон нийгмийн салбарын зарим хэсгийг арилжааны горимд шилжүүлэх, нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгох, санхүүжилтийн стандартыг улам нарийвчлан тогтоож мөрдүүлэх зэргээр төсвийн зардлын удирдлагыг шинэ түвшинд гаргана. Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд Засгийн газар, Монгол банкнаас хүний нөөцийн удирдлагын боловсронгуй мэдээллийн санг байгуулах, төрийн үйлчилгээний шинэтгэлийг ил тод явуулах ямарваа нэг төсвөөс гадуурх санхүүгийн үйл ажиллагааг явуулахгүй байх, төрийн албан хаагчдын цалинг үндэслэлгүйгээр нэмэхгүй байх зарчим баримтална. Үүний зэрэгцээ гадаад болоод дотоодын санхүүжилттэй төслүүдийн шалгуурууд, хэрэгжүүлэх боломжийн судалгааг сайжруулна.

3.45 Төсвийн зарлагын удирдлагын шинэ үйл ажиллагаанд дагаж мөрдөх заавар, журам, гарын авлагыг боловсруулах, байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүгийн үр дүнг хянах, шинжлэх, үнэлэх талаар холбогдох ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг СЭЗЯ болон төсвийн ерөнхийлөн захирагч нар авч хэрэгжүүлнэ. Гол чиглэл нь ТБУСТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох бүх төрийн байгууллагын ажиллагсадын чадавхийг сайжруулах, яам, байгууллага бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, түүний хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадварыг дээшлүүлэх явдал юм.

3.46 **Төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх үе шат, цаг хугацаа.** ТБУСТХ-ийн хэрэгжилт болон төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийг дараахь гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Бэлтгэл үе шат

Нэгдүгээр үе шат: Бүтээгдэхүүнд суурилсан удирдлагын тогтолцоог бүрэн нэвтрүүлэх.

Хоёрдугаар үе шат: Эрх мэдэл шилжүүлэх.

3.47 Улсын салбарын шинэчлэлийн үе шат, хэрэгжүүлэх дэс дарааллыг зөв тогтоосноор төсвийн зарлагыг бууруулж, төрийн албыг оновчтой, цомхон, чадварлаг болгож, төрийн үйлчилгээний үр ашиг дээшилж, чанар хүртээмж сайжирна.

3.48 Төсөв, санхүүгийн шинэчлэлийн эхний үе шатанд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 2003 онд боловсруулна. 2004 оноос төсвийн шинэчлэлийн стратегийг бүхэлд нь боловсруулахаар төлөвлөж байна. Дээрхи хоёр ажлын хүрээнд төрийн албаны шинэчлэлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Мөн нийгмийн салбарт бүтцийн өөрчлөлт хийх, шинэчлэлийг эрчимжүүлэх, санхүүжилтийн хувьд бие даан үйл ажиллагаагаа явуулж чадах боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын аж ахуйн нэгжүүдийг арилжааны горимд аажмаар шилжүүлнэ.

3.49 Улсын салбарын шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцоог нарийвчлан гаргаж, гадаад дотоод эх үүсвэрийг тодорхойлно. Улсын салбарын шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй уялдаж эрх мэдлийг шилжүүлэх ажлыг дараагийн үе шатанд хэрэгжүүлнэ.

3.50 Бараа үйлчилгээ, худалдан авах ажиллагаа. Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа өнөө үед Засгийн газрын үүрэгт үндсэн өөрчлөлтүүд гарсны нэг нь улсын салбарт шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудтай гэрээ байгуулах замаар нээлттэй зах зээлээс сонгон шалгаруулалтаар, ил тод байдлаар худалдан авах явдал юм.

3.51 Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр улсын салбарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах зах зээлийн эдийн засагт нийцсэн систем хөгжүүлэх шаардлага хурцаар тавигдсан. Татвар төлөгчдийн буюу нийтийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шударгаар зарцуулах, зарцуулалтыг харилцан тайлагнах, хариуцлагын зарчмыг сайжруулах асуудал нийгмийн амьдралын бүх хүрээг хамарч олон нийтийн зүгээс зүй ёсны хүсэлт, шаардлагатай тулгарсан юм.

3.52 Энэ асуудлыг зохицуулахын тулд Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын (хуучин нэрээр) хамтарсан тушаалаар 1996 онд батлагдсан журмаар зохицуулж эхэлсэн. Гэвч энэхүү журмаар зөвхөн барилга, байгууламжийн объектын гүйцэтгэчийг сонгоход ашиглаж байсан, мөн дээрх журам нь Сангийн сайд болон Дэд бүтцийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан тул холбогдох бүх байгууллагууд ашиглахаар нийтлэг журам болж чадаагүй. Засгийн газрын байгууллагууд бараа, ажил, үйлчилгээг хязгаарлагдмал хүрээнээс буюу тодорхой хэсэг байгууллагуудаас худалдан авч байсан нь татвар төлөгчдийн буюу нийтийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, ил тод байдлаар зарцуулах зарчмыг алдагдуулж байсан юм.

3.53 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, шударга байдлыг хангасан тогтолцоог бий болгож, Засгийн газрын үйл ажиллагаанд шударга, ил тод байдлыг хангах зорилгоор 1999 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банктэй хамтран Засгийн газрын худалдан авах ажиллагааны шинэчлэлийн ажлыг эхэлсэн.

3.54 Улсын хэмжээнд цоо шинээр нэвтрүүлж эхэлж буй энэхүү тогтолцооны үндэс суурийг хөгжүүлэхийн тулд юуны өмнө дараах 3 гол зорилтыг дэс дараатай хэрэгжүүлж байна. Нэгдүгээрт, Засгийн газрын бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохицуулах зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцсэн эрх зүйн орчинг бий болгох, хоёрдугаарт, Засгийн газрын байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах чадавхийг бүрдүүлэх, гуравдугаарт, шинэ тогтолцоонд нийцсэн удирдлага, хяналт, зохицуулалтын бүтцийг бий болгож бэхжүүлэх зэрэг болно.

3.55 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” Монгол улсын хууль 2000 оны 4 сард батлагдсан болон хуулийг дагаж холбогдох дүрэм журам, стандарт бичиг баримтууд боловсруулагдсанаар Монгол улс улсын салбарт хийх худалдан авах ажиллагаанд олон улсын стандартад нийцсэн эрх зүйн орчинг бий болгож, төсвийн хөрөнгийн зарцуулалтад үр ашиг, хэмнэлт, ил тод байдал, шударга өрсөлдөөний зарчмуудыг баталгаажуулсан юм. Хуулийг хэрэгжүүлэх “Бараа, ажлын гүйцэтгэчийг сонгоход баримтлах тусгай журам”, “Зөвлөхийг сонгоход баримтлах тусгай журам”, “Худалдан авах ажиллагаанд оролцогч төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” зэрэг үндсэн журмууд 2000 оны 6-р сард Засгийн газрын 101-р тогтоолоор батлагдсан бөгөөд үүнээс гадна 2001-2003 онд Засгийн газрын тогтоолоор 6 журам батлагдсан. Мөн Санхүү, эдийн засгийн сайдын тушаалаар нийтдээ 15 журам, заавар, жишиг бичиг баримтуудыг боловсруулж батлуулсан. Эдгээр заавар, журам, тендерийн жишиг бичиг барим, хууль, тогтоомж, тусгай журмуудыг амьдралд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байв.

3.56 Ингэснээр тендер шалгаруулалтыг үр ашигтайгаар зохион байгуулах арга, техник, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг мэргэжлийн түвшинд тодорхойлж гаргасан.

3.57 Төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх, төсвийн зарлагыг үр ашигтай хэлбэрт шилжүүлэх зорилгоор батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулинд Засгийн газрын худалдан авах бараа, ажил, үйлчилгээг сонгон шалгаруулалтын журмаар явуулахаар заасан нь хуулийн ач холбогдлыг дахин нотолсон юм.

3.58 Хууль, эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн боловч худалдан авах ажиллагааны хууль, журам, зааврыг хэрэгжүүлэх уламжлалт арга барил, туршлага, бэлтгэгдсэн үндэсний боловсон хүчний чадавхи Засгийн газарт байхгүй байв. Үүний улмаас тэдгээрийг буруу ойлгож дутуу дулимаг хэрэгжүүлэх эсвэл огт хэрэгжүүлэхгүй байх явдал амьдралд гарч, гүйцэтгэгчийг буруу сонгох, зардлыг нэмэгдүүлэх, Засгийн газрын аливаа төслийн хэрэгжилт удаашрах, олон нийтийн дунд Засгийн газрын байгууллагыг шүүмжлэх, санаатай буюу мэдлэг чадвар дутсанаас хууль эрх зүйн аргуудыг зөрчих явдал зарим үед гарч байна. Засгийн газраас худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй, үр ашигтай болгох зорилгоор худалдан авах ажиллагааны талаар бүх шатны төрийн албан хаагчдад сургалт явуулж байна.

3.59 Засгийн газар 2001 оны 9 дүгээр тогтоолоор “Засгийн газрын худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн дагуу Засгийн газрын бүх байгууллагын холбогдох ажилтнуудад 2001-2002 онд анхан шатны болон дунд шатны сургалт явуулснаар худалдан авах ажиллагааны шинэ тогтолцоо, хууль тогтоомжийн талаарх үндсэн мэдээлэл, худалдан авах ажиллагааны арга техник, тендерийн бичиг баримт бэлтгэх, тендер шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээ явуулах, гэрээ байгуулах эрх олгох зэрэг техникийн нарийн асуудлуудыг зааж өгсөн. Хөтөлбөрийн дагуу 2003 оноос гүнзгийрүүлсэн шатны сургалтуудыг зохион байгуулах ажил эхлээд байна.

3.60 Захиалагч байгууллагуудын техникийн болон боловсон хүчний чадавхийг сайжруулах ажлууд хийж байгаагийн дотор ил тод, үр ашигтай мэдээллийн системийг бий болгох ажилд ихээхэн анхаарал хандуулж байна. Энэхүү мэдээллийн систем нь захиалагч байгууллагын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, ялангуяа худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хянаж зохицуулах үйл ажиллагааг сайжруулах, мэдээлэл боловсруулах, солилцох системийг автоматжуулах, шуурхай найдвартай болгоход чиглэгдэх юм. Энэ ажлын хүрээнд СЭЗЯ АХБ-ны ТТ-ны төсөлтэй хамтран дараах программ хангамжийг боловсруулав. Үүнд:

1. Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб-хуудас бий болголоо.
2. Нийлүүлэгч, гүйцэтгэгчдийн бүртгэлийн системийн программ хангамжийг боловсруулав.
3. Худалдан авах ажиллагааны хяналтын систем буюу төслийн удирдлагын мэдээллийн сангийн программ хангамжийн эхний хувилбарыг боловсруулсан.

3.61 Засгийн газар шинэ тогтолцоонд нийцсэн удирдлага, зохицуулалтын болон хяналтын оновчтой бүтцийг бий болгоход чухал ач холбогдол өгч байгаа юм. Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мөн хуулийн хэрэгжилтийг хангах болон түүнд хяналт тавих үүрэг бүхий Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэс (ХААБЗХ)-ийг Засгийн газрын 2001 оны 75 дугаар тогтоолоор СЭЗЯ-ны бүтцэд багтааж байгуулсан.

3.62 ХААБЗХэлтэс нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалттай холбогдсон бүх үйл ажиллагааг хариуцсан мэргэжлийн нэгж бөгөөд худалдан авах ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжоор Санхүү, эдийн засгийн сайдад хариуцуулсан үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд туслах, түүнийг шаардлагатай бодлогын зөвлөгөөгөөр хангаж ажиллаж байна.

3.63 ХААБЗХэлтсийн нэг үүрэг бол гүйцэтгэгч сонгох үйл ажиллагаа/тендер шалгаруулалт/-ны үед гарсан аливаа гомдлыг шүүхийн өмнөх шатанд хянан шийдвэрлэх

юм. Гэвч уг хэлтэс нь хуулийг хэрэгжүүлэх бүтцэд багтаж байгаа нь дээрх үүргийг биелүүлэхэд зарчмын зөрчил үүсэхэд хүргэж байна. Иймээс хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, ХААБЗХ-ийн статусыг бэхжүүлэх зорилгоор Санхүү, эдийн засгийн сайдын тушаалаар 2002 оны 10 дугаар сарын 1-нээс тус хэлтсийн статусыг өөрчилж худалдан авах ажиллагааны бодлого боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлаар сайдын шууд удирдлаганд харьяалуулсан юм.

3.64 Цаашид ХААБЗХ-ийн зохион байгуулалт болон боловсон хүчнийг сайжруулах, тус хэлтсийн үүрэг функц, статусыг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. СЭЗЯ-ны зүгээс хийсэн судалгаагаар Засгийн газрын байгууллагууд сүүлийн 2 жилийн хугацаанд нийтдээ 1371 тендер шалгаруулалт зохион байгуулж 328.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг тендер шалгаруулах замаар худалдаж авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3:4: Худалдан авахын үзүүлэлтүүд

| Он | Тендер шалгаруулалтын тоо | Нийт төсөвт өртөг | /Тэрбум төгрөгөөр/ | |
|-----------------|---------------------------|-------------------|--------------------|-----------------|
| | | | Гэрээний дүн | Зөрүү /үр ашиг/ |
| 2001 онд | 620 | 150.3 | 144.7 | 5.5 |
| 2002 онд | 751 | 178.4 | 170.1 | 8.3 |
| Нийт дүн | 1'371 | 328.7 | 314.9 | 13.8 |

3.65 Дээрх хүснэгтээс харахад Засгийн газрын байгууллагууд 2001-2002 онд худалдан авах ажиллагаа хийхдээ нийтдээ 13.8 тэрбум төгрөгийн үр ашиг гаргасан байна. Захиалагч байгууллагууд барилга, байгууламж, зам, их засвар болон урсгал засварын ажил болон тоног төхөөрөмж, эм, дүрэмт хувцас нийлүүлэх зэрэг худалдан авах ажиллагааг тендер шалгаруулах хэлбэрээр тогтмол зохион байгуулж хэвшжээ. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3:5: Худалдан авахын хэмжээ

| ¹ | Салбарын нэр | /Тэрбум төгрөгөөр/ | | | |
|----|--|--------------------|--------------|--------------|------------|
| | | 2001 | 2002 | Нийт | Хувь |
| 1 | Байгаль орчны салбар | 0.2 | 1.6 | 1.8 | 0.6 |
| 2 | Батлан хамгаалах салбар | 2.7 | 2.7 | 5.4 | 1.6 |
| 3 | Боловсрол, соёл, ШУ-ны салбар | 4.0 | 8.4 | 12.4 | 3.8 |
| 4 | Гадаад хэргийн салбар | 1.5 | 0.4 | 1.9 | 0.6 |
| 5 | Дэд бүтцийн салбар | 96.6 | 118.5 | 215.1 | 65.4 |
| 6 | Нийгмийн хамгааллын салбар | 0.2 | 0.5 | 0.7 | 0.2 |
| 7 | Санхүү, эдийн засгийн салбар | 7.1 | 3.0 | 10.1 | 3.1 |
| 8 | Үйлдвэр, худалдааны салбар | 1.4 | 2.0 | 3.4 | 1.1 |
| 9 | Хууль зүй, дотоод хэргийн салбар | 10.7 | 8.2 | 18.8 | 5.7 |
| 10 | Хүнс, хөдөө аж ахуйн салбар | 1.3 | 4.6 | 5.9 | 1.8 |
| 11 | Эрүүл мэндийн салбар | 0.8 | 2.8 | 3.6 | 1.1 |
| 12 | ТӨҮГ болон төрийн өмчийн оролцоотой ҮГ | 13.6 | 12.8 | 26.4 | 8.0 |
| 13 | Аймаг, орон нутаг | 8.7 | 12.6 | 21.3 | 6.5 |
| 14 | Бусад | 1.6 | 0.4 | 2.0 | 0.6 |
| | Нийт дүн | 150.3 | 178.4 | 328.7 | 100 |

3.66 Хууль батлагдаад 3 жил болж байгаа боловч түүний хэрэгжилт нь шаардлага хангахуйц түвшинд бүрэн хүрээгүй байна. Хуулийн хэрэгжилтийн явцад зарим салбар, байгууллагуудад түүнийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа бөгөөд хуулинд зарим өөрчлөлт оруулах шаардлага гарч байна. Нөгөө талаас худалдан авах ажиллагааны хууль, тогтоомж нь олон улсын жишигт нийцсэн, худалдан авах ажиллагааны үндсэн зарчмуудыг агуулсан сайн хууль болсон боловч худалдан авах

ажиллагааг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулах, хянах болон хариуцлагын тогтолцоог нарийн тусгаагүй сул тал байгаа нь ажиглагдаж байна. Дээр дурдсан сул талууд нь хуулийг амжилттай хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавихад хүндрэл үүсгэж байна.

3.67 Хуулийг хангалттай түвшинд хэрэгжүүлж чадахгүй байгаа нь нэг талаас Засгийн газрын албан хаагчдын мэдлэг чадвар сул, нөгөө талаас хуулийн дээр дурдагдсан сул талуудаас болж байна.

3.68 Иймээс цаашид худалдан авах ажиллагааны тогтолцоог сайжруулах, худалдан авах ажиллагааг үр ашигтай, ил тод байдлыг илүү хангахын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болгох, энэ ажлын хүрээнд хуулинд зохих өөрчлөлтүүдийг оруулж цомхон болгох, түүнд удирдлага, зохион байгуулалт, хяналтын болон хариуцлагын тогтолцоог нарийвчлан тусгаж өгөх, хуулийг дагалдаж гарсан тогтоол, заавар журмуудыг шинэчлэх, хуулийн уян хатан чанарыг тогтоол, заавар, журмуудыг өөрчлөлт оруулах замаар хангаж өгөх, тендерийн хороо түүний бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах нөхцөл, хариуцлагын талаар тодорхой тусгах
2. Хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналтын механизмыг боловсронгуй болгох үүднээс худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтыг хариуцсан бөгөөд хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий ХААБЗХэлтсийн статусыг дээшлүүлж бие даасан мэргэжлийн алба болгох.

3.69 Засгийн газрын байгууллагуудын боловсон хүчний чадавхийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлдэг албан хаагчдыг байнгын сургалтанд хамруулах болон гадаадын мэргэжлийн сургалтын байгууллагуудад сургах замаар мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх.
- Төрийн албан хаагчийг давтан сургах сургалтын программ болон их, дээд сургуулийн мэргэжлийн ангийн сургалтын хөтөлбөрт “Засгийн газрын худалдан авах ажиллагаа” хичээлийг оруулах арга хэмжээ авах.

3.70 Донор орнууд, олон улсын байгууллагуудын зээл тусламжийн хөрөнгөөр Монгол улсад 2001-2002 онуудад 90 орчим тэрбум төгрөгний худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтаар явуулсан байна. Зээл, тусламжийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг явуулж буй Засгийн газрын ажилтнууд тухайн донорын журам, дүрмийг сайн мэдэхгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагаа удаашрах, улмаар төслийн хэрэгжилт саатахад хүргэж байв. Мөн олон улсын байгууллага, донор орнууд өөр өөрийн гэсэн тусдаа худалдан авах ажиллагааны журам, дүрэмтэй байдгаас шалтгаалан худалдан авах ажиллагаа явуулдаг Засгийн газрын ажилтнуудад тэр бүгдийг сурах, онцлогийг нь мэдэхэд цаг алдах, худалдан авах ажиллагааг үр ашигтай, цаг алдалгүй явуулахад хүндрэл учирч байна. Монгол улс зээл тусламж ашиглалтын хувь хэмжээгээрээ Зүүн Өмнөд Ази, Номхон Далайн бүсэд хамгийн доогуурт орж, төслийн хэрэгжилт удааширч байгаагийн нэг гол шалтгаан нь худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулж чадахгүй, хугацаа алдаж байгаагаас болж байгаа юм. Иймд энэ байдлыг өөрчлөхийн тулд Засгийн газрын ажилтнуудыг доноруудын дүрэм, журмын талаар сайн мэдлэгтэй болгох, нөгөө талаар доноруудын худалдан авах ажиллагааны журмыг нэгтгэж нэг журамтай болох нь төслийн хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд нь явуулах гол нөхцөл болох юм.

II. Төрийн сангийн удирдлага.

3.71 Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт: “Төрийн сангийн бэлэн мөнгөний удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлнэ” гэж заасан. Хэдийгээр 1998 онд тэр үеийн Сангийн яаманд төрийн сангийн газар байгуулагдсан боловч 2000 он гэхэд Монгол

улсад төрийн сангийн нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшиж бий болоогүй байв. Төрийн сангийн үүргийг яамд болон банкууд хариуцан гүйцэтгэж байлаа.

3.72 Төсвийн гүйцэтгэлийн чанар муу эсвэл хугацаандаа гардаггүй байснаас шийдвэр гаргах түвшиний шаардлага хангадаггүй байв. Төсвийн хэрэгжилт, төлөвлөлтийг Сангийн яамны төсвийн газар хариуцан гүйцэтгэж байсан нь төсвийн төлөвлөх, хэрэгжүүлэх асуудал нэг газарт төвлөрч, төсвийн ил тод байдал, хяналтыг сулруулж байв.

3.73 Засгийн газрын болон улс, орон нутгийн төсөв, төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог банкууд гүйцэтгэдэг байснаас болж, Засгийн газрын төлбөр хүлээх чадвар суларч, гадаад дотоод өр зээл нэмэгдэх, хугацаа хэтэрсэн зээлийн болон хүүгийн төлбөрт орж, банкны хараат байдал бий болсон байв.

3.74 Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан хуульд заасан хугацаандаа гарч чаддаггүй, Сангийн яамны холбогдох газар нь бүртгэлийн программ хангамжгүй, улсын төсвийн харилцах дансууд олон банкинд тарж байршсан, төрийн сангийн үүрэг төсвийн газарт харяалагдаж байсан зэргээс болж Монгол улсын төсвийн гүйцэтгэлийн тухайн жилийн тайлан дараа жилийнхээ сүүлийн хагаст УИХ-аар батлагддаг байсан төдийгүй зарим үед 9, 10-р сард нэгтгэгдэж дуусаад 10, 11-р сард УИХ-аар хэлэлцүүлж батлуулдаг тохиолдол ч байсан юм. Мэдээлэл хугацаандаа гардаггүй байснаас энэ нь шийдвэр гаргах үйл явцад ач холбогдолгүй болдог байв.

3.75 Төсвийн эрх захирагч нар СЭЗЯамнаас зөвшөөрөл авч бүртгүүлэлгүйгээр арилжааны банкинд олон тооны харилцах данс нээлгэж бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байв.

3.76 2001 онд хийсэн тооллогоор нийт 5475 байгууллагаас 1192 нь нэгээс дээш харилцах данстай байсан бөгөөд энэ нь нийт байгууллагын 21.0 хувийг эзэлж байв. Мөн 5-аас дээш данстай байгууллага 139 байсан ба 11.6 хувийг эзэлж байлаа.

3.77 Төсвийн байгууллагууд дээр төсвөө хэтрүүлэн төлөвлөгөөт бус зардал гаргах асуудал хавтгайрах хандлагатай байв. Тухайлбал, 2001 оны төсвийн гүйцэтгэлээр төсвийн байгууллагуудын эд хогшил худалдан авах зардал төлөвлөснөөс 4.0 дахин, урсгал засварын зардал 2.0 дахин тус тус хэтэрсэн байна.

3.78 ОУВС-тай байгуулсан ЯБӨХ хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газар үр ашигтай төрийн сангийн тогтолцоог бий болгох үүрэг хүлээсэн бөгөөд энэ тогтолцооны гол үндэс нь Төрийн сангийн нэгдсэн дансны арга дээр тулгуурласан төвлөрсөн төлбөр тооцооны зарчим юм.

3.79 ОУВС-гаас зөвлөмж болгосны дагуу Төрийн Сангийн Нэгдсэн Дансны тогтолцоонд шилжих зорилгоор төвлөрсөн төлбөр тооцооны болон тэг үлдэгдэлтэй дансны аргыг Засгийн газрын 2001 оны 132 дугаар тогтоолоор дагуу төвлөрсөн төсвийн 11 байгууллага дээр 2001 он, 2002 оны эхний хагаст туршиж үр дүнг тооцож үзсэн юм. Туршилтын явцад "ТЭГ" үлдэгдэлтэй дансны арга нь Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар батласан "Банк хоорондын клирингийн тооцооны журам"-ын заалттай зөрчилдөж байсан учраас төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хийхэд хэрэглэх бололцоогүй нь тодорхой болсон .

Харин төвлөрсөн төлбөр тооцооны бүртгэлийн дансны арга нь манай орны хувьд хэрэглэх боломжтой төсөвт байгууллагуудын зардлыг нэг бүрчлэн хянах төлөвлөгөөт бус зардал гаргуулахгүй байх нөхцлийг бүрдүүлж байгаагаараа давуу талтай байсан тул уг аргыг нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн .

Уг тогтолцооны гол агуулга нь төсвийн байгууллагуудыг арилжааны банк дахь дансаар бус төрийн сан дээрх бүртгэлийн дансаар дамжуулан төлбөр тооцоо хийх, орлого төвлөрүүлэх

явдал юм. Өөрөөр хэлбэл төрийн сан нь төсвийн хөрөнгийг эрсдлээс хамгаалж, төлөвлөгдөөгүй аливаа зардал гарахаас сэргийлэхэд чиглэгддэг.

3.80 Төсвийн зарлагын удирдлагыг сайжруулах замаар Засгийн газрын бэлэн мөнгөний удирдлагыг боловсронгуй болгох төсвийн шинэчлэлийн хүрээнд СЭЗЯ-ны Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газарт банкны төлбөр тооцооны хэсэг шинээр байгуулан 2002 оны 7-р сарын 1-нээс төсвийн байгууллагын бүх дансыг төвлөрүүлэн төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжин ажиллаж эхэллээ. Энэ арга хэмжээнд 21 аймаг, 331 сум, 9 дүүрэг нийслэл хот, төвлөрсөн болон орон нутгийн төсөвтэй харилцагч 2660 гаруй төсвийн байгууллага хамрагдлаа. Төсөвт байгууллагуудын арилжааны банкуудад байгаа олон харилцах дансыг хааж, Засгийн газрын төвлөрсөн төсөвтэй харилцах бүртгэлийн дансыг тухайн төсөвт байгууллагын нэрээр нээж өгсөнөөр Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.

3.81 Монгол улсын Засгийн газрын тогтоолын дагуу Төрийн сангийн газар байгуулагдаж 2002 оны 7 сарын 1-нээс Улаанбаатар хот, түүний дүүргүүдэд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Төрийн сангийн нэгдсэн дансны системд шилжсэнээр төсвийн дансад байгаа сул чөлөөтэй хөрөнгийг эргэлтэнд оруулах бололцоог бий болгож байгаа төдийгүй бүртгэлийн хяналтыг сайжруулж байна. Энэ нь мөн орон нутгийн санхүүгийн бүртгэл хөтлөлтийн чанарыг дээшлүүлэх, төсвийн болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн сахилгыг дээшлүүлж үр ашиггүй зардлыг бууруулах, хугацаа хэтэрсэн болон шинээр өр үүсэхээр сэргийлэх, төлөвлөгдөөгүй зардал гаргахыг хязгаарлах, төсвийн зардлын хэтрэлтийг бууруулах зэргээр үр дүнгээ өгч эхлээд байна.

3.82 Шинэ систем нь СЭЗЯ-нд төсвийн хуваариалт, санхүүжилтийн хэт төвлөрөлөөс сэргийлэх ба холбогдох хууль тогтоомжоор баталгаажина. Төрийн сангийн хэлтсийг орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд байгуулах бөгөөд төсөв батлах, хэлэлцэх, шийдвэр гаргах эрхийг нь Төсвийн тухай хуулиар баталгаажуулна.

3.83 2002 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс нийт 21 аймгийн төрийн сангийн хэлтэст төлбөр тооцооны “Оракли” системтэй ажилладаг программ хангамж суурилуулж, тэднийг төв төрийн сантай “Диал-ап” сүлжээгээр холбож, төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог гийцэтгэж байна.

3.84 ТСНДансны тогтолцоонд шилжсэнээр дараахи үндсэн 4 давуу тал гарч байна. Үүнд:
1-рт: Татвар төлөгчдөөс хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт төлсөн хөрөнгө төсвийн хуулийн хэрэгэнд зарцуулагдаж буй эсэхийг шууд хянадаг болов. Үүний үр дүнд төлөвлөгөөт бус зардал гаргаж төсөв хэтрүүлэх, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах зэрэг санхүүгийн зөрчлийг багасгах нөхцөл бүрдсэн.

2-рт: Төсвийн төлөвлөлтийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Төсвийн байгууллагын бодит хэрэгцээ, өөрийн орлогыг үнэн зөв тодорхойлж төлөвлөх шаардлага бий болсон. Өөрөөр хэлбэл төсвийн төлөвлөлтөнд гарч буй алдаа бидэнд тодорхой болсон.

3-рт: Төсвийн гийцэтгэлийн мэдээ, тайланг богино хугацаанд үнэн зөв гаргах нөхцөл бүрдсэн. Үндсэндээ төсвийн байгууллагын төсвийн гийцэтгэлийн сарын мэдээ төрийн сан дээр шууд гарах боломж бий болов.

4-рт: Төсвийн бэлэн мөнгөний төлөвлөлт, удирдлага эрс сайжирсан байна. Төвлөрсөн төсвийн байгууллагуудын дансны үлдэгдлийг төсвийн хэрэгжилтийг хангахад ашиглаж байна.

3.85 Одоо орон нутгийн төрийн сангийн хэлтсүүд, тэнд ажиллаж байгаа төсөвт байгууллагууд, сумдын төрийн сангийн төлөвлөгч, нягтлан бодогч нар программ хангамж, сүлжээний асуудлаа шийдвэрлүүлэхээр санал хичээлт тавьж байна.

Төрийн сангийн тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр дунд хугацаанд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. **Засгийн газрын мөнгөн хөрөнгийн бүх үйл ажиллагааг Монголбанк дахь Төрийн Сангийн Нэгдсэн Дансанд хамруулах ажлыг дуусгана.**
 - Нийгмийн даатгалын сангууд болон үйл ажиллагааны данс
 - Засгийн газрын харьяа агентлагууд
 - Гадаад зээл тусламжийн тусгай данс
2. **Мөнгөн хөрөнгийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрэн хэрэгжүүлнэ.**
 - Санхүүгийн төлөвлөлтийг сайжруулах
 - Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх
 - Бүтээгдэхүүн ажил үйлчилгээ худалдан авалт дээр үндэслэсэн төсвийн хуваарилалтын шинэ журмыг хэрэгжүүлэх
3. **Төсвийн хяналтыг сайжруулна.**
 - Төсөв бэлтгэх, хэрэгжүүлэх ажилд оролцох төсвийн ерөнхийлөн захирагчдын үүргийг дээшлүүлэх
 - Төсөвт байгууллагын санхүүгийн тайлагнал болон дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой алхам хийх
 - Төсөвт байгууллагуудад амлалтын болон зардлын хяналтыг сайжруулах
4. **Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг ОУНББСтандартад нийцүүлэх ажлыг эрчимжүүлнэ**
 - Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг тайланд бүрэн тусгах
 - Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах
 - Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийж, бүртгэлд тусгах
 - Зардлын бүртгэлийг хэрэгжүүлэх
5. **Төрийн сангийн иж бүрэн компьютержсэн программ хангамж нэвтрүүлнэ.**
 - Завсарын программ хангамжийг бололцоотой сумдад нэвтрүүлэх
 - Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийг төв болон орон нутгийн төрийн сангуудад бүрэн нэвтрүүлэх
 - Төв төрийн сангийн одоо ашиглаж байгаа программд тйшиглэн төрийн сангаар ййлчлйлгчдийн гадаад телбер тооцоог гййцэтгэх асуудлыг 2003 оны 1 дйгээр улиралд багтаан шийдвэрлэх
 - Эрчим хичний найдвартай эх ййсвэр бйхий сумдын төрийн сангийн хэлтсийг аймгийн төрийн сангийн хэлтэстэй нь сйлжээгээр холбох асуудлыг 2003 оны 4 дйгээр сараас хэрэгжйлж эхлэх
 - Төв төрийн сан болон аймгийн төрийн сангийн хэлтсээр дамжуулан телбер тооцоогоо хийдэг төсөвт байгууллагуудыг тухайн төрийн сантай нь сйлжээгээр холбох
 - Төрийн сангийн телбер тооцооны программ хангамжийн ййл ажиллагааг “Онлайн” горимд шилжйллэх бэлтгэл ажлыг хангах
 - Орон нутагт бэлэн менгений гййлгээ эрхлэх боломжийг судалж, санал боловсруулах
 - Цалин, тэтгэвэр, тэтгэмж олголтыг картын системд шилжүүлэх асуудлыг судалж санал боловсруулах

3.86 Ийнхүү дунд хугацаанд төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог бэхжүүлж, үйл ажиллагааг шуурхай болгож, төсвийн хөрөнгийн зарцуулалт, тайлагналтын ил тод байдлыг хангана. Ингэснээр бас ядуучуудад очих хөрөнгийн бүртгэл мэдээ тодорхой болж, эх үүсвэр нь нэмэгдэн, ил тод болно.

3.87 Улаанбаатар хотын захиргаанаас дээр дурьдсан зорилтуудыг биелүүлэх бөгөөд, тухайлбал төсвийг төлөвлөхөөс авахуулаад төсөв хэлэлцэх, батлах, эх үүсвэр зарцуулах, тайлагнах зэргийг төсвийн үйл явцыг нэгдсэн төрийн сангийн удирдлагын тогтолцоогоор хооронд нь нягт уялдаа холбоотой болгох юм. Үүний зэрэгцээ гар ажиллагааг багасгах бөгөөд төсвийн гүйцэтгэл, санхүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн оролцоог өргөжүүлж, хяналт, шинжилгээ, хэрэгжилтийн үйл явцыг ил тод болгох болно.

III. Төлбөрийн тэнцэл

3.88 *Худалдааны тэнцэл.* 1997 онд манай гадаад худалдааны тэнцэл эерэг гарснаас бусад жилүүдэд худалдааны тэнцэл алдагдалтай гарч байв. 2001 он хүртэл худалдааны тэнцлийг тооцохдоо импортын үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний импортыг нийт импортод оруулдаг байв. Гэвч гаалийн импортын мэдээний хамрах хүрээ сайжирсанаар энэхүү зохицуулалтыг 2002 оноос 5 хувь болгож бууруулан, 2003 оноос тэг болгох юм.

3.89 Экспортолсон бараа, үйлчилгээний ДНБ-нд эзлэх хувь 1993 онд хамгийн их буюу 93.1 хувь, импорт нь 96 хувь байсан ба дараа онуудад буурч 1995 онд хамгийн бага буюу экспорт 43.7 хувь, импорт 44.8 хувь тэнцэж, цаашид импорт экспорт хоёул өсч байсан ч, импортын өсөлт илүүтэй байж, 2002 оны эцэст урьдчилсан байдлаар экспорт нь 63.9 хувь, импорт 85.4 хувьтай тэнцэж байна.

3.90 Манай бараа, үйлчилгээний худалдааны тэнцэлийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ сүүлийн жилүүдэд нэлээд өссөн бөгөөд 2002 онд хамгийн өндөр буюу урьдчилсан дүнгээр-20.6 хувьд хүрээд байна. 1997 онд энэ дүн 2.6 хувь гарч ДНБ-нд эерэг нөлөө үзүүлж байжээ. Энэ нь тухайн онд манай улсын гадаад эдийн засгийн орчин тааламжтай байж, манай гол нэрийн экспортын бүтээгдэхүүн зэс /211.4 сая ам.доллар/ мөн алтнаас/117.0 сая ам.доллар/ олсон орлого өндөр байсантай шууд холбоотой байв. Сүүлийн жилүүдэд манай уламжлалт нэр төрлийн барааны экспорт буурч, экспортын орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг гол нэрийн бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн уналт, гадаад эрэлт буурсантай холбоотойгоор экспортын орлого буурсан байна. Нөгөө талаас манай улс Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орон болсноор импортын тарифыг бага түвшинд байлгаж, худалдааг нээлттэй чөлөөтэй байлгах бодлого баримтлан, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлоготой уялдаад импортын хэмжээ нэмэгдэж байгаагаас худалдааны алдагдал нэмэгдэж ирлээ.

3.91 Үйлчилгээний эргэлт 1993 онд 55.5 сая ам.доллар байсан бол 1997 онд 107.5 сая ам.доллар, 2002 оны урьдчилсан дүнгээр 378.4 сая ам.долларт хүрч 1997 оныхоос даруй 3.6 дахин өссөн байна. Энэ нь манай аялал жуулчлалын салбарын орлого нэмэгдсэн, мөн харилцаа холбоо, даатгал, санхүүгийн үйлчилгээ, зорчигч болон агаарын тээврийн үйлчилгээ хурдацтай хөгжих хандлагатай болсон, эдийн засгийг либеральчилсаны үр дүн юм.

3.92 Монголоос гадаадад суралцагчдын тоо нэмэгдэж байна. Тэд цаг заваараа ажил хийж хэрэглээгээ хангахаас гадна гэр бүлдээ мөнгө гуйвуулж байна. Гадаадад ажиллаж, амьжиргаагаа сайжруулах нь элбэг болж хувийн гуйвуулга ихээр хийх болж, банкуудын үйлчилгээний хүрээ өргөжин, шинэ төрлийн үйлчилгээнүүдийг богино хугацаанд шуурхай нэвтрүүлж байна. Энэ талын статистик бүртгэл, тайлагналт ч сайжрав. 2002 онд 64.4 сая ам.долларын хувийн шилжүүлэг хийгдсэн нь 1993-1995 он хүртэл бараг байхгүй байсан үеийнхийг бодвол хүмүүсийн амьжиргаанд ихээхэн хувь нэмэр болж байна. Цаашид ч энэ шилжүүлэг нэмэгдэх хандлагатай байж дунд хугацаанд 70.0 сая ам.доллараас багагүй байхаар тооцож байна.

3.93 Шилжүүлгүүд нь манай урсгал дансны алдагдлын тодорхой хувийг нөхөж байна. Албан ёсны буцалтгүй тусламж 1997 онд хамгийн бага буюу 47.7 сая ам.доллар, 2001 онд хамгийн их 107.4 сая ам.долларыг авч ашигласан бөгөөд бусад жилүүдэд авч ашигласан ашиглалтын зөрүү, хэлбэлзэл бага байлаа. Дунд хугацаанд бага зэрэг буурах хандлагатай байхаар тооцож байна.

3.94 Хувийн шилжүүлэг мөн албан ёсны тусламж болон бусад албан ёсны шилжүүлэг зэрэг нь шууд орлого болж нэг талт бичилтээр бичигддэг. Иймээс гадаад эдийн засгийн харилцааг бодитоор харахын тулд эдгээр шилжүүлгийг урсгал данснаас хасах нь зүйтэй гэж зарим эдийн засагчид үздэг. Урсгал тэнцлийг албан шилжүүлгийг хассанаар тооцвол 1993-2002 оны хооронд 1997 оноос бусад жилд алдагдалтай гарч байна. Жишээ нь 1993

онд ДНБ-ний -7.7%, 1997 онд 1.9%, 1999 онд -13.2%, 2002 оны урьдчилсан дүнгээр ДНБ-ний -16.1 %-тай тэнцэж байв. Дунд хугацаанд буюу 2006 онд урсгал дансны алдагдлыг ДНБ-ий -11.5% хүртэл буурахаар тооцож байна.

3.95 Урсгал дансны тэнцэл, албан шилжүүлгийг оролцуулаад 1993-1997 онуудад 1996 оноос бусад жилд нь ашигтай гарч байснаа 1998 оноос хойш алдагдалтай гарах болсон. 1997 онд урсгал дансны тэнцэл албан шилжүүлгийг оролцуулаад ДНБ-ий 6.2 хувь байсан бол 2002 оны урьдчилсан дүнгээр ДНБ-ий -9.5 хувь болж буурсан байна.

3.96 Ингэж алдагдалтай гарах болсон нь албан ёсны шилжүүлгийн хэмжээ нэмэгдсэн ч гадаад худалдааны тэнцэл маань алдагдалтай гарч байснаас шалтгаалж байна. Цаашид худалдааны тэнцэл сайжирснаар урсгал дансны алдагдлыг багасгах дунд хугацаанд ДНБ-ий 6-7 хувь орчим байх төлөвтэй.

3.97 Хөрөнгийн данс. Улс орны өрийн дарамтыг бууруулах, авсан зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулах чиглэлээр Засгийн газраас гол зээлдүүлэгч түншүүдтэй хамтын ажиллагаа, яриа хэлэлцээг өргөжүүлж байна. Монгол Улсын Засгийн газар гадаадын зээл, тусламжийн зохицуулалтыг боловсронгуй болгоход онцгой анхаарал тавьж ажиллаж байна. Сүүлийн 10 жилийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд 1994-1995 оны хооронд хөрөнгийн данс алдагдалтай гарч байсан бол 2002 онд 157 сая ам. долларт хүрсэн байна. 1993 онд хөрөнгийн данс 4.2 сая ам.доллар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 7.7 сая ам.доллар байв. Энэ үед Монгол улс 60.9 сая ам.долларын гадаад зээл ашиглаж, 21.5 сая ам.долларын өрийн төлбөр хийж байсан бөгөөд богино хугацааны хөрөнгө -42.9 сая ам.доллартай тэнцэж байв. Харин 1994 онд хөрөнгийн данс 39.0 сая ам.долларын алдагдалтай байсан бөгөөд үүнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үндсэн өрийн төлбөр 52.3 сая ам.доллар, богино хугацааны хөрөнгө -52.8 сая ам.доллар байв. Хөрөнгө данс 1995 онд -16.9 сая ам. долларт тэнцэж байв. Түүнчлэн 18.7 сая ам.долларын урт болон богино хугацааны хувийн зээл авсан байна. Харин шууд хөрөнгө оруулалт 9.8 сая ам.доллар болж нэмэгджээ. 1996 онд хөрөнгийн данс 41.3 сая ам.долларын тэнцэлтэй байсан ба Монгол улс 84.2 сая ам.долларын гадаадын зээл ашиглаж, 39.4 сая ам.долларын зээлийн өрийг төлсөн байна. Хөрөнгийн дансны тэнцэл 1997 онд 27.0 сая ам.доллар болсон байна. Гадаадын зээлийн ашиглалт хамгийн өндөр түвшиндээ буюу 142.2 сая ам.долларт хүрсэн байна. Мөн богино хугацааны хөрөнгө хамгийн их буюу -77.3 сая ам.доллар хүрч, эдийн засгийн тэнцвэрт муугаар нөлөөлж байв. Хөрөнгийн дансны тэнцэл сайжирч 1998 онд 128.6 сая ам.долларт хүрсэн бөгөөд Монгол улс 101.2 сая ам.долларын гадаадын зээл ашигласан байна. Мөн гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид төлсөн хувийн салбарын урт болон богино хугацааны зээлийн төлбөр 21.2 сая ам.доллар байв. Богино хугацааны хөрөнгийн урсгал тухайн жилд 4.5 сая ам.доллар болж тогторжсон. Хөрөнгийн дансны тэнцэл 1999-2001 он хүртэл аажмаар нэмэгдэж 69.1-109.0 сая ам.долларт хүрсэн бол 2002 онд хамгийн өндөр буюу 157.0 сая ам.доллар болсон байна.

3.98 Монгол улс 2002 онд 87.1 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашигласны дотор эдийн засгийн үйл ажиллагаагаар нь авч үзэхэд, холбооны салбар 23.4 хувь, үйлдвэр, барилгын салбар 1.8 хувь, уул уурхайн салбар 15.8 хувь, хөдөө аж ахуйн салбар 1.9 хувь, тээврийн салбар 16.1 хувь, эрчим хүчний салбар 7.3 хувь, эдийн засгийн бусад салбарт 22.1 хувь тус тус ногдож байна. Нийгмийн үйлчилгээнд 10.0 сая ам.доллар ногдож байна.

3.99 Энэ жил 21.5 сая ам.долларын өрийг барагдуулсны 19.5 хувь нь ОХУ-д, 13.9 хувь нь Японд, 5.1 хувь нь Германд хийсэн төлбөр байна. 2002 оны байдлаар манай улсын гадаад өрийн хэмжээ нь 984.9 сая ам.доллар байна.

3.100 Засгийн газрын шугамаар ашиглагдсан зээлийн дийлэнх хэсгийг буюу 30.4 хувийг АХБ, 16.5 хувийг Дэлхийн банк, 18.5 хувийг БНСУ, 16.0 хувийг Япон улс тус тус эзэлж байна.

3.101 Аж ахуйн нэгжүүд болон бусад байгууллагын шугамаар 98.2 сая ам.долларын урт ба дунд хугацааны зээл гадаад орон, олон улсын байгууллагуудаас орж ирсэн байна.

3.102 Гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээгээр Монгол улсад 2002 онд 172.5 сая ам.долларын хөрөнгө оруулахаар бүртгүүлсний дотор БНХАУ-ын оролцоотой компаниуд 134.8 сая ам.доллар, БНСУ-ын оролцоотой компаниуд 14.9 сая ам.доллар, Канадын оролцоотой кампаниуд 5.9 сая ам.долларын хөрөнгө оруулахаар эрхийн гэрчилгээ авсан байна.1990-2002 оны хооронд хамтарсан буюу дагнасан хөрөнгө оруулалттай нийт 2399 компани шинээр байгуулагдсаны дотор 2002 онд 387 компани шинээр бүртгүүлсэн байна. Үүнээс худалдаа, нийтийн хоолны салбарт 121 компани, аялал жуулчлалын салбарт 21 компани, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт 34 компани бүртгүүлжээ. Гадаадын нийт хөрөнгө оруулалтын 51.9 хувь нь худалдаа, барилгын салбарт, 23.1 хувь нь уул уурхайн хайгуул, судалгаа, олборлолтод зарцуулагдсан байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ хөрөнгө оруулалтыг урамшуулах бодлоготой уялдан 2001 оноос нэмэгдсэн байна.

3.103 **Нийт тэнцэл.** Сүүлийн 10 жилийн гүйцэтгэлээс харвал 1996, 2001 онуудад нийт төлбөрийн тэнцэл сөрөг бусад жилүүдэд эерэг дүнтэй байна. Төлбөрийн тэнцлийг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр ОУВС-ын аргачлалаар тооцож байна. Цаашид хөрөнгийн дансны үзүүлэлтүүд огцом өөрчлөлтгүй байж, урсгал тэнцлийн алдагдал багассанаар нийт тэнцлийг эерэг байлгахар тооцоолж байна.

3.104 **Санхүүжилт.** Төлбөрийн тэнцлийн алдагдлыг гадаад валютын нөөц болон ОУВС-ын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг.

Хүснэгт 3:6: Монгол улс: Төлбөрийн тэнцэл 1993-2002

| | 1993 | 1994 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|---|-------|-------|-------|------|-------|-------|--------|-------|-------|--------|
| Гадаад худалдааны тэнцэл | -12.2 | -12.2 | -12.8 | 87.4 | -30.4 | 120.1 | -113.1 | 140.1 | 169.9 | -228.8 |
| Урсгал дансны тэнцэл албан ёсны шилжүүлгийг оролцуулаад | 38.5 | 46.2 | 38.9 | 36.9 | 68.0 | -75.5 | -57.8 | -69.9 | -61.7 | -105.0 |
| Хөрөнгийн данс | 4.2 | -39.0 | -16.9 | 41.3 | 27.0 | 128.6 | 69.1 | 89.8 | 109.9 | 157.5 |
| Нийт төлбөрийн тэнцэл | 31.0 | 3.8 | 33.4 | 22.5 | 54.8 | 1.6 | 40.9 | 1.0 | -15.9 | 66.5 |

3.105 Дунд хугацаанд гадаад худалдааны алдагдлыг ДНБ-ний -10.0 хувьд хүртэл буурахаар тооцоолж байгаа бөгөөд энд үйлдвэрлэлийн өсөлт болон засгийн газраас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны өргөжилт, дэлхийн зах зээл, гадаад орчны тааламжтай байдал зэргийг гол нөхцөл болгон авч үзэж байна. Экспортыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах макро эдийн засгийн тогтвортой байдал чухал ач холбогдолтой юм. Дотоод таатай орчин бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авна. Үүнд:

- Нэмүү өртөг өндөртэй, шинэ технологид түшиглэсэн оюуны багтаамж өндөртэй экспортын үйлдвэрлэлийг дэмжих
- экспортын барааны сурталчилгаа, зах зээлийн судалгаа, шинжилгээний чадавхи, мэдээллийг сайжруулах, экспортын салбарын технологийн мэдээллийн сан, технологи дамжуулах төвүүд байгуулах, үүнд хувийн хэвшлийн үүсгэл санаачилга, оролцоог нэмэгдүүлэх

- Монгол банк, арилжааны банкуудын хамтын ажиллагааг сайжруулж зээлийн үр дүнтэй бодлого явуулах
- экспортын шинэ зах зээлд гарахад чиглэсэн арга хэмжээг авах, татварын хуулийн хэрэгжилтийг хангах замаар гадаад худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх
- Экспортын бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж олон улсын стандартыг мөрдүүлэх

3.106 Төлбөрийн тэнцлийн хөрөнгийн дансны удирдлагыг сайжруулах зорилгоор өрийн удирдлагыг улам боловсронгуй болгож, гадаад зээл тусламжийн ашиглалтыг сайжруулна. Ялангуяа Засгийн Газар болоод мөнгө санхүүгийн байгууллагууд дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад бодлогын бичиг баримтуудад тусгагдаагүй нөхцөлд ямарваа нэгэн төсвөөс гадуурх санхүүгийн үйл ажиллагааг хийхгүй. Нягтлан бодох бүртгэлийн тайлангийн систем олон улсын стандартын дагуу хийгдэх болно. Хандивлагчдын үйл ажиллагааг илүү сайн удирдаж зохицуулахын тулд хөгжлийн албан ёсны тусламжийн талаарх хууль зүйн орчныг бий болгож төсөв, гадаад өрийн тогтвортой байдалтай уялдуулан хөгжлийн болон гадаад санхүүжилтийн тэргүүлэх чиглэлийг оновчтой тодорхойлно. Улсын салбарын шинэчлэлтэй уялдан төсөв, өрийн удирдлага сайжирсан нөхцөлд Монгол улсын гадаад өр удирдахуйц түвшинд тогтвортой байхаар байна. Шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх хандлагатай байна. Улс орны хөгжлийн чиг хандлагыг урт хугацаанд тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, “Мянганы зам”-ын төсөл зэрэг томоохон арга хэмжээнүүд нь хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход суурь баримт бичгүүд болж байна. Төрөл бүрийн судалгаанаас харахад аялал жуулчлал, тээвэр, холбоо, банк, даатгал мэргэжлийн болон бизнесийн үйлчилгээний салбар нь гадаадын хөрөнгө оруулалтын гол талбар болохоор байгаа ба эдгээр салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого зохицуулалтанд ойрын үед онцгой анхаарал тавина.

Хүснэгт 3:76: Цаашдын хандлага 2003-2006

| | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|---|-------------|-------------|-------------|-------------|
| Худалдааны тэнцэл | -215.5 | -198.9 | -195.7 | -210.2 |
| Урсгал тэнцэл, албан шилжүүлгийг оруулаад | -106.9 | -92.5 | -91.4 | -101.5 |
| Хөрөнгийн тэнцэл | 115.2 | 117.3 | 122.6 | 131.1 |
| Нийт тэнцэл | 8.2 | 25.0 | 31.4 | 29.3 |

3.107 **Тулгамдсан асуудлууд** .Олон улсын байгууллага болон гадаад орнуудаас хувийн хэвшлийн болон бусад байгууллагуудад өгсөн зээлийг тооцох нь бэрхшээлтэй бөгөөд үүнийг шийдэхэд аж ахуйн нэгж, байгууллагууд нь жилийн тайландаа гадаад улс болон олон улсын байгууллагуудаас авсан зээлийг харуулдаг болгох замаар шийдвэрлэнэ. Энэ мэдээллийг цаашид боловсруулж, бүртгэн, тоймлож тайлан гаргах хэрэгтэй байна.

3.108 Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Гадаадын хөрөнгө оруулалтын агентлагаас өгсөн мэдээгээр тодорхойлогддог. Ерөнхийдөө энэ мэдээлэл нь тэдгээр аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулах лиценз авахаар бүртгүүлдэг мэдээллээс гардаг. Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалтыг тооцох нь бэрхшээлтэй бөгөөд үүнийг шийдэхийн тулд бүх оролцогч талууд хамтран ажиллаж мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох шаардлагатай байна.

3.109 Төлбөрийн тэнцлийн тооцоо нь давхар бичилтийн системд үндэслэн хийгддэг бөгөөд гарч байгаа болон орж байгаа хөрөнгийг ойролцоогоор тэг гэж тооцсоноор таамаглал алдаатай болдог. Гэсэн хэдий ч бодит байдалд статистик мэдээллийн дутагдалтай байдал болон оновчтой бус байдлаас үүдэн алдаа гарч байна. Жишээ нь, гаалийн мэдээгээр гадаадын хөрөнгө оруулалтаар импортлож байгаа бараа, зээл тусламж нь бүртгэгдсэн хэмжээнээсээ гол төлөв зөрдөг. Хэдийгээр гадаадын хөрөнгө оруулалт нь орж ирэхээсээ өмнө зөвшөөрөл авдаг ч ихэнх тохиолдолд зөвшөөрөгдсөн хэмжээнээсээ бага хэмжээгээр орж ирдэг нь мөн алдаа гарахад хүргэдэг. Мөн цуглуулж байгаа мэдээлэл

нь хязгаарлагдмал хүрээг хамардаг. Нөгөөтэйгүүр хувийн хэвшил дэх гадаадын зээл тусламж нь бүрэн хэмжээгээр бүртгэгддэггүй.

3.110 Гадаад эдийн засгийн удирдлага. Аливаа хөгжиж буй бусад орны нэгэн адил Монгол улс хөгжлийн өнөөгийн үе шатанд дутагдаж байгаа хөрөнгийн эх үүсвэрийг нөхөх үүднээс гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглан эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж хүн амын тогтвортой амьжиргааг хангах нөхцөлийг бүрдүүлж байна. 1990-ээд оноос хойш Монгол Улсын Засгийн газар 2.1 тэрбум ам. долларын зээл, тусламжийг гадаад орнууд, олон улсын байгууллагаас авч ашигласны 48.0 хувь нь хөнгөлөлттэй зээл байна. Монгол улс 1991 оноос 2002 оны эцэс хүртэл нийт өссөн дүнгээр 1.25 тэрбум ам.долларын зээлийг авч ашиглаад байгаагаас 265.3 сая ам.долларын үндсэн өрийн төлбөр, 86.3 сая ам.долларын хүү болон шимтгэлийн төлбөр төлөөд байна.

3.111 2002 оны эцсийн байдлаар Монгол улс гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудад төлөх 984.9 сая ам.долларын үндсэн өрийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2002 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ний 88.9 хувьтай тэнцэж байна.

Зураг 4.




Олон улсын зарчмын дагуу өрийн дарамтыг тодорхойлдог өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн гадаад өрийн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2002 оны эцэст 58.4 хувь байна. Монгол улсын гадаад өрийн үлдэгдлийн бүтцэд Азийн хөгжлийн банкинд төлөх өр 37.4 хувь, Японд 22.7 хувь, Дэлхийн банкинд 18.3 хувь, Германд 6.2 хувь, ОУВС-нд 4.3 хувь тус тус эзлэж байна.

Монгол улсын гадаад өрийн үлдэгдэл сүүлийн 10-н жилд хэрхэн нэмэгдэж

ирсэнийг дээрх зурагт харууллаа.

Түүнчлэн Монгол улсын нийт гадаад зээлийн үлдэгдлийн 38.4 хувь нь хоёр талын хөнгөлөлттэй зээл, 57.3 хувь нь олон талын хөнгөлөлттэй зээл, 4.3 хувь нь Олон улсын валютын сангийн зээл байна. (Зураг 5-т үзүүлэв).

Зураг 5.




3.112 Монгол улсын Засгийн газар 2002 онд 104.6 тэрбум төгрөг ашиглахаар төлөвлөснөөс 98.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийг хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авч ашиглалаа. Төслийн зээлийн төлөвлөгөөний биелэлт 98.5 хувь байна. 2002 онд нийт авч ашигласан зээлийн 67.3 хувь буюу 65.9 тэрбум төгрөгийг төслийн, 16.1 хувь буюу 15.8 тэрбум төгрөгийг авто замын зориулалтаар, 16.6 хувь буюу 16.3 тэрбум төгрөгийг санхүүгийн хөтөлбөрийн

зориулалтаар тус тус авч ашиглалаа. Гадаад зээлийн ашиглалтыг зориулалтаар нь зураг №6-т үзүүлэв.

Зураг 6.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЗЭЭЛИЙН 2002 ОНЫ АШИГЛАЛТЫН БҮТЭЦ




Монгол улсын гадаад өрийн үлдэгдлийг тухайн зээлийг зарцуулсан эдийн засгийн салбарын ангилалаар авч үзье.


Зураг 7.

График4. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЗЭЭЛИЙН 2002 ОНЫ ҮЛДЭГДЛИЙН БҮТЭЦ


(ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛААР)



НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН БҮТЭЦ




3.113 Дээрх Зургаас харахад зээлийн дийлэнх хэсгийг эдийн засгийн үйл ажиллагаанд зориулж авсан байна. Үүний дотор тээвэр, эрчим хүч, уул уурхайн салбарт илүү их зээл авч ашиглажээ.

3.114 **Гадаад өрийн үйлчилгээ.** Монгол улс хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудад 1991 оноос хойш авч ашигласан зээлийнхээ үйлчилгээний төлбөрт нийтдээ 265.3 сая ам.долларыг үндсэн өрийн төлбөрт, 86.3 сая ам.долларыг хүү болон шимтгэлийн төлбөрт төлөөд байна. Эдгээр үйлчилгээний төлбөрийг зээлийн үндсэн валютаас 2002 оны жилийн эцсийн ханшаар ам.долларт шилжүүлэн зэрэгцүүлснийг Зураг 8-д харуулав.

График5. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

(сүүлийн арван жилд)



Тайлбар: 2002 оны жилийн эцсийн ханшаар ам.долларт шилжүүлэн зэрэгцүүлэв.

Зураг 8.

3.115 Уг зургаас харахад Монгол улсын гадаад зээлийн үйлчилгээний төлбөр 1992-1997 онууд ихээхэн өндөр байсан нь 1990-ээд оны эхээр өндөр хүүтэй, богино хугацааны арилжааны зээлүүд авч ашигласан бөгөөд тэдгээрийн төлбөр ихээхэн дарамт бий болгож байсныг харуулж байна. Монгол улс цаашид арилжааны зээл авахгүй байх нь чухал юм.

3.116 Монгол улс 2002 онд гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудад ашигласан зээлийн төлбөртөө 12.8 тэрбум төгрөгийн хүү, 24.2 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, нийтдээ 37.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төлбөрийг тухайн зээлийг авсан үндсэн валютуудаар нь төллөө. 2002 онд нийтдээ 9-н зээлийн үндсэн төлбөр шинээр төлөгдөж эхэлж байгаатай холбоотойгоор төлбөрийн хэмжээ 4.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2002 оны нийт өрийн үйлчилгээний дийлэнх хэсгийг Олон улсын валютын сан (25.0%), Япон (21.1%), Оросын Холбооны Улс (18.7%), Азийн хөгжлийн банк (10.9%)-ны төлбөр тус тус эзэлж байна. Монгол улс гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр авч ашигласан зээлийн төлбөрөө цаг хугацаанд нь төлж барагдуулж байна.

3.117 ОХУ-ын урсгал өрийн төлбөрт 2002 онд 10.2 сая ам.доллараас валютаар төлөх 6.1 сая ам.долларыг төлсөн бөгөөд бараагаар төлөх 4.1 сая ам.долларыг ОХУ-ын талын тендерийн үйл ажиллагаанаас үүдэн хойшлогдож байгаа бөгөөд 2003 оны эхний улиралд төлөхөөр болсон. Ийнхүү Монгол улс 2002 онд хугацаа хэтэрсэн гадаад өргүй боллоо. Одоогоор өрийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүд боломжийн түвшинд байна гэсэн судалгаа байгаа боловч гадаадын зээл, тусламжийн ашиглалтын асуудал эдийн засгийн удирдлагын гол асуудлын нэг байсаар байна. Монгол улсын Засгийн газар гадаад өрийн удирдлагыг сайжруулах зорилгоор 2001 онд СЭЗЯ-ны Төрийн сангийн удирдлага зохицуулалтын газарт Өрийн удирдлагын хэлтсийг байгуулж 1990-ээд оноос хойш авсан зээлийн хэлэлцээрүүд, дамжуулан зээлдүүлэх гэрээг нэг бүрчлэн бүртгэн авч мэдээллийн нэгдсэн сан байгуулж ажиллаж байна. Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас Монгол улсын Засгийн газрын ашигласан зээлийн 73 орчим хувь буюу 912 сая ам.долларыг дотооддоо дамжуулан зээлдүүлсэн байна.

3.118 Гадаад зээлийн төлбөрийг эргүүлэн төлөхөд дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн орлого ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Гэтэл гадаад зээлийн төлбөрийг дотоодоо дамжуулан зээлдүүлсэн зээлийн буцаан төлбөрийн орлогоор нөхдөг зарчим төдийлан хангалттай биш байна. Гэхдээ дамжуулан зээлдүүлэлтийн эргэн төлөлт сүүлийн үед сайжирч зөвхөн 2002 он гэхэд л 5.5 сая ам доллар эргэж төлөгдсөн байна. Дэлхийн банкны төсвийн техник туслалцааны төслийн хүрээнд 2001 онд өрийн удирдлагын санхүүгийн программ хангамжийн олон улсын тендерийг зарлан шалгарсан НҮБХХ-тэй 2001 оны 6-р сард гэрээ байгуулсан. 2001 оны 9 дүгээр сараас эхэлж НҮБХХ-өөс программыг суурилуулж эхэлсэн. Төслийн эхэнд мэдээллийн баазыг бүрэн оруулж дуусгах ёстой байсан бөгөөд энэхүү ажлыг 8 сарын хугацаанд хийж дуусган улмаар 2002 оны 5 дугаар сард мэдээллийн баазын мэдээллийг урьдчилсан байдлаар бүрэн бүрдүүлж дууссан. НҮБХХ-өөс энэ төслийг маш амжилттай хэрэгжсэн төслүүдийн тоонд оруулдаг бөгөөд энэхүү төсөл богино хугацаанд амжилттай хэрэгжихэд Санхүү, эдийн засгийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн хүчин чармайлт ихээхэн нөлөөлсөн. Өрийн удирдлага, Санхүүгийн Шинжилгээний Системийн ололттой талуудын нэг нь СЭЗЯ-ыг Монголбанктай нэг сүлжээнд холбож чадсан явдал юм. Зохих амжилтуудаас онцолж дурьдвал:

1. Өр зээлийн бүртгэл, мэдээлэл сайжирсан
2. Өрийн дарамтыг тооцож судлах суурь бүрдсэн
3. Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний системийг ашиглаж эхэлсэнээр Монгол улсад өрийн дарамтын тооцоо судалгааг хийн өрийн удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрэлдэн бий болсон.

3.119 Хэдийгээр Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний системд Монгол улсын гадаад өрийн талаарх мэдээллийг бүрэн оруулж, одоо хэвийн ажиллаж байгаа боловч зарим нэгэн бэрхшээлтэй асуудлууд байна. Хамгийн гол нь Монгол улсын Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авч ашигласан тусламжийн талаарх мэдээлэл зарим талаар хангалтгүй байгаа нь дан ганц өрийн

удирдлагыг хэрэгжүүлэхэд бус Монгол улсын хөгжлийн албан ёсны тусламжийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байгаа юм.

3.120 Цаашид өрийн удирдлагыг улам боловсронгуй болгож, гадаад өрийн эргэн төлөлтийг төсөвт нэмэлт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж, гадаад зээлийн үр ашгийг дээшлүүлэх бодлого баримталж байна. Гадаад зээлийн хүрээнд дараах зүйлүүдийг хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Монгол улс цаашид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авч байх,
2. Гадаад зээлийн талаарх стратегийг боловсруулах
3. Цаашид шинээр авах зээлд дараах тооцоо судалгааг хийдэг байх
 - *Эдийн засгийн буцаан төлөх чадвартай холбож авч үзэж байх.* Жишээ нь: тухайн зээл авснаар нэмэгдэх гадаад зээлийн үйлчилгээний төлбөр төсвийн орлого, зарлагад болон гадаад төлбөрийн тэнцэлд хэрхэн нөлөө үзүүлэх, дотоодод дамжуулан зээлж авсан байгууллагын буцаан төлбөр хийх чадвар хэрхэн нөлөөлөх,
 - *Эдийн засгийн дотоод өр өгөөжийг тооцож харуулдаг байх.* Жишээ нь тухайн зээлийг хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааны явцад зээлийн хэдэн хувь нь дотоодод зарцуулагдах, хэдэн хувь нь гадагшаа гарах вэ, хэдэн ажлын байр нэмэгдэх, ямар хугацааны дараагаас өгөөжөө өгч эхлэх,
 - *Эдийн засагт мэдээгдэхүйц хувь нэмэр оруулах салбарыг илүү дэмжих.* Жишээ нь экспортын бүтээгдэхүүний чиглэлийн салбарыг хөгжүүлэхэд зээлийг зарцуулах нь өнөөдрийн хувьд үр дүнтэй болов уу.
4. Гадаад зээлтэй холбоотойгоор хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлангийн системийг олон улсын аргачлалын дагуу сайжруулах
5. Шинээр авах зээлийг баталдаг гадаадын зээл, тусламжийг зохицуулах зөвлөлтэй хариуцлага тооцдог механизмыг бий болгох хэрэгтэй байна. Тухайн цаг хугацаанд, ажиллаж байсан хүмүүс зээлийг авах саналыг боловсруулаад Засгийн газар, УИХ-д өргөн барьдаг боловч зээлийн зарцуулалтанд, үр ашгийг анхаарахдаа хангалтгүй байдаг. Иймд, хэрэв тухайн зээл нь үр ашиг муутай байсан бол эргээд хариуцлага тооцдог хяналтын механизмыг бүрдүүлэх хэрэгтэй.

3.121 Гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор аль болох бүх төрлийн буцалтгүй тусламж авах эх үүсвэрийг хайж, гадаад зээл, хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулах бодлогыг баримталж байна. Дунд хугацаанд өрийн үйлчилгээг ДНБ-ий 10 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримтална. Иймд дунд хугацаанд гадаадын зээлийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог улам сайжруулах, зээлийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох хууль эрхзүйн орчин бүрдүүлж, зээл тусламж авч ашиглах салбарыг оновчтой тогтоож бодлогын тэргүүлэх чиглэлээр үр ашигтай удирдах зэргээр гадаадын зээл, тусламжийн ашиглалтыг сайжруулна.

3.122 Зах зээлийн харилцаа руу шилжихээс өмнө бусад социалист орнуудын адил Монгол улс Оросын Холбооны Улс болон Зүүн Европын зарим улсаас их хэмжээний зээлийг авч ашигласан юм. 2002 оны байдлаар Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсаас бусад орнуудтай өрийн асуудлыг үндсэнд нь шийдвэрлэсэн бөгөөд Оросын Холбооны Улсын Засгийн газартай их өрийн асуудлаар удаа дараа санал солилцсоны эцэст өр үүссэн түүхэн нөхцөлийг харгалзсаны үндсэн дээр олон улсын практикт хэрэглэдэг механизмуудыг ашиглан Монгол улсын эдийн засагт хохирол багатай шийдвэрлэхээр харилцан тохиролцоод байна. Хуучин системийн үед үүссэн шилжих рублийн өр, авлагыг зохицуулах чиглэлээр холбогдох орнуудын Засгийн газартай хэлэлцээ хийж байгаа бөгөөд зарим орнуудтай өрийг зохицуулах хэлэлцээг амжилттай хийж байна. Тухайлбал, 1 ам.дол: 14.5 шилжих рублиэр өрийг зохицуулсан туршлага Монгол улсад байна. Унгар, Чех, Герман улсуудтай үүссэн шилжих рублийн өрийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Харин Польш, Болгар, Словак зэрэг улсуудтай үүссэн шилжих рублийн өрийг зохицуулах хэлэлцээг хийж байна.

3.123 Монгол Улсын Засгийн газар ОХУ-тай 1990-иэд оны эхээр “их өр”-ийн талаар харилцан ярилцаж, уг өрийн төлөх хугацааг хүү төлөхгүйгээр сунгахаар тохиролцсон юм. Өнөөгийн байдлаар ОХУ-д төлөх Монгол улсын өр 10.2 тэрбум шилжих рубльтэй тэнцүү гэсэн мэдээлэл бий. Энэ өрийг барагдуулах талаар сүүлийн 2 жилд багагүй ажил хийсэн боловч одоогоор эцсийн тохиролцоонд хараахан хүрээгүй байна. ОХУ-тай үүссэн шилжих рублийн өрийг зохицуулах талаар хоёр орны төр, засгийн дээд түвшинд ярилцаж хэлэлцсэний дүнд өрийн асуудлыг зохицуулахад баримтлах үндсэн дөрвөн зарчмыг тохиролцсон юм. Үүнд:

- Өр үүссэн түүхэн онцлог нөхцөл байдлыг харгалзан авч үзэх
- Монгол улсын эдийн засгийн бодит боломжийг тооцон, өрийг зохицуулах талаар олон улсад хэрэглэгддэг аргачлалуудыг ашиглах
- Хоёр орны уламжлалт найрсаг хамтын ажиллагаа, найрамдалт харилцааг өрийг зохицуулах үед авч үзэх
- Монголын экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих

3.124 СЭЗЯ, ОХУ-ын Сангийн яамтай өрийг зохицуулах талаар шинжээчдийн түвшинд уулзалт хэлэлцээг үргэлжүүлж байна.

3.125 Урт хугацаанд Засгийн газрын шугамаар авч ашиглах зээлийг аажмаар багасгаж, бизнесийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхүү татах бодлого баримтална. Ингэснээрээ төсөвт ирэх өрийн төлбөрийн дарамтыг багасгаж ядуучуудад очих хөрөнгийг нэмэгдүүлж, иргэдэд үйлчлэх нийгмийн үйлчилгээний салбарын хүртээмжийг дээшлүүлнэ.

3.126 Дунд хугацаанд эдийн засгийн гадаад харилцаанд нээлттэй бодлогыг үргэлжүүлж, харилцан үр ашигтай хамтын ажиллагааны бүх хэлбэр, механизмуудыг ашиглана.

3.127 Зээл, тусламжийн зохицуулалт. Хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас өнгөрсөн он жилүүдэд үзүүлж ирсэн, өнөөдөр үргэлжлүүлэн үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламж нь Монгол улсын ардчилал, зах зээлийн эдийн засаг бүхий нийгэм руу шилжих үйл явцыг эрчимжүүлэх, сайн засаглал бүрэлдүүлэх, ард иргэдийн амьдралыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад онцгой үүрэг гүйцэтгэж байна.

3.128 Өнөөдөр Монгол улсад шинэчлэлийн үйл явц улам гүнзгийрч урт хугацааны нийгэм, эдийн засгийн хөгжлийн баттай бааз суурийг тавих үедээ ороод байна.

3.129 Нийт амалсан ХАЁТ-ийн 2.1 тэрбум ам.долларын зээл, тусламжийг 1991-2001 оны хооронд бодитойгоор ашигласан байна. Нийт ашигласан ХАЁТ-ийн 52.4 хувийг буцалтгүй тусламж, 47.6 хувийг хөнгөлөлттэй зээл эзэлж байна.

3.130 Гадаадаас хүлээн авч ашиглаж буй зээл, тусламжийн хэмжээ, хандивлагч орон, олон улсын байгууллагуудын цар хүрээ өргөжих тусам Монгол улсын Засгийн газар гадаадын зээл, тусламжийн зохицуулалтыг улам боловсронгуй болгоход байнга анхаарал тавьж ирсэн юм. Тухайлбал,

1. *Тогтвортой институц бий болгох хүрээнд:* Засгийн газрын тогтоолоор Санхүү эдийн засгийн яамыг шинэчлэн зохион байгуулж чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд зээл, тусламжийг зохицуулах асуудлыг төвлөрүүлсэн байна.
2. *Зохицуулах механизм бүрдүүлэх ажлын хүрээнд:* Засгийн газрын хуульд өөрчлөлт оруулж Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг зохицуулах Зөвлөл, түүний бүрэлдэхүүн, эрхлэх асуудлын хүрээг тогтоож өгсөн.
3. *Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд:* Зээл, тусламжийг зохицуулах эрх зүйн хүрээг бий болгох зорилгоор СЭЗЯ-наас санаачлан хуулийн төсөл боловсруулсан бөгөөд ХАЁТ-ийн асуудлаар Зээл, тусламжийн дотоод зохицуулалтыг СЭЗЯ-д хариуцуулан хэвшүүлж байна.

4. Мэдээлэл солилцоо, зохицуулалтыг сайжруулах ажлын хүрээнд: Хандивлагчидтай ажлын уялдаа холбоо, өрийн удирдлага, тогтолцоог сайжруулах ажлыг байнга хийдэг боллоо.

3.131 Хандивлагч орон, олон улсын байгууллагуудтай Засгийн газар хамтран ажиллахад макро түвшингийн бодлого, ХАЁТ-ийн харилцан уялдааг сайжруулахад онцгой анхаарах хэд хэдэн чухал асуудал байна. Үүнд:

- ◆ Төсвийн төлөвлөлтийг гурван жилийн интервалтай боловсруулах журамд шилжиж буйтай холбогдуулан хандивлагч орон, олон улсын байгууллагуудтай дунд хугацааны болон жил жилээр бодлого, үйл ажиллагаагаа нягт зөвлөлдөж байх шаардлага гарч байна.
- ◆ Төсвийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс хөнгөлөлттэй зээлийн сонголт хийх, ашиглахал ихээхэн анхааралтай хандаж, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.
- ◆ Дунд хугацаанд улсын өр, өрийн үйлчилгээний хэмжээ их байх төлөвтэй байгаа учир ХАЁТ-ийн бүтцэд тусламжийн хэмжээг их байлгах нь чухал юм. Засгийн газар өрийн удирдлагыг сайжруулах стратеги баримталж, энэ асуудлаар хандивлагчидтай нягт хамтран ажиллах болно.

Засгийн газар зээл тусламжийн зохицуулалтыг сайжруулах үүднээс нилээд арга хэмжээ авч байна. Тухайлбал:

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс олгож буй зээл, тусламжийн харьцаа тухайлбал, АХБ-ны хувьд 95 хувь нь зээл, 5 орчим хувь нь буцалтгүй тусламж, Дэлхийн Банкны хувьд 90/10 орчим байгаа тул цаашид энэхүү харьцааг шат дараалан ойртуулах, зохистой хэмжээнд хүргэх талаар хамтран ажиллах шаардлагатайг харгалзан олон улсын банк, санхүүгийн байгууллагуудад энэ чиглэлээр санал тавьсан болно.
- Засгийн газар хандивлагчдаас нийгмийн салбарт, тухайлбал, эрүүл мэнд, боловсролын салбарт буцалтгүй тусламж, техникийн туслалцаа түлхүү авч ашиглах харин энэ салбарт авч буй зээлийн хэмжээг бууруулах, буцалтгүй тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.
- Мөн цаашид Монгол улсын хүлээн авч ашиглаж буй гадаадын зээл, тусламжийг бүс нутгийн хамтын ажиллагаанд илүү өргөнөөр оролцох замаар ашиглахыг зорьж байгаа болно. Монгол улс нь Төв Азийн бүс нутагт хамрагдаж энэ бүсийн хамтын ажиллагаа, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд түлхүү оролцох сонирхолтой байгаа бөгөөд энэ талаар хандивлагч улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж байна.
- Эдийн засгийн өсөлтийг хангахад хувийн хэвшил шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэдгийг гүнээ ухамсарлан ажиллаж байна. Хувийн хэвшил, хөрөнгө оруулалтаар асуудлыг шийдвэрлэж болох тодорхой салбар, чиглэлд хувийн хэвшил, *ТББ-ын оролцоог* нэмэгдүүлэхийг анхаарч байна.

IV. Мөнгөний бодлого

3.132 Урт болон дунд хугацаанд баримтлах мөнгөний бодлогын гол зорилт нь макро эдийн засаг болон санхүүгийн тогтворжилтыг бэхжүүлэх, ДНБ-ий өсөлтийг дэмжихүйц мөнгө санхүүгийн орчинг бүрдүүлэх, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх, санхүү, банкны үйлчилгээний хүрээг тэлэхэд оршино. Төв банкнаас төлбөрийн тэнцэл, банк хоорондын гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн байдалтай уялдуулан зохицуулалт хийж ханшны уян хатан бодлогыг үргэлжлүүлэн явуулна. Дунд хугацаанд инфляцийн түвшинг 5 хувиас

хэтрүүлэхгүй байлгаж, гадаад цэвэр албан нөөцийн хэмжээг импортын 18 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд хүртэл нэмэгдүүлнэ.

Хүснэгт 3:8: Мөнгөний үндсэн үзүүлэлтүүд, 1998-2002 оноор, хувиар


| (хувиар) | 1998 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
|-------------------------------------|------|------|------|------|------|
| ДНБ-д эзлэх мөнгөний нийлүүлэлт | 20.5 | 23.8 | 24.8 | 29.7 | 38.2 |
| ДНБ-д эзлэх хадгаламжийн хэмжээ | 10.4 | 11.4 | 12.3 | 15.7 | 23.0 |
| ДНБ-д эзлэх зээлийн үлдэгдэл | 10.5 | 8.4 | 6.4 | 12.1 | 18.8 |
| ДНБ-д эзлэх чанаргүй зээлийн хэмжээ | 3.8 | 4.6 | 1.5 | 1.5 | 1.3 |

3.133 Үнийн түвшин сүүлийн жилүүдэд тогтворжиж, 2002 оны 2 дугаар хагаст буурсан байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд мөнгөний уян хатан бодлого явуулж эдийн засагт дутагдаж байгаа мөнгөний эрэлтийг хангахын хамт инфляцийг хөөрөгдөхгүй байх түвшинд мөнгөний нийлүүлэлтийг жолоодох бодлого баримтална.

3.134 Хэдийгээр Монгол орны эдийн засгийн үйл ажиллагаа, үүнийгээ дагаад хүн амын хэрэглээ улирлын чанартай хэлбэлзэлтэй байдаг ч сүүлийн жилүүдэд инфляцийн жилийн түвшин нэг оронтой тоонд хүрч тогтворжиж байна. Энэ нь хүн ам, тэр дундаа ядуу иргэдийн амьжиргааг дэмжих томоохон дэмжлэг болж байна.

3.135 Дунд хугацаанд инфляцийн түвшинг 5.0 хувь орчим байлгах зорилт тавьж байна. Үүнтэй уялдаад мөнгөний бодлогыг оновчтой явуулах, нөөц мөнгөний өсөлтийг зохих түвшинд байлгана. Мөн хүн амын хэрэгцээт бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулах тогтвортой байлгах бодлого явуулна.

3.136 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш үндсэндээ тогтвортой байна. Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх бодлого явуулж байгаа нь үр дүнд хүрч байна.



2002 оны эцэст төгрөгийн ханш 2.0 орчим хувиар суларч нэг доллартай 1125 төгрөг тэнцэж байв.

3.137 Төв банкны бодлого нь мөнгөний нийлүүлэлтийн удирдлагыг инфляци болон валютын ханшны тогтвортой байдлыг харилцан уялдуулахад чиглэгдэж байна. Мөнгөний нийлүүлэлт 2002 онд өмнөх онтой харьцуулахад 42 хувиар, гадаад болон дотоод валютын хадгаламж 55-62 хувиар өссөн байна. Хэдийгээр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өндөр байгаа ч мөнгөний нийлүүлэлтийн бүтцэд эерэг өөрчлөлт гарч, иргэдийн банкны системд итгэх итгэл аажмаар нэмэгдэж байна. Эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжсэнээр зээлийн эрэлт нэмэгдэж байна. Одоогоор зээлийн дундаж хүү 35 хувьтай байна. Тиймээс зээлийн хүүг бууруулахын тулд мөнгө зээлийн бодлогыг эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих, банкуудын дунд өрсөлдөөний орчин бий болгоход чиглүүлэх шаардлагатай байна. Дунд хугацаанд валютын ханшны бодлогыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар дэлхийн зах зээлд манай экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бууруулж мэдэх дотоодын валютын чангаралт болон бүтээмж муутай импорт өсөх, ирээдүйд гадаад зээлийн буцаан төлөх чадварт сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлнэ.

Засгийн Газар өөрийн мөнгөний бодлогыг доорхи байдлаар хэрэгжүүлнэ.

- Монгол банкны бондны хүү, байршуулалтыг өсгөх
- Зээлдүүлэх үйл ажиллагааны хяналтыг сайжруулах
- Удирдлага ба хяналтын хүрээг сайжруулах
- Засгийн газрын дунд хугацааны бодлогын баримт бичиг эсвэл жилийн төсөвт ороогүй бол гуравдагч талуудын зээлийн баталгаа болон төлбөрийн барагдуулалтыг хязгаарлах

3.138 **Санхүү, банкны тогтолцоо.** Санхүүгийн зуучлалын түвшинг илэрхийлэгч гол үзүүлэлтүүд болох нийт мөнгө, зээл болон харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл тус бүрийн ДНБ-д эзлэх хувийн жин бага зэрэг өсч байгаа нь эдийн засаг дахь санхүүгийн зуучлал гүнзгийрч буйг харуулж байна. 2002 оны байдлаар 16 банк, 60 орчим банк бус санхүүгийн байгууллага, нийтдээ 502 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээрийн 85 хувь нь нийслэл Улаанбаатар хотоос бусад газар байршиж байгаа боловч нийт олгосон зээлийн зөвхөн 13 хувь нь хөдөө, орон нутгийн үйлчлэгчдэд ногдож буй нь санхүүгийн төвлөрөл үүсч буйг харуулж байна. Монголбанкнаас явуулсан судалгаагаас жижиг бизнес эрхлэгчид, хөдөөгийн үйлчлүүлэгч нарт зээлийн хүртээмж хангалтгүй байна гэсэн дүн гарсан байна.

3.139 Иймээс санхүүгийн үйлчилгээг хөдөөд чиглүүлэх бодлого явуулж байгаагийн үр дүнд банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль 2002 оны эцсээр батлагдсан бөгөөд хадгаламж зээлийн хоршоог хөгжүүлэх явдлыг дэмжсэн эрхзүйн заалтуудын хоршооллын тухай хуульд нэмж оруулан батлуулж, мөрдөж байна. Эдгээр хууль эрхзүйн хүрээнд банк, санхүүгийн зуучлалыг өргөжүүлнэ.

3.140 Банк, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх талаар дунд хугацаанд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг нь банк, санхүүгийн салбар дахь шударга өрсөлдөөнийг өрнүүлэн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, техник, технологийг шинэчлэх, хяналтын арга механизмыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг хөхиүлэн дэмжинэ. Мөн банк санхүүгийн зуучлал, үйлчилгээг хөдөө орон нутагт өргөжүүлэх шат дараалсан арга хэмжээ авна. Энэ хүрээнд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг хөдөө орон нутагт идэвхижүүлж, дэмжлэг үзүүлнэ. Төрийн өмчийг хувьчлах хөтөлбөрийн дагуу зохих бэлтгэлийг хангасны дараа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой арилжааны банкуудыг хувьчлах ажлыг дуусгана. 2002 онд Монголын хамгийн том банк болох Худалдаа Хөгжлийн банкныг, 2003 оны эхээр хөдөөд олон салбартай Хөдөө аж ахуйн банкныг хувьчлав.

3.141 Бизнес эрхлэх, тэр дундаа жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зээлийн хүртээмж, түүний хүүгийн түвшин онцгой байр суурьтай байна. Иймд банкны зээлийн нэрлэсэн хүүг бууруулж, бодит хүүг эерэг түвшинд байлгах хүрээнд өрсөлдөөнийг өргөжүүлж, банкнаас гадуурхи бэлэн мөнгөний урсгалыг багасгах алхмуудыг хэрэгжүүлнэ.

Мөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын сул чөлөөтэй хөрөнгийн эх үүсвэрийг банкинд төвлөрүүлэх замаар хадгаламж болон зээлийн хүүгийн түвшингийн одоо байгаа зөрүүг аль болох багасгах бодлого хэрэгжүүлнэ. Банк санхүүгийн тогтолцоог сайжруулах, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх нь орон нутаг дахь бэлэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлж бүс нутгууд дахь эдийн засгийн хөгжлийг хангах, ажлын байр бий болгох, улмаар иргэдийн орлогыг нэмэгдүүлж ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ гэж үзэж байна.

3.142 Банкуудын дотоод хяналт шалгалтыг олон улсын стандартын дагуу хийж, хөндлөнгийн хяналтын чанарыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах, зээлийн эрсдлийг бууруулах арга механизмыг нэвтрүүлнэ.

3.143 Төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлж хэвшүүлэх, бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээг багасгах зорилгоор бэлэн бус төлбөр тооцооны үндэсний сүлжээг байгуулна.

3.144 УИХ үнэт цаасны зах зээлийг дунд хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэх гэж байна. Энэ үндсэн чиглэлд үнэт цаасны бирж болон үнэт цаасны хадгаламж, тооцооны төвийг тусгаарлах, үнэт цаасыг бүртгэх шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэх, шаардлагатай байгаа хууль эрхзүйн шинэчлэлийг хийх, үнэт цаасны зах зээл дахь хүн амын оролцоог урамшуулах, тэдний мэдлэгийг дээшлүүлэх асуудлууд багтаж байна. Үүний зэрэгцээ Итгэлцлийн сангийн тухай хуулийг гаргана.

3.145 Даатгалын бодлого нь хууль эрхзүйн орчныг сайжруулах, даатгалын компаниудын хөрөнгийн мониторинг болон удирдлагыг оновчтой болгох, даатгалын нэр төрөл, хамрах хүрээг өргөтгөх, олон улсын стандартуудыг мөрдүүлэхэд төвлөрнө.

V. Эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлт

3.146 Хувийн хэвшил дээр суурилсан эдийн засгийн бүтцийг бүрдүүлж, улмаар үр ашгийг дээшлүүлэх нь Засгийн газрын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг юм. Иймд дунд хугацаанд өмч хувьчлалын явцыг эрчимжүүлэх, үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг дээшлүүлэх замаар эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог 80 орчим хувьд хүргэж үйлдвэрлэл, экспортын бүтцийг сайжруулна.

3.147 Монгол улсын эдийн засагт голлох үүрэгтэй үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг оновчтой шийдвэрлэх нь эдийн засгийн цаашдын хөгжилд чухал нөлөөтэй. Аж ахуйн нэгжүүдийг хувьчлахдаа эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, тэдгээрийг экспортын шинэ зах зээлтэй холбох чадавхи бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах чиглэл баримтална.

3.148 Стратегийн гол салбар болох эрчим хүчний салбарыг арилжааны горимд бүрэн шилжүүлэх замаар тус салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлнэ. Эрчим хүчний тухай хууль 2001 онд батлагдсан юм. Энэхүү хуулийн дагуу эрчим хүчний салбарт хувьцаат компаниудын зохион байгуулж улмаар хувийн хэвшлийн оролцоо, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлэв.

3.149 Дунд хугацаанд эрчим хүчний компаниудын бие даасан байдлыг бэхжүүлж, эрчим хүчний салбарын шинэчлэлийг эрчимжүүлж хувьчлалыг үе шаттай хэрэгжүүлнэ. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлснээр түүний хяналт, үнэлгээ сайжирч, компаниуд нь ямар нэг хөндлөнгийн зуучлагчгүйгээр хэрэглэгчдээс төлбөрөө шууд хураан авч% улмаар төрөл бүрийн шимтгэл бууруулах замаар үр ашгаа дээшлүүлэх юм. Дамжуулах шугамыг хувьчилж, техникийн бус алдагдал, эрчим хүчний дотоод хэрэгцээг мөн бууруулах болно.

3.150 Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах Засгийн газрын зорилтын хүрээнд хүн ам, тэр дундаа хөдөөгийн болон ядуу иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг өргөжүүлж орлогын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх үүднээс газар өмчлүүлэх, эзэмшүүлэх

ажлыг зохион байгуулна. Газрыг эдийн засгийн харилцаанд оруулахдаа удаан хугацаагаар түрээслэх, газрын төлбөрийн арга хэрэгслийг боловсронгуй болгох, үйлдвэрлэл, газар тариаланг хөгжүүлэх оновчтой хөшүүрэг болгон ашиглах төдийгүй эдийн засгийн өсөлтийг хангахад газрын шинэчлэлийн бодлогыг чиглүүлэх зорилт баримтална. Хөдөөгийн иргэдийн ахуй амьдрал газар нутаг, байгалиас хараатай байдаг онцлогийг харгалзан бэлчээрийн удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

3.151 УИХ-аар батлагдсан Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг мөрдлөгө болгон төрийн үйлчилгээний хүртээмж, чанарын түвшинг бууруулахгүйгээр боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг зэрэг нийгмийн үйлчилгээний салбарт бүтцийн өөрчлөлт хийж, төрийн өмчийн сургууль, эмнэлэг, соёлын газруудыг удирдлагын гэрээ, түрээсийн гэрээ зэрэг арга хэлбэрээр хувьчлах, мөн боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн хувийн хэвшлийн байгууллагын тогтвортой, чанартай үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бүтцийн өөрчлөлтийг хийнэ. Ингэхдээ ядуучуудад үзүүлэх боловсрол эрүүл мэнд соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй байх механизмыг бий болгон хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

3.152 Дунд хугацаанд хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хувьчлалыг үргэлжлүүлж, нийтийн тээврийн үйлчилгээг бүхэлдээ хувийн хэвшилд шилжүүлнэ.

3.153 Орон нутгийн өмчийн шинэтгэл нь нийт өмч хувьчлалын явцтай хамт үргэлжилнэ. УИХ-ын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан 2001-2004 онд төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан нийгмийн салбарын хувьчлал, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн үзэл санаа, үндсэн зорилго нь нийслэлд нийгэм-эдийн засгийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгоход оршино.

3.154 2003 онд нийт 35 объектийг хувьчилна. Нийгмийн салбарын хувьчлалын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийтийн тээвэр, нийтийн аж ахуйн үйлчилгээ, уурын зуухны зарим байгууллага, нэгжүүдийг менежментийн хувьчлалаар хувьчлахаар бэлтгэж байна.

3.155 Эдийн засаг, нийгмийн хүрээнд хийгдэж буй бүтцийн өөрчлөлтийн үр дагавар нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст харилцан адилгүй тусч байна. 1990-иад оны эхээр хийгдсэн өмч хувьчлалын явцын сөрөг үр дагавар эмэгтэйчүүдэд илүү хүнд мэдрэгдсэн юм. Эмэгтэйчүүд давамгайлсан ажиллаж байсан хөнгөн үйлдвэр, ахуй үйлчилгээний газруудын олон зуун эмэгтэйчүүдийг нийгмийн баталгаагүй албан бус салбар луу ямар ч бэлтгэлгүйгээр түлхэн оруулсан явдал болсон. Тухайн үед тэтгэврийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж эмэгтэйчүүдийг ажлын байраа алдахад нь түлхсэн төдийгүй тэднийг ядууралд хамгийн түрүүнд өртөхөд хүргэсэн гашуун сургамж бий. Иймээс урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн хүрээний бүтцийн өөрчлөлтийн бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийж, эдийн засгийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах шударга ёсыг бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн бодлогын үр ашгийг эмэгтэй, эрэгтэйчүүд эрх тэгш хүртэх боломжийг дээшлүүлнэ. Ялангуяа гадаад, дотоод хөрөнгийн урсгал, хуваарилалт хэрхэн хийгдэж буйгаас хамран эмэгтэйчүүдийн аж байдалд зарим талаар нөлөөлж байна. Иймд эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийг хийхдээ жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс газар, өмч эзэмших, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн салбар дахь бүтцийн өөрчлөлт, төсвийн шинэчлэлийн талаар тодорхой судалгааны ажлуудыг хийж, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. Өмнөхөөсөө сургамж авч эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ ядуурлыг гаргахгүй байх, нийгмийн баталгааг хангах бодлогыг урт болон дунд хугацаанд баримтална.

3.156 Хувийн секторт тулгуурласан эдийн засгийн өсөлтийг хангах дунд хугацааны зорилтууд нь эрчим хүч, газар, төрийн алба, тэтгэвэр, тэтгэмж, татвар зэрэг эдийн засаг, нийгмийн олон салбаруудыг хамарсан бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийг гүнзгийрүүлэх замаар хэрэгжинэ. Эдгээр салбаруудын бүтцийн өөрчлөлт нь нийгмийн байдал, ялангуяа

эмзэг бүлгийхэнд нөлөөлөх урт хугацааны хүндрэл бэрхшээлтэй үйл явц юм. Тиймээс бүтцийн өөрчлөлттэй холбогдон гарах сөрөг үр дагаварыг багасгах, эрсдлийг бууруулах нь Засгийн газрын анхаарах асуудлын нэг болно. Засгийн газар Олон улсын байгууллагуудын туслалцаатайгаар хувьчлал, бүтцийн өөрчлөлтийн үр дагаварыг судлах хэд хэдэн арга хэмжээ аваад байна. Дэлхийн банктай хамтран улсын салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас санаачлан эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлт, түүний хөгжлийн талаар хэд хэдэн судалгааг явуулсан байна. Гэхдээ энэхүү шинэчлэлийн бодлогууд нь хүн амын бүлгүүдэд өөр өөр нөлөөлөл үзүүлж байна. Иймээс олон улсын зөвлөх, эрдэмтэн судлаачид болон бодлого боловсруулагчдыг оруулцуулан жендерийн асуудалд гол анхаарлаа хандуулан дунд хугацаанд бодлогын шинэчлэлийн үзүүлэх нөлөөллийг үнэлэн дүгнэх шаардлагатай байна.

VI. Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, аудит

3.157 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал. Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш анх удаа 1993 онд "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" батлагдсан. Энэ хуулийн гол агуулга нь Монгол улсад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг (IAS) нэвтрүүлэх явдал байлаа. Энэ үед Монгол улсад нягтлан бодох бүртгэлийн нэр хүнд их унасан, түүнийг хэрэгцээ шаардлага багатай зүйл гэсэн буруу үзэл санаа нэлээд дэлгэрсэн, тэр тусмаа Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мэддэг мэргэжилтэн байхгүй байв. Иймээс 1993 онд Дэлхийн банк, 1995 онд АХБ-ны санхүүжүүлсэн 3 удаагийн төсөл хэрэгжүүлж, Монголын гол мэргэжилтнүүд болон багш нарт Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын мэдлэгийг нэлээд системтэй олгосон юм.

3.158 Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын 1996 оны хувилбарыг 1998 онд орчуулж, нийтэд тараасан ба нягтлан бодох бүртгэлийн чиглэлтэй болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэхтэй холбогдсон аргачлал, гарын авлагыг Санхүү, эдийн засгийн яамнаас нэлээд олныг гаргасан.

3.159 Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг 1996 онд шинэчилж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг заах болов.

3.160 Монгол улсад 30 шахам мянган нягтлан бодогч байгаа бөгөөд тэдгээрийн гуравны нэгийг нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын мэдлэг олгох 2-3 долоо хоногийн сургалтад хамруулаад байна.

3.161 1993-2000 оны хооронд төсөвт байгууллага, орон нутгийн төсөв, санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад шилжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна. Дэлхийн банкны Төсвийн Техник Туслалцааны төслийн хүрээнд 1999 оноос Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад шилжүүлэх аргачлал заавар боловсруулж эхэлсэн боловч ажлын явц удаан байв.

3.162 2001 онд Монгол улсын бүх аж ахуйн нэгж, төсөвт байгууллагад нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэг хийсэн. Энэ үзлэгийн дүнгээр бүх төсөвт байгуулагад НББОУС нэвтрээгүй, аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй хувь нь бүртгэл хөтөлдөггүй, санхүүгийн тайлан гаргадаггүй, татварын байгууллагатай тооцоо хийдэггүй, мөн 40 шахам хувь нь ажил гүйлгээндээ баримт бүрдүүлдэггүй, бүх аж ахуйн нэгжүүдийн 27 хувь нь НББОУС нэвтэрсэн гэсэн дүн мэдээ гарсан юм.

3.163 Энэ байдалд Засгийн газар дүгнэлт хийж олон чухал арга хэмжээ төлөвлөсний нэг нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийг 2001 оны 12 сард шинэчилж баталсан явдал юм. Энэ хуульд Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгж, төсөвт байгууллагад НББОУС-ыг нэвтрүүлэхийг заасан. Нягтлан бодох бүртгэл хөтөлхгүйгээр санхүүгийн тайлан гаргадаг зөрчил байсан учраас нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг

хуульд заав. Аж ахуйн нэгж, байгууллага бүр бүтэн буюу хагас цагаар ажилладаг нягтлан бодогчтой байхаар хуульд тусгав. Энэ хуулиар нягтлан бодогч нарт хуульд харшлах буюу баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх эрх, мөн үүргийг тодорхой зааж өгсөн юм. Хуулиар нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийг бий болгож тэдэнд хяналт, шалгалт, шийтгэлийн эрх олголоо. Энэ хуулийг хэрэгжүүлэх ажлыг түргэтгэхийн тулд Засгийн газар 2002 оныг Бүртгэлийг сайжруулах жил болгон зарлаж 2002-2004 онд Бүртгэл хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж батлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын хөтөлбөрт НББОУС-ын нэвтрэлтийг 2002 онд бүх аж ахуйн нэгжийн 50 хувьд, 2003 онд 70 хувьд, 2004 онд 90 хувьд хүргэх, анхан шатны баримт бүрдэлтийг 2003 онд 80 хувьд хүргэх, 2003 оноос төсөвт байгууллагад НББОУС нэвтрүүлэхээр заасан.

3.164 2002 онд СЭЗЯ-наас 34 аргачлал заавар шинээр гаргав. Үүний дүнд Нягтлан бодох бүртгэлийн хууль хэрэгжих эрх зүйн болон арга зүйн орчин бүрдлээ. НББОУС-ыг бизнесийн салбарт хэрэгжүүлэх аргачлал, заавраар хангалаа.

3.165 Шинэ хуулиар Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг төсөв болон бизнесийн байгууллага бүр заавал хэрэгжүүлэхийг заасан. 2002 оны нэг чухал үр дүн бол төрийн өмчит аж ахуйн нэгж, хувьцаат компаниудад НББОУС-ыг үндсэндээ нэвтрүүлсэн бөгөөд аж ахуйн нэгжүүдийн нийт дүнгээр нь авч үзвэл тэдгээрийн 55 хувьд НББОУС нэвтэрсэн дүн гарсан. Одоо НББОУС нэвтрүүлээгүй байгаа 45 хувь бол жижиг аж ахуйн нэгжүүд юм. Энэ бол маш хүнд ажил бөгөөд бидний өмнө тулгараад байгаа нэг бэрхшээл юм.

3.166 2002 онд Дэлхийн банкны Төсвийн Техник Туслалцааны төслийн хүрээнд Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад шилжүүлэх заавар журмыг баталж, 2003 оны 1 сарын 1-нээс эхлэн мөрдүүлэн ажиллаж байна.

3.167 2002 оны 9 сард 60 зөвлөх багш нарт дээрхи аргачлал зааврын талаар сургалт зохион байгуулав. Эдгээр сургагч багш нарын хүчээр орон нутагт 2002 оны 10, 11 дүгээр сард 2000 шахам нягтлан бодогчид сургалт явуулсан нь нийт суралцвал зохих хүмүүсийн 50 орчим хувийг хамрав. Бүх төсөвт байгууллагад нягтлан бодох бүртгэлийн шинэ заавар, бүртгэлийн маягтыг хүргэлээ.

3.168 Энэ маягт зааврыг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуульд нийцүүлэн боловсруулав. Энэ хуулиар болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланг НББОУС-ын дагуу гаргахаар заасан. Мөн санхүүгийн тайлан гаргах хугацааг тодорхойлсон юм.

Хүснэгт 3:9: Улсын салбарын санхүүгийн тайлан гаргалт хугацаа

| Тайлагнагч ба тайлангийн төрөл | Тушаах хугацаа | Хэн Хэрэглэх |
|--|---|------------------------------------|
| <p>1. Төсөвт байгууллага</p> <p>Санхүүгийн тайлангийн бүтэц:</p> <p>а. баланс</p> <p>б. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан</p> <p>в. мөнгөн гүйлгээний тайлан</p> <p>г. өмчийн өөрчлөлтийн тайлан</p> <p>д. санхүүгийн тайлангийн тодруулга</p> | <p>Дараа жилийн 2 сарын 15-ны дотор</p> | <p>Төсвийн Ерөнхийлөн захирагч</p> |
| <p>2. Төсвийн ерөнхийлөн захирагч</p> <p>Санхүүгийн тайлангийн бүтэц төсөвт байгууллагатай адил байна.</p> | <p>Дараа жилийн 2 сарын 20-ны дотор</p> | <p>СЭЗЯ</p> |

| | | |
|--|---|---|
| <p style="text-align: center;">3. СЭЗЯ</p> <p>Засгийн газрын санхүүгийн тайлан: а. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан б. баланс в. мөнгөн гүйлгээний тайлан г. өмчийн өөрчлөлтийн тайлан д. Тодруулга</p> | <p>Дараа жилийн 3 сарын 20-ны дотор</p> | <p style="text-align: center;">УИХ</p> |
| <p style="text-align: center;">4. Төрийн өмчит аж ахуйн нэгж Санхүүгийн тайлангийн бүтэц төсөвт байгууллагын адил байна</p> | <p>Дараа жилийн 2 сарын 10-ны дотор</p> | <p style="text-align: center;">СЭЗЯ</p> |

3.169 Төрийн сангийн нягтлан бодох бүртгэлийг шинэчилэн 2003 онд аккруэл суурьт бүртгэлд шилжүүлэх заавар гаргалаа. 2003 оны 4 дүгээр сард Төрийн сангийн нягтлан бодогч нарт семинар хийхээр төлөвлөж байна. Харин Төрийн санг 2004 онд аккруэл суурьт бүртгэлд шилжүүлэх шаардлага Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуультай холбогдон гарч байна.

3.170 Төсөвт байгууллагын бүтээгдэхүүний хэмжээг зөв тодорхойлох, бүтээгдэхүүний өртөгийг бүрэн илэрхийлэх, мөн төсөвт байгууллагын эдийн засгийн чадавхийг харуулах үүднээс үндсэн хөрөнгийг зөв үнэлэх мөн элэгдлийн зардлыг зөв тодорхойлох шаардлагатай байна.

3.171 Төрийн өмчийг тоолох, дахин үнэлэх, дансанд тусгах, элэгдлийн шимтгэл байгуулах аргачлалыг боловсруулж байгаа боловч арга зүйн хувьд шийдэхэд бэрхшээлтэй олон асуудал гарч байна. Тухайлбал, тооллогод ямар хөрөнгийг хамруулах, өмнөх онуудад янз бүрийн үнээр бэлтгэсэн хөрөнгө барилга, байгууламжийг өнөөгийн үнэ цэнэд хэрхэн шилжүүлэх, төрийн өмчийн компанийг ямар үнээр үнэлж төрийн сангийн дансанд бүртгэх зэрэг болно.

3.172 Төв төрийн сангийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд төрийн өмчийн аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, нийтийн хэрэгцээний зам, гүүр зэрэг объектууд тусгагдаагүй байна. Орон нутагт ч мөн нэгэн адил ийм байна. Ийм байдал нь Засгийн газрын эдийн засгийн боломжийг бүрэн харуулж чадахгүй, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хууль хэрэгжихэд бэрхшээл гарч болохоор байна.

Төрийн өмчийн ба төрийн өмч оролцоотой бизнесийн байгууллагууд 2001 оны үзлэгээр Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад бүгд шилжсэн байлаа.

3.173 Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийг 2003 оны 3 дугаар сарын байдлаар авч үзвэл:

Хүснэгт 3:10: Нягтлан бодох бүртгэлийн шинэчлэл, 2003 оны 3 сараар

| | |
|---|---|
| | <p style="text-align: center;">Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрэлт</p> |
| <p>1.Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд</p> | <p>Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт бүрэн нэвтэрсэн</p> |
| <p>2.Төсөвт байгууллага</p> | <p>Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт буюу аккруэл суурьт бүртгэлд шилжих ажил эхэлж байгаа</p> |
| <p>3.Төрийн сангууд</p> | <p>2003 онд шинэчилсэн аккруэл суурьтай бүртгэлд шилжих бөгөөд 2004 онд аккруэл суурьт буюу Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад шилжинэ.</p> |

3.174 Ийм 3 төрлийн бүртгэлийн суурь хэрэглэж байгаа учраас улсын салбарын санхүүгийн нэгдсэн тайланг гаргахад бэрхшээл байгаа юм. Түүгээр ч барахгүй Засгийн газрын санхүүгийн тайланд төсөвт байгууллагын санхүүгийн үр дүнг нэгтгэн оруулахад нилээд цаг, хүч хөдөлмөр шаардаж байна. Гэхдээ 2004 оноос энэ бэрхшээлээс гарах зорилт тавиад ажиллаж байгаа юм.

3.175 Одоо улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг орчуулж байна. Түүнийг 2003 онд дуусгах зорилт тавиад байна.

3.176 Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг 2003 оны 3 дугаар сард хийлээ. Энэ ажлын дүнг 2003 оны 4 сард аймаг, нийслэлийн нягтлан бодогчдын зөвлөлгөөнөөр, 6 сард улсын зөвлөлгөөнөөр хэлэлцэх юм. Энэ ажил амжилттай хэрэгжиж чадвал Засгийн газрын нягтлан бодох бүртгэлийн ажилд эргэлтийн шинжтэй нөлөө үзүүлнэ гэж найдаж байна.

3.177 Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын сургалтад хамрагдаж чадаагүй байгаа төсөвт байгууллагын 2000 орчим нягтлан бодогчдыг ойрын хугацаанд сургалтанд бүрэн хамруулна.

3.178 Аймагуудын төрийн сан, төсвийн төвлөрүүлэн захирагчдын ерөнхий нягтлан бодогчдыг гүнзгийрүүлсэн сургалтад хамруулах шаардлага тулгарч байна.

3.179 Төрийн өмчийн тооллогыг нэн даруй хийж, шинээр үнэлж, өнөөгийн үнэ цэнээр холбогдох төсөвт байгууллага, төрийн сангийн нягтлан бодох бүртгэлд тусгах, элэгдлийн зардлын тооцоог хийдэг болох, үүний тулд аргачлал, заавар боловсруулан, орон даяар нэгдсэн журмаар мөрдөж ажиллах шаардлага гарч байна.

3.180 Төсөвт байгууллагын бүтээгдэхүүн ба зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгах, ертөгийг тооцоолох аргачлалыг боловсруулж нэвтрүүлнэ.

3.181 Төсөвт байгууллагын нягтлан бодогчдод Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх талаар биет туслалцаа үзүүлэх, газар дээр нь зөвлөгчдийг очуулж зөвлөлгөө өгүүлэх, аймаг бүрд 10-аас доошгүй улсын хэмжээнд 500-аас багагүй байгууллагын нягтлан бодох бүртгэлийг үлгэр жишээ байдлаар шинэчилж тусална.

3.182 Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг бүрэн эхээр нь орчуулж, хэвлүүлэн, нийт байгууллагад хүргүүлнэ.

3.183 **Аудит.** 2003 оныг хүртэл төсвийн зохицуулалтын хяналт шалгалтын асуудлыг Төрийн хянан шалгах хороо, СЭЗЯ-ны санхүүгийн хяналт шалгалтын газар, бусад салбарын яамдын дэргэдэх салбарын хяналт шалгалтын газар эрхэлж байлаа.

3.184 Төрийн Хянан шалгах хороо нь Парламентын дэргэд ажиллаж санхүүгийн хяналт шалгалт, гүйцэтгэлийн хяналт шалгалт, төрийн албан хаагчдын ёс зүйн хяналт шалгалтын асуудал хариуцаж байв.

3.185 Төрийн хянан шалгах хороо аль ч байгууллагад аудит хийдэггүй, гол төлөв санхүүгийн шалгалт хийж, алдаа дутагдал илрүүлж, төлбөр торгууль ногдуулдаг байлаа.

3.186 СЭЗЯ-ны Санхүүгийн хяналт шалгалтын газар нь төсөвт байгууллага төрийн өмчийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөгөөр санхүүгийн шалгалт хийдэг байв. Санхүүгийн хяналт шалгалтын газар нь санхүүгийн шалгалт хийж дутагдал зөрчлийг илрүүлэх үүрэг гүйцэтгэдэг байв.

3.187 Салбарын яамдын дэргэдэх хяналт шалгалтын газрууд нь Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, хүрээлэн байгаа орчин, хүн амд үзүүлэх үйлчилгээний асуудлыг шалгадаг байлаа.

3.188 Дээрхи хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагаа их давхарддаг, нэг аж ахуйн нэгж дээр хяналт шалгалтын олон байгууллагууд зэрэг юмуу эсвэл цуварч очдог, түүгээр ч барахгүй Төрийн хянан шалгах хорооны шалгалт хийгээд үнэлэлт дүгнэлт өгөөд буцсаны дараа Санхүүгийн хяналт шалгалтын газраас шалгалт хийгээд их хэмжээний зөрчил илрүүлдэг зэрэг явдал гардаг байв.

3.189 2003 оны 1 дүгээр сард Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай гэсэн 2 хууль шинэчлэн батлагдав. Үүний дараа ТХШХ-г Үндэсний аудитын газар болгон өөрчлөв.

3.190 Үндэсний аудитын газар хуулиар дараах 2 төрлийн аудит хийнэ.

- санхүүгийн тайлангийн аудит
- гүйцэтгэлийн аудит

3.191 Мэргэжлийн хяналтын газар нь дараах үүрэг гүйцэтгэнэ:

- хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих
- хяналтын хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах.

3.192 Мөн салбарын яамдын дэргэд байсан 11 хяналт шалгалтын агентлагийг нэгтгэн Ерөнхий сайдын дэргэд Улсын Мэргэжлийн хяналтын газар байгуулав. СЭЗЯ-ны харъяанд байсан Санхүүгийн хяналт шалгалтын газар ч Улсын мэргэжлийн хяналтын газарт шилжсэн.

3.193 Дээрх шинэчлэлийг хийснээр Үндэсний аудитын газар нь яам, агентлаг, төрийн өмчийн болон төрийн өмч оролцоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, дүгнэлт гаргах үүрэгтэй болж өмнөх үүрэг нь үндсээрээ өөрчлөгдсөн. ТБУСХ-ийн дагуу Үндэсний аудитын газар нь дараах аудитыг хийхээр болсон:

Хүснэгт 3:11. Аудит хийх хуваарь

| Засгийн газрын байгууллага | Аудит хийх байгууллага | Аудитын байгууллагад өгөх хугацаа | Аудитыг гүйцэтгэх хугацаа | Аудитын тайланг хэрэглэгч |
|-------------------------------|----------------------------------|-----------------------------------|-------------------------------|---------------------------------------|
| 1.Төсөвт байгууллага | Үндэсний аудитын газар | дараа оны 2 сарын 15-ны дотор | 1 сарын дотор | Төсвийн ерөнхийлөн захирагч ба СЭЗЯ-д |
| 2.Орон нутгийн засаг дарга | Орон нутгийн аудитын байгууллага | дараа оны 2 сарын 20-ны дотор | 1 сарын дотор | СЭЗЯ |
| 3.Засгийн газар | Үндэсний аудитын газар | дараа оны 3 сарын 20-ны дотор | 1 сарын дотор | УИХ |
| 4. Төрийн өмчит аж ахуйн нэгж | Үндэсний аудитын газар | дараа оны 2 сарын 20-ны дотор | Дараа оны 1 сарын 1-ний дотор | Удирдах зөвлөл |

3.194 Гэхдээ Төрийн аудитын хуулинд зарим асуудлыг шийдэж өгөөгүйгээс амьдрал дээр зөрчил үүсгэж магадгүй төлөвтэй байна.

1.Үндэсний аудитын газар шалгалт хийх явцдаа том хэмжээний зөрчил дутагдал илрүүлбэл түүнийг нөхөн төлүүлэх, торгууль шийтгэл ноогдуулах үүрэг хүлээхгүй юм. Гэтэл ийм тохиолдолд зөвхөн аудитын дүгнэлтэд бичээд орхих уу? Уг дүгнэлтээр дурьдсан зөрчлийг арилгах асуудлыг яах вэ гэдгийг хуульчлаагүй орхисон байна.

2.Хувийн өмчийн аж ахуйн нэгжид мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй, аудиторын лицензтэй нягтлан бодогч аудит хийдэг. Гэтэл төрийн том аж ахуйн нэгжид Үндэсний аудитын газрын байцаагч нягтлан бодогч мэргэжилгүй хүн аудит хийх болж байгаа юм.

Энэ нь олон улсын туршлагатай нийцэхгүй, бусад харилцагчдын хувьд ч хүлээн зөвшөөрөхөд бэрх асуудлыг үүсгэж байна.

3. Аудит бол хараат бус хөндлөнгийн хяналт байх ёстой. Гэтэл төрийн өмчийн аж ахуйн нэгжид төрийн нэг байгууллага нь аудит хийснийг гуравдагч талын сэтгэлгээгээр хандвал хараат бус хөндлөнгийн хяналт болж чадах уу гэдэг асуудал тавигдаж байна.

4. Үндэсний аудитын газар аудит хийгээд нааштай дүгнэлт өгсөний дараа Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн шалгалтын хэсэг шалгаад их хэмжээний зөрчил илрүүлж болох юм. Энэ тохиолдолд Үндэсний Аудитын Газар ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа юм.

5. Үндэсний аудитын газар төрийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн санхүүгийн тайланд аудит хийхдээ алдаа гаргаж, америкийн "Энрон" компанийн дампууралтай төстэй үйл явдал болбол Үндэсний Аудитын Газарт ямар хариуцлага ногдуулах асуудал бас тодорхойгүй байна.

Ийнхүү Үндэсний аудитын газрын үйл ажиллагаа Засгийн газрын байгууллагын хувьд хөндлөнгийн хяналт байж болох боловч Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд хөндлөнгийн хараат бус байгууллагын үүргийг гүйцэтгэж чадахгүй тал гарч болохыг үгүйсгэхгүй байна.

6. Монгол улсын бүх яам агентлаг бусад төсөвт байгууллагын төсвийг хянах, хуваарилах санхүүгийн тайланг хянаж хүлээн авах үүрэг зөвхөн Санхүү, эдийн засгийн яаманд ногддог. Иймээс Үндэсний аудитын газар аудитын дүгнэлтийг СЭЗЯ-нд хүлээлгэн өгөх тайлагнах шаардлагатай болж байна. СЭЗЯ аудитын дүгнэлтийг буруу гэж үзвэл дахин хийлгэх эсвэл экспертиз томилж шалгуулах шаардлага тулгарч болно. Гэтэл Үндэсний аудитын газар нь Парламентын байгууллага атал доод шатны байгууллагадаа тайлагнах болж байна. Энэ нь удирдлагын харилцаанд зохимжгүй байдал үүсгэж болохоор байгаа юм. Ийнхүү аудитын хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим бэрхшээл гарч болзошгүй байна.

- Аудит хийхтэй холбогдуулж дунд хугацаанд боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авна.
- Төрийн аудитын хуулийг дахин хянаж сайжруулна.
- Үндэсний аудитын газрын орон нутгийн салбарын удирдлагуудыг өөрчилж, мэргэшсэн нягтлан бодогч болгох зохион байгуулалтын арга хэмжээ авна.
- Аудитын олон улсын стандартыг нэвтрүүлнэ.
- Аудитын үйл ажиллагааны удирдамж, гарын авлага, төрийн санхүүгийн аудитын дотоод стандарт боловсруулж батлан мөрдүүлнэ.
- Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хянан шалгагчдын мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Аудитыг төсвийн бүх байгууллага, төрийн өмчит газруудад хийнэ. Ингэснээр төсвийн болон төрийн өмчийн хөрөнгийн зохицуулалтын ил тод байдал, үр ашгийг дээшлүүлж, ядуучуудад очих ёстой хөрөнгө эзнээ олж, бодитой зарцуулагдаж байгаа эсэхэд төрөөс тавих хяналт сайжирна.

3.195 **Улсын мэргэжлийн хяналт.** Хяналтын албадууд нь 1991 оноос хойш янз бүрийн бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллаж ирсэн бөгөөд ихэвчлэн бодлого хариуцсан албад салбаруудад харъяалагдан ажиллаж байсан юм.

3.196 Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газрын 9 дүгээр сарын 6-ны өдрийн 139-р тогтоолоор :

1. Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Дэд бүтцийн хяналтын алба"
2. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Хөдөлмөр Нийгмийн хамгааллын улсын хяналтын алба"

3. Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Санхүүгийн улсын хяналтын алба”
4. Үйлдвэр худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Үйлдвэр худалдааны улсын хяналтын алба”
5. Хүнс хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба”
6. Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Байгаль орчныг хамгаалах алба”
7. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Эрүүл мэндийн улсын хяналтын алба”
8. Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Боловсрол соёл, шинжлэх ухааны хяналтын алба” гэсэн тохируулагч агентлагуудыг байгуулан ажиллуулж байв. Эдгээр агентлагууд нь дараах чиглэлээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байжээ. Үүнд :

3.197 Дэд бүтцийн хяналтын алба нь авто тээвэр, авто зам, аялал жуулчлал, барилга техник, геодези зураг зүй, нислэг техникийн хэргийг шинжлэн шалгах, харилцаа холбоо, түлш эрчим хүч гэсэн салбаруудад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн осол зөрчлийг арилгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байсан байна. Дэд бүтцийн хяналтын алба нь 66 орон тоотойгоор ажиллаж байсан.

3.198 Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын алба нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн стандарт, нийгмийн хамгааллын холбогдолтой бүх төрлийн сан, зээл тусламж, хандивын хөрөнгө бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт тавих үндсэн үүрэгтэй 28 орон тоотой ажиллаж байсан.

3.199 Санхүүгийн улсын хяналт шалгалтын газар нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай зориулалтын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, Засгийн газрын шугамаар авсан зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт болон төсвөөс санхүүжилт авдаг байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт, үр ашгийн байдлыг үндсэн баримтаар шалгаж үнэлэлт дүгнэлт гарган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж 200 гаруй орон тоотой ажиллаж байсан.

3.200 Үйлдвэр худалдааны улсын хяналтын алба нь геологи уул уурхай болон худалдаа үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр гаргасан Монгол улсын хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах ашигт малтмалын ордын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа болон худалдаа үйлдвэр үйлчилгээ, нефтийн бүтээгдэхүүний талаар мөрдөх олон улсын жишигт нийцсэн дүрэм журам заавруудыг боловсруулан гаргах, тэсрэх бодис, тэсэлгээний багаж, хэрэгслийн аюулгүй ажиллагаа хадгалалт хамгаалалт, олборлолтын явцад хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх уурхайг хайх, хайгуулын талбайг буцаан хүлээлгэн өгөхөд хяналт тавих үндсэн үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байсан.

3.201 Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба нь мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хил, гүний хяналт, мал аж ахуйн үржлийн болон таримал ургамлын үрийн чанар, сортын хяналт, мал сүрэг, аж ахуйн ашиг тустай амьтад таримал ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах чиглэлийн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үндсэн үүрэгтэй ажиллаж байсан.

3.202 Байгаль орчныг хамгаалах алба нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, байгаль орчин, экологийн салбарын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үндсэн үүрэгтэй ажиллаж байсан.

3.203 Эрүүл мэндийн, улсын хяналтын алба нь эрүүл ахуй, хилийн эрүүл ахуй, халдвар судлал, эм био бэлдмэл, эмчилгээний чанар гэсэн салбаруудын хяналтын чиг үүргийг

хэрэгжүүлж холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй ажиллаж байсан бөгөөд энэ албаны харъяанд холбогдох лабораториуд улсын байцаагчдыг зохих дүгнэлт гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүнээс шинжилгээ судалгааны үйл ажиллагаа явуулж байсан байна.

3.204 Боловсрол соёл, шинжлэх ухааны хяналтын алба нь бага, дунд боловсрол, шинжлэх ухаан, технологи, мэргэжлийн боловсрол, соёл урлаг гэсэн салбаруудын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар зохих арга хэмжээ авах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байсан.

3.205 Эдгээр хяналтын газруудын чиг үүргийг орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс, Байгаль орчны хяналтын газар, Мэргэжлийн хяналтын алба гэсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж байлаа. Улсын Их Хурлын 2002 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2002 оны “Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай” 162 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг болох Улсын мэргэжлийн хяналтын газар шинээр байгуулагдан ажиллаж байна.

3.206 Улсын мэргэжлийн, хяналтын газрын эрхэм зорилго нь хууль тогтоомж стандартын хэрэгжилтэнд төрийн захиргааны хяналт тавих замаар ард түмний өмнө Засгийн газрын хүлээх хариуцлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах явдал юм.

3.207 Энэ хүрээнд улсын мэргэжлийн хяналтын газрын үндсэн зорилт нь санхүү, даатгал, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, ахуй, халдвар судлал, эм биобэлдмэл, эмчилгээ, хөдөлмөр, боловсрол, соёл шинжлэх ухаан, цацраг, байгаль орчин, геодези зураг зүй, стандарт чанар, хэмжил зүй, барилга, авто зам, эрчим хүч, харилцаа холбоо, аялал, жуулчлал, тээвэр, геологи уул уурхай, үйлдвэр, худалдаа, мал эмнэлэг, үржил, ургамал хамгаалал, үр сорт, хорио цээр, хүнсний үйлдвэрлэл, технологийн хүрээнд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг хангуулахад оршино.

3.208 Улсын мэргэжлийн хяналтыг Монгол улсын нутаг дэвсгэрт Улсын мэргэжлийн хяналтын газар, улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн болон хилийн байгууллага, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хэрэгжүүлнэ.

3.209 Улсын мэргэжлийн хяналтын газар нь босоо удирдлагатай 21 аймаг, нийслэлд өөрийн мэргэжлийн хяналтын газруудтай ажиллаж байна.

3.210 Улсын мэргэжлийн хяналтын газар нь төвдөө 320, нийслэлд 290, аймаг, орон нутагт 560, Хилийн мэргэжлийн хяналтын албанд 120, нийтдээ улсын хэмжээнд 1250 улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

3.211 Хяналтыг хэрэгжүүлэхэд учирч буй зарим хүндрэл, бэрхшээл :

- Улсын хэмжээнд мэргэжлийн хяналт тавьж байгаа учир хяналт шалгалтын мэдээлэл системийн хэмжээнд нягт уялдаа холбоотой байх шаардлагатай. Мөн төрийн бусад байгууллагатай холбоотой байх зайлшгүй шаардлагатай учир компьютерийн нэгдсэн сүлжээнд холбох шаардлага зүй ёсоор гарч байна.
- Хяналтын албад нь яамдын дэргэдэх төсвөөс санхүүждэг байгууллагууд байсан учир материаллаг баазын хувьд хангалтгүй, төсөв нь хүрэлцэхгүй зөвхөн урсгал зардлаа санхүүжүүлдэг байснаас компьютер, хяналт шалгалтанд шаардлагатай бусад техник хэрэгсэл дутагдалтай байна. Мөн орон нутгийн улсын байцаагчид компьютер, техник хэрэгслээр хангагдаагүй, ашиглагдаж байгаа компьютер нь хүчин чадлын хувьд

хоцрогдсон, хяналт шалгалтын шаардлагатай техник хэрэгсэл авах хөрөнгийн боломжгүй байна.

- Улсын байцаагчдыг гадаад хэлний болоод мэргэжлийн, компьютер, техникийн сургалтанд байнга хамруулах, шинээр улсын байцаагчаар томилогдсон хүмүүсийг мэргэшлийн сургалтанд хамруулах зайлшгүй шаардлагатай байна.
- Мөн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих явцад хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага гарч ирдэг. Шалгалтын материалыг судалж, дүгнэлт хийж, судалгаа гаргах мэдээлэл, судалгааны төвтэй болох шаардлагатай байна. Улсын байцаагчдыг байнга давтан сургалтанд хамруулж байх сургалтын болон судалгааны төвтэй болох зүй ёсны шаардлага гарч байна.
- Манай улсын байцаагчид нь бүх салбарт ажиллаж, улсын хэмжээнд хууль тогтоомжийн, хэрэгжилтэнд хяналт тавьж, зөрчлийг илрүүлж, таслан зогсоох, арилгуулах арга хэмжээ авч ажилладаг, улсын байцаагчдын ажил хүнд, цалин бага байна. Улсын байцаагчид маань хууль бус зүйлтэй тулгарч байдаг учир авилгал, хээл хахуульд өртөхгүй, үнэнч шударгаар хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

3.212 Улсын байцаагчид нь холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дутагдлыг арилгах ажлыг хэрэгжүүлж байна. Энэхүү үйл явцад улсын байцаагчид төрөл бүрийн хууль бус үйл ажиллагаа, нөхцөлтэй учирдаг. Тиймээс байцаагч нарын дунд мэргэжилдээ үнэнч байх явдлыг дэмжиж, авилгал, хээл хахуулиас сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

3.213 . Монгол улсын Хяналт шалгалтын тухай хуульд “хэрэв улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэж явахдаа нийтийн тээврийн хэрэгслээр (таксинаас бусад) холбогдох журмын дагуу үнэ төлбөргүй зорчино.” гэж заасан. Энэ хуулийн заалтийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй боловч нөгөө талаас тэднийг унаагаар хангах боломжгүй юм.

VII. Төрийн албаны шинэчлэл.

3.214 **Төрийн алба.** Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд 1990 оноос шилжин өмч хувьчлалыг эрчимтэй хийж хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн бүтцийг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй зэрэгцэн эдийн засгийг төлөвлөдөг зохицуулдаг байсан захиргааны эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж улмаар төрийн захиргааны үүрэг ихээхэн өөрчлөгдөж ирсэн юм. Үүнтэй уялдаад төрийн албыг цомхотгох хэлбэрийн өөрчлөлтийг 1990 оны 3 сараас эхлэн өнгөрсөн 10 гаруй жилд хэд хэдэн удаа хийсэн юм. 1994 оноос зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд төрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох ажлыг Шведийн засгийн газрын тусламжтайгаар хийж “Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл” төслийг хэрэгжүүлсэн юм. Уг төслийн хүрээнд төрийн албанд зарим өөрчлөлтийг 1996 онд хийж 9 яам, 60 гаруй агентлаг, яаманд сайд, төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтэс гэсэн бүтэцтэй болгосон. 2000 онд яамдын тоог 12 болгож, дэд сайдын орон тоог нэмж бий болгосон. Гэвч төрийн алба, ялангуяа төрийн үйлчилгээ, төрийн захиргаа, төрийн тусгай албанд гэрээгээр гүйцэтгүүлэх зарим ажил үйлчилгээ, туслах ажил байсаар байна. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрууд бизнес стратегийн төлөвлөгөөгөө шаардлагын хэмжээнд боловсруулахгүй, ажлын байрны тодорхойлолт ажил үүргийн хуваарь нь тодорхойгүй байсаар байна.

-Төрөөс иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх шаардлагыг хангасан төрийн албан хаагчдын тоог бодитой тогтоогоогүйгээс төрийн албан хаагчдын орон тоо, цалингийн сан болон нийгмийн хамгаалалтай холбогдсон бусад арга хэмжээ улсын төсөвт бодитой тусгалаа олж чадахгүй байна.

-Төрийн албаны хүний нөөцийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт хийхэд шаардагдах мэдээлэл дутмаг, анхан шатны байгууллагууд төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн,

хөдөлгөөний тайлангийн тоон мэдээлэлд одоо ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг бүрэн хамруулдаггүй, төрийн жинхэнэ албаны дээд түвшний удирдах албан тушаалтны тогтвор суурьшил хангалтгүй байна.

-Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журам гараагүй албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах арга механизм бүрдээгүй, тухайн ажил эрхэлсэн ажилтнуудын туршлага дутмаг байна.

-Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдээс төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн хүмүүсийг нөөцөд бүртгэх, тэднийг шалгалт өгсөн албан тушаалынх нь сул орон тоонд томилуулах ажил ил тод, шударгаар хийгдэж чадахгүй байх тохиолдол гарсан хэвээр байна.

-Албан тушаалтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг бодитойгоор үнэлэх шалгуур үзүүлэлт дутмаг, удирдах албан тушаалтны үзэмжээр дүгнэдэг субъектив хандлагын нөлөөлөл их, албан тушаал дэвшүүлэх асуудлаар гомдол гаргах, түүнийг хүлээн авч хянан шийдвэрлэх, барагдуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

-Төрийн бүх шатны байгууллагад дотоод хяналтын тогтолцооны арга, механизм бүрдээгүй, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүлэх ажил шаардлагын хэмжээнд хүрээгүй, бүх шатны төрийн захиргааны байгууллага ажлаа төлөвлөх, тайлагнах, үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлж дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох харилцан уялдаа холбооны нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.

-Өнөө үед төрийн захиргааны албанд бакалавр болон түүнээс дээшхи түвшингийн боловсролтой хүн ажиллах эрэлт хэрэгцээ байгаа боловч нийт сум, багийн захиргааны байгууллагад бүрэн ба тусгай дунд боловсролтой, захиргааны удирдлагаар мэргэшүүлэх шаардлагатай 15000 гаруй хүн ажиллаж байна.

-Төрийн удирдлагаар мэргэшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалт эрхэлсэн төрийн өмчийн ганцхан байгууллага-Удирдлагын Академийн хүчин чадал, хичээлийн болон сонсогчдын дотуур байрны хүрэлцээ, тохижилт, үйлчилгээний соёл, суралцагчдын тоо, хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй байна.

3.215 Дунд хугацаанд баримтлах төсвийн шинэчлэлийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, төрийн албаны болон нийгмийн салбар дахь бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн, гарцад тулгуурласан санхүүжилт байх бөгөөд төрийн албанаас чөлөөлөх хүмүүсийн амьдралын баталгааг хангаж, ядуурлыг багасгах, төсвийн удирдлагын шинэчлэлийн цогц арга хэмжээ байх болно.

3.216 Дунд хугацаанд төлөвлөж буй улсын салбарын шинэчлэлийн нэг гол зорилт нь төсвийн удирдлагыг боловсронгуй болгох, тухайлбал, төрийн албаны туслах үйлчилгээ үзүүлж буй ажил үйлчилгээг гэрээ түрээсээр гүйцэтгүүлэх, улмаар арилжааны хэлбэрт шилжүүлэх, орон тоо, бүтэц зохион байгуулалтын давхардлыг арилгах, төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны болон стратегийн шинжтэй болгох, хөгжлийн тухайн үеийн бодлоготой нягт уялдуулан, нөөц ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн тайлагнал, хяналтын тогтолцооны нээлттэй ил тод байдлыг сайжруулахад чиглэнэ.

3.217 Улсын салбарын шинэчлэлийн салшгүй хэсэг бол төрийн албаны шинэчлэл буюу үр дүнгийн удирдлагын шинэ загварыг нэвтрүүлэх явдал юм. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүйгээр хамгийн бага зардлаар илүү үр дүнд хүрэх нь төрийн албаны шинэчлэлийн гол зорилго юм. Төрийн албаны шинэчлэлийг төрийн захиргаа болон үйлчилгээ, тусгай албаны бүх байгууллагыг хамруулан хийнэ. Үүнтэй уялдаад юуны өмнө нийгмийн салбар дахь хувьчлал, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэнэ. Засгийн газраас ядуурлыг бууруулах талаар баримталж буй бодлогын хэрэгжилтийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын ажлын үр дүнгийн үзүүлэлтээр илэрхийлэх боломжтой учраас эдгээр салбаруудын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын шинэчлэлд

онцгой ач холбогдол өгч байна. Харин төрийн албаны шинэчлэлийг хийхдээ сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, тодорхой шалгуурыг үндэслэн дэмжлэг үзүүлэх замаар ядуурлаас урьдчилан сэргийлэх нь чухал юм. Иймд төсвийн байгууллагуудын нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлох, түүнийг гүйцэтгэх үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийн явц байдалд хяналт тавих, үр дүнгийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, урамшуулах, хариуцлага тооцох зэрэг үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлнэ. Үүнтэй уялдаад ойрын жилүүдэд төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг анхаарна. Үүнд:

- Сул орон тоон дээр хүн томилохгүй байх,
- Тэтгэврийн насанд хүрсэн төрийн албан хаагчийг тэтгэвэрт нь гаргах,
- Өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх хүмүүст зохих тэтгэмжийг олгох, тэтгэмж олгох журам гаргах,
- Зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хэлбэрт шилжүүлэх,
- Яам, газрууд, аймаг, нийслэлийн Тамгын газрын бүтцийг шинэчлэх
- Зарим боломжтой байгууллагуудыг өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх
- УИХ-аас гаргасан зөвлөмжийн дагуу нийгмийн салбарт хувьчлал, өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх зэрэг болно.

Төрийн албаны шинэчлэлийн талаар дунд хугацаанд дараах зорилт арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдсэн төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлнэ.
- Яам агентлаг, аймаг, нийслэл, төсвийн бүх шатны байгууллагын бизнесийн стратегийн төлөвлөгөөг зохих шаардлагын дагуу боловсруулж, түүнийг үндэслэн ажил, үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг зохих журмын дагуу боловсруулан баталж мөрдүүлнэ.
- Төрийн албаны боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох, уг хэрэгцээг хангах хүний нөөцийн төлөвлөлтийн стандарт, аргачлал боловсруулж зарим яам, аймгийн хэмжээнд нэвтрүүлнэ.
- Аймаг, нийслэл, яамдаас гаргуулан авч байгаа төрийн албан хаагчдын дэлгэрэнгүй бүртгэлийг нэгтгэсний үндсэн дээр төрийн албаны боловсон хүчний нөөцийн одоогийн байдлыг тогтоож, үнэлэлт, дүгнэлт өгнө.
- Хүний нөөцийн мэдээллийн асуудал хариуцсан бүх шатны ажилтныг сургах, төрийн байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр хангах, төрийн албан хаагчдын байршил, хөдөлгөөнийг үр нөлөөтэй төлөвлөж зохицуулах чадавхи бий болгоно.
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын (оновчтой шалгуур үзүүлэлт бүхий) мэдээллийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн шинэ тогтолцооны өгөгдөл үзүүлэлтүүдийг олон улсын орчин үеийн жишигт нийцүүлэн шинээр боловсруулж ашиглана.
- Дэлхийн банкны шинжээчдийн оролцоотойгоор төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн шинэ тогтолцооны олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг монгол, англи хэл дээр ашиглаж болох байдлаар боловсруулж хэрэглэнэ.
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн улсын хэмжээний нэгдсэн сүлжээ буй болгож зүгшрүүлнэ.
- Төрийн бүх байгууллагыг хамарсан хүний нөөцийн мэдээллийн шинэ сүлжээ буй болгох замаар бодитой мэдээллийг төрийн бүх шатны байгууллагаар гаргуулан авч, нэгтгэх нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрийн албаны бүх түвшний ажилтныг нээлттэй, ил тод, мерит зарчимд үндэслэн сонгон шалгаруулах тогтолцоог төлөвшүүлнэ.

-Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд ажилтныг сонгон шалгаруулах журмын төслийг нээлттэй, ил тод байх зарчимд тулгуурласан үзэл баримтлалаар боловсруулж, УИХ-аар батлуулж мөрдөж ажиллана.

-Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд ажилтныг сонгон шалгаруулах комиссыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулан ажиллуулна.

-Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэний нөөцийг зөв бүрдүүлж, тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шударгаар зохион байгуулна.

-Төрийн жинхэнэ албанд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журмыг нээлттэй, ил тод байх зарчмаар шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөл батлан хэрэгжүүлэх;

-Удирдлагын бүх түвшинд төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэх үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх нэгдсэн стандартыг тогтоосон журам баталж мөрдүүлнэ.

- Албан тушаал дэвшүүлэх, түүнтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлнэ.

-Төрийн албан хаагч албан тушаал дэвших, зэрэглэл, зэрэг дэв ахих шалгуур үзүүлэлтийг нарийвчлан судалж, түүний үндсэн дээр энэ харилцааг зохицуулсан журам батлан гаргаж мөрдүүлнэ.

-Төрийн албан хаагч албан тушаал дэвших асуудлаар гаргасан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

- Төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн хэрэгцээтэй уялдуулан төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг ахиулна.

-Дунд хугацааны стратегитай уялдуулан Улсын хэмжээгээр төрийн албан хаагчдын сургалтын эрэлт хэрэгцээг зорилго, агуулга, тооны болон бусад үзүүлэлтээр судалж тодорхойлно.

-Төрийн албан хаагчдын дотоод, гадаад сургалтын нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

-Засгийн газрын 1999 оны 96 тогтоолоор баталсан “Төрийн албаны сургалт ба мэдлэг, чадвар бий болгох хөтөлбөр”-ийн дагуу бүх шатны төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдах ажилтнуудыг 2003-2006 онд мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.218 Засгийн газар дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах макро эдийн засгийн тэнцвэрийг улсын салбарын бүтцийн өөрчлөлтийн үндсэн дээр хангана. Эдгээр арга хэмжээний гол хэсэг нь бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн улмаас бий болох ядуурал болон сөрөг үр дагаврыг бууруулах юм. Улсын салбарын өөрчлөлт, шинэчлэл нь төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах төдийгүй нийгмийн ядуу хэсэгт үзүүлэх үйлчилгээг сайжруулах, чанарыг дээшлүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох явдал юм. Төсвийн тогтвортой байдал нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндэс суурь нь болно. Үнийн хэлбэлзэл болон ханшийг тогтворжуулах, гадаад худалдааны алдагдлыг бууруулж, арилгах явдал нь макро эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлнө. Улсын салбарын шинэчлэлд Монгол улсын Засгийн газар дотоод эх үүсвэрээ ашиглах бөгөөд олон улсын байгууллагуудаас зарим техник туслалцааг авах болно.

БҮЛЭГ 4. ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

I. Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх

4.1 Монгол улс зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хувийн хэвшлийг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх чиглэлээр олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Өмнөх бүлэгт өгүүлсэн макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах стратеги, улсын салбарын шинэчлэл нь бизнес эрхлэх таатай орчны нэг юм.

4.2 Урт болон дунд хугацаанд хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд чиглэсэн бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх нь Засгийн газраас баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл юм. Засгийн газраас макро эдийн засгийн

тогтворжилтыг бататгах, тэр дундаа үнэ ханшийг тогтвортой байлгах, гадаад дотоод зах зээлийн хүрээг тэлэх замаар бизнес эрхлэх, ялангуяа хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн өөрсдийн идэвхи, санаачлагыг өрнүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

II. Хууль эрхзүйн орчин

4.3 Нийгэмд гарсан өөрчлөлт шинэчлэлтийг бататган амжилттай хэрэгжүүлэхэд эрх зүйн шинэтгэл, түүний үзүүлэх үр нөлөө чухал үүрэгтэй билээ.

4.4 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталснаар уг хуулийн үзэл баримтлалын дагуу улс орны хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох, нийгмийн шинэ харилцааг зохицуулсан хууль эрх зүйн оновчтой тогтолцоо бүрдүүлэх үйл явц эхэлсэн гэж үзэж болно

4.5 Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн үйл явцыг Үндсэн хууль батлагдсанаас хойш Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэлх буюу 1992-1998 он хүртэл, 1998 оноос өнөө үе хүртэл гэж цаг хугацааны хувьд хоёр үндсэн хэсэгт хамааруулан авч үзэж болно. Эрх зүйн шинэтгэлийн эхний үе болох 1992-1998 он хүртэл хугацаанд Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгааг хангах, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, эдийн засаг, нийгэм, улс төрийн салбарт олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм. Тухайлбал, сонгууль, парламент, Ерөнхийлөгч, Засгийн газрын эрх зүйн байдал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төсөв, батлан хамгаалах, хил, гаалийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн олон хуулийг баталсан. Мөн эдийн засгийн салбарт Өмч хувьчлалын тухай, Аж ахуйн нэгжийн, Аж ахуйн нэгжийн дампуурлын, Татварын, Банкны, Шударга бус өрсөлдөөний тухай зэрэг олон хуулийг батлан гаргасан байна.

4.6 Монгол улсын үндсэн хуульд өмчийн олон хэвшил, эрх тэгш байхаар заасны дагуу хувийн хэвшил хөгжих үндэс тавигдсан юм. 1990-2000 оны хооронд компанийн тухай хууль бий болж хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулан мөрдөж байна. Мөн шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хуулийг 1994 оноос эхлэн мөрдөж байна. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулахад нь олгох элдэв зөвшөөрөл, хориг хязгаарлалтыг багасгах арга хэмжээг авч байна. 1992-1998 онд Улсын Их Хурал 180 орчим бие даасан хуулийг батлан гаргаж, 200 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 60 орчим олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон байна.

4.7 1998 онд Улсын Их Хурал эрх зүйн шинэтгэлийн гүнзгийрүүлэх, энэ ажилд төлөвлөгөө, нэгдсэн бодлогоор хандах үүднээс Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталсан байна. Энэ цаг үеэс эрх зүйн шинэтгэлийн 2 дахь үе эхэлсэн гэж үздэг.

4.8 Энэ хөтөлбөрийн дагуу Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан бөгөөд үүний дагуу 118 хууль батлахаар зааснаас 70 орчим хуулийн төслийг баталжээ.

4.9 Энэхүү баримт бичигт “Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь Монгол Улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм, цогцлуулан байгуулах зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчин бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

4.10 Үүний дараа Улсын Их Хурал 2001 онд Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан. Энэ чиглэлд нийт 136 хууль батлахаар тусгагдсанаас 2002 оны байдлаар 60 гаруй хуулийг батлаад байна.

4.11 Тусгай зөвшөөрөл авч үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тоог цөөрүүлсэн шийдвэр гаргаж гааль дээрхи олон шалгалт хураамж төлбөрийг нэгтгэн цөөрүүлэх арга хэмжээг 2002 онд авч хэрэгжүүллээ. Ингэснээр бизнес эрхлэх эрхзүйн таатай орчин улам сайжирлаа. 2001 онд Улсын Их Хурлаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас авах тухай хуулийг тус тус баталсан.

4.12 Нийгмийн бодлогын чиглэлээр 2002 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг баталсан. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, даатгалын сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтыг салбарын онцлог, бодлого, стратегитай уялдуулах, даатгуулсан иргэн бүр даатгалын ашиг тусыг хүртэх боломж бүрдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл мэндийн даатгалыг бие даалган хөгжүүлнэ” гэж заасныг удирдлага болгон хуулийг боловсруулсан болно.

4.13 Мөн Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай зэрэг багц хуулийг шинэчлэн баталсан. Эдгээрээс Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль нь шинэ хууль бөгөөд уг хуулиар мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, агуулга, бүтэц, түүний удирдлага зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Өнгөрсөн хугацаанд энэ талаар төрөөс баримтлах бодлого нэлээд орхигдож байсан бөгөөд хүн амын дундаж болон түүнээс доош давхаргад хамаарагдах хэсгийг мэргэжил эзэмшүүлэх, тэдний амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын чухал арга хэмжээ юм.

4.14 Мөн 2003 онд Улсын Их Хурал Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг баталсан юм. Нийгмийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний чанар, үр ашиг хүртээмжийг сайжруулах зорилгоор энэхүү үндсэн чиглэлийг баталсан. Үндсэн чиглэлд нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэр, хамрах хүрээ, авах арга хэмжээг бүрэн тодорхойлсон.

4.15 Нийгмийн бодлогын хүрээнд ядуурал, ажилгүйдэл, орон байрны асуудал, эрүүл мэндийн асуудалд чиглэсэн хууль тогтоомжууд батлагдаж байгаа ч боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдсаар байна. Тухайлбал, ядуучуудын эрүүл мэндийн даатгалын асуудал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны доод түвшин зэргийг эргэн харж хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь ядуурлыг бууруулахад чухал хувь нэмэр болно

4.16 2002 оныг шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаа, зохион байгуулалтын хувьд нилээд шинэчлэл, өөрчлөлтийн жил болсон гэж нэрлэж болно. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хууль сахиулах байгууллагуудын чиг үүрэг, зохион байгуулалтад зарчмын өөрчлөлт оруулах, улмаар нийгмийн дэг журмыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, бататгахад чиглэсэн олон арга хэмжээг энэ онд авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд шинээр батлагдсан бөгөөд Прокурорын байгууллагын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Нотариатын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай зэрэг хуулиудад тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

4.17 Мөн эдийн засаг, төсөв, санхүүгийн чиглэлд хууль тогтоомжийг боловсронгуй болгох нилээд ажил хийгдэв. Тухайлбал, Үнэт цаасны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн тухай хууль, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийг баталсан байна.

4.18 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийн зорилго нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсвийн удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, төсөв захирагч нарын хариуцлагыг дээшлүүлэх, орон нутгийн захиргааны байгууллагын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чиглэгдэж байгаа юм.

4.19 Авилгалтай тэмцэх асуудал төрийн бодлогын чухал хэсэг байсаар ирснийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Энэ чиглэлд 2001 онд Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан. 1996 онд Авилгалын эсрэг хууль батлагдсан боловч түүний хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд төрийг албан ёсны хэм хэмжээ төлөвшөөгүй байна. Авилгалын эсрэг тэмцэх, түүнийг бууруулах ажлыг тууштай зохион байгуулан амжилтад хүргэхэд нийгэм, иргэдийн идэвхтэй оролцоо, тэдний дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байна. Ийм учраас төр засаг, иргэний нийгмийн хүч боломжийг нэгтгэн авилгалын эсрэг тэмцэхэд чиглэсэн урт хугацааны бодлого болгон энэхүү хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсад авилгалтай тэмцэх нөхцөл бүрдүүлэх, нийгэмд авилгалыг үл тэвчих уур амьсгалыг бий болгох, төр засаг иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр авилгалаас урьдчилан сэргийлэх, улмаар түүний үүсч буй шалтгаан, нөхцөлийг хязгаарлах, арилгахад оршино.

4.20 Авилгалтай тэмцэх, төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, иргэд хуулийн этгээдийн аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд хийгдсэн томоохон ажлын нэг нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль юм. Энэ хуулиар давхардсан тоогоор 600 гаруй тусгай зөвшөөрөл олгодог байсныг 95 болгож өөрчилсөн. Ийнхүү бизнес эрхлэх хууль эрхзүйн орчин үндсэндээ бүрдсэн.

4.21 **Хууль тогтоомжийн сурталчилгаа, хэрэгжилт.** Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн санаа бодлыг тусгах асуудал зайлшгүй анхаарах ёстой асуудлын нэг мөн. Энэ асуудлыг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд зааснаар зохицуулж байна. Хуульд хуулийн төсөл санаачлагч нь тухайн боловсруулж буй хуулийн төслийн талаар эрдэмтэд, төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авч болохоор заасан. Түүнчлэн хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тохиолдолд Улсын Их Хурал шийдвэрлэхээр заажээ.

4.22 Дээр дурдсан хуулиас өөр энэ асуудлыг зохицуулсан эрх зүйн акт байхгүй бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан хуулийн төсөл боловсруулахын тулд олон нийтээс санал авах тогтвортой, төлөвшсөн механизмыг бүрдүүлэх явдалд анхаарах хэрэгтэй байгаа юм.

4.23 Батлагдсан хууль тогтоомжийг сурталчилах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах асуудалд шинэлэг байдлаар хандахыг шаардаж байна. Төрөөс олон тооны хууль тогтоомжийг батлан гаргаж байгаа ч түүнийг сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулах явдал хангалтгүй байгаагаас хууль тогтоомжийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нь зохих ёсоор хэрэгжихгүй байна. Хууль тогтоомжийг сурталчилах ажил ялангуяа хөдөө, орон нутагт ихээхэн дутагдалтай байгаа бөгөөд энэ асуудлын гол шалтгаан нь хөрөнгө мөнгө, төсвийн хүрэлцээгүй байдлаас гадна төрийн байгууллага, албан тушаалтны санаачилга, идэвх зүтгэлээс ихээхэн хамаарч байна.

4.24 **Дунд хугацааны зорилтууд.** Цаашид эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын чанартай баримт бичгүүдийг удирдлага болгон ажиллана.

4.25 Эрх зүйн шинэтгэл, засаглалын бэхжилтийн хүрээнд баримтлах ойрын хугацааны зорилт бол “Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэн хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг бэхжүүлэх замаар хүний эрхийг хамгаалах, хүнийг чөлөөтэй хөгжүүлэх, иргэдийн амгалан тайван байдлыг төлөвшүүлэх” явдал юм. Энэ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд туссан хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажилд анхаарна.

4.26 Түүнчлэн батлагдсан хуулиудыг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах ажилд онцгой анхаарал тавина. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан гарын авлагын хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэн, хууль зүйн сурталчилгааг, оновчтой, хүрээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах, ялангуяа хууль тогтоомж гарын авлагыг хэвлүүлж баг, сумдад болон иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна, ”шүүх эрх мэдлийн хүрээний шинэ хуулиудын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, түүнд нийцүүлэн шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааны дэг журам, зохион байгуулалтыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан юм.

4.27 Төрийн захиргааны байгууллагын шинэчлэлийг эрчимжүүлэх бодлогын зорилтын хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, төрийн албаны үйл ажиллагааны стандарт, дүрэм, заавар, журмыг шинэчилэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.28 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Арбитрын тухай, Хуульчдыг сонгон шалгаруулах журмын тухай хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцэхээр бэлтгэж байна. Даатгалын тухай, Дампуурлын тухай, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах сангийн тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж шийдвэрлүүлнэ. Эрчим хүч, зам, холбоо зэрэг дэд бүтцийн суурь салбарууд нь эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, ядуурлыг бууруулахад чухал байр суурьтай. Иймд дэд бүтцийн салбар нэг талаас эдийн засгийн өсөлтийг түргэтгэх нэг хүчин зүйл болж, хүн ам, тэр дундаа ядуучуудад орлого олох боломжийг бүрдүүлнэ.

III. Дэд бүтэц

4.29 Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхэд нэн тэргүүнд эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх явдал онцгой ач холбогдолтой. Энэ нь Монгол орны нэг онцлог гэж үзэж болно. Хүн ам цөөн, таруу сийрэг байршсан тул нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох дэд бүтцийн материаллаг бааз хэт бага юм.

4.30 **Эрчим хүч.** Монгол улсын эрчим хүчний салбар нь Төвийн эрчим хүчний сүлжээ /ТЭХС/, баруун, зүүн бүсийн эрчим хүчний сүлжээ, дизелийн цахилгаан станц, дулааны цахилгаан станцуудаас бүрдэж байна. ТЭХС-д нийт 11 аймгийн төв, 102 сумын төв, ББЭС-д 3 аймгийн төв, 8 сумын төв, аймгийн төвүүдийн төвлөрсөн цахилгаан хангамжид 12 сум, усан цахилгаан станцад 3 сум тус тус холбогдсон байна. Ингэснээр төвлөрсөн эрчим хүчний хангамжаас нийт сумдын 44 орчим хувь, үлдсэн нь орон нутгийн жижиг дизель станцаас эрчим хүч хэрэглэж байна. Эдгээрийг Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр шинэчлээд байна. Газарзүйн байршил, хүн амын орлогын ялгаатай түвшингээс шалтгаалан сумдын цахилгаан хангамж, хүртээмж харилцан адилгүй байна. Монгол Улсын эрчим хүчний салбар нь Төвийн эрчим хүчний систем, Зүүн бүсийн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний систем болон төвлөрсөн эрчим хүчний системд холбогдоогүй аймаг, сумын төв, суурин газруудын дизелийн цахилгаан станц, дулааны цахилгаан станцаас бүрдэж байна.

4.31 Өнөөдрийн байдлаар Монгол Улсын төв бүс нутгийн 40 гаруй, хүн амын 50 гаруй хувь нь Төвийн эрчим хүчний систем /ТЭХС/-ээс цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна.

4.32 Монгол Улсын төвийн хэсэгт нийт суурилагдсан хүчин чадал 764 мвт бүхий 7 дулааны цахилгаан станц ажиллаж байгаагийн 2 нь орон нутагт байрлаж байна.

4.33 Манай улсад 220 квт-ын 1044 км, 110 квт-ын 2500 орчим км, 35 квт-ын 4000 шахам км цахилгаан дамжуулах шугам, 220 квт-ын 5, 110 квт болон 35 квт-ын 150 гаруй дэд өртөөтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

4.34 Дорнод аймгийн төвийн 36 мвт-ын дулааны цахилгаан станцаас Чойбалсан-Баруун-Уртын цахилгаан дамжуулах шугамаар Сүхбаатар аймгийн төв цахилгаан эрчим хүчээр хангагдаж эхэлсэн нь манай улсын дорно хэсэг дэх орон нутгийн эрчим хүчний бие даасан жижиг системийн эхлэл боллоо.

4.35 Даланзадгад хотын 6 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц 2000 онд ашиглалтад орсноор Өмнөговь аймгийн төв болон ойр орчим нь орших сумын төвүүд, жуулчин баазууд найдвартай эрчим хүчээр хангагдах нөхцөл бүрдлээ.

4.36 Эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй сумдад дизель хөдөлгүүр ашигладаг бөгөөд дизель хөдөлгүүр нь зардал ихтэй, үнэ өндөртэй байна. Тиймээс сумдын иргэд зардлаа хэмнэн хоногт хэдхэн цаг эрчим хүч хэрэглэж байна. Эдгээр сумын сургууль, эмнэлэг зэрэг байгууллагууд өвлийн цагт хэвийн нөхцөлд ажиллах боломжгүй шахам байдаг бөгөөд эрчим хүч хэрэглэдэг жижиг үйлдвэрүүд байнгын ажиллагаатай байж чадахгүй байна. Хүн амын 40 орчим хувийг эзэлдэг малчид эрчим хүчээр үндсэндээ хангагдаагүй бөгөөд малчин өрхийн 10 орчим хувь нь л зөвхөн гэрэл чийдэн асааж ажиллуулах төдий бага хүчин чадал бүхий жижиг цахилгаан үүсгүүртэй байна. Иймээс цахилгаан, дулаанаар хангагдаагүй өрхүүд ядуу өрхийн тоонд шилжих магадлал өндөр байна.

4.37 Эрчим хүчний салбар нь Засгийн газрын шугамаар авдаг гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр өргөтгөл шинэчлэл хийдэг боловч техник технологийн хувьд хоцрогдсон, өртөг зардал өндөртэй, шугамын алдагдал ихтэй, байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна. Иймээс үйлдвэрлэн гаргаж буй эрчим хүч, дулааны үнэ өндөр тул орлого багатай иргэд, аж ахуйн нэгжүүдэд бэрхшээл учруулж байна.

4.38 Монгол улсын эрчим хүчний салбар нь тус улсын дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн чухал хэсэг бөгөөд эрчим хүчний салбарын үйл ажиллагаанаас тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, бүс нутгийн хөгжил болон бусад салбарын үйл ажиллагаа шууд холбоотой нь хэн бүхэнд ойлгомжтой байна.

4.39 Дэд бүтцийг сайжруулах, ялангуяа эрчим хүчний найдвартай тогтолцоог бүрдүүлэх явдал нь ядуурлыг бууруулах болон бүс нутгийн хөгжилд түлхэц үзүүлэх урьдчилсан суурь нөхцөл болдог.

4.40 Олон жилийн туршид цахилгаан, дулааны үнийг хатуу барьж байсны улмаас эрчим хүчний салбар нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах чадваргүй болж, хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлт, их засварын ажлыг өөрийн хөрөнгөөр хийж чадахгүй болсноос гадаадын зээл, тусламжийн нилээд хэсгийг авсан билээ.

4.41 1992-2000 онд гадаадаас 400 сая ам. долларын зээл, тусламжаар дулааны цахилгаан станцуудад хэсэгчилсэн шинэчлэлт хийж, сэлбэг материалаар хангах арга хэмжээ авсны үр дүнд эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнд тогтворжих хандлага гарч байгаа боловч хямралт байдлаас бүрэн гараагүй байна.

4.42 Хүн амын 50 хувь нь төвийн эрчим хүчний сүлжээнээс цахилгаан дулаанаар хангагдаж байна. Эрчим хүчний энэ сүлжээ нь хэт их төвлөрсөн, 100 хувь төрийн өмч дээр байна. Эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангахтай холбогдсон үнэ өртгийг хянаж зохицуулах чадвар сул, орчин үеийн зах зээлийн зарчимд нийцсэн үнэ,

тариф болон төлбөрийн уян хатан тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, борлуулалтын орлого цуглуулалт хангалтгүй, удирдлагын давхардсан шат дамжлагатай, санхүүгийн хүндрэлд байнга байдаг, өр авлага ихтэй болон техникийн бус алдагдал ихтэй байна. Ийм учраас эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх, зах зээлийн нөхцөлд тохируулан арилжааны горимоор ажиллуулах хууль эрхзүйн орчин шаардагдаж байв. Монгол улсын Засгийн газар 2001 онд Эрчим хүчний тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж эхэлснээр эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, бие даасан, хараат бус төрийн зохицуулалтын механизмыг бий болгох, хувийн хэвшлийг тус салбарт орж ирэх нөхцөлийг бүрдүүлж, тус салбарт өрсөлдөөнийг бий болгох эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр шаардлагатай чухал алхмууд хийж байна.

4.43 Эрчим хүчний бүтцийн өөрчлөлтийн чухал хэсэг болох бие даасан, хараат бус зохицуулалтын механизмыг бий болгож, Эрчим хүчний зохицуулах газар /ЭХЗГ/- ыг байгуулснаар тус салбарт гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжтой боллоо. Бие даасан зохицуулалтын орчинг бүрдүүлснээр хамгийн хямд үнэ тарифаар хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, өрсөлдөөнийг бий болгох, үр ашгийг дээшлүүлэх эрх зүйн орчинг бий болсон юм.

4.44 Эрчим хүчний төрийн өмчит үйлдвэрийн газруудыг үйл ажиллагааны чиглэлээр нь задалж, үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт бүхий 18 төрийн өмчит хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниудыг байгууллаа. Эдгээр компаниудын хувьцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын шийдвэрээр Дэд бүтцийн яам, Төрийн өмчийн хороо, Санхүү, эдийн засгийн яам эзэмшиж байна.

4.45 Хувийн хэвшлийг тус салбарт татан оруулахад тус салбарт үүссэн хэрэглэгчид, түгээх компаниуд, станцууд, нүүрсний уурхайнуудын хуримтлагдсан өр авлагыг шийдвэрлэх, үнэ тарифыг үйлдвэрүүдийн үйл ажиллагааны зардлаа нөхөх хэмжээнд хүргэх, түгээх сүлжээний алдагдлыг бууруулах, орлого цуглуулалтыг сайжруулах, төлбөрийн нэхэмжлэлийг боловсронгуй болгоход дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг багагүй ажил хийгдэж байна.

4.46 Дэд бүтцийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2002 оны 214/155 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувьчлах бодлогыг боловсруулахаар ажиллаж байна.

4.47 2003 онд “Улаанбаатарын 2-р цахилгаан станц” ХК, “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийг хувьчлах, “Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийг хувьчлах бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна. 2002 онд Ховд аймгийн эрчим хүчний барилга угсралтын “Алтай” ТӨҮГ-ийг дуудлагын худалдаагаар, 2003 онд “Багануурын дулааны станц” ХК, “Налайхын дулааны станц” ХК нь менежментийн гэрээгээр тус тус хувьчлагдаад байна. Эрчим хүчний тухай хууль 2001 онд гарч, эрчим хүчний 18 хувьцаат компанийг зохион байгуулан арилжааны горимд оруулсан нь томоохон алхам болсон. Мөн эрчим хүчний үнийг чөлөөлж, нэмэх арга хэмжээ авлаа. Эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбогдоогүй сумдын дизель цахилгаан станцыг Япон улсын тусламжтайгаар 2000-2002 онд бүгдийг шинэчлэв. Улсын төсвийн хөрөнгөөр цахилгаан дамжуулах 400-600 км урт шугамыг жил бүр барьж аймаг, сумыг эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбох арга хэмжээ авч байна.

4.48 Үнэ өртөг хямд усны эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэх чиглэлээр усан цахилгаан станц барих, түүний хөрөнгийн эх үүсвэрийг олох талаар 2000-2002 онд хэд хэдэн арга хэмжээ авав. Гэвч хөдөө, орон нутгийг үнэ өртөг хямд эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр бүрэн хангах, малчин өрхийг цахилгаанжуулах, эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах, эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах ажил бэрхшээлтэй хэвээрээ байна. Үүнээс шалтгаалаад хөдөөд жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр бий болгох, иргэдийн оюун санааны хэрэгцээг хангах ажил хязгаарлагдаж, ядуурлыг бууруулах боломжийг багасгаж байна.

4.49 Монгол Улсын эрчим хүчний гол эх үүсвэр бол нүүрс юм. Нүүрсний уурхайнууд нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хувьцаат компаниуд хэлбэрээр ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоосон үнээр нүүрсээ борлуулж байна.

4.50 Монгол улсын нүүрсний уурхайнууд нь ил уурхай бөгөөд 1990-иэд оны дунд үеэс том уурхайнуудад эхэлсэн техникийн шинэчлэл 2002 онд үндсэндээ дуусав.

4.51 Зарим нүүрсний уурхай удаан хугацааны турш ашиглагдаж байгаагаас бөгөөд хүн ам ба үйлдвэрлэл өндөр нягтшралтай зарим бүсүүдийн нүүрсний нөөц дуусч байгаа бөгөөд уурхайнууд технологийн хувьд хоцрогдож байна. Тэдгээрийн нэг нь Төвийн бүсэд байрлах Шарын Голын нүүрсний уурхай юм. Эдийн засгийн хөгжлийн гол тулгуур бүсүүдийн нүүрсний хэрэгцээг хангахын тулд нүүрсний уурхайнуудын технологийн шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд Дархан, Сэлэнгэ аймгуудад шинээр нүүрс олборлох үйл ажиллагаа эхэлж байна. Үүнд Улаан-Овоогийн нүүрсний уурхайн бэлтгэл ажил хийгдсэн бөгөөд бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэнэ. Нүүрсний уурхайнууд ядуу иргэдийг нүүрсээр хангахад гол үүрэг гүйцэтгэдэг. Иймээс хот, хөдөө орон нутагт суурьшдаг ядуу иргэдийг хямд нүүрсээр хангах ажил хийгдэнэ.

4.52 2000 оны 10 сараас өмнө үүсч хуримтлагдсан өрийг тусгай хуваарийн дагуу барагдуулах, түүнээс (10 сараас) хойш нийлүүлэгдэх нүүрсний төлбөрийг цаг тухайд нь хийж байх журам тогтоож 2 жил ажилласан нь үр дүнтэй болж, шинээр өр үүсээгүй байна. Энэ өр авлагыг барагдуулахад эрчим хүчний борлуулалтын орлогыг бүрэн цуглуулах асуудал ихээхэн нөлөөтэй. 2000 оны 10 сараас өмнө үүсч хуримтлагдсан өр 2003 оны 2 сарын байдлаар 7.0 тэрбум төгрөгөөр багасч 41 хувиар буурсан байна. Улаанбаатарын III, Дархан Эрдэнэтийн дулааны цахилгаан станцууд өрөө бүрэн барагдуулаад байна.

4.53 Урт болон дунд хугацаанд эрчим хүчний салбарт баримтлах гол бодлого нь эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийг хангаж, үр ашигтай эрчим хүчний хангамжийг бий болгон, түүнд хувийн хэвшил иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаанд тулгуурлан шинэ дэвшилтэт техник технологийн ололтыг нэвтрүүлж, тус салбарын үр ашгийг дээшлүүлж ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах явдал юм. Бодлогын хувьд эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай орчинг бүрдүүлэх, тус салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах явдлыг дэмжих, тус салбарын төрийн өмчит хувьцаат компаниудыг арилжааны хэлбэрт шилжүүлж улмаар шат дараатай хувьчлахад тэргүүн зэргийн ач холбогдол өгч байна.

4.54 Эрчим хүчний салбарт 2002 оны 7 сард Монгол Улсын Засгийн газрын 140-р тогтоолоор баталсан “Монгол Улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө”-г үе шаттайгаар хэрэгжүүлнэ. “Монгол Улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө” нь доноруудын тусламж дэмжлэгтэйгээр боловсруулагдсан бөгөөд энэхүү ЭЗӨХЯБСББ-тэй зарчимын хувьд нийцсэн бодлогын баримт бичиг юм.

4.55 Монголын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн 2010 он хүртэлх стратеги нь дараахь үндсэн зарчмууд дээр тулгуурласан. Үүнд

4.56 Санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлснээр эрчим хүчний салбарыг улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц өгөх, улсын төсөвт үзүүлж буй дарамтыг бууруулан аажмаар арилгах

4.57 Бүтцийн өөрчлөлтийг хийснээр салбарыг арилжааны хэлбэрт шилжүүлж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх

4.58 Бүтэц, зохион байгуулалт, удирдлагын чадавхийг нэмэгдүүлснээр зах зээлийн харилцаанд амжилттай шилжих

4.59 Эрчим хүчний хангамжийг сайжруулж, амьжиргааны түвшинтэй уялдуулсан үнийн тогтолцоог бий болгосноор хүн амын орлого багатай болон хөдөө орон нутагт байгаа хэсэгт бүтцийн өөрчлөлтийн үр шимийг хүртээх

4.60 Эрчим хүчийг хэмнэх замаар үр ашгийг нь дээшлүүлэх, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зэрэг болно.

4.61 Эрчим хүчний салбарын үр өгөөжийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор эрчим хүчний хямд эх үүсвэрийн ашиглалтыг өргөжүүлнэ. Энэ бодлогын хүрээнд тодорхой бүс нутгуудад усан цахилгаан станцыг барьж, эрчим хүчний шугамын уртыг нэмэгдүүлнэ.

4.62 Эрчим хүчний салбарт үүссэн өрийн сүлжээний дийлэнхи нь ахуйн хэрэглээ, тэр дундаа орлого багатай иргэдтэй холбоотойг харгалзан хүн амын орлогын түвшинтэй уялдуулан эрчим хүчний уян хатан тариф, үнийн тогтолцоог боловсруулж нэвтрүүлнэ. Ингэхдээ ядуу иргэдийн цахилгаан, дулаан хангамжийн наад захын хэрэгцээг хангах бодлогыг баримтлана. Үүнтэй уялдаад ядуу хүмүүст нөлөөлөх эрчим хүч, дулаан, нефть бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөллийг бууруулах асуудлыг судална. Эрчим хүчний түгээх хэсгийг эхний ээлжинд хувьчилж борлуулалтын орлого цуглуулалтыг сайжруулна.

4.63 Хөдөө орон нутагт, тэр дундаа газарзүйн хувьд төвөөс алслагдсан сум, сууринд нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, иргэдийн ахуйн хэрэгцээг хангах зорилгоор сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг өргөн ашиглана. Ийнхүү эрчим хүчний салбарын хөгжил нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, ажлын байр нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

4.64 *Тээвэр.* Монголын тээврийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь авто, агаарын болон төмөр замын тээвэр юм.

4.65 *Авто зам, гүүр.* Монгол улсад авто тээврийн хэрэгсэл зорчдог улсын чанартай 11063 км авто замтайгаас 1317.6 км буюу 12 хувь нь хатуу хучилттай, 1379 км буюу 12.5 хувь нь хайрган хучилттай засаж сайжруулсан, бусад нь байгалийн ердийн хөрсөн зам байна. Засгийн газар шинээр зам тавих болон ашиглаж байгаа замуудаа засварлах, замын ашиглалтыг сайжруулахад бодлогоо чиглүүлж байна. Засгийн газраас авто замын салбарт бүтцийн өөрчлөлт хийснээр зам барилга, засвар арчлалтын байгууллагуудыг хоёр салган засвар арчлалтын хэсгийг төрийн өмчийн мэдэлд хэвээр үлдээн зам барилгын хэсгийг хувьчлаад байна. Ингэж бүтцийн өөрчлөлт хийснээр улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтыг цомхон засвар арчлалтын байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломж бүрдлээ. Мөн түүнчлэн хувь хүмүүст авто замын тодорхой хэсгийг гэрээлэн өгч засвар арчлалтыг хийлгүүлж байгаа нь үр дүнд хүрч байна. Замын нөхцөл муугаас цаг хугацаа алдаж, зардал чирэгдэл ихээхэн гарч, орон нутагт бизнес эрхлэх, зах зээлийн харилцаа хөгжихөд саад бэрхшээл болж байна. Монгол Улсын Их Хурал 2001 онд тус улсын баруунаас зүүн тийш чиглэсэн хөндлөн тэнхлэгийн болон босоо 5 чиглэлийн авто зам барих “Мянганы зам” томоохон төслийг баталсан. Энэ замын ирээдүйн хөгжил нь бүс нутгийн төдийгүй Монгол орны гадаад худалдаа, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэн Евро-Азийн дэд бүтцийн үндсэн сүлжээнд холбогдох, түүгээр дамжин далайд гарцтай болох, мөн Транс-Азийн авто замтай холбогдох боломжийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

4.66 Мянганы замын тэнхлэгийн дагуух 200 км-ын эргэн тойронд нутаг дэвсгэрийн гуравны нэг, хүн амын 77 хувь, төв суурингийн 72 хувийг хамрах судалгаа гарч байна.

4.67 ОХУ, БНХАУ-ын улс төр, эдийн засгийн харилцаа түргэн өргөжиж байгаатай холбоотойгоор манай орны нутаг дэвсгэр дээгүүр тэдгээрийн хооронд зорчигч, ачаа тээвэрлэх хэмжээ эрс өсч байна. ОХУ-аас Казахстаны нутгаар дамжуулан БНХАУ руу

авто машинаар тээвэрлэлт хийх нь Монголын нутгаар дамжуулан тээвэрлэлт хийхээс 539 км-ээр тойруу байгаа юм.

4.68 Авто замын салбарт Япон, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Кувейтийн сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагаас зээл, тусламжийг авч ашиглаж байгаагийн дүнд зам барилгын техник, технологи тодорхой хэмжээгээр шинэчлэгдэн байгууллагуудын хүчин чадал нэмэгдэж байгаа боловч шинээр зам, гүүр барих хэрэгцээ их хэвээр байна.

4.69 Улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын хөрөнгийг төлөвлөхдөө замын техник ашиглалтын түвшинг тодорхойлсны үндсэн дээр хөрөнгийг хуваарилдаг. Замын сангийн хөрөнгөөр улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг хийж байна.

4.70 Мянганы зам төслийн хүрээнд Улаанбаатараас Багануурын чиглэлийн замыг хатуу хучилттай болгох, баруун чиглэлд нь томоохон давааны замыг засах гүүр барих ажлыг эрчимтэй хийж байна. Гадаадын томоохон хандивлагчдын хөрөнгө санхүүгийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар-Сүхбаатар-Алтанбулгийн 400 шахам км урт авто замыг шинэчилж Налайх-Чойрын 200 км хатуу хучилттай замыг барьж байна. Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр Дархан-Эрдэнэтийн 184 км авто замыг барьж Дэлхийн банкны төслөөр баруун чиглэлийн авто замыг сайжруулж Улаанбаатар-Арвайхээрийн 420 км урт замд шинэчлэл хийж байна. Ийнхүү авто зам барих ажил 2000-2002 онд ихээхэн эрчимжиж хөрөнгийн хэмжээ ч өслөө.



4.71 Эрдэнэт-Булган-Мөрөнгийн 140 гаруй км, Багануур-Өндөрхааны 220 гаруй км авто замын зураг төсөл, баримт бичигт бэлэн болгоод байна. Авто замын барилгын ажил эрчимжихийн зэрэгцээ засвар арчлалтын ажил нэмэгдэж, түүнд орон нутгийн олон зуун ажилгүй иргэдийг татан оруулах арга хэмжээ авсан нь ядуурлыг бууруулахад нэмэр болж байна.

4.72 Ийнхүү зам, тээврийн үйлчилгээг сайжруулснаар иргэдийг, ялангуяа хөдөөгийн малчдыг зах зээлд ойртуулах, нийгмийн болон төрийн үйлчилгээг хүн амд хүргэх, хөдөөд шинээр ажлын байр олноор бий болгох зэргээр ядуурлыг бууруулахад тус болж байна. Муу зам, муу машин техник, чадвар муутай жолоочоос шалтгаалан зам, тээврийн осол их гарч байгаа нь ядуурал бий болгох нэгэн хүчин зүйл болж байна. Иймээс зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, түүний найдвартай, аюулгүй байдлыг хангах замаар алслагдсан бүс нутгийг ойртуулахад авто зам, гүүр ихээхэн үүрэгтэй тул Засгийн газар анхаарлаа хандуулж байна. Сайн авто зам нь зардлыг ихээхэн бууруулж, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг болно гэж тооцож байна. Замын нөхцөл муугаас цаг хугацаа алдаж, зардал

чирэгдэл ихээхэн гарч, орон нутагт бизнес эрхлэх, зах зээлийн харилцаа хөгжихэд саад бэрхшээл болж байна.

4.73 Урт болон дунд хугацаанд Засгийн газраас баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг нь хот хоорондын авто замын сүлжээг сайжруулж, Монгол улсын баруун, зүүн хоёр чиглэлийг холбосон хөндлөн тэнхлэгийн зам болон босоо тэнхлэгийн замыг барих ажлыг үргэлжлүүлэх юм. Энэхүү замын сүлжээ нь Европ, Азийг холбосон авто тээврийг хөгжүүлэх үндэс суурь болох бөгөөд замын дагуух аймаг сум, суурин газрын эдийн засгийг хөгжүүлэх, зах зээлийн харилцаанд идэвхитэй оролцоход зохих дэмжлэг болж орон нутагт бизнес хөгжих орчин бүрдэж, хүн амын орлогын эх үүсвэр гадаад дотоод зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна. Ажилгүйчүүд, орон нутгийн иргэдийг авто зам, гүүр барих ажилд өргөнөөр татан оролцуулах замаар ажлын байр бий болгож ядуу иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

4.74 Өртөг зардал багатай зам барих, ялангуяа авто зам, гүүрийн засвар арчлалтын ажилд иргэдийн хүч анхаарлыг төвлөрүүлэн, ядуучуудыг өргөн оролцуулж, орлогыг нь нэмэгдүүлнэ.

4.75 Хотын болон орон нутгийн авто замын засвар арчлалтыг түрээсийн гэрээгээр гүйцэтгэх ажлыг үргэлжлүүлж, иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.76 **Авто тээвэр.** Манай улс нийт 140.0 гаруй мянган тээврийн хэрэгсэлтэйгээс нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн 3 авто, 1 троллейбусны бааз, цөөн тооны төрийн захиргааны болон улсын үйлдвэрийн газрын тээврийн хэрэгслээс бусад нь хувьчлагдсан байна.

4.77 Улс болон хот хоорондын байнгын зорчигч тээвэрлэлтийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр гүйцэтгэж байна. Улсын захиалгат ачаа тээвэрлэлтийг хувьцаат компаний хэлбэрт шилжсэн авто тээврийн баазуудаар гүйцэтгүүлж байна.

4.78 Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээнд төрийн өмчит 4 компанийн 250 орчим автобус, 90 орчим троллейбус, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн 220 орчим том оврын автобус, 1800 гаруй бага оврын автобус гүйцэтгэж байна. Эдгээрийн дийлэнх нь ашиглалтын хугацаа дуусаад байна.

4.79 Эдэлгээний хугацаа дууссан, стандартын бус автобусыг зориулалтын, шинэ тээврийн хэрэгслээр шинэчлэхийг дэмжих зорилгоор Гаалийн тарифын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудад нэмэлт оруулах тухай хуулийг 2002 оны 10 дугаар сард баталсан.

4.80 Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд гадаадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн такси бааз ажиллаж байна.

4.81 Засгийн газрын 2002 оны 8 дугаар тогтоолоор төрийн өмчит Автобус-2, Автобус-3, Цахилгаан тээвэр компаниудыг менежментийн аргаар хувьчлах ажлыг зохион байгуулахыг нийслэлийн удирдлагад даалгасан. Үүний дагуу Автобус-3 компанийг хувьчлах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

4.82 Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээнд Улаанбаатараас орон нутгийн 60 гаруй чиглэлд 30 гаруй байгууллага үйлчилгээ үзүүлж байна. Дэд бүтцийн сайдын 2002 оны 115 дугаар тушаалаар “Аймаг, нийслэлийн Тээвэр зохицуулалтын албадын үлгэрчилсэн дүрэм”, “Аймаг, нийслэлийн Засаг дарга, Тээвэр зохицуулалтын албаны даргын хооронд байгуулах үлгэрчилсэн гэрээ”-ний загварыг баталж, аймаг орон нутгийн удирдлагуудад хүргүүлж, зохих заавар зөвлөмж өгснөөр аймаг, нийслэлд Тээвэр зохицуулалтын албад байгуулагдан, хувийн зорчигч тээврийн хэрэгсэл бүхий иргэд байгууллагуудыг зохион байгуулалтанд оруулах, үйлчилгээг зохицуулах арга хэмжээ авч

байна. Ялангуяа сүүлийн 10-аад жилд алга болоод байсан аймгийн төвөөс сум, сумаас багт зорчигч, шуудан тээвэрлэх ажлыг зохион байгуулах боломж бүрдэв.

4.83 Улаанбаатар хот нь улсын зорчигч тээврийн зангилаа хот бөгөөд орчин үеийн шаардлагад нийцсэн зорчигч тээврийн терминалгүй байсаар байна. Мөн Улаанбаатар хотыг томоохон хотуудтай холбосон авто замыг шинээр болон шинэчлэн барьж байгаа боловч хот хоорондын зорчигчдыг ая тухтай тээвэрлэх стандарт шаардлагад нийцсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэж чадахгүй байна.

4.84 Авто тээврийн салбарт ойрын жилүүдэд техник технологийн шинэчлэлт хийх, тэгэхдээ тээврийн хэрэгслийн ашиглалтаас байгаль орчин, хүн амд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах, техник ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангах оновчтой бүтцийг бий болгох бодлогыг хэрэгжүүлэх үүднээс авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт болон аймгийн төвүүдэд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны төвүүдийг байгуулна.

4.85 **Төмөр зам.** Анх 1949 онд Монгол улс, ОХУ “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулснаас хойш эдүгээ ОХУ, БНХАУ-ыг , мөн дотоодын аж үйлдвэрийн томоохон хотуудыг холбосон 1815 километр төмөр замтай болж улсын нийт ачаа эргэлтийн 90 орчим хувийг энэ байгууллага гүйцэтгэж байна.

4.86 Төмөр зам нь сүүлийн жилүүдэд хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, замыг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хилийн өртөөдийн техникийн хүчин чадлыг бэхжүүлэх, холбоо харилцаа, хөдлөх бүрэлдэхүүний засварын технологийг шинэчлэх чиглэлээр багагүй ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал: шилэн кабелийн сүлжээг төмөр замын шугамын дагуу тавьж 2000 онд ашиглалтанд оруулсан нь төмөр замын дагуу мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээ байгуулах, үйлдвэрлэлийг холбоожуулах таатай нөхцлийг бүрдүүлээ.

4.87 Дамжин өнгөрөх ачаа урсгалын хэмжээ 1995 онд 133.8 мянган тонн байсан бол 2002 оны байдлаар 3.1 сая тонн хүрч 23.1 дахин нэмэгдэв. Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын төмөр замаар тээвэрлэгдэх ачааны хэмжээ тохирох зөвлөгөөн дээр 2003 онд Монгол улсаар дамжин өнгөрөх транзит ачааны хэмжээг 4.6 сая тонн байхаар тохирсон нь Монголын төмөр зам эх газрын тээврийн сүлжээнд өрсөлдөх чадвар нь ихээхэн дээшилсэнийг харуулж байгаа боловч дэлхийн II дайны дараагаар хурдавчилсан аргаар баригдсан эргэлт тойруу ихтэй, өгсөлт уруудалт нь огцом, хоёр талын хөдөлгөөн бүхий нэг замтай нэвтрүүлэх чадвар хязгаарлагдмал, зам, зүтгүүрийн техникийн хүчин чадал дутмаг зэрэг нь Монголын төмөр замаар жилд өнгөрөх транзит ачааны урсгалыг цаашид нэмэгдүүлэх бололцоог хязгаарлаж байна.

4.88 Дунд хугацаанд төмөр замын мастер төлөвлөгөөг боловсруулж эхний ээлжинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг бодит ажил болгоно. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, паркийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэхийн хамт, тээх нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

4.89 **Агаарын тээвэр.** Монгол улсад иргэний агаарын тээврийн салбарт 100 хувь төрийн өмчийн МИАТ, хувийн хэвшлийн Хангарьд, Централ Монголиан Авиашэн, Мон Мэт Айрсервис, гадаадын хөрөнгө оруулалттай Тэнгэрийн улаач шинэ, Блуе скай зэрэг хэд хэдэн авиа компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай авиа компаниуд үйл ажиллагаагаа явуулж байгаа ч гэсэн МИАТ компанитай өрсөлдөн дотоод, гадаадын тогтмол нислэгүүдийг үйлдэх хэмжээний техникийн хүчин чадал байхгүй байна.

4.90 Монгол улсад төв, орон нутгийн 22 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас Буянт-Ухаа болон Өлгий нисэх буудлууд нь олон улсын нислэгт үйлчилж байна. Буянт-Ухаа олон улсын нисэх буудал нь Монгол улсыг олон улстай холбодог гол хаалга, гарцын үүргийг гүйцэтгэдгээс гадна орон нутгийн нислэгийн зангилгаа төв юм. Аялал жуулчлал

хөгжиж жуулчдын тоо өсөх хандлагатай болж буйтай уялдан олон улсын нислэг, нисэх онгоцны тоог нэмэгдүүлэх шаардлага гарч болно.

4.91 Агаарын тээврийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах, МИАТ компаний онгоцны паркийг шинэчлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэн сайжруулахад Засгийн газраас ихээхэн анхаарч байгаа боловч улсын агаарын тээврийн салбарын дотоод, гадаад нислэгт өрсөлдөөн гарахгүйгээр үнэ тарифт нэг компаний монополь үүсэх, үйлчилгээний чанарт ахиц гарахгүй байх зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байна. Иймд иргэний нисэхийн салбарыг хувьчлах бодлогыг баримталж байна. Ойрын жилүүдэд дотоодын шугамд үйлчилдэг нисэх онгоцны паркийг шинэчлэх, олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлж онгоцны тоог нэмэх, МИАТ компанийг хувьчлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.92 **Мэдээлэл, харилцаа, холбоо.** Монгол улсын Засгийн газар харилцаа холбооны салбарыг хөгжлийн нэг гол хөдөлгүүр хэмээн үзэж байна. Энэхүү салбар нь мэдлэгийг бий болгох, түгээх дэлгэрүүлэх, жижиг, дунд үйлдвэрүүд, корпорацууд, алслагдсан бүс нутагт худалдааг хөгжүүлэх зэргээр үндэсний өрсөлдөх чадварт маш чухал нөлөөтэй төдийгүй нийтийн үйлчилгээ үзүүлэхэд дэм болох юм. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг бууруулахад мөн боломж олгож байна. Монгол улсын эдийн засагт харилцаа, холбооны үүрэг ихээхэн нэмэгдэж байна. Тухайлбал ДНБ-д харилцаа, холбооны салбарын эзлэх хувийн жин 1995 онд 1.44 байсан бол 2000 онд 5.3 болсон байна. 2001-2002 онд энэхүү салбараас улсын төсөвт ААН-ийн орлогын татварын орлогын 10 хувь, НӨТ-ийн орлогын 7 хувийг бүрдүүлсэн байна.

4.93 Монгол Улсын Засгийн Газар нь мэдээлэл харилцаа холбооны салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги болон 2002 оны 1 дүгээр сард уг стратегийг хэрэгжүүлэхүйл ажиллагааны төлөвлөгөөг батласан юм. Үүнээс гадна Засгийн газар нь Харилцаа холбооны хуулийг 2001 онд баталж улмаар Харилцаа холбоог зохицуулах хороог тус салбарын үйл ажиллагааг зохицуулах зорилготойгоор байгуулсан. Мөн Дэд бүтцийн яаманд мэдээлэл, холбооны технологийн газрыг бий болгосон байна. Монгол улсын Засгийн Газар нь эдгээр бодлого болон зохицуулалтыг тус салбарын бүтцийн удирдлага зохицуулалтыг дээшлүүлэх мөн харилцаа холбооны сүлжээний суурийг шинэчлэх зорилгоор хийсэн.

4.94 Харилцаа холбооны тухай хуулийг анх 1995 онд батлан тус салбарын үйл ажиллагааг зохицуулж байсан ба 2001 онд мэдээлэл холбооны технологийн хөгжил, зах зээлийн нөхцөлтэй уялдуулан шинэчилж бие даасан зохицуулах байгууллага, төрөл бүрийн үйлчилгээний үүрэгтэй санг байгуулахаар хуульчилсан нь хувийн хөрөнгө оруулалт, шударга өрсөлдөөнийг дэмжсэн чухал алхам боллоо. Үүнийг цахилгаан холбооны олон улсын байгууллагууд ч үнэлж байгаа болно. УИХ-аас “Монгол улсад мэдээлэл, холбооны технологийн салбарыг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг 2000 оны 2 дугаар сард баталсан байна. Энэхүү баримт бичгийн гол зорилго нь мэдлэг, оюуны хүчинд тулгуурласан нийгмийг байгуулж, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэх болно.

4.95 Засгийн Газрын дунд хугацааны стратеги нь одоо байгаа харилцаа холбооны технологийг сайжруулах замаар хөгжлийн гол хөдөлгүүр хүч болгох бөгөөд энэхүү үйл ажиллагаагаа доорхи 4 хүчин зүйлээр баталгаажуулах юм . Эдгээрт 1) зохистой бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын орчныг бий болгох 2) хэрэгцээг бүрэн хангахуйц , найдвартай харилцаа холбоог бий болгох мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх 3) мэдээллэл харилцаа холбооны технологийг засаглал болон бусад хэрэгцээнд зориулан ашиглах эдийн засгийн болон бизнесийн орчинг бүрэлдүүлэх 4) мэдээлэл, холбооны технологийг үр ашигтайгаар ашиглаж чадахуйц хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг болно.

4.96 Монгол Улсын мэдээлэл, холбооны дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд Засгийн Газар нь дараахи асуудлуудыг нэн тэргүүнд авч үзнэ. (1) үндэсний мэдээлэл, харилцаа

холбооны технологийн хөтөлбөрийг удирдан хэрэгжүүлэх Засгийн газрын чадавхийг дээшлүүлэх (2) харилцаа холбооны найдвартай, зохистой дэд бүтэц болон үйлчилгээг дэмжихүйц бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох (3) интернетийн үйлчилгээг хөгжүүлэх хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог бий болгох (4) Монгол Телеком-ыг хувьчлах (5) аймаг, сум хоорондын электрон сүлжээг бий болгох мөн интернетийн холбоог сайжруулах (6) хөдөө орон нутагт мэдээлэл харилцаа холбооны технологийг хөгжүүлэх хувийн хэвшилтэй хамтран ажиллах зохицуулалтын болон институцийг бий болгох (7) нийгмийн үйлчилгээний салбарт, ялангуяа боловсрол эрүүл мэндийн салбарт интернетийн хэрэглээг өргөтгөх зэрэг болно.

4.97 Хүний нөөцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Засгийн Газраас дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна (i) боловсрол олгох сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийг түлхүү тусгах (ii) эдийн засгийн бодлого, татварын болон бусад бодлогыг ашиглан олон нийтэд мэдээллийн технологийн суурь мэдлэг олгох болон мэдээллийн технологийг анхан, дунд, дээд шатны дамжаа, төвүүдэд дэмжлэг үзүүлэх, тэдгээр сургалтуудад олон нийтийг өргөнөөр хамруулах боломж олгох төсөл хэрэгжүүлэх (iii) мэдээлэл, холбооны технологид суурилсан зайны сургалтыг хөгжүүлэх, нээлттэй сургалтын хөтөлбөрөөр олгох албан боловсрол эзэмшүүлэх тогтолцоог бий болгох, цахим тексттэй номыг хэрэглэн сургалт явуулдаг сургалтын төвүүдэд туслалцаа үзүүлэх.

4.98 Бизнес болон хувийн хэвшлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд Засгийн Газраас мэдээллийн холбооны технологийн салбарт хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн бодлого боловсруулж, таатай орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

4.99 Сүүлийн жилүүдэд хөдөлгөөнт холбоо, утасгүй холбооны хэрэглэгчдийн тоо эрчимтэй өсөж 1996 онд 1800 хэрэглэгчтэй байсан бол 2002 оны жилийн эцсийн байдлаар 235.0 мянгад хүрчээ. Үндсэн шугамын тоо 1996 онд 100 хүнд 3.5 ногдож байсан бол 2002 онд 5.4 болж өссөн байна. Интернетийн үйлчилгээний зах зээл бүрэн либеральчилагдаж нийт 50 шахам мянган интернет хэрэглэгчтэй боллоо. Мөн ВСАТ үйлчилгээний лицензтэй олон тооны ААН-үүд бий болж мэдээлэл, харилцааны технологийн бизнесийн үр ашгийг дээшлүүлэх, сүлжээний үйлчилгээ үзүүлэх зэрэг нэмэгдсэн өртөг өндөртэй төрөл бүрийн үйлчилгээ үзүүлж байна. Ойролцоогоор суурилагдсан сүлжээний дэд бүтцийн 80 хувь нь тоон технологид шилжээд байна. Түүнчлэн Монголын төмөр зам шилэн кабелийн дэд бүтцийг эзэмшиж байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх сүлжээний хүчин чадлыг зохистой ашиглах нөхцлийг хангахыг шаардаж байна. Засгийн газраас дэд бүтэц, үйлчилгээний шударга, өрсөлдөөнт орчныг бий болгох бодлого, зохицуулалт хийх юм. Монгол улсын хувьд тулгамдсан асуудлын нэг нь мэдээлэл, холбооны технологийн дэд бүтэц, үйлчилгээг хөдөөд хөгжүүлж, нэмэгдүүлэх явдал юм. Улсын хэмжээнд 2052 сум, баг радио харилцаатай байна. 120 орчим суурин газар төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдож, 150 суманд нарны эрчим хүчээр ажилладаг холбооны төв ажиллаж байна.

4.100 Дэд бүтэц, үйлчилгээний шударга, өрсөлдөөнтэй нөхцлийг бүрдүүлэхийг зорьж байна. Монгол улсын хувьд тулгамдсан асуудал бол мэдээлэл холбооны технологийн дэд бүтэц, үйлчилгээг хөдөө орон нутагт хөгжүүлэх явдал юм.

4.101 Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг нь иргэд тэр дундаа ядуу хүмүүсийг мэдээллээр ханган, Монгол улсын хөгжилд чухал үүрэгтэй учир радио, телевизийн тоног төхөөрөмжийг сайжруулж, дамжуулах байгууламж, телевизийн нэвтрүүлгийн станцуудыг шинэчлэх шаардлагатай байна. 2003 оны байдлаар 4 телевизийн нэвтрүүлэг, богино долгионы 4 радио станц ажиллаж байна.

4.102 Шуудан холбооны үйлчилгээг “Монголшуудан”ХХК, түүний аймгийн төвүүд дэх албад, Улаанбаатар хотын 19, сумдын 328 салбараар дамжуулан Монгол улсын бүх нутаг дэвсгэрт хүргэж байна. “Монголшуудан”ХХК нь шуудангийн бүх төрлийн илгээмж, шуудангийн марк, үнэт цаасны эх зураг зохион хэвлүүлэх, улмаар гадаад, дотоодын зах зээл дээр борлуулах, шуудангийн хэрэглэгчдийн хайрцаг ажиллуулах, зорчигч тээвэр,

шуудан илгээмжийн худалдаа, улс хоорондын яриа, факс, Улаанбаатар хотын зарим салбарт имэйлийн үйлчилгээг “Монголын Цахилгаан Холбоо”ХХК-тай хамтран гүйцэтгэж байна.

4.103 Мэдээлэл холбооны технологи болон дэд бүтцийн хөгжлийн талаарх богино болон дунд хугацааны стратегийг хэрэгжүүлснээр мэдлэгт тулгуурласан нийгмийг бүрдүүлэх, шинэ төрлийн үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлэх, тогтвортой хөгжил, хөдөөгийн хөгжлийг хангах, боловсрол болон нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй төвшинг хангах, ядуурлыг бууруулахад чиглэсэн нэг урьдчилсан нөхцөл бүрдэнэ.

4.104 Дунд хугацаанд Монгол улсын Засгийн газраас мэдээлэл, холбооны технологийн талаар дараах тэргүүлэх чиглэлийг дэвшүүлж байна.

- Монгол улсын хөдөөд болон төв суурин газарт хүрч үйлчлэх иж бүрэн үйлчилгээний санг байгуулж, хэрэгжүүлэх.
- Бизнес, нийгмийн салбар, иргэний нийгэмд мэдээлэл, холбооны технологийг ашиглах, нэвтрүүлэх урамшууллын механизмыг боловсруулж хэрэгжүүлэх.
- Холбооны салбарыг зохистой удирдах үүднээс харилцаа холбооны зохицуулалтын комиссын чадавхийг сайжруулж, Монголын мэдээлэл холбооны дэд бүтцийн хувийн хэвшилд тулгуурласан хөгжлийг хангах зорилгоор өрсөлдөөнийг дэмжсэн орчинг бүрдүүлэх.
- Үйлчилгээний шинэ төрлийг өргөн нэвтрүүлэх зохицуулалтын тогтолцоог бий болгох
- Цахим сургалт, теле-эм үйлчилгээ, үндэсний мэдээллийн бааз зэрэг мэдээлэл, холбооны технологийн үйлчилгээний шинэ боломжуудыг ашиглах, нэмэгдүүлэхэд шаардлагатай орчныг бий болгох.
- Мэдээлэл, холбооны технологийг эдийн засаг, нийгмийн салбаруудад өргөн нэвтрүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглүүлэх.
- Мэдээлэл, холбооны технологийн салбарт суурь болон хавсарга судалгааны үр дүн, чадавхийг дээшлүүлэх.
- Зохицуулалтын /мэдээлэл технологийн хууль болон бусад/ механизмын өөрчлөлт, шинэчлэлийг өргөжүүлж, гүнзгийрүүлэх.
- Бүх салбарт е-арилжаа, е-үйлчилгээг өргөжүүлэх
- Тоон технологит үйлчилгээний алсын зайн сургалт, боловсрол, алсын зайн эмчилгээ, үндэсний бүртгэлийн сүлжээг боловсруулж хэрэгжүүлэх.

IV. Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих

4.105 Зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990 оноос хойш Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалттай нийт 800 гаруй сая ам. долларын дүрмийн сангийн хөрөнгөтэй 70 гаруй орны 2300 орчим аж ахуйн нэгж байгуулагдав. Үүний гуравны нэг нь уул уурхайн чиглэлээр, 20 орчим хувь нь хөнгөн үйлдвэрийн салбарт ногдож байна. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өсч буй нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, улмаар Монголын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ юуны түрүүнд макро эдийн засгийн тогтвортой байдлыг бататгахад анхаарахын хамт гадаад хөрөнгө оруулалтыг татах, хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр сүүлийн 2 жилд хэд хэдэн арга хэмжээ авлаа. Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын импортоор оруулан ирж буй технологийн зориулалттай тоног төхөөрөмж, машин механизмыг импортын болон гаалийн албан татвараас бүрэн чөлөөлж байна. Мөн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд 2002 онд нэмэлт тодотгол оруулж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагууд тогтвортой байдлын гэрээ байгуулж ажиллах эрхзүйн үндэс бүрдэв. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах нөхцөлөөр гэрээ байгуулан ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн байгууллагын олборлосон газрын тосны өөрт нь ногдох хэсэгт

ногдох албан татварыг чөлөөлөх арга хэмжээ авлаа. 2002 оныг гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих жил болгон зарлаж 2002 оны 9 сард хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулав. Тус чуулга уулзалтад 40 гаруй орны 300 шахам төлөөлөгч оролцов. Уг чуулга уулзалтаас хойших 3 сарын хугацаанд гадаад хөрөнгийн хэмжээ 150.0 орчим сая доллараар нэмэгдэхээр хэлцэл хийгдсэн байв. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрхзүйн зохицуулалт сайжирч, тэдэнд үзүүлэх дэмжлэг нэмэгдэж байгаа боловч 8 томоохон төсөл хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн байдал харагдахгүй байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага байгуулж ажиллах бизнесийн орчныг улам сайжруулах шаардлага байсаар байна.

4.106 Урт хугацаанд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх стратеги нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, хүчин чадлыг сайжруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, тус улсын хөгжлийг хурдасгахад чиглэгдэнэ.

4.107 Ойрын жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн орчныг сайжруулахад анхаарна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагад ажиллах чадвартай техникийн ур чадвартай ажилчдыг бэлтгэхэд чиглэсэн арга хэмжээ авна. Гадаадын хөрөнгө оруулагчдын чөлөөтэй, дэг журамтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.108 Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой төрөл бүрийн зөвшөөрөл олгодог тогтолцоог хялбаршуулах замаар экспортын үйлдвэрлэл болон орон нутагт бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

4.109 Гадаадын хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэл үйлчилгээний бүхий л салбарт татан оруулах бодлого баримтлах, ялангуяа уул уурхайн салбарт түлхүү оруулах чиглэл баримтална. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр ажлын байр шинээр бий болохын хамт иргэдийн орлого нэмэгдэж, ядуурлыг бууруулахад зохих дэмжлэг болно.

V. Зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх

4.110 *Бараа бүтээгдэхүүний зах зээл.* Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд голдуу анхан шатны боловсруулалт хийх зориулалт бүхий мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэрэг боловсруулах үйлдвэрийн салбар, эрдэс түүхий эдийн баялгийг олборлох чиглэлтэй уулын баяжуулах цөөн үйлдвэр, оёдол, сүлжмэл хүнсний болон хэвлэл, модон эдлэл, барилгын материалын зарим үйлдвэрлэл нь тус улсын аж үйлдвэрийн салбарын үндсийг бүрдүүлж байна. Зах зээлийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос өмч хувьчлал эмх цэгцтэй, тодорхой бодлого, чиглэлтэй явагдаагүйгээс үйлдвэрлэлийн технологийн уялдаа холбоо алдагдаж, үйлдвэрүүдийн дийлэнх нь эргэлтийн хөрөнгийн дутагдалд орж, бүтээгдэхүүнээ борлуулах гадаад, дотоод зах зээлээ тооцоогүй зэргээс шалтгаалан сул зогсож, олон тооны ажилчид ажлын байргүйн улмаас орлогын эх үүсвэргүй болсон байна.

4.111 Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг дотоодод боловсруулах хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн сул хөгжил, өрсөлдөх чадваргүй байдал болон гадаад зах зээлд олигтой хүрч чадаагүй нь дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд гол бэрхшээл учруулж байв. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дотоод, гадаад худалдааны нөхцөл муудах хандлага үргэлжилсээр байгаа бөгөөд 2001 оныг 1995 онтой харьцуулахад малчдын худалдсан түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өсөлт нь худалдаж авсан барааныхаас 33.2 пунктээр доогуур түвшинд байна. Хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг хөдөөд хөгжүүлэх нь нэг талаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ үнэ хүргэж борлуулах боломжийг нэмэгдүүлж, нөгөө талаас улирлын чанартай хөдөөгийн ажиллах хүчийг нэмэгдэл ажлын байраар хангах чухал эх үүсвэр болно. Ингэснээрээ эцсийн дүнд эрсдэлд нэн өртөмтгий хөдөө аж ахуйгаас хараат байдлыг багасгаж, хөдөөгийнхний орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахад онцгой ач холбогдолтой. Сүүлийн 2-3 жилд үндэсний үйлдвэрлэлийг сэргээх бодлогын хүрээнд Засгийн газраас уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлал, мэдээлэл технологийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон зарласан бөгөөд Арьс шир, ноос,

ноолуур, Мах, Алт, Үр тариа, Уринш зэрэг тодорхой хөтөлбөрүүдийг боловсруулан хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байна. Хувьчлагдсан үйлдвэр аж ахуйн газруудын менежмент, мэдээлэл, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслийг Хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжүүлж байна. Өрсөлдөх чадвар бүхий жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд Засгийн газар, хандивлагчид, ялангуяа ХБНГУ-ын Засгийн газар, Дэлхийн банкнаас үзүүлж байгаа тусламж ихээхэн үр дүнтэй болж байгаа төдийгүй манай улсад импортыг орлох үйлдвэрлэлийг өргөжүүлэх, ажлын байр шинээр нэмэгдүүлэхэд түлхэц өгч байна. Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ноос, арьс шир, нэхий, барилгын материалын зарим үйлдвэр сэргэж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн 2002 оны урьдчилсан гүйцэтгэлээр 29.0 хувиар өсчээ. Ингэснээр 2002 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 27.0 хувь болж байна.

Хүснэгт 4:1: ДНБ-ийн бүтэц

| Салбаруудын эзлэх хувийн жин | | | | | | | |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| | 1993 | 1995 | 1996 | 1999 | 2000 | 2001 | 2002 |
| Аж үйлдвэр | 30.9 | 25.8 | 18.6 | 18.2 | 20.0 | 20.1 | 21.4 |
| Уул уурхай, олзворлох үйлдвэр | | 12.0 | 10.4 | 8.7 | 11.5 | 9.0 | 8.6 |
| Боловсруулах үйлдвэр | | 12.1 | 5.9 | 5.9 | 6.1 | 8.1 | 9.5 |
| Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж | | 1.8 | 2.2 | 3.6 | 2.4 | 3.0 | 3.3 |
| Хөдөө аж ахуй | 35.1 | 38.0 | 43.8 | 37.0 | 29.1 | 24.9 | 20.7 |
| Барилга | 1.6 | 1.7 | 2.8 | 2.5 | 1.9 | 2.0 | 2.1 |
| Тээвэр, холбоо | 4.6 | 6.4 | 7.4 | 9.1 | 11.0 | 13.0 | 14.0 |
| Худалдаа материал техникийн хангамж | 16.0 | 17.0 | 16.7 | 20.7 | 24.1 | 26.7 | 27.6 |
| Үйлчилгээ | 11.8 | 11.1 | 10.8 | 12.5 | 13.9 | 13.4 | 14.2 |
| ДНБ /оны үнээр/ | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |

4.112 Сүүлийн жилүүдэд хүнсний том, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаа харьцангуй тогтмолжиж, жижиг үйлдвэрүүд шинээр бий болж байгаагаас салбарын үзүүлэлтүүд өсөх хандлагатай болж байна.

4.113 Мах, сүү, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл жигд нэмэгдэж, дэвшилтэт техник, технологи, сав, баглаа боодол үйлдвэрлэлд нэвтэрсэнээр дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэж, чанар аюулгүй байдлын үзүүлэлт дээшилж байна.

4.114 Мөн мах, махан бүтээгдэхүүн, архины экспортын хэмжээ нэмэгдэж уламжлалт гадаад зах зээлээс гадна шинэ зах зээл нээх талаар экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид идэвхитэй ажиллаж байна.

4.115 Хувийн хэшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг хангах бодлогын хүрээнд сэргэж буй үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлтэй холбох талаар Засгийн газар хувийн хэвшил, ард иргэд, гадаадын түншүүдтэйгээ идэвхтэй хамтран ажиллаж байна. Энэ бодлогын хүрээнд дотоод худалдааг хөгжүүлэх, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг уялдуулан үйлдвэрлэлийг түүхий эдтэй нь, хотыг хөдөөтэй холбох, хөдөөгийн хүн амд хүргэж байгаа бараа, өргөн хэрэглээний зүйлсийн үнийг хот, суурин газрынхтай ойртуулж хямдруулах, тэднээс малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг газар дээр нь худалдан авах, тэдэнд учрах зардал чирэгдлийг багасгахад чиглэсэн маркетингийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Засгийн газар "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжүүлэн эхэлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд Орхон, Хэнтий, Баянхонгор аймгуудад энэхүү сүлжээг 2002 онд байгуулан туршсан нь үр дүнгээ өгсөн тул дунд хугацаанд зах зээлийн багтаамжтай нь уялдуулан бусад аймгуудыг

хамруулан зохион байгуулах шаардлагатай байна. Бараа бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх бизнес эрхлэгчдийг мэдээллээр хангаж зах зээлтэй нь холбож өгөх ажил дутагдаж байна. Төвлөрсөн зах зээлээс алслагдах тутам мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ буурч, өргөн хэрэглээний барааны үнэ өсдөг, нэн ялангуяа малчид зах зээлтэй оновчтой холбогдож чадаагүй, гол төлөв бараа солилцоогоор арилжаа хийгддэг, түүхий эдийн боловсруулалтын түвшин доогуур, дотоод зах зээлд гадаадын өрсөлдөгчид давамгайлж байгаа нь мал аж ахуйн маркетингийн тогтолцооны үндсэн бэрхшээлүүд болж байна.

Шигтгээ 4.1. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн туршлагаас...

Бөөний худалдааны сүлжээний давуу талууд:

- Малчдыг мэдээллээр хангах, үнийн эрсдлээс хамгаалах
- Бизнес эрхлэх өртөг, тэр дундаа тээврийн зардлыг эрс бууруулах,
- Бараа, түүхий эдийг хадгалах, арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах
- Хэрэгцээт бараагаа сонгон авах, үнийг хямдруулах, хүнсний эрүүл ахуйн нөхцөл сайжирч аюулгүй байдлыг хангах

Цаашид анхаарах асуудлууд:

- Оролцогчдын сонгон шалгаруулалтанд тухайн орон нутгийн бизнес эрхлэгчдийг өргөн оролцуулах,
- Бараа бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах дэд бүтцийг бүрдүүлж сайжруулах
- Бөөний худалдааны сүлжээн дэх өрсөлдөөнийг дэмжих сум, багт худалдааны сүлжээг хүргэх

4.116 Урт болон дунд хугацаанд бизнес эрхлэгчдийг зах зээлд ойртуулах, тэдгээрийн эрхлэж буй бизнесийг аль болох ашигтай байлгах хүрээнд зах зээлд оролцогчдыг мэдээллээр хангах зорилт тавьж байна. Бөөний худалдааны сүлжээний хүрээнд болон бусад сувгийг ашиглан гадаад, дотоодын зах зээлийн талаарх мэдээлэл, бизнесийн анхан шатны мэдлэгийг түгээх нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл мөн бөгөөд эдгээр үйл ажиллагаанд ядуучуудыг өргөн татан оролцуулж, тэдэнд бизнесийн мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.117 Аж үйлдвэрийн салбарт өнөөгийн байдлаар ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг эс тооцвол том хэмжээний боловсруулах үйлдвэрүүдийн хөгжил нэн сул байна. Харин сүүлийн үед хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарт жижиг, дунд үйлдвэр байгуулагдаж, өрсөлдөөн бий болох эхний хандлагууд гарч байна. Үндэсний статистикийн газрын мэдээгээр 2002 оны байдлаар улсын хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулдаг 407 хүнсний үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагийн 75.8 хувь нь дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, зах зээлийн нөхцөл сайтай Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, Сэлэнгэ, Төв аймагт байршилтай байна. Эдгээр үйлдвэрүүдийн 29.7 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өлөн гэдэс боловсруулах чиглэлээр 27.3 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүний, 7.4 хувь нь арьс шир боловсруулах, 1.0 хувь нь малын болон ургамлын гаралтай тос үйлдвэрлэх, 31.4 хувь нь гурил үйлдвэрлэх, 1.7 хувь нь жимс, ногоо боловсруулах, 1.5 хувь нь малын тэжээл, цардуул үйлдвэрлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Үйлдвэрүүдийн ихэнх нь 50 хүртэл ажилчидтай жижиг, дунд үйлдвэр байна. Судалгаанд хамрагдсан нийт хүнсний үйлдвэрүүдийн 58.1 хувь нь суурилагдсан хүчин чадлынхаа 50 хүртэл хувийг ашиглаж байна.

4.118 Түүхий эдийн нөөц, ашиглаж буй технологийн түвшингээр нь авч үзвэл манай оронд ноолуурын үйлдвэрлэл нэлээд хөгжсөн. Монгол улс түүхий ноолуурын үйлдвэрлэлээрээ дэлхийд 2-рт ордог юм. Ноолуурын түүхий эдийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээл дээр борлуулах худалдааны нөхцөлийг сайжруулах зорилт тавьж байна.

4.119 Хөдөөд санхүүгийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй хөгжүүлэхгүйгээр зах зээлийн харилцааг төлөвшүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бус жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, улмаар хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр хөдөөгөөс хот руу чиглэсэн нүүдлийг сааруулах боломжгүй

юм. Иймд хөдөөд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгийн урсгалыг чиглүүлэх үүднээс макро эдийн засаг, түүний дотор санхүүгийн бодлогыг авч хэрэгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээг өргөжүүлж, таатай орчин бүрдүүлэх гол арга зам бол шударга өрсөлдөөнийг дэмжсэн оновчтой бүтцийг бүрдүүлэх явдал юм. Энэ зорилгоор сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод, даатгалын байгууллагуудыг хөгжүүлэх талаар ихээхэн чармайлт гаргаж байна. Одоогийн байдлаар Монгол улсад 63 ББСБ хот, хөдөөд үйл ажиллагаагаа явуулж байна. Иймд хүн амын ядуурлыг бууруулахад богино хугацаанд үр өгөөжөө өгөхүйц банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тэдгээрийн тогтвортой орчинг бүрдүүлнэ.

4.120 Засгийн газраас хувийн хэвшил, гадаадын түншүүдтэй хамтран тодорхой нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, менежмент, арга технологийг дэлгэрүүлэх, борлуулах дуудлага худалдаа зохион байгуулах зэргээр ажиллаж, алслагдсан аймгууд болон хөдөөгийн иргэд, ялангуяа ядуучуудад хүргэж байна. Зах зээлийн хүртээмжийг өргөжүүлэхэд бизнесийн үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, хувь хүмүүс, хэрэглэгчдийн маркетингийн чадавхийг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхний хоорондын түншлэлийг хангахад анхаарч ажиллана.

4.121 Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулан гадаад зах зээлд экспортлох чиглэл баримталж байгаа боловч мал аж ахуйн гаралтай боловсруулаагүй түүхий эдийн экспортод хориг тавих, тарифын хязгаарлалт хийж, технологийн хувьд хоцрогдсон үйлдвэрүүдийн эрх ашгийг хамгаалах нь тийм ч оновчтой арга биш юм. Иймээс дунд хугацаанд орчин үеийн дэвшилттэй технологи бүхий өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, дэлхийн экспортын зах зээлд нэвтрэх чадавхийг дээшлүүлэх зорилтыг тавьж байна. Дунд хугацаанд арьс шир, түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний чанар, ялангуяа ноолуурын бүтээгдэхүүнийхийг олон улсын зах зээлийн түвшинд хүргэх, байгаль орчинд халгүй технологийг нэвтрүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Ноолуур боловсруулах салбарын хөгжлийн зорилт нь түүхий эдийн чанарыг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн толтолцоог боловсронгуй болгоход чиглэгдэнэ. Энэ хүрээнд дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Малын нас, хүйсийн онцлогийг харгалзан малын хөлийн татварыг тогтоох механизмыг бий болгох замаар малын ашиг шимийг сайжруулах, түүхий эдийн чанарыг дээшлүүлэх,
- Түүхий эдийн бэлтгэлд зориулсан банк, санхүүгийн үйлчилгээг хөгжүүлж, малчин, үйлдвэрлэгч, худалдаачдын үйл ажиллагааны нэгдлийг хангах, худалдааны эрсдэлийг багасгах,
- Үйлдвэр, аж ахуйн газрын менежментийг сайжруулах, гадаад зах зээлийг өргөжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, экспортыг нэмэгдүүлэх

4.122 Хүнсний салбарт орчин үеийн технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, аюулгүй хүнсээр хүн амын хэрэгцээг хангах, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Хүний биеийн бичил махбодийн дутлаас сэргийлэх, зохицуулах үйлчилгээтэй болон хүүхдийн хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мах махан бүтээгдэхүүний боловсруулалтын чанарыг дэлхийн жишигт хүргэж, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг дунд хугацаанд баримталж байна.

4.123 Тухайн бүс нутгийн нөөц, онцлогтой уялдуулан уламжлалт жижиг гар урлалыг хөгжүүлэхэд түлхүү анхаарна. Тухайлбал, тодорхой чиглэлээр мэргэжлийн сургалтыг зохион байгуулах, зах зээлийн мэдээллээр хангах, ур чадварыг сурталчлах замаар уламжлалт гар урлалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Ийнхүү жижиг дунд үйлдвэр, гар урлалын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх нь Монгол улсын онцлогтой холбоотой бөгөөд

ажлын хямд төсөр байрыг хот хөдөөд олноор бий болж, ядуучуудыг ажилтай болгон орлогыг нь нэмэгдүүлэх нэг гол чиглэл гэж тооцож байна.

4.124 Улс орны эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах, нэмэгдсэн өртөг илүү шингэсэн оёмол, нэхмэл зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж байгаа боловч урт болон дунд хугацаанд эрдэс түүхий эдийн олборлох, боловсруулах чиглэлтэй уул уурхайн үйлдвэрүүд тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байх болно.

4.125 Тухайлбал дунд хугацаанд манай эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд чухал ач холбогдол бүхий томоохон үйлдвэрүүд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар бий болох бөгөөд Төмөртэйн цайр боловсруулах үйлдвэр, Бороогийн алтны ордыг ашиглах уулын үйлдвэрийг барьж дуусган, Цагаан суварга, Оюу Толгой, Хармагын зэс, Тавтын алт, Асгатын мөнгөний үйлдвэр, Тамсаг булаг дахь нефть олборлох үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлнэ. Ер нь Монгол Улсад 80 гаруй нэр төрлийн эрдэс түүхий эдийн 6000 орчим ордыг илрүүлсний 160 орчмыг нь одоогоор ашиглаж байгаа бөгөөд нийт газар нутгийн 75 хувьд нь геологийн шинжилгээ, судалгаа хийгдээгүй байна. Иймд байгалийн нөөцийн судалгаа, тэр дундаа уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлыг дэмжсэн хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм.

4.126 Уул уурхайн салбарт бизнес эрхлэх хууль эрхзүйн үндэс суурь нь нэлээд тогтвортой бөгөөд таатай байна. Тиймээс Засгийн газар байгалийн нөөцийн, ялангуяа эрдэсийн хайгуул, байгаль орчны үнэлгээ, судалгаа, шинжилгээ боловсруулалтын шаттай холбоотой хуулийн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж байна.

4.127 Ашигт малтмалын тухай хуулиар алтны нөөц ашигласны төлбөрийг үндсэн ордод 2.5 хувь, шороон ордод 7.5 хувиар ялгавартай тогтоож, алтны экспортод ногдуулах НӨАТ-ыг тэглэх, томоохон хөрөнгө оруулагчидтай тогтвортой байдлын гэрээ байгуулах, тэргүүлэх чиглэлийн салбар гэсэн заалтын дагуу татварын зарим хөнгөлөлтүүдийг эдлүүлэх арга хэмжээг авч байна. Ингэснээр дунд хугацаанд бизнес эрхлэх хууль эрхзүйн тогтвортой орчин бүрдэж, үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулснаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт түлхүү орно гэж тооцож байна.

4.128 Дунд хугацаанд эрдэс түүхий эдийн шинэ ордуудын хайгуулыг эрчимжүүлнэ. Уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн аргаар олборлох, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн гаргахад түлхүү анхаарч ажиллана. Зэсийн баяжмалыг эцсийн бүтээгдэхүүн болгох асуудлыг судлаж шийдвэрлэнэ. Эрдэс түүхий эдийг олборлох боловсруулах томоохон үйлдвэрүүдийг хөгжүүлсэнээр ажлын байр олноороо нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлт дээшлэн ядуурлыг бууруулахад ихээхэн түлхэц болно гэж үзэж байна. Нөгөө талаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэх гол стратеги мөн.

4.129 *Аялал жуулчлал.* Өнөөдөр Монгол улсад 6400 гаруй ор бүхий 130 гаруй жуулчны бааз, 7000 ор бүхий 260 гаруй том, жижиг зочид буудлууд, 400 гаруй тур оператор компани үйл ажиллагаа явуулж байна. 2002 онд Монгол улсад гадаадын 230188 гийчид ирснээс 198057 нь жуулчин гэсэн ангилалд багтаж, өмнөх жилийнхээс 20 хувь өсч, 1990 онд ирсэн гийчдийн тоотой харьцуулбал 56 хувь өссөн бөгөөд салбарын орлого 2002 онд 130.1 сая ам.долларт хүрчээ.

4.130 Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор 2000 онд УИХ-аас Аялал жуулчлалын тухай хуулийг батлан гаргасан бөгөөд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны санхүүгийн чадварыг нэмэгдүүлж, энэ салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монгол улсын Засгийн газраас уг салбар дахь аж ахуйн нэгжүүдийг “Нэмэгдсэн өртгийн албан татвар”-аас чөлөөлсөн болно. Мөн түүнчлэн зар сурталчилгаанд зориулсан зардлын 5 хувийг татварт ноогдох орлогоос чөлөөлж байсныг 10 хувь болгосон нь аялал жуулчлалын хөгжилд бодитой дэмжлэг үзүүлж байгаагийн жишээ юм. Монгол улсад 30 хоногийн хугацаагаар аялагчдыг холбогдох байгууллагад бүртгүүлэхгүй байхаар шийдэж,

визийн хөнгөлөлтийн асуудлаар зарим улс орнуудтай тохиролцоонд хүрч байгаа зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд бодитой дэмжлэг болж байна.

4.131 Аялал жуулчлалын зах зээлийг судлаж, жуулчдын сонирхлыг татах, Монгол орныг гадаад орнуудад өргөнөөр сурталчилах зорилгоор гадаад орнуудад зохион байгуулагдаж байгаа олон улсын аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн яармагуудад сүүлийн жилүүдэд тогтмол оролцож байна. Тухайлбал :

- Голланд улсын Утрехт хотноо зохиогддог /CBI/ үзэсгэлэн яармаг
- ХБНГУ-ын Штутгарт хотноо зохиогддог СМТ үзэсгэлэн
- ХБНГУ-ын нийслэл Берлин хотноо зохиогддог ITB үзэсгэлэн яармаг
- Английн Лондон хотноо зохиогддог WTM үзэсгэлэн яармагуудыг дурьдаж болно.

4.132 Мөн Аялал жуулчлалын компаниудад шинэ түнш олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2002 онд “Монголыг Нээхүй -2001” үзэсгэлэнг, 2003 онд Токио хотноо “Монголд зочлох жил”-ийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. МИАТ компанийн төлөөлөгчийн газруудад аялал жуулчлалын сурталчилгааны ажлыг давхар хариуцуулах болсноор БНСУ, Япон, БНХАУ, Тайвань, Герман, Итали, Франц, Голланд, АНУ, Канад, ОХУ-д Монголын аялал жуулчлалын сурталчилгааны ажлууд хийгдэж байна.

4.133 Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, шинэ маршрут бий болгох зорилгоор аялал жуулчлалын голлох зах зээлийн орнууд болох Япон, Солонгос зэрэг орнуудад аялал жуулчлалын төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулж байгаа бөгөөд БНХАУ, Герман, Англи, Орос зэрэг орнуудад төлөөлөгчийн газар байгуулах ажлыг судалж байна. Монгол улсад жуулчлахыг хүсэгчдийг хэрэгцээтэй мэдээллээр хангах зорилгоор интернэтэд Англи, Япон хэл дээр Аялал жуулчлалын веб хуудсыг байрлуулж, аялал жуулчлалын мэдээллийн сан, бааз бий болгох ажлын эхлээд байна.

4.134 Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн ивээлээр боловсруулан хэрэгжүүлж буй “Түмэн гол бүсийн хөгжлийн хөтөлбөр”, Ази номхон далайн аялал жуулчлалын холбоо зэрэг олон улсын байгууллагуудын гишүүн орны хувьд тэдгээрээс зохион байгуулж буй Олон улсын үзэсгэлэн яармаг, чуулга уулзалтанд оролцох, аялал жуулчлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийхээр томилогдсон гадаадын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдэд санал өгөх, харилцан мэдээлэл солилцох зэргээр идэвхтэй хамтран ажиллаж байгаа нь Монгол улсыг гадаадад сурталчлах, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, дэлхийн жишигт ойртуулахад тустай алхам болж байна. Өнгөрсөн оны 9 дүгээр сард Монголд болсон хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын үеэр аялал жуулчлалын салбарын хуралдаан болов.

4.135 Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулах, зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоож, үйлчилгээний стандарт мөрдүүлэх зорилгоор “Зочид буудлын ажил үйлчилгээнд зөвшөөрөл олгох, зэрэглэл тогтоох журам”, “Хөтөч, тайлбарлагчийн мэргэжлийн ангилал, зэрэглэл”, “Хөтөч тайлбарлагчийн эрх олгох журам”-ыг Дэд бүтцийн сайдын 2001 оны 133, 134, 135 дугаар тушаалаар, “Аялал жуулчлалын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага стандарт”-ыг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлийн 93-р тогтоолоор, “Аялал жуулчлалын улсын хяналтын дүрэм”-ийг Засгийн газрын 69-р тогтоолоор тус тус батлуулан мөрдүүлж байна.

4.136 Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдний мэргэжил боловсролыг дээшлүүлэх зорилгоор аялал жуулчлалын дээд боловсролын агуулгын цөм хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд аялал жуулчлалын салбарт ажиллаж буй боловсон хүчнийг давтан сургалтанд хамруулах, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангахад чиглэгдсэн сургалт, семинаруудыг Монгол улсад хэрэгжиж буй төслүүдтэй хамтран зохион байгуулж байна. Одоогоор цөөнгүй дээд сургуульд аялал жуулчлалын төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байна.

4.137 Засгийн газрын 2001 оны 200 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих” журам батлагдсанаар “Аялал жуулчлалын сан” байгуулагдан ажиллаж байна. Аялал жуулчлалын сан байгуулагдсанаар Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Монгол орныг дотоод, гадаадад сурталчилахад дэмжлэг үзүүлэх юм.

4.138 2003 оныг “Монголд зочлох жил” болгох нь улс орноо дэлхий дахинд сурталчилаад зогсохгүй “Утаагүй үйлдвэрлэл” хэмээн нэрлэгддэг аялал жуулчлалын хөгжлийг хурдасган, дэлхий нийтийн жишигт ойртуулах боломжийг олгоход тодорхой түлхэц болно гэдэгт бид итгэлтэй байна.

4.139 Бэлтгэл ажлын хүрээнд 2002 онд “Монголд зочлох жил”-д зориулсан сүлд дуу, клип, видео кино, тусгай вэб хуудас, Монголын түүх соёлын талаархи CD гаргасан бөгөөд Нийслэл Улаанбаатар хотноо жуулчны гудамж, мэдээллийн төв, Нүүдэлчний соёл иргэншлийн хүрээлэн байгуулах ажлуудыг эхлээд байна. Аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх нь ДНБ-ний үйлдвэрлэлд бага хувийн жин эзэлдэг тээвэр, холбоо, зочид буудал, ресторан зэрэг үйлчилгээний бусад салбарыг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох юм. Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар ихээхэн анхаарч 1995-2005 онд аялал жуулчлалын талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлж энэ ажлын хүрээнд Монгол улсад аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг Европын холбоо болон Япон улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр боловсрууллаа.

4.140 Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд Монгол улсад үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий стратегийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Байгалийн болон соёл, түүхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, сайжруулах
- Аялал жуулчлалын салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлэх
- Хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг болно.

4.141 Мөн бүс нутгийг 2005 он хүртэлх хугацаанд хөгжлүүлэх стратегийн хүрээнд Улаанбаатар, Хархорин, Өмнөговь дахь аялал жуулчлалын төвийг бэхжүүлж Хөвсгөл, Хэнтий, Өлгий орчимд өвөрмөц, сонирхолтой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар Монголын аялал жуулчлалын үндэс суурийг бүрдүүлнэ гэж тодорхойлсон. Монгол орны түүх соёлын нөөц, нүүдэлчдийн соёл иргэншил, байгалийн унаган төрх, Мянганы суут хүнээр тодорсон Их Чингис хааны өлгий нутаг гэдгээрээ гадаадын жуулчин, гийчдийн сонирхлыг ихээр татах боломжтой юм. Аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбар болгож хөгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч, түүний бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, гадаад сурталчилгааг эрчимжүүлэх явдал тус салбарын хөгжлийн стратегийн зорилт болж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авна. Үүнд: 2010 он хүртэл аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, салбар дундын удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна. Улаанбаатар, Хархорин, Өмнөговь, Хөвсгөл зэрэг газарт аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ. Аялал жуулчлалыг өргөтгөн хөгжүүлж, жуулчны үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Аялал жуулчлалыг хөгжүүлэх дунд хугацааны стратегийн хүрээнд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- үндэсний аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх
- орон нутаг дахь аялал жуулчлал эрхэлсэн төрийн захиргааны нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- аялал жуулчлалыг бүсчлэн, дэд бүтцийг хөгжүүлэх
- байгалын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлж, аялалын чиглэл төрлийг нэмэгдүүлэх
- дотоодын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх

- аялал жуулчлалын үйлчилгээний дунд шатны боловсон хүчин бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах
- үйлчилгээний соёл, чанар, нэр төрлийг сайжруулж олон улсын жишигт ойртуулах
- хөрш орнуудын хилийн ойролцоо ирсэн жуулчдыг Монголд аялуулах олон улсын маршрут зохион байгуулах зэрэг болно.

4.142 *Гадаад худалдаа.* Монгол Улсын хөгжлийн онцлогоос шалтгаалан гадаад худалдаа онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн. 1990-иэд оны эхээр экспортын бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийн тогтолцоо задарч, боловсруулах үйлдвэрүүд уналтад орж үйлдвэрлэл нь эрс буурч, техник технологи нь хоцрогдож, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх менежмент дутагдсан явдал экспортыг бууруулахад хүргэсэн. Зэсийн баяжмал, ноолуур зонхилж, оёмол сүлжмэл эдлэл зэрэг цөөн нэрийн бүтээгдэхүүнийг экспортолж байна. Харин 1990 оноос гадаад худалдааг либеральчилж чөлөөтэй нээлттэй болгосон, тарифын хязгаарлалт, гаалийн элдэв хориг тавихгүй байх талаар арга хэмжээ авсан нь гадаад худалдааг хөгжүүлэх үндэс болж байна. Нийт экспортын 80 орчим хувийг БНХАУ, ОХУ, АНУ, Япон, БНСУ зэрэг цөөн оронтой хийж байна. Иймд олон улсын зах зээл дээр нэвтэрч, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх зорилгоор Дэлхийн худалдааны байгууллага, бүс нутаг болон хоёр талын хамтын ажиллагаанд олон улсын худалдааны арга хөшүүргүүд болон дотоодын зах зээлийн маркетингийн нөөц бололцоог оновчтой ашиглах зорилт тавьж байна.

4.143 Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах замаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ. Мах, махан бүтээгдэхүүнийг орчин үеийн үйлдвэрлэлийн аргаар боловсруулан экспортлох хэмжээг өргөжүүлнэ. Байгаль орчин, ойн нөөцийг хамгаалах, мал сүргийг өсгөхтэй холбогдуулж мод, ямааны арьс, ноолуурт экспортын татвар ногдуулсныг эс тооцвол Монгол улсын экспортын бүтээгдэхүүнд тарифын хязгаарлалт хориг байхгүй юм. Цаашид ч экспортыг дэмжих бодлогын хүрээнд тарифын хувь хязгаарлалт, хориг тавихгүй.

4.144 Дэлхийн худалдааны байгууллагад Монгол Улс 1997 онд нэгдэн орсон нь олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн гэсэн байр сууриа бэхжүүлж, эрх ашгаа хамгаалуулах, улс орныхоо хөгжил, гадаад худалдааны чиг баримжааг тодорхойлоход цаг үеэ олсон алхам болсон бөгөөд уг байгууллагын гишүүн бүх улс оронтой нэн тааламжтай нөхцөлөөр худалдаа хийх боломж бүрдсэн юм. Иймд ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, ялангуяа эхний ээлжинд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд олгож буй төрөл бүрийн хөнгөлөлтүүдийг эдлэх, үйлчилгээний салбар дахь гэрээ хэлэлцээрийн заалтуудыг өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах зэргээр өөрийн орны ашиг сонирхлыг илүү хамгаална. Хөгжиж буй орнуудын үйлдвэрлэл, экспортод чухал байр эзэлдэг нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний зах зээлийг нээлттэй болгох талаар ДХБ-ны хүрээнд хүлээсэн үүрэг амлалтынхаа дагуу манай улсаас нийлүүлдэг бараа бүтээгдэхүүний импортод ногдуулах хязгаарлалтыг багасгаж, АНУ-ын зүгээс үзүүлж буй хөнгөлөлтийг Европын орнуудад тэлэх бодлого баримтална. Дунд хугацаанд Доха-гийн хэлэлцээрийн хэрэгжилтэд анхаарч ажиллана. Дэлхийн зах зээл дээр өөрийн орны хувьд өрсөлдөх чадвараараа өндөр гэж тооцогдох бүтээгдэхүүний нэр төрлийг сонгож, олон улсын стантартад нийцсэн бүтээгдэхүүний борлуулалтын асуудлыг ДХБ-ын хүрээнд хийж буй гэрээ хэлэлцээрт тусгана. Энэ зорилтын хүрээнд үндэсний стандартуудыг олон улсын түвшинд ойртуулж, зах зээлд нэвтэрч буй дотоод болон гадаадын бараа, бүтээгдэхүүний стантартад иж бүрэн үнэлгээ хийх ажлыг хэрэгжүүлнэ.

4.145 Монгол улсын далайд гарцгүй газар зүйн байршил нь гадаад худалдааны нөхцөлд ихээхэн сөргөөр нөлөөлдөг учраас бараа, бүтээгдэхүүний тээврийн зардлыг бууруулах чиглэлээр далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг ашиглах талаар судалж, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна. Тухайлбал, дамжин өнгөрүүлэх тээврийн асуудлаар ОХУ, БНХАУ-тай гурван талын

хэлэлцээрийг эрчимжүүлж, түүний үр дүнд байгуулагдах дамжин өнгөрөх тээврийн Ерөнхий хэлэлцээрийг бүс нутгийн хэмжээнд байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

4.146 Гадаад худалдааны таатай нөхцөл бүрдүүлэхэд тарифын оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал юм. Монгол орны хувьд 1998 оноос мөрдөж буй импортын татварын хувь хэмжээг дэлхийн бусад оронтой харьцуулахад чөлөөт худалдааны түвшинд хүрсэн гэж хэлж болох бөгөөд энэ нь жижиг эдийн засаг, зах зээлтэй манай улсын хувьд амаргүй алхам байсан хэдий ч үйлдвэрлэл, хэрэглээний зах зээлийн хангамж, нийлүүлэлтийг мэдэгдэхүйц сайжруулах чухал хөшүүрэг болж байна. Өнөөдөр импортын ихэнх бараанд 5 хувийн гаалийн татвар ногдуулж, улс орны хөгжилд чухал шаардлагатай зарим салбарын, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой техник, тоног төхөөрөмж, материал зэрэг нэрийн барааг импортын татвараас чөлөөлж байна. Монгол улсын худалдааны либеральчлалын өнөөгийн цар хүрээг үргэлжлүүлж дунд хугацаанд Засгийн газраас гадаад худалдааны үйл ажиллагаанд ямар нэг саад, хязгаарлалт хийхгүй болно.

4.147 Гадаад худалдааны таатай орчин бүрдүүлэх, түүнчлэн үйлдвэрлэл, худалдаа эрхлэхэд тарифын бус зохицуулалтыг зохистой болгох, хүнд суртлыг багасгах, элдэв шат дамжлага, зөвшөөрлийг цөөлөх зэргээр төрийн зохицуулалтын оролцоог улам багасгана. Ийнхүү гадаад худалдааг улам нээлттэй чөлөөтэй болгож буй нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, экспортыг нэмэгдүүлж гадаад худалдаанаас олох орлогыг нэмэгдүүлж, хүн амын хэрэглээ, ялангуяа ядуучуудад өртөг багатай бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөл бүрдэхийн зэрэгцээ тэдний орлого өсөх үндэс болно гэж үзэж байна.

4.148 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хүрээнд хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, улмаар хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд үйлдвэрлэл, худалдааг урамшуулсан чөлөөт бүс чухал байр суурьтай байна. Монгол Улсад чөлөөт бүсийг худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байж болох тухай хууль эрхзүйн орчин бүрдүүлсэн бөгөөд эхний ээлжинд худалдааны чөлөөт бүсийг Алтанбулаг, Замын-Үүдэд байгуулах зорилт тавьж байна. Ийнхүү бараа бүтээгдэхүүний зах зээлийг хөгжүүлэх, гадаад худалдааны нөхцөлийг сайжруулах талаар тавьж буй стратеги нь ядуучуудын орлогыг нэмэгдүүлэх, хот хөдөөд жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг нь гадаад, дотоод зах зээлд борлуулахад чиглэгдэж байгаа юм.

VI. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил.

Бүсийн хөгжил

4.149 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Монгол Улсын Их Хурал 2001 оны 6 сард баталсан. Энэхүү үзэл баримтлалын гол зорилго нь бүс нутгийн байгалийн нөөц баялаг, хөдөө аж ахуй, газар тариалан, хүний нөөцийг зөв ашиглаж тухайн бүс нутагт эдийн засгийн өсөлт болон нийгмийн дэвшлийг түргэсгэж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах таатай нөхцөлийг бий болгох, улмаар хүн амын хэт төвлөрлийг сааруулахад оршиж байгаа юм. Үзэл баримтлалын үндсэн зарчмуудыг бүхий л хүрээнд нэвтрүүлснээр эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх нэг үндэс болно. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу тухайн бүс нутгийн иргэдэд сурах, амьдрах, мэдээллийг олж авах, амьдралд идэвхтэй оролцох, ижил тэгш боломжийг олгохоос гадна боловсрол, эрүүл мэнд, соёл, мэдээлэл, ахуйн үйлчилгээг жигд хүртээх боломжийг олгох юм. Бүс нутгийн хөгжлийг дэмжих хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх ажлыг дунд хугацаанд хийж, тухайн бүс нутгийн хөгжлийн стратеги тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, тухайн бүсийн банк, санхүү, дэд бүтцийн сүлжээг сайжруулах бодлого баримталж байна.

“Манайх зах зээлээс их хол, зөвхөн ганзагын наймаачид өөрсдөө бид нар руу ирдэг. Тэд өмч хөрөнгө, малынх нь тоогоор хүмүүсийг ялгаварлан харьцдаг, тэд малын хашаанд нь цөөхөн мал байвал шууд өнгөрөөд явчихдаг. Малчид дурандаж байгаад наймаачид түр буудалласан айлууд дээр өөрсдөө очдог. Хэдийгээр бид тэднийг бэлэн

мөнгөтэй гэдгийг нь мэддэг боловч тэд бидэнтэй бэлэн мөнгөөр наймаа хийдэггүй. Тэд малын маань оронд бараа өгдөг. Харин заримдаа баян чинээлэг өрхүүдтэй том наймаа хийж байхдаа бэлэн мөнгөөр тохиролцдог. Тэд малыг маань шилж, сонгон хамгийн сайныг нь авдаг, гэвч бидэнд өгч байгаа зүйл нь тун ч өчүүхэн. Тэдэнтэй наймаа хийхэд шударга бус, хэцүү байдаг. Бидэнд хуучин байсан худалдааны агентын сүлжээ тун ч их үгүйлэгдэж байна” гэж Дорнод аймгийн Дашбалбар сумын эрэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.

4.150 Иймээс хөдөөгийн хүн ам, ядуурлын асуудлыг бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлоготой уялдуулан авч үзэх шаардлага гарч байна. Монгол улсын хөдөөгийн хөгжлийн стратегийн гол зорилго нь хөдөөгийн хүн амыг бүх талаар хөгжих нөхцөлийг бүрдүүлж, тэдний сайн сайхан амьдралыг хангахад чиглэгдэж байна. Манай орны ихэнх нутаг ган, зуд, цасан болон шороон шуурга, ой хээрийн түймэр, үер усны аюул, хөнөөлт шавьж, хортон мэрэгчдийн өсөлт зэрэг 10 гаруй төрлийн гамшигт үзэгдэл байнга тохиолдож, давтамж нь нэмэгдэж байгаа нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд муугаар нөлөөлж, улмаар байгаль цаг агаарын энэ бэрхшээлтэй хөдөөгийн хүн ам байнга тулгарч, эдийн засаг, эрүүл мэндийн хувьд хохирч байна.

4.151 Нийслэл хотын эргэн тойронд таван мянга гаруй гектар ургацын талбай бий. 1998 онтой харьцуулбал сүүлийн 2 жилийн тариалангийн талбай дунджаар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Ногоон Хувьсгал Хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэд идэвхгүй оролцсонтой холбоотой. 2002 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс үзвэл 2050 гектар талбайд төмс, хүнсний ногоо тариалжээ. Хотын хүнсний хангамж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахын тулд дээрх боломжуудыг үр ашигтай ашиглах, тариалангийн талбайн газрыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүнсний хангамжийн бас нэг эх үүсвэр нь жимсний бизнес юм. Хотын захирагчийн алба нь жимсний тариалалтыг дэмжих, энэ бизнесийн түвшинг 1998-1999 оныхтой адил 8.4 тоннд хүргэхээр төлөвлөөд байна. 2002 оны байдлаар хөдөө аж ахуйн чиглэлээр 208 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна 59 аж ахуйн нэгж мал аж ахуйг дангаараа болон газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан эрхэлж байна. Тэдгээр аж ахуйн нэгжүүдийн дийлэнх ажиллагчид (70.6 хувь) нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ба мал аж ахуй нь гэр бүлийн бизнесд тооцогддог. Эдгээр гэр бүлийн бизнес болон аж ахуйн нэгжүүд нь өөрийн бүтээгдэхүүнээрээ сүү болон махан бүтээгдэхүүний 100 хувь, гурилын 70 хувь, төмс, хүнсний ногооны 55 хувь, өндөгний 10 хувийн хэрэгцээг хангадаг. Чихэр, жимс, цөцгийн тос, наранцэцгийн тос зэрэг зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг импортлон авдаг. Ерөнхийдөө, аж ахуй эрхлэгчид нь зөвхөн өөрсдийн гэр бүлийн хэрэглээг хангаж чадаж байгаа ч нийслэл хотын хүнсний хэрэглээг хангахад хөдөө аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үүрэг маш бага байгаа юм.

Хүснэгт 4:2: Бүсүүдийн эдийн засгийн тухайн жилийн гол үзүүлэлт (2000 оны байдлаар)

| | Хүн амын эзлэх | Газар нутгийн эзлэх | Төрийн толгойн эзлэх | Хүнсний -рын эзлэх | Бүтээг-дэхүүний | Сүлд өртөмт-гий бэйцээ | -рийн усжуу | Сайныг сүлжээ-ний | Орон нутгийн төсвийн орлого |
|----------------------|----------------|---------------------|----------------------|--------------------|--------------------|------------------------|-------------|-------------------|-----------------------------|
| I. Баруун бүсийн дүн | 450.0 мян. хүн | 4170.5.4 мян.га | 8702.4 мян. толгой | 956 тн | 10069.9 сая төгрөг | 25-30% | 31.5% | 0.13 /улс-1 коэф/ | 17.9% |
| Баян-Өлгий | 22.5 | 11.4 | 15.1 | 15.3 | 0.0 | 20-30 | 23.5 | 0.11 | 23.1 |
| Говь-Алтай | 15.2 | 33.9 | 23.4 | 29.4 | 90.0 | 20-30 | 34.5 | 0.15 | 11.9 |

| | | | | | | | | | |
|------------------------|----------------------|---------------------------|-----------------------------------|-------------|-------------------------------|------------|-----------|------|-------|
| Завхан | 20.8 | 19.8 | 22.3 | 16.5 | 0.0 | 40-50 | 29.3 | 0.11 | 16.3 |
| Увс | 20.6 | 16.7 | 18.1 | 16.4 | 0.0 | 30-40 | 33.6 | 0.13 | 19.2 |
| Ховд | 20.9 | 18.2 | 21.1 | 22.4 | 10.0 | 20-30 | 36.7 | 0.14 | 18.9 |
| II. Хангайн бүсийн дүн | 554.2 мян. Хүн | 3843 9.3 мян.г а | 1071 1.7 мян. толго й | - | 20324 0 сая төгрөг | 30- 40% | - | 0.26 | 35.2% |
| Архангай | 17.6 | 14.4 | 20.7 | - | 2.1 | - | - | 0.26 | 30.1 |
| Баянхонгор | 15.4 | 30.2 | 22.2 | - | 1.0 | - | - | 0.19 | 17.3 |
| Булган | 11.3 | 12.6 | 14.2 | - | 0.7 | - | - | 0.37 | 28.6 |
| Өвөрхангай | 20.4 | 0.2 | 20.2 | - | 3.8 | - | - | 0.20 | 27.1 |
| Хөвсгөл | 21.6 | 16.4 | 21.1 | - | 0.7 | - | - | 0.30 | 20.2 |
| Орхон | 13.7 | 26.2 | 1.6 | - | 91.7 | - | - | 4.0 | 84.6 |
| III. Төвийн бүсийн дүн | 445.3 мян. Хүн | 4735 5.9 мян.г а | 6792.7 7 мян. толго й | 665.8 тн | 87429.2 сая төгрөг | 20- 25% | 46.1 % | - | 49.8% |
| Дорноговь | 11.5 | 1.1 | 15.3 | 15.2 | 1.9 | 13-20 | 35.2 | - | 43.5 |
| Дундговь | 11.5 | 0.7 | 18.9 | 19.9 | 1.1 | 20-30 | 35.5 | - | 25.4 |
| Өмнөговь | 10.5 | 23.1 | 21.9 | 36.5 | 0.9 | 13-20 | 47.8 | - | 23.7 |
| Сэлэнгэ | 22.7 | 15.8 | 9.6 | 6.2 | - | 20-30 | 69.3 | - | 60.4 |
| Төв | 22.0 | 34.9 | 29.8 | 18.5 | 17.3 | 30-40 | 42.5 | - | 58.3 |
| Дархан-Уул | 19.0 | 8.7 | 2.9 | 2.2 | 53.9 | 13-20 | - | - | 59.0 |
| Говьсүмбэр | 2.8 | 15.7 | 1.6 | 1.4 | 21.5 | 13-20 | 46.6 | - | 43.6 |
| IV. Зүүн бүсийн дүн | 201.5 мян. хүн | 2862 1.0 мян.г а | 3790.1 1 мян. толго й | - | 4251.5 сая төгрөг | 35- 45% | 40.5 % | 0.63 | 21% |
| Дорнод | 36.8 | 43.2 | 21.8 | - | 32.4 | 30-35 | 25.6 | 1.31 | 26.8 |
| Сүхбаатар | 27.8 | 28.7 | 39.4 | - | 29.5 | 40-50 | 36.5 | 0.28 | 12.6 |
| Хэнтий | 35.4 | 28.1 | 38.8 | - | 38.1 | 30-40 | 59.5 | 0.31 | 22.6 |
| Улаанбаатар | 786.5 мян. Хүн | | | | 574.2 тэрбу м төгрөг | | | | |

Эх үүсвэр: Геоэкологийн хүрээлэнгийн судалгаа, 2000 он

4.152 Иймээс хөдөөгийн хүн ам, нэн ялангуяа ядуу иргэдийн орлогын тогтвортой өсөлтийг хангах, хөдөөгийн иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчин, байгалийн нөөцийн ашиглалтын тогтвортой байдлыг хангах нь дунд хугацааны тэргүүлэх чиглэлийн зорилтууд болж байгаа бөгөөд эдгээрийг дараах байдлаар томъёолж болох юм. Үүнд:

- Бүс нутгийн удирдлагын зарчмыг тодорхойлж чадавхийг дээшлүүлэх
- Бүс нутаг тус бүрийн хөгжлийн стратегийг тодорхойлох

- Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэн газар тариалангийн салбарын уналтыг зогсоож сэргээх
- Хөдөө аж ахуйн маркетинг, агро-бизнес, хөдөө аж ахуйн бус орлого нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах
- Хөдөөгийн хүн амын нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийн зохистой ашиглалтыг хангах, байгалийн гэнэтийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх
- Хөдөөгийн дэд бүтцийг сайжруулах зэрэг болно.

4.153 Эдгээр зорилтууд нь Эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, ядуурлыг бууруулах стратегийн энэхүү баримт бичгийн холбогдох бүлгүүдэд тусгагдаж байгаа бөгөөд энэ бүлэгт зөвхөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, байгалийн нөөцийн удирдлага, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг өргөжүүлэх, хөдөө дэх дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг өргөтгөх, иргэдийн чадавхийг дээшлүүлэх зэрэг стратегийн асуудлуудыг товчхон авч үзэж байна. Хөдөөгийн хөгжлийн стратегийг Дэлхийн банкны техникийн тусалцаатайгаар 2002 онд тусгайлан боловсруулсан болно.⁴

4.154 Сүүлийн жилүүдэд нийслэл хотод хотжих явц түргэн газар авсан нь хүн ам, үйлдвэрийн хэт нягтрал, хотын хүн амыг түргэн өсөлтөд хүргэсэн. 2002 онд Улаанбаатарын хүн ам 817.6 мянга буюу улсын нийт хүн амын 32 хувь орчим болсон байна. Улаанбаатарын хүн амын 48.7 хувь нь буюу 35000 орчим гэр бүл нь гэр хороололд амьдарч байна. Хүн амын нүсэр суурьшил болон нягтрал өссөнөөр хотын оршин суугчдын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж, ялангуяа нийслэл хотын гэр хороололд хүний амьдрах эрүүл, аюулгүй орчинг гажуудуулахад хүргэж байна. Тиймээс Улаанбаатар хотын гэр хорооллын тэргүүлэх зорилт нь хотын хөгжлийн стратегид дэлхийн бусад нийслэл хотуудаас Монгол улсын ялгагдах өвөрмөц онцлогыг тусгасан уламжлалт сууц болох гэрүүдийг тухтай амьдрах нөхцөл бүхий тохилог сууцны хороолол болгож шинэчлэн барих явдал юм.

Мал аж ахуй

4.155 Монгол улсын эдийн засгийн гол үндэс болсон бэлчээрийн мал аж ахуйн салбар нь Монгол улсын эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод гол байр суурь эзэлсэн хэвээр байна. Одоогоор дотоодын нийт бүтээгдэхүүн, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогын гуравны нэг орчим хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн системд шилжиж эхэлсэн 1990-д онд мал сүрэг улсын болон хоршооллын өмчөөс шууд хувийн өмчид шилжсэн юм. Ийнхүү мал сүрэг өмчийн нэг хэлбэрээс өмчийн олон хэлбэрт шилжсэн нь төрөөс баримтлаж байсан бодлого, чиглэлийг өөрчлөх шаардлага зүй ёсоор гарч ирсэн. Энэ үеэс мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэл өөрчлөгдсөн хэдий ч мал нь улс орны эдийн засаг, хүмүүсийн амьжиргааны гол хэрэгсэл хэвээр байсан бөгөөд харин ч уг салбарын ач холбогдол өссөн юм.

4.156 1990 онд улсын нийт мал сүргийн 68.2 хувь нь улс, хоршооллын өмчид байсан бол одоо 97.2 хувь нь хувийн өмчид шилжээд байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1996-1999 оны хооронд 2.4- 4.0 хүртэл өссөн байхад ХАА-н нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл мөн хугацаанд 4.2-6.4 хувиар өссөн байна. Гэтэл байгалийн гамшиг, ган зудын улмаас 2000 онд ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 16.8 хувиар, 2001 онд 18.5 хувиар тус тус буурсан байна. Үүнтэй уялдаад нэг хүнд ноогдох сүү, цагаан идээний хэмжээ мөн л буурчээ.

⁴ Хөдөөгийн хөгжлийн стратеги. Бодлого судлалын төв. 2002,10 сар

Хүснэгт 4:3: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мал аж ахуйн салбарын гүйцэтгэх үүрэг / хувиар /

| Үзүүлэлт | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 |
|--|------|------|------|------|------|------|------|------|------|
| ДНБ-д ХАА-н бүтээгдэхүүний эзлэх хэмжээ | 31.7 | 35.9 | 37.1 | 38.0 | 36.8 | 34.6 | 37.5 | 37.0 | 33.4 |
| ХАА-н бүтээгдэхүүнд мал аж ахуйн салбарын эзлэх хэмжээ | 81.7 | 76.7 | 85.7 | 85.2 | 86.8 | 86.5 | 87.7 | 89.8 | 87.6 |

Эх сурвалж : Монгол улсын статистикийн эмхтгэл

4.157 Сүүлийн жилүүдэд ДНБ-нд ХАА-н бүтээгдэхүүн, ХАА-н бүтээгдэхүүнд малын гаралтай бүтээгдэхүүний эзлэх хувийн жин тогтвортой хэмжээнд байна. Харин 2000-2001 онд энэ үзүүлэлт буурсан нь тухайн жилүүдэд зун нь гандуу байснаас ихэнх нутагт бэлчээрийн ургац муу байсан, үр тарианы ургац бага авсан, өвөл нь цас их орж, зуд болсноос 2000 онд 3.5 сая, 2001 онд 4.7 сая мал хорогдсон, эх малын хээл хаялт, сувайралт үлэмж нэмэгдсэн оны эхний 100 хээлтэгчээс бойжуулах төлийн тоо цөөрсөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн болно.

4.158 Мал аж ахуйн үйл ажиллагаа нь нийслэл хотын хүн амын хоол, тэжээлийн гол эх үүсвэрийн нэг хэвээр байна. Нийслэл хотод 2001 онд 221.4 мянган толгой мал бүртгэгдсэн. Сүүлийн үед малын тоо толгой буурах хандлагатай байгаа нь хотын гаднах бэлчээрийн даац буурснаас малыг хамгаалахад шаардагдах зардал нэмэгдэж байгаатай холбоотой. Энэ нь хотын орчимд уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх боломжгүй болохыг харуулж байна. Нийслэл хотод 7496 малчин өрх байгаагаас 3976 өрх 10-аас цөөн малтай, 1606 өрх 30 хүртэл, 1422 өрх 100 хүртэл, 481 өрх 100-500, 11 өрх 1000 хүртэл толгой малтай байна. Мал аж ахуйн бүтцийн хувьд хотын төвд ихэнх нь үхэр байна. Гэхдээ хотын гадна амьдардаг малчид хонь, ямаатай байхыг илүүд үздэг. Мөн 1134 гахай, 38573 шувуу бий. Судлаачид, мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлаас үзвэл өрхийн нэг жилийн хэрэглээг хангахын тулд нэг малчин өрх доод тал нь 300 малтай байх ёстой. Нийслэл хотын малчдын зөвхөн 34.8 хувь нь өрхийнхөө хэрэглээг хангаж чадахуйц зохих тооны малтай байгаа бөгөөд үлдэх хэсэг нь мал аж ахуйн бизнесээрээ зөвхөн өдөр тутмынхаа хэрэгцээг дөнгөж хангадаг. Нийслэл хотын хөдөө аж ахуйн дорой байдал, хөдөөгийн малчдын нийслэл рүү шилжин суурьших зэрэг хүчин зүйлүүд нь хотын ядуурлыг механикаар өсгөх нэг шалтгаан болж байна. Тиймээс эдгээр асуудлуудыг бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан шийдвэрлэх хэрэгтэй юм.

4.159 Бүсчилсэн Хөгжлийн Үзэл баримтлалын дагуу нийслэлийг бүх төрлийн үйлчилгээ, аж ахуйн нэгж, мэдээллийн технологи, олон улсын түвшний банк, санхүүгийн сүлжээ бүхий бие даасан бүс болгон хөгжүүлэх нь Улаанбаатар хотын стратегийн зорилт болж байна. Тиймээс суурин болон хагас-суурин эрчимжүүлсэн мал аж ахуй, цаг агаарын бага эрсдэлтэй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь Улаанбаатар хотын мал аж ахуйг өсгөх тэргүүлэх зорилтын нэг болж байна.

Хүснэгт 4:4: Мал аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

| Бүтээгдэхүүн | / мян тонн / | | | | | | | | | |
|---------------------------|--------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--|
| | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | |
| Мах /нядалгааны жингээр / | 251.2 | 216.1 | 203.9 | 211.7 | 259.9 | 240.5 | 268.3 | 289.0 | 310.6 | |
| Үүнээс: Үхрийн мах | 75.7 | 64.5 | 64.4 | 69.4 | 90.0 | 86.6 | 99.3 | 104.6 | 113.4 | |
| Хонь, ямааны | 116.3 | 112.5 | 111.9 | 111.5 | 121.3 | 104.4 | 120.2 | 128.9 | 120.0 | |
| Гахайн мах | 1.8 | 0.7 | 0.7 | 0.6 | 0.3 | 0.2 | 0.2 | 0.3 | 0.9 | |
| Хонины ноос | 21.0 | 20.8 | 19.6 | 19.6 | 19.5 | 18.3 | 20.1 | 20.9 | 21.7 | |
| Ноолуур | 1.4 | 1.3 | 1.8 | 2.1 | 2.5 | 2.6 | 2.9 | 3.3 | 3.3 | |
| Сүү /сая литр/ | 308.1 | 292.9 | 312.5 | 369.0 | 369.8 | 418.6 | 430.8 | 467.0 | 375.6 | |
| Өндөг / сая ширхэг / | 18.6 | 10.0 | 3.6 | 3.5 | 4.9 | 6.1 | 8.5 | 9.6 | 6.7 | |

Эх сурвалж: Монгол улсын статистик эмхтгэл

4.160 Зах зээлийн харилцаанд шилжихээс өмнө улсын хэмжээнд жил бүр дунджаар 7.6 сая мал буюу амьдын жингээр 480 гаруй мянган тонн мах хүнсэнд нийлүүлж, хэрэглэж байсан бөгөөд хэрэглэсэн нийт махны 40 гаруй хувийг хонь, 30 орчим хувийг үхэр, 10 гаруй хувийг адуу, 10 орчим хувийг ямаа, 4 орчим хувийг тэмээний мах эзлэж байсан байна.

4.161 Мах үйлдвэрлэл 1994 он хүртэл буурч байснаа 1995 оноос эхлэн аажмаар нэмэгдэх хандлага ажиглагдаж байв. Үүнд гадаадад мах гаргах хэмжээ өссөн нь тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Монгол улсын Засгийн газраас 2001 оныг “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлсэний үр дүнд дотоодын үйлдвэрүүд сэргэх хандлага ажиглагдаж байна. Одоогийн байдлаар тус улсад нэг ээлжээр ажиллаж жилд 62.0 мянган тонн мах боловсруулах хүчин чадалтай 220 үйлдвэр байгаагийн 19 нь гадаадад мах гаргах эрх авч энэ чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

4.162 Сүү боловсруулах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 10 гаруй томоохон, 200 орчим жижиг үйлдвэр ажиллаж байна. Мөн ноос боловсруулах чиглэлийн 46, арьс шир боловсруулах 70 гаруй, ноолуур боловсруулах 48, сүлжмэлийн 37 үйлдвэр байна. Эдгээр үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргэж жигд ажиллавал малын гаралтай түүхий эдийг боловсруулж экспортлох бүрэн боломжтой.

Хүснэгт 4:5: Мал аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалт

/ сая төгрөг /

| | Зардлын төрөл | 1990 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 |
|---|--|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| 1 | Мал сүргийн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ | 668.0 | 870.0 | 900.0 | 1900.0 | 1900.0 | 1900.0 | 2100.0 | 2900.0 |
| 2 | Малын тэжээлийн үндсэн бааз бий болгоход | - | - | - | 74.9 | 89.2 | 103.5 | 269.3 | 1720.9 |
| 3 | Бэлчээрийг хортон шавьж, мэрэгчидээс хамгаалах арга хэмжээнд | 10.0 | 16.0 | 150.0 | 200.0 | 200.0 | 300.0 | 450.0 | 600.0 |
| 4 | Бэлчээрийн усан хангамж сайжруулахад | - | | | | 260.0 | 300.0 | 426.0 | 466.0 |
| 5 | Байгалийн гамшиг ган, зудад учирсан хохирол нөхөхөд/ малжуулахад / | - | | | | | | 1300.0* | |
| 6 | Байгалийн гамшиг зудтай тэмцэхэд туслах | - | | | | | 437.4 | 1900.0 | 71.8 |
| 7 | Малын гоц халдварт өвчинтэй тэмцэхэд | - | | | | 0.4 | - | - | 753.7 |

Эх сурвалж : Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэдээ

*Дэлхийн банкны урт хугацааны зээлийн 1300.0 сая төгрөгийн хөрөнгөөр

байгалийн гамшиг зудын улмаас малгүй буюу цөөн малтай болсон 5 аймагт малжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

4.163 Мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төвлөрсөн төсвөөс зөвхөн сүүлийн 3 жилд 1.9-2.9 тэрбум, нийт 6.9 тэрбум төгрөг зарцуулж, давхардсан тоогоор жил бүр 37- 48 сая мал нийт 127.8 сая малыг дээрх арга хэмжээнд хамруулсан байна.

4.164 Байгалийн гамшиг, ган зудын улмаас учирч байгаа хохирлыг нөхөх зорилгоор малчдыг малжуулах ажлыг гадаад дотоодын хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл тусламжийн хөрөнгөөр хийж байна. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны урт хугацааны зээл 1.3 тэрбум төгрөгөөр 5 аймгийн 33 сумын 1728 өрхөд 103.4 мянган мал, НҮБ-ын ХААХОУС-аас 2 аймгийн 1276 өрхөд 767.0 мянган мал олгож малжуулах ажлыг зохион байгуулав.

1998 онд малчдын дунд явуулсан түүвэр судалгаагаар нэг малчин өрхийн дундаж орлого 500.2 мянган төгрөг, сарынх нь 41.7 мянган төгрөг байв. Энэ үед 2000 –аас дээш малтай малчин өрхийн жилийн дундаж орлого 4.5 сая төгрөг байв.

4.165 1000-с дээш толгой малтай, бизнесийн хэв шинжтэй малчин өрхүүдэд эрдэм шинжилгээний байгууллагуудаас 2000-2001 онд явуулсан судалгааны дүнгээс үзвэл өрхийн жилийн мөнгөн орлогын 94.8 хувийг мал аж ахуйн орлого, 1.1 хувийг бусад үйлдвэрлэлийн орлого, 3.4 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байжээ. Үүнээс үзэхэд өнөөгийн малчин өрхүүд дан ганц салбар – мал аж ахуй эрхэлдэг, тэр нь байгаль цаг агаараас ихээхэн хараат шинжтэй байгаа нь тэдний орлого, амьжиргааны түвшин тогтвортой бус байх нөхцлийг бий болгож байна. Малчин өрхийн жилийн мөнгөн орлого нь 4.6 сая төгрөг, мөнгөн зарлага нь 4.5 сая төгрөг байв.

4.166 Малчин өрхийн мөнгөн орлогын хэмжээг бүтээгдэхүүний орлогоор гаргаж үзвэл 59.5 хувийг ямаанаас, 23.3 хувийг хониноос, 10.4 хувийг үхрээс, 3.9 хувийг тэмээнээс, 2.9 хувийг адуунаас олжээ. Бэлчээрийн мал аж ахуй нь байгаль цаг агаарын өөрчлөлтөөс хараат, ашиг шим доогуур юм. Зах зээлийн харилцаанд шилжих явцад дээр дурдсан мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа хэвээр үлдэж, хувийн хэрэгцээгээ хангах төдий өрхийн аж ахуйн хэлбэртэй хэвээрээ байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээ муудаж, маркетингийн тогтолцоо төдийлөн бүрдээгүй байна. Шилжилтийн үеийн эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийн явцад олон хүн ажилгүй болж, хөдөө гарч мал маллаж амьжиргаагаа авч явахаас өөр аргагүй хүмүүсийн тоо эрс нэмэгдсэн байна. Малчин өрхийн тоо 1990-ээд оны эхэнд 190 мянга, малын тоо 25.8 сая толгой байсан бол 2000 оны эхэн гэхэд өрхийн тоо 2 дахин малын тоо 33 сая болтлоо нэмэгдэв. Гэвч нийт малчин өрхийн 85 хувь нь 200-аас доош толгой малтай, 63 хувь нь 100-аас доош малтай байна. Хэт жижиг аж ахуй бүхий малчин өрхүүд нь өвс тэжээл бэлтгэх, нүүдэл, тээвэр хийх, мал эмнэлгийн болон бусад үйлчилгээ авах, бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлд хүрэх, байгалийн хүндрэл бэрхшээл болон үнийн эрсдэлийг даван туулахад хүчин мөхөсдөж байгаа бөгөөд ядууралд өртөх эрсдэл ихтэй, нэн эмзэг байдалтай байна. Туршлагатай малчдын тоо цөөрч, мал аж ахуйн салбарын тэргүүний туршлагыг дэлгэрүүлэх, малчдын халааг бэлтгэх тогтолцоо алдагдсан байна. Малчин өрх амьдралынхаа наад захын хэрэгцээг хангахад 300-400 толгой мал хэрэгтэй гэсэн судалгаа гарсан байна.

4.167 Малын тоо толгой өсч, нөгөө талаар бэлчээрийн усан хангамж хангалтгүй байгаагаас нэг дор олон мал бөөгнөрч бэлчээрийн даац хэтрэн бэлчээр талхлагдах, зуд ган гачиг тохиолдох үед ашигладаг нөөц бэлчээрт мал хэт бөөгнөрч туурайн зуд болох зэрэг нь мал олноороо хорогдох нэг шалтгаан болж байна.

4.168 Малын тоо, үр ашгийн үзүүлэлттэй холбоотойгоор баян хоосны ялгаа ихсэж, малчин өрхийн ядуурал, нийгмийн асуудал улам бүр хурцаар тавигдаж байна. 2000 оны байдлаар нийт малчин өрхийн дөнгөж 10.6 хувь нь цахилгаан гэрэлтэй, 12.8 хувь нь телевизортой байна. Малчид жалгын нэг болж тарсан нь тэдэнд нийгмийн үйлчилгээг хүргэхэд ч бэрхшээл учруулж байна. Шилжилтийн үеийн эдийн засгийн бэрхшээлээс улбаалж, төсвөөс олгодог боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хөрөнгө багассан нь хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулж байна.

4.169 Дээрх байдалд үнэлгээ хийж Засгийн газраас “Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл” – ийн хүрээнд бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэх, тодорхой бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж дотоодын хүнсний хэрэгцээг хангах, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг тогтвортой нэмэгдүүлэх замаар малчид, хөдөөгийн иргэдийн амьдралын түвшинг сайжруулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, "Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах үндэсний хөтөлбөр", "Малын эрүүл мэнд хөтөлбөр", "Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр", "Усны үндэсний хөтөлбөр", "Цагаан хувьсгал", "Ноолуур", "Ноос" хөтөлбөрүүдийг дурьдаж болно. Улсын төсвөөс зохих хөрөнгийн дэмжлэг үзүүлж малын эрүүл мэндийг хамгаалах, тэжээл бэлтгэл, бэлчээрийн хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх, усан хангамжийг сайжруулах, малжуулах, ган, зудын гамшигт нэрвэгдэгсдэд туслах, гоц халдварт өвчнийг таслан зогсоох зэрэг арга хэмжээг авч, түүнд жил бүр 3-5

тэрбум төгрөг зарцуулж байна. Эдгээр төсөл, арга хэмжээ нь малчдын амьдрал ахуйг дээшлүүлэх, хөдөөгийн ядуурлыг бууруулахад чиглэгдэж байгаа юм.

4.170 Дээрх хөтөлбөрүүдийн зэрэгцээ хандивлагчдын дэмжлэгтэйгээр малжуулах төслийг 1-2 аймагт хэрэгжүүлсэн нь үр дүнтэй болсон. Гэхдээ малчдыг эрсдэлээс хамгаалах тогтолцоог найдвартай болгох, мал аж ахуйн бус орлого нэмэгдүүлэх бололцоог ашиглах арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

4.171 Урт болон дунд хугацаанд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилт нь мал аж ахуйд байгаль цаг уур, халдварт өвчнөөс учрах эрсдэлийн менежментийн чадавхийг бий болгох замаар малчдын хөрөнгө, орлогыг найдвартай хамгаалах, бүс нутгийн онцлог, давуу талыг харгалзан мал аж ахуйг эрчимжүүлэх замаар тус салбарын тогтвортой хөгжлийг хангах явдал юм.

4.172 Малчид хоорондоо хөдөлмөрөө хорших энгийн хэлбэрийг хөхиүлэн дэмжиж, шаардлагатай чадавхийг бэхжүүлэх, сургалт, жижиг зээл, санхүүгийн үйлчилгээгээр дэмжих замаар бусад жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, төмс, хүнсний ногоо тариалах, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах болон боломжийг нэмэгдүүлэх нь малчдын амьжиргааны эх үүсвэрийн эрсдэлийг бууруулна.

4.173 Малчид хоорондоо хоршиж, хамтран ажиллах явдлыг дэмжих замаар тэдний тулгамдсан асуудлыг өөрсдийн санаачилга, хамтын хүчээр шийдэх чадавхийг бүрэн дүүрэн ашиглах чиглэл баримтална. Энэ нь ядуурлыг бууруулахад баримталж байгаа бэлэнчлэх сэтгэлгээг даван туулах зарчим, дээрээс зааварлах бус доороос гарах санаачилгыг өрнүүлэх хөгжлийн орчин үеийн хандлагатай нийцэх юм. Малчдын хамтын ажиллагааг дэмжих бодлого нь сайн дурын үндсэн дээр доороос өрнөх санаачилга, уламжлалт гол ус, айл саахалтын бүлгийн зохион байгуулалтын албан бус хэлбэрүүдийг дэмжих замаар хэрэгжинэ.

Мал аж ахуйн эрсдэлийн менежментийн чадавхийг бий болгох зорилтын хүрээнд:

- Малчдын бүлэг, хоршоог дэмжих
- Бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох
- Тэжээлийн хангамжийг сайжруулах
- Усан хангамжийг сайжруулах
- Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх
- Эрсдэлийн урьдчилсан мэдээллийн тогтолцоо, түүнд хариу үйлдэл хийх чадвар, гамшгийн менежмент зэрэг асуудлыг хамарна.

4.174 Малаа эрүүлжүүлэх нь мал аж ахуйн салбарын тэргүүлэх зорилтын нэг болох бөгөөд юуны өмнө малаа эрүүлжүүлэх сонирхлыг малчдад төлөвшүүлнэ.

Мал аж ахуйг эрчимжүүлэхдээ бэлчээрийн монгол малыг орон нутгийн нөхцөлд сайн зохицсон, өндөр ашиг шимтэй нутгийн шилмэл омгийн малаар сайжруулах тэжээлийн бааз, зах зээлд ойр бүс нутагт зах зээлийн жамаар өөрийгөө аваад явах чадвар бүхий эрчимжсэн ба хагас эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх гэсэн 2 чиглэлийг баримтална. Олон тооны өрх хөдөө аж ахуйн ерөнхий болон туслах аж ахуйгаас малчид болон хувирсан нь хүүхдээ асрахын хажуугаар үнээ саах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх /эдгээр нь Үндэсний тооцонд тусгагддаггүй/ зэргээр эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн цагийг нэмэгдүүлэхэд хүргэсэн. Малчин өрхийн дийлэнх нь өөрсдийн өмчин дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг боловч өрхийн үйлдвэрлэл эрхлэх ямар нэг лицензгүй, банкны үйлчилгээнд хамрагддаггүй, аж ахуй эрхлэх үндсэн арга хэрэгслээр байнга дутагддаг байдалтай байна. Энэхүү мал аж ахуйд түшиглэх байдал нь хүүхдэд мөн нөлөөлдөг. Холбогдох газрууд болон иргэний нийгмийн байгууллагууд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст ижил боломж, ашиг тус хүртээхэд болон эдийн засаг, нийгмийн аливаа эрсдлийг бууруулах чиглэлээр зохицуулан ажиллах шаардлагатай байна.

Газар тариалан

4.175 Газар тариалангийн салбарт 1990 оноос өмнө 700-880 мянган тонн үр тариа, 100-120 мянган тонн төмс, 500-700 мянган тонн малын тэжээл хураан авч бэлтгэж байв. 1990 оноос өмнөх газар тариалангийн салбарын бодлого нь үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахын хамт түүнийг экспортлоход чиглэж байсан ба 1990- 1996 онд өмч эзэндээ ойртох тутам түүний үйл ажиллагаа сайжирна гэсэн зарчимд нийцүүлэн тариалангийн аж ахуйнуудыг төрийн өмч оролцсон хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсан байна. Улсаас шууд болон шууд бусаар дэмжиж байсан тусламж багассан, шилжилтийн эхэн үеийн эдийн засгийн таагүй орчин /импортын үнийн өндөр өсөлт, инфляци, зээлийн хүүгийн өндөр түвшин, зээлийн буруу бодлого, банк-санхүүгийн хямрал/ болон зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөлд аж ахуй эрхлэх менежементийн ур, чадвар хангалтгүй байсан зэргээс шалтгаалан газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ ихээхэн буурсан. Албан ёсны бүртгэлээр тариалангийн эдэлбэр газрын хэмжээ нь 1.2 сая га боловч 2001 оны гүйцэтгэлээр үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ нь 217.6 мян га, уриншилсан талбай 275.4 мянган га буюу нийт эдэлбэр газар 497.0 мянган га болж 707.0 мянган га нь ашиглагдахгүй атаршин хаягдсан байна.

2001 оны гүйцэтгэлээр 150.2 мянган тонн үр тариа, 58 мянган тонн төмс, 44.5 мянган тонн хүнсний ногоо, 1.7 мянган тонн тэжээл хураасан нь дотоодын хэрэгцээнийхээ үр тарианы 34 хувь, төмс, хүнсний ногооны 42- 46 хувь, таримал тэжээлийн 4.0 хувийг хангаж байна.

4.176 “Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх хөтөлбөр”-ийг Засгийн газраас батлан зарим хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох зэргээр дэмжихийн зэрэгцээ хандивлагч болон Монголын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний хангамжийг сайжруулах КР-1 /гурил, цагаан будаа, хүнсний буудай нийлүүлэх/, “Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” КР-2 /трактор, комбайн, хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин, бордоо зэрэг газар тариалангийн салбарт нэн дутагдаж байгаа импортын орцыг нийлүүлэх/ төслүүдийн хүрээнд жилдээ 40-50 трактор, комбайныг хөдөө аж ахуйн урт хугацааны зээлээр олгож байна. Хэдийгээр Засгийн газраас газар тариаланг сэргээх зорилтыг хөдөө аж ахуй дахь бодлогын тэргүүлэх чиглэл болгон дэвшүүлж байгаа боловч байгалийн хүчин зүйлээс хамааран бодлого, хөтөлбөрүүд төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

4.177 1995 оныг хүртэл Засгийн газраас газар тариалангийн гол бүтээгдэхүүн буудай, гурил, талхны зах зээлийн үнэд хяналт тавьж, үнэ огцом өсөхөөс болгоомжилж байсан нь энэ салбарын уналтанд бодитой нөлөөлсөн юм.

4.178 1996 оноос газар тариалангийн салбар дахь төрийн өмчийн оролцоотой бүх аж ахуйн нэгжийг хувьчилж дуусгахыг энэ салбарын гол бодлого болгохын зэрэгцээ төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчийн оролцоотой байсан арилжааны банк, нефть хангамжийн байгууллагуудаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгож байв.

4.179 Хөдөөгийн иргэдийн ажилгүйдлийг багасгаж, ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, төмс, ногоо, жимс тариалж буй иргэд, өрхийг дэмжих зорилгоор ” Ногоон хувьсгал” хөтөлбөрийг батлаж, бүх аймаг, сумдад ногоо тариалах, арчлах, хүнсэндээ хэрэглэх арга технологид сургаж, үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг болж байгаа боловч төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээнийхээ 43- 45 хувийг, жимс, жимсгэний 6 хүрэхгүй хувийг хангаж байна.

4.180 2001 онд Засгийн газраас ”Үр ” дэд хөтөлбөр баталж КР-1 сангаас 1.8 тэрбум төгрөг, ” Уринш - 2001” төслийн хүрээнд 2001 онд 2.5 тэрбум, 2002 онд 2.5 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх нөхцлөөр газар тариалангийн салбарт олгосон боловч сүүлийн 4 жил дараалан тохиолдож байгаа гангийн улмаас ургац алдаж ихэнх аж ахуйнууд хөнгөлөлттэй зээлээ төлөх чадваргүй болсон.

4.181 Ийнхүү зах зээлийн зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх чиглэлээр Засгийн газраас уринш бэлдэх, паркийн шинэтгэл хийх, тарих үрээ худалдан авахад нь их хэмжээний зээл олгож байгаа боловч угаасаа эргэлтийн хөрөнгийн нөөцгүй, их хэмжээний өртэй болсон аж ахуйнууд сүүлийн жилүүдийн цаг агаарын таагүй байдал, нэн ялангуяа жил дараалан тохиолдсон гангийн улмаас олигтой ургац авч чадсангүй.

4.182 Иймээс газар тариалангийн талаарх бодлогод зарчмын өөрчлөлт оруулахаар ХХААЯ-аас ажлын хэсэг томилогдон, мэргэжлийн эрдэмтэд эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, "Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого" –ын төслийг боловсруулаад байна.

4.183 Нийт хүн ам, нэн ялангуяа ядуу хэсгийн амьжиргаанд стратегийн онцгой ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүн болох үр тарианы аюулгүй байдлыг хангах нь тэргүүлэх зорилтын нэг юм. Үр тарианы үйлдвэрлэлийг сэргээж гурилын үйлдвэрүүдийн хүчин чадлыг дээд зэргээр ашиглах, импортын эрсдэлийг бууруулах замаар хүн амын гурилын хангамжийн сайжруулж, баталгаатай хангах зорилт тавьж байна. Үр тарианы үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх нь 60 гаруй мянган тариаланчдын амьжиргааг баталгаажуулах төдийгүй малын тэжээлийн найдвартай эх үүсвэрийг бүрдүүлж мал аж ахуйн эрсдэлийг мөн багасгах юм. Иймээс үр тарианы үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхийн зэрэгцээ, түүнийг тариалах технологийг шинэчилэн хөрсний эвдрэл багатай технологи нэвтрүүлэх, үрийн аж ахуйг хөгжүүлэх, нэг га-гаас өндөр ургац авах, элит үр тариалах, усалгаатай газар тариаланг бий болгох зэргээр бүтээмж өндөртэй эрчимжсэн, механикжсан газар тариалан эрхлэх стратегийг урт болон дунд хугацаанд баримталж байна. Өөрөөр хэлбэл бага талбайгаас их ургац авч хэрэгцээгээ хангах зорилт тавьж байна. Үр тарианы үйлдвэрлэлд улаан буудайгаас гадна малын тэжээлийн ургамал тариалах хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Газрыг орчин үеийн аргаар хөрсний эвдрэл элэгдэл багатай технологиор боловсруулах техникийг нэвтрүүлнэ. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрсдэлийг багасгах, баталгаатай байдлыг хангах үүднээс газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна. Энэ нь тариаланчид төдийгүй ядуучууд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, үр тариа, таримал ургамал тариалж аж, амьдралаа дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. Газар өмчлүүлэх тухай хуулийг УИХ 2002 оны 6 сард баталсан бөгөөд уг арга хэмжээг 2003 оны 5 сараас хэрэгжүүлнэ.

VII. Хүрээлэн буй орчин

4.184 Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжил нь байгаль, цаг уурын байдал, байгалийн нөөц баялгийн ашиглалтаас ихээхэн хамааралтай байна. Байгаль орчныг хамгаалж, зөв ашигласнаар ажлын байр бий болж, хүн амын эрүүл мэнд сайжирч, биологийн төрөл зүйл хадгалагдан үлдэнэ гэсэн зарчмыг баримталж байна. Байгалиас бүрэн хамааралтай бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан болон ашигт малтмал олборлолт Монгол улсын эдийн засагт зонхилох үүрэгтэй хэвээр байна. Шилжилтийн үед олон хүн ажилгүй болж, амь зуухын эрхээр мал маллах, эрдэс түүхий эд олборлох, ан агнах, байгалийн жимс, самар түүх, мод бэлтгэх чиглэлээр байгаль орчинтой ихээхэн хатуу харьцах болсноос зарим тохиолдолд байгалийн нөөц баялаг хомсдон, байгаль орчны доройтол нэмэгдэж байна. Нөгөө талаас цаг агаарын дулаарлаас шалтгаалсан цөлжилт, элсний нүүлт, бэлчээрийн талхлагдал болон ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр уламжлалт мал аж ахуй эрхэлдэг ард түмний амьдрал доройтож, хот суурин газрыг бараадан шилжих хөдөлгөөн ихэссэн байна. Үүнээс үүдэн хот суурин газарт хүн амын төвлөрлийг үүсгэж, ажилгүйдлийг ихэсгэн, нийгмийн доройтол, ядуурлыг нэмэгдүүлж, орчны хог хаягдал, хөрс, усны бохирдол нэмэгдэж байна. Ийм учраас ядуурлыг бууруулах стратегийг тодорхойлохдоо нэг талаас иргэдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, нөгөөтэйгүүр байгаль орчныг хамгаалах шаардлагатай зохистойгоор уялдуулах нь чухал болж байна.

4.185 Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан Монгол оронд цөлжилтийн үйл явц түргэсч, нуур, ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц эрс муудах, хөрс ус давсжих, үржил шимээ алдах, элсний нүүлтийн хөдөлгөөн ихсэх зэргээр илэрч байна. Бэлчээрийн талхлагдал нь мал аж ахуй эрхлэн амьдардаг хүн амын 40 орчим хувийн амьжиргааны түвшинд муугаар нөлөөлж байна. Манай орны нийт бэлчээрийн 70 хувьд ямар нэг хэмжээгээр мал бэлчээж байгаа бөгөөд нэг га-гийн өвсний ургац сүүлийн 30 жилд 19-24 хувиар буурсан байна. Малын тоо толгой өсч, мал малладаг өрхийн тоо нэмэгдэхийн хэрээр бэлчээрийн даац хэтэрч, худаг, хашаа хүрэлцээгүй болж байна. Бэлчээр талхлагдаж, ган зудын сөрөг нөлөө нэмэгдсэнээр малчид малгүй болж, олон мянган айл өрх амьдралын эх сурвалжаасаа хагацаж, ядуурлын ирмэгт тулж очих аюул байнга нүүрлэж байна. Урт болон дунд хугацаанд бэлчээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, говь хээрийн бүсийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, түлшний хангамжийг сайжруулах замаар цөлжилт, элсний нүүлттэй тэмцэх зэргээр хөрсний хамгаалалтыг сайжруулна. Бэлчээрийн талхлагдлыг бууруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, газрын шинэтгэлийн бодлогыг тархимтэй явуулах, орон нутагт бэлчээр болон байгалийн нөөцийн менежментийн оновчтой арга хэлбэрийг бий болгох, элсний нүүдлээс хамгаалах ногоон зурвас байгуулах, ганд тэсвэртэй нутгийн уугуул ургамлыг тарималжуулах, бэлчээрийг сэлгүүлэн ашиглах, малын чанарыг дээшлүүлэх зэрэг бодитой ажлыг орон нутгийн захиргаа, иргэдийн өргөн оролцоотойгоор зохион байгуулах зорилт тавьж байна.

4.186 Говь, хээрийн бүсэд элсний нүүлтийг тогтоон барих чадвартай бутлаг ургамалыг тарих, ургамалжуулах арга хэмжээ авна. Заган ойг түлшинд ихээр хэрэглэснээс элсний нүүлт ихсэн цөлжих нэг шалтгаан болж байна. Ийм учраас шахмал болон бусад төрлийн хямд түлшийг үйлдвэрлэн говийн бүсийн хэрэгцээг хангах асуудал чухал болж байна.

4.187 Ойжуулалтын ажлыг эрчимжүүлэх, тарьж ургуулсны үндсэн дээр ойн дагалт баялагийг зохистой ашиглах бодлого баримтална. Монгол улсын нутаг дэвсгэрийн 8.1 хувийг ой мод эзэлдэг бөгөөд энэ нь НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан судалгаагаар манай улс дэлхий нийтийн жишгээр ойн нөөцөөр ихээхэн ядуу орны тоонд орж байна. Сүүлийн арваад жилд ажилгүйдэл, ядуурлын улмаас хууль бусаар түлшний зориулалтын мод бэлтгэх явдал газар авсны зэрэгцээ 1996 оноос хойшхи хугацаанд 6.0 орчим сая га талбай ойн түймэрт өртсөн нь ойн нөөцийг улам хомсдуулсан байна. Мод үржүүлгийн газар байгуулах, түүний нөхөн сэргээлтийг дэмжих, ойжуулах, ойн түймэрт дутуу шатсан мод, модны нүүрсийг ашиглах, түймрээс сэргийлэх зэрэг ажилд орлого багатай, ядуу иргэдийг өргөн татан оролцуулснаар байнгын болон түр ажлын байрыг олноор нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Самар жимс, эмийн ургамал зэрэг байгалийн дагалт баялгийг зохистой ашиглах, заримыг тарималжуулах, замаар орлогын нэмэлт эх үүсвэр бүрдүүлэхийг дэмжинэ.

4.188 Хатуу хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх явдал нь Монгол улсын тулгамдсан зорилт болоод байна. Улсын хэмжээнд 3145 га талбайг хамарсан 447 заагдсан цэгт хог хаягдлыг ил задгай хаяж 11115 га газар хог хаягдлаар бохирджээ. Тиймээс хатуу хог хаягдлыг зайлуулж, боловсруулах нь хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Урт болон дунд хугацаанд агаарын бохирдлыг бууруулах, хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар ард иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гарах үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжин урамшуулна. Хог хаягдлыг ангилан ялгах болон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна. Улаанбаатар хотын захиргаанаас хатуу хог хаягдлыг цуглуулах, ялгах, салгах зэрэг боловсруулах, устгах үйл ажиллагаанд онцгой анхаарал тавина.

4.189 Хатуу хог хаягдлыг цуглуулах, ялгах, дахин ашиглах, тээвэрлэх, зайлуулах менежментийг сайжруулах, энэ чиглэлээр гарч буй олон нийтийн санаачилгыг дэмжиж, ядуучуудыг энэ ажилд идэвхитэй татан оролцуулна.

4.190 Монголд улсад нийт 67 000 км урт том, жижиг 4113 гол мөрөн, 500 шоо километр усны нөөц бүхий 3060 том жижиг нуурууд, 7000 гаруй тогтмол ундаргатай булаг шанд, 659 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий 262 мөсөн гол, 120 рашаан, хөрсөн доорхи

усны 139 нөөц газар байна. Монгол улсын нийт усны нөөц 38.8 шоо километр бөгөөд түүнээс 34.6 шоо километр нь ашиглаж болох нөөц юм. Ашиглаж болох бүх усны нөөцийн 64 хувь буюу 22 шоо километр нь гадаргуугийн ус, 36 хувь буюу 12.6 шоо километр нь хөрсөн доорх гүний ус байна.

4.191 Хотын хүн ам өсч, үйлдвэрийн тоо нэмэгдэж, өрх бүр ногоо тарьж услах, гэр хорооллууд ус түгээгүүрийн гол сүлжээнд холбогдож байгаагаас нийслэлийн усны хэрэглээ нэмэгдэж, 2010 онд хоногт 218 мянган шоо метрт хүрэх тооцоо гарч байна. Иймээс байгалийн усны нөөцийн нөхөн сэргэх чадавхийг дээшлүүлж, нөөцийг үр ашигтай ашиглах зохистой хэрэглээг төлөвшүүлэхийн зэрэгцээ шугам сүлжээг шинэчлэх замаар усны алдагдлыг багасгана. Мөн хотын гэр хорооллын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжүүлэн авна. Том хот, суурин газруудын гэр хороололд амьдардаг оршин суугчид өдөртөө 8-10 литр ус хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан бөгөөд энэ нь эрүүл мэндийн шаардлагыг хангах түвшнээс 5 дахин бага байна. Говь, тал хээрийн бүс нутгийн нэлээд олон сумдын усны хангамж ихээхэн хязгаарлагдмал байна. Сум, суурин газруудын 38 хувьд оршин сууж байгаа хүн амын ундны усны чанар нь эрүүл мэндийн шаардлагыг хангахгүй байгаа нь тогтоогджээ. Иймээс хүн амын ундны усны чанарыг сайжруулж, иргэдийн өвчлөлийг бууруулах зорилт тулгарч байна. Мөн усны хангамж, хүрэлцээ муу байгаагаас ихээхэн газрын бэлчээр, тариалангийн талбайг ашиглаж чадахгүй байна. Усгүйн улмаас мал нэг доор олноор бөөгнөрч, бэлчээр хэт талхлагдах, ургамлын гарц буурах зэрэг нь иргэдийг ядууралд хүргэх нэг нөхцөл болж байна. Ядуучуудад дийлэнх нь эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус хэрэглэж чадахгүй байна.

4.192 Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, усны чанарыг сайжруулах, байгалийн усны нөөцийн нөхөн сэргэх чадавхийг дэмжинэ. Хүн ам ялангуяа ядуучуудыг цэнгэгжүүлсэн ундны усаар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

4.193 Агаарын бохирдол нь хүний аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарлаж, хүн амын эрүүл аж төрөх орчинд занал учруулж байна. Улаанбаатарын гэр хорооллын 75 мянган айл жилдээ 200 гаруй мянган тонн нүүрс, 160 мянган шоо метр мод түлж, орчин тойрондоо үнс, хогийг ил задгай хаяж, агаарыг бохирдуулж, хүн амын өвчлөлийг нэмэгдүүлж байна. Хотын нэг оршин суугчид 90 кг хорт утаа ногдож байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд нийт хүн ам, ялангуяа хүүхдийн дунд амьсгалын замын өвчлөл зонхилж байна. Агаарын бохирдлыг бууруулах эрхзүйн үндсийг боловсронгуй болгох, гэр хорооллын ядуу айл өрхийг түлш бага хэрэглэдэг, бүрэн шаталттай зуухаар хангах, автомашинаас ялгарах бохирдуулах бодисын хэмжээг хянах, цахилгаан станц болон уурын зуухнуудыг утааны шүүлтүүрээр хангах зэрэг арга хэмжээ авч байна. Бүрэн шаталт явагдах технологи бүхий үндэсний стандартын шаардлага хангасан зуухыг хөнгөлөлттэй үнээр олгох, үүний үр дүнд түлшийг хэмнэж, өрхийн зардлыг бууруулах, ялангуяа Улаанбаатар хотын гэр хорооллын ядуу иргэдийг эхний ээлжид хангах талаар анхаарч байна. Ядуу айл өрхөд эдгээр зуухыг хөнгөлөлттэй үнээр түгээх замаар түлшийг хэмнэх, өрхийг орлогыг нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

4.194 Нийслэл дэх агаарын бохирдлын хэмжээг бууруулах хүрээнд ногоон байгууламжийг сэргээх, арчлах үйл ажиллагаанд орлого багатай иргэдийг ажиллуулах, байгууламжийг хамгаалах, эзэмших хариуцлагыг сууц өмчлөгчдийн холбоогоор дамжуулан хэрэгжүүлнэ. Байгаль орчныг хамгаалах, сайжруулах стратеги нь нийт хүн ам, ялангуяа ядуучуудын цэвэр орчинд аж төрөх, ундны цэвэр усаар хангагдах, байгалийн нөөц баялагийг илүү хүртэх боломжийг бүрдүүлнэ.

БҮЛЭГ 5. ХҮНИЙ ТОГТВОРТОЙ Хөгжлийг Хангах

5.1 Хүн амын тогтвортой амьжиргааг хангаж, ядуурлыг бууруулах зорилтууд нь эдийн засгийн өсөлтийн хүрсэн түвшингээс хамаарах боловч хүний тогтвортой хөгжлийг хангах, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, сайн засаглалыг бүрдүүлэх зорилттой нягт уялдаатай хэрэгжинэ. Эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах стратегийн хүний хөгжлийн асуудлууд нь ядуучуудад орлого нэмэгдүүлэх боломжийг

өргөжүүлэх, тэдгээрийг шийдвэр гаргахад оролцуулах, улмаар нийгмийн баталгаатай байдлыг хангахад чиглэгдэнэ. Нийгмийн үйлчилгээг тодорхой салбарын бодлогоор дамжуулан дараах байдлаар авч үзэж байна. Үүнд:

Нэгд, хүн ам, тэр дундаа ядуучуудад хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох боломжийг бүрдүүлэхэд чиглүүлнэ. Ингэснээр ядуучуудын орлого нэмэгдэх болно.

Хоёрт, нийгмийн болон дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхийн зэрэгцээ нөөцийн ашиглалт, удирдлагын талаар шийдвэр гаргахад ядуучуудыг өргөн оролцуулах нь хүн амыг ядуу болон эмзэг байдлаас гарах нэг арга зам гэж үзэж байна.

Гуравт, хүн ам, ядуучуудыг шийдвэр гаргахад оролцуулснаар хүн ам, ядуурал, эмзэг байдалд орохоос урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

5.2 Өнөөгийн байдлаар ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, нийгмийн хамгааллын тогтолцоо нь хүн ам, тэр дундаа ядуучуудад зарим талаар бэлэнчлэх сэтгэлгээг төрүүлж болзошгүй учраас тухайн бүлэг хүмүүсээс гарсан үүсгэл, санаачилгыг дэмжих замаар ядуурлыг бууруулах, улмаар хүн амын тогтвортой амьжиргааг хангах чиглэл баримталж байна. 2002 оны 9-р сард эхэлсэн "Тогтвортой амьжиргааг дэмжих" төсөл нь ядуурлыг бууруулах үндэсний стратегийг хэрэгжүүлэх, хөдөөгийн иргэдийн амьжиргааг найдвартай, тогтвортой болгох үйл явцад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Төслийг туршилтын журмаар сонгосон 8 аймагт хэрэгжүүлж эхлээд байна. Уг төсөл нь дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна.

5.3 *Бэлчээрийн эрсдэлийн удирдлага:* Бэлчээрийн мал аж ахуйд тохиолддог зуд, ган, малын өвчин, үнийн хэлбэлзэл зэрэг эрсдлийг бууруулахад чиглэгдсэн цогцолбор стратеги боловсруулж хэрэгжүүлнэ. Төслийн бусад бүрэлдэхүүн хэсэгтэй нэгдэж малчид ган, зудад нэрвэгдэж байгаа гол шалтгаануудыг тодорхойлж, эрсдэлийг хязгаарлахад чиглэсэн санаачилгыг дэмжиж, өвс тэжээлийн аж ахуйг хөгжүүлнэ.

5.4 *Бичил санхүүгийн үйлчилгээний хүрээг өргөтгөх:* Санхүүгийн болон жижиг зээлийн үйлчилгээг хөдөөгийн ядуу болон эмзэг бүлгийн иргэд, өрхүүдэд үзүүлэх бөгөөд үүнийг бичил санхүүгийн хөгжлийн сан, урьд нь бүрдсэн зээлийн эргэлтийн сангаар дамжуулан хэрэгжүүлнэ. Жижиг зээлийн эрсдэлийг багасгах арга хэрэгсэл, зээлийн баталгааны хэлбэр болгон бага хэмжээний зээлийн даатгалын тогтолцоог туршин нэвтрүүлнэ.

5.5 *Орон нутгийн хөгжлийн санаачилгын сан:* Орон нутагт дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, түүнийг нэн тэргүүн ээлжийн арга хэмжээнд чиглүүлэх сонголт хийх, хамтран санхүүжүүлэх, хамгийн үр ашигтай хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангасан ил тод, арга хэрэгслийг тогтооно. Ингэхдээ Засгийн газраас оруулж буй хөрөнгө оруулалттай орон нутгийн хөгжлийн санг уялдуулна.

5.6 Төслийн эдгээр 3 бүрэлдэхүүн хэсэг нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд ядуу, эмзэг өрх, иргэдийн чадавхийг дээшлүүлж, орлогын тогтвортой эх үүсвэртэй болох боломжийг олгож, орон нутгийн дэд бүтэц, нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг хийж, үйлчилгээг нь тэдэнд хүртээх юм. Ийнхүү хүн амын тогтвортой амьжиргааг дэмжсэн хөтөлбөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар Монгол дахь ядуурлыг бууруулна.

5.7 *Хүний хөгжлийн түвшин.* Хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас гадна хүний хүчин зүйлсийн нөлөөллийг чухалчилдаг үзэл баримтлал дэлхий дахинд баримталдаг болсон өнөө үед Монгол улсын Засгийн газар хүний нөөцийн хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна.

5.8 Хүний хөгжил гэдэг нь аливаа зүйлийг хүмүүс сонгох явц, боломжийг өргөжүүлэхийг хэлнэ. Энэхүү сонголт нь эрүүл саруул байх, урт удаан наслах, өндөр боловсрол эзэмших, хөрөнгө мөнгөтэй байх, шийдвэр гаргахад оролцох, хүрээлэн байгаа орчноо ариг гамтай ашиглаж хойч үедээ өвлүүлэх, улс төрийн эрх чөлөөтэй байх, бие биенээ хүндэтгэх зэрэг болно. Хүний хөгжлийг хэмжих үзүүлэлт нь хүний хөгжлийн индекс (HDI) юм. Монгол улсын хүний хөгжлийн индекс 1990 онд 0.737 байснаа 1995 онд 0.604, 1998 онд 0.669, 1999 онд 0.618, 2000 онд 0.628 болсон байна. Харин энэ үзүүлэлт 2002 оны байдлаар 0.619 болж Монгол улс дэлхийн 173 орноос 113 –т бичигдэх болжээ.

5.9 XX зууны эхэнд Монгол улсын хүн амын 90 гаруй хувь нь бичиг үсэггүй, дундаж наслалт 40 нас хүрэхгүй, төрсөн хүүхдийн дийлэнх нь нас барж байсан нь боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хувьд нэн хоцрогдсонтой холбоотой байв. 1921 оны ардын хувьсгалын үрээр Монгол улсад иргэний боловсролыг хөгжүүлэх, хүн амын эрүүл амьдрах, ажиллах таатай орчин бүрдэж, эрэгтэй, эмэгтэй, яс үндэс, хөрөнгө чинээ, шашин шүтлэгийн байдлыг харгалзахгүйгээр хүн ам, хүүхдэд үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, боловсрол эзэмшүүлэх бололцоотой болсон. Зах зээлийн харилцаа руу шилжих 1990-иэд оны үед Монгол улсын нийт хүн ам бичиг үсэг тайлагдсан, дундаж наслалт 60-аас дээш, нялхсын эндэгдэл харьцангуй бага болсон байв.

5.10 Монгол Улсын Засгийн газраас тавьж буй эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, улмаар ядуурлыг бууруулах зорилго нь эдийн засаг дахь хувийн хэвшлийн өргөн оролцоо, улсын салбарын шинэчлэл дээр тулгуурлана. Энэхүү төрийн албаны шинэчлэл нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, түүнтэй уялдсан хөрөнгийн оновчтой хуваарилалтаас хамаарна. Энэ зорилгоор төсвийн байгууллага, удирдлага санхүүжилтийн шинэ тогтолцоог нэвтрүүлэх ажлыг бүх шатанд хэрэгжүүлж эхлээд байна.

5.11 Засгийн газар нийгмийн салбарт хуваарилсан төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх бодлого баримталж байна. Өнгөрсөн 6 жилд нийгмийн салбарт зарцуулсан төсвийн зарлага, түүний үр дүнг харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5:1: Нийгмийн салбарын төсвийн зарлагын дүн

| | Төсвийн нийт зарлагад эзлэх хувь | | | | | | | ДНБ-д эзлэх хувь | | | | | | |
|--|----------------------------------|------|------|------|------|------|------|------------------|------|------|------|------|------|------|
| | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 |
| Нийгмийн салбарын нийт зардал | 49.1 | 44.4 | 45.5 | 46.2 | 48.4 | 52.3 | 55.9 | 13.3 | 11.3 | 16.0 | 19.4 | 19.1 | 21.5 | 24.2 |
| Боловсролын үйл ажиллагаа | 17.0 | 15.9 | 16.2 | 17.1 | 17.8 | 19.1 | 20.4 | 4.6 | 4.0 | 5.7 | 7.1 | 7.0 | 7.9 | 8.9 |
| Эрүүл мэндийн үйл ажиллагаа | 11.3 | 10.6 | 9.9 | 9.6 | 9.8 | 10.5 | 12.1 | 3.1 | 2.7 | 3.5 | 4.0 | 3.9 | 4.3 | 5.2 |
| Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 15.7 | 13.6 | 14.9 | 15.1 | 16.4 | 17.2 | 17.6 | 4.3 | 3.4 | 5.2 | 6.3 | 6.5 | 7.3 | 7.6 |
| Орон сууц, нийтийн аж ахуйн үйл ажиллагаа | 1.6 | 1.1 | 1.2 | 1.1 | 1.3 | 1.6 | 2.8 | 0.4 | 0.3 | 0.4 | 0.5 | 0.5 | 0.7 | 1.2 |

| | | | | | | | | | | | | | | |
|--|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| Амралт, биеийн тамир, соёл, урлагийн үйл ажиллагаа | 3.5 | 3.2 | 3.2 | 3.3 | 3.1 | 3.3 | 3.1 | 1.0 | 0.8 | 1.1 | 1.4 | 1.2 | 1.4 | 1.3 |
|--|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|

Эх сурвалж: СЭЗЯ

5.12 Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь боловсрол, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, хүн амын ажил эрхлэлт болон орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих замаар нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулан хүний тогтвортой хөгжлийг хангах явдал юм. Ингэхдээ ядуу болон эмзэг бүлэгт нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэснээр тэдгээрт хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломжийг улам нэмэгдүүлж нээлттэй болгоно. Өөрөөр хэлбэл тухайн хүн боловсролын түвшин, хоол хүнсний хангамж, эрүүл мэндийн байдлаараа наад захын шаардлагыг хангахуйц түвшинд хүрэх орчинг бүрдүүлснээр ядуу, эмзэг байдал, ялангуяа удам дамжсан ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ядуурлаас гарах нэг утгвар нөхцөл гэж үзэж байна.

5.13 Орон нутагт зохион байгуулсан "Ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах нь" бүсийн семинар дээр боловсролын болон жендэрийн асуудлыг бас давтан шүүмжилж байв. Тухайлбал, *"Хөдөөд оюуны ядуурал бий болж байна. Ялангуяа хэдэн малаа маллуулах нэрийдлээр хөвгүүдийг сургууль завсардуулах явдал их байгааг анхаарч, хөдөөгийн сургуульд хамрагдагчдын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр дотуур байрны орчин нөхцөл, мэргэжилтэй багшлах боловсон хүчний хангалтыг сайжруулах шаардлагатай байна. Түүнчлэн их, дээд сургуулийн элсэлтэд төрөөс зохицуулалт хийж, шинээр төгсөгчдийг хөдөө орон нутагт ажиллуулах асуудлыг төрийн бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсролд жендэрийн харилцааг хангах хэрэгтэй"* гэж Завхан, Хөвсгөл аймгийн бүсийн семинарт оролцогчид ярьжээ.

Шигтгээ 6.1: Хүний хөгжил

Монгол улс хүний хөгжлөөрөө Дэлхийд 1990 онд 70-д байснаа 1995 онд 110, 1998 онд 101-д, 1999 онд 113-д, 2000 онд 117-д орж ухралт гарсан байна. Харин 2002 оны байдлаар 113-р байрт орж сайжрах хандлага гарч байна. Хүний хөгжлийн индекс нь хөгжлийн гурван үндсэн хэмжүүр болох наслалт, боловсрол, орлогын нэгдсэн үзүүлэлтээр нийгмийн ахиц, дэвшлийн байдлыг тодорхойлдог. Хүн амын наслалтыг дундаж наслалтаар тодорхойлдог бөгөөд Монголд энэ үзүүлэлт 65 (эрэгтэй 62.7, эмэгтэй 67.6) болсон байна.

Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалт, бага, дунд болон дээд боловсролын хамран сургалтын нэгдсэн хувь зэрэг үзүүлэлтээр боловсролын ололтыг тодорхойлдог. Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хувь 2000 оны тооллогоор 97.8 (эрэгтэйчүүд 98.0, эмэгтэйчүүд 97.5), хамран сургалтын нэгдсэн хувь 69.6 (эрэгтэйчүүд 63.7, эмэгтэйчүүд 75.5), боловсролын ололтын индекс 0.884 (эрэгтэйчүүд 0.865, эмэгтэйчүүд 0.901)-д хүрээд байна.

Орлого нь худалдан авах чадварын харьцаат хэмжээ болон орлого нэмэгдэх тутам өгөөж буурах итгэлцүүрээр засварлагдсан нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр тодорхойлогддог. Монголд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 450 орчим ам доллар байна.

5.14 Урт болон дунд хугацаанд ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх хүрээнд хүний хөгжлийн индексийг сайжруулна.

I. Боловсрол

5.15 Боловсролын салбарын статистик мэдээгээр 2002-2003 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол олгох 665 байгууллагад 3-7 насны 83.6 мянган хүүхэд хүмүүжиж байна. 510.3 мянган сурагч ерөнхий боловсролын 700 гаруй сургуульд мөн 15.1 мянган оюутан мэргэжил олгох сургалтанд хамрагдаад байна. Өмнөх жилүүдийн олон тооны судалгаанаас харахад боловсролын салбарт жендерийн ялгаа их биш боловч хот,

хөдөөгийн иргэдийн боловсролын түвшинд ихээхэн ялгаа байна.Тиймээс боловсролын талаарх бодлогыг хот хөдөөгийн боловсролын түвшний ялгааг багасгахад чиглүүлэх нь чухал байна.

Хүснэгт Анхан шатны боловсролын үзүүлэлтүүд ,бүс нутгаар, 2001-2002

| | Баруун | Зүүн | Хангай | Төв | Улаанбаатар |
|-------------------|--------|------|--------|------|-------------|
| Байгууллагын тоо | | | | | |
| Цэцэрлэг | 131 | 66 | 152 | 152 | 164 |
| Дунд сургууль | 153 | 70 | 169 | 158 | 150 |
| Хамралтын хүрээ * | | | | | |
| Цэцэрлэг | 22.5 | 8.9 | 25.4 | 18.8 | 24.4 |
| Дунд сургууль | 19 | 9.1 | 24.6 | 19.4 | 28 |
| Насны бүлэг ** | | | | | |
| 6 - 7 нас | 14.6 | 22.8 | 16.5 | 26.5 | 42.5 |
| 9 ба түүнээс дээш | 16.1 | 15.1 | 16.5 | 12.2 | 9.3 |

Эх үүсвэр: БСШУЯ ны жилийн тайлангаас

* тухайн насны бүлэгт хамрагдсан сурагчдын хувь

**1-р ангид бүртгэгдсэн хүүхдийн хувь

5.16 1990 оноос өмнө Монгол улсад боловсролын хамралтын түвшин хамгийн өндөр байсан бөгөөд Монгол улс бичиг үсэг мэдэгчдийн хувиараа хамгийн өндөр орнуудын тоонд орж байв. Гэвч 1990-ээд оны эхээр улс орон зах зээлийн эдийн засагт шилжих явцад сургуульд хамрагдалтын түвшин эрс буурсан байна. Энэхүү бууралтын гол шалтгаан нь малчин өрхүүдийн хөвгүүдтэй холбоотой бөгөөд эдгээр нь ар гэрийнхээ хувьчилж авсан мал аж ахуйд тус болох үүднээс сургуулиа орхин мал дээр гарсан явдал юм.

5.17 2002-2003 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд 510.3 мянган сурагч хамрагдаж байсан бөгөөд энэ нь 1990 оны үзүүлэлтээс өндөр юм. Хэдийгээр ийм эерэг үзүүлэлттэй байгаа ч хөдөө орон нутгийн сургуульд хамрагдалтын түвшин хот суурин газрынхаас доогуур байна.

5.18 Сүүлийн жилүүдэд хот суурин газар луу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсэнээс хүн амын нягтаршил эдгээр газруудад ихэссэн байна. Үүний зэрэгцээ орон нутгийн сургуулиудад суралцагчдын тоо эрс буурчээ.

5.19 Ерөнхий боловсролын сургуулийн бага болон дунд ангиудад эмэгтэй эрэгтэй сурагчдын хүйсийн харьцаа 56:44 бол их дээд сургуулиудад энэ харьцаа 2:1 байгаа нь олон улсын түвшинд түгээмэл бус үзэгдэл юм.

5.20 1990 онд хүүхдийн цэцэрлэгт 97.2 мянган хүүхэд хүмүүжиж байсан бол 1995 онд 64.1 мянга болтлоо буурсан байна. Үүний гол шалтгаан нь шилжилтийн үеийн төсвийн хүндрэл болон хүн амын төрөлт буурсан зэрэг шалтгааны улмаас сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдан, олон цэцэрлэг үйл ажиллагаагаа зогсоосонд оршино. Харин сүүлийн 6 жилд цэцэрлэгт хүмүүжигчдийн тоо өсөн нэмэгдэж байна. Сүүлийн 10 гаруй жилд цэцэрлэгийн барилгад засвар хийгээгүй, ширээ сандал, цагаан хэрэглэлийг сольж чадаагүй нь сургалтын чанарт муугаар нөлөөлж байна. Цэцэрлэгүүд нь аймаг, сумын төвд байрладгаас болж хөдөөгийн, тухайлбал малчдын хүүхэд цэцэрлэгт үндсэндээ хамрагдаж чадахгүй байна.

5.21 Техник мэргэжлийн сургуульд суралцагчдын тоо 1989 онд 31.2 мянга байсан бол энэ тоо нь 1994 онд 7.6 мянга болтлоо буурсан байна. Сүүлийн жилүүдэд эдгээр сургуулиудад суралцагчдын тоо аажмаар өсч байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 19.0 мянган оюутан суралцаж байна.

5.22 1990 онд их, дээд сургуулиудад бакалаврын зэрэг горилж буй оюутны тоо 13.8 мянга байсан бөгөөд 1997-2001 оны хооронд энэ тоо 44.9 мянгаас 83.2 мянга болтлоо өссөн байна. Гэвч дээд боловсролын дипломтой төгсөгчдийн тоо буурч байна.

5.23 1990-ээд оны эхний хагаст 30 гаруй мянган хүүхэд сургуулиас завсардсан бөгөөд энэ нь нийт сурагчдын 8.8 хувийг эзэлж байв. Сургууль завсардсан хүүхдийн 70 хувийг хөвгүүд эзэлж байв. Энэ нь Монгол улсын хүн амын бичиг үсэг үл мэдэгчдийн түвшинг нэмэгдүүлэхэд хүргэсэн.

5.24 Сүүлийн жилүүдэд сургууль завсардалтын түвшин буурч байгаа хэдий ч жилд дунджаар 12-13.0 мянган хүүхэд сургуулиас завсардаж байгаа нь энэ үзүүлэлт дорвитой буурахгүй байгааг харуулж байна. Ядуурал болон сургууль, багш нарын хангалттай бус үйл ажиллагаа ч мөн үүнд нөлөөлж байна.

5.25 Анги улиралтын жилийн түвшин 0.11 хувь байгаа бөгөөд энэ нь 1-р ангид элсэгчдийн 1.0 хувь, 2-р ангийн сурагчдын 0.6 хувь юм. Эдгээр ангиудад анги улирах явдал хамгийн өндөр байдаг байна. Сургуулиас завсардсан сурагчид ихэнхдээ сургуулиа бүрмөсөн орхидог байна. Нэгдүгээр ангид элсэн орогчдын 86 хувь нь анхан шатны боловсрол, 66.3 хувь нь суурь боловсрол авдаг нь маш хангалтгүй үзүүлэлт юм.

5.26 Өндөр ачаалалтай ажилладаг 26 сургуулийн өргөтгөл болон шинэ сургуулиудын барилгыг төсвийн хөрөнгө оруулалт болон хандивлагчдын зээл тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ. Ингэснээр нийт 11.5 мянган шинэ суудал бий болгосон байна. Үүнээс гадна 300 сургууль, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны их засвар хийсэн байна. Эдгээр арга хэмжээнүүд нь боловсролын тухтай орчинг бий болгоход зохих нэмэр боллоо.

5.27 Хөдөөгийн дотуур байранд амьдардаг сурагчдын ар гэрийнхэн тэднийг мах, хүнсээр хангадаг байсан бол одоо Засгийн газар эдгээр зардлыг хариуцах болсон байна. Үүний зэрэгцээ Засгийн газраас 4 ба түүнээс дээш хүүхэд нь, сургуульд зэрэг явдаг айлын нэг хүүхдэд хичээлийн хэрэгсэл олгох, нэн ядуу өрхийн нэг хүүхдийг сургалтын төлбөрөөс хураамжаас бүрэн чөлөөлөх арга хэмжээг авч байна. Энэ нь сургуульд завсардалтын түвшинг бууруулахад эерэгээр нөлөөлж байна.

5.28 Ерөнхий боловсролын дунд сургуулийн багш нарын хүрэлцээ мэдэгдэхүйц сайжирч байна. Засгийн газраас багш нар дутагдалтай байгаа газар руу багш нарыг сайн дурын үндсэн дээр илгээх, багшийн сургуулийн оюутнуудад илүү таатай нөхцөл олгож, багш нарын цалинг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авсан байна.

5.29 Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын агуулга, хөтөлбөр, стандартыг нь шинэчлэн мөрдөж эхлээд байна. Сурах бичгийг мөн шинэчлэлээ. Үүний үр дүнд сургууль завсардалт буурч боловсролын үнэлэмж өсч байна.

5.30 Боловсролын чанар болон үр ашиг нь хангалттай түвшнээс доогуур байна. Хот суурин болон хөдөө, орон нутгийн боловсролын хооронд ихээхэн ялгаа байна. 1990-2000 оны боловсролын түвшингийн үр дүнгийн шинжилгээгээс харахад сумын сурагчдын түвшин хот суурингийнхаас 10 хувиар доогуур байна. Үүнд нөлөөлж буй дараах хүчин зүйлс байна. Үүнд :

1. Хөдөө орон нутагт багш дутагдалтай байна. Тухайлбал 2002-2003 оны хичээлийн жилд 495 багш дутагдалтай байна. Багш нарыг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх үйл явц хангалтгүй хэвээр байна.
2. Багш нарын заах аргын ур чадвар хангалтгүйгээс тэд сургалтын явцад орчин үеийн сургалтын арга зүйг нэвтрүүлж чадахгүй байна.

3. Цэцэрлэг, сургууль болон дотуур байрны барилгын чанар улам дордсоор байна. Сүүлийн жилүүдэд нэлээд тооны барилгыг шинэчлэн засварлаж байгаа боловч, засвар шаардлагатай олон барилга байна.
4. Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж, техник хэрэгсэлүүд хуучирсан ба сүүлийн 10 жилийн турш ямар нэгэн шинэчлэл хийгдээгүй байгаа юм.
5. Боловсролын салбарын төсвийн ихэнх хэсэг нь шууд бус зардалд буюу тухайлбал цахилгаан, ус, дулаан зэрэгт зарцуулагдаж байна. Өөрөөр хэлбэл төсвийн зарцуулалт боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдэхгүй байна.
6. Бүх шатны сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь сайжраагүй байгаа бөгөөд сурах бичгийн нийлүүлэлт, чанар нь өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахгүй байна.
7. Техник, мэргэжлийн сургуульд суралцагчдын тоо өсөж байгаа хэдий ч зах зээлийн эрэлтийг хангахуйц боловсон хүчнийг бэлтгэж чадахгүй байна.
8. Хөдөлгөөний сааталтай (тахир дутуу, сохор, дүлий зэрэг) хүүхдүүдийн сургалт болон нийгмийн халамж хангалтгүй байгаагаас эдгээр хүүхдүүд сургуульд хамрагдахгүйд хүрч байна.

5.31 Боловсролын тухай хуулинд жилийн төсвийн 20 хувиас доошгүй хувь нь боловсролын салбарт зарцуулагдахаар заасан. Сүүлийн жилүүдэд 113.9-126.8 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, мөн 64.7-72.6 тэрбум төгрөгийг дунд сургууль болон хүүхдийн цэцэрлэгт зарцуулж байв. Хэдийгээр боловсролын салбарын санхүүжилт өсч байгаа ч төсвийн энэ санхүүжилт нь бүх түвшиний сургууль, цэцэрлэгийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

5.32 Сүүлийн жилүүдэд Засгийн газар нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормыг тодорхойлсон нь энэ салбарын зардлын төлөвлөлтийг сайжруулж байна. Бодит байдал зардлын энэ норм нь сургуулийн чанар болон аймгууд, нийслэлийн байршлын байдлаас шалтгаалж ялгаатайгаар тодорхойлогддог нь зарим сургуулиудад эх үүсвэр дутагдаж мөн сурагчдын тооноос шалтгаалж төсвийн хувиарлалт хангалтгүй болоход хүргэж байна. Төвийн болон орон нутгийн боловсролын байгууллагуудын удирдлагын чадавхи хангалттай сайн биш байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт сургууль болон цэцэрлэгийн багш, захирлаар ажиллах боловсон хүчинг олоход хэцүү болоод байна. Иймд боловсролын ахлах менежерүүдийг сургах болон дахин сургах боловсронгуй тогтолцоог бий болгох хэрэгтэй байгаа бөгөөд тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна.

5.33 Ядуурлыг бууруулах арга хэрэгсэлүүдийн нэг нь хүн амын боловсролын түвшинг сайжруулах явдал юм. Үүний тулд Засгийн газар боловсролын үйлчилгээний хүрээг өргөжүүлж, чанарыг сайжруулсанаар хүн амыг өндөр чанартай боловсрол олж авах таатай нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. Боловсролын салбарыг хөгжүүлэхэд дараах бодлогын зорилтууд тавигдаж байна:

5.34 **Нэгдүгээрт**, бүх шатны сургуулиудын боловсролын чанарыг дээшлүүлэх мөн иргэдэд зах зээлийн эдийн засгийн нөхцөлд амьдарч чадах боловсрол олгох явдал юм. Тодорхой үнэлгээнүүд дээр үндэслэн сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн системтэй хөтөлбөрийг бэлтгэх шаардлагатай байна. Эдгээр хөтөлбөрүүдийг эхлүүлэхдээ сургуулиуд болон багш нарын үйл ажиллагаа, мөн оюутнуудын үзүүлж буй сурлагын үр дүнд үнэлгээ, шинжилгээ, хяналт хийх, мөн боловсролын чанарт нөлөөлж байгаа орчин, нөхцөлийг үнэлж түүндээ дүн шинжилгээ, оношлогоо хийхээс эхлэх нь зүйтэй юм. Энэ ажил нь сургалтын чанарт үзүүлж байгаа гол хүчин зүйлсүүдийг бодитойгоор тодорхойлоход туслах бөгөөд оновчтой төлөвлөх, мөн зохицуулалт хийх, алдааг засах боломжийг өгөх болно.

5.35 **Хоёрдугаарт**, бүх нутагт, ялангуяа хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээг хүртээмжтэй байх тогтолцоог бий болгох, мөн бага орлоготой бүлгийн боловсрол олж авах хэрэгцээ, мөн тэднийг боловсролын үйлчилгээгээр хангах боломжийг дэмжих.

5.36. **Гуравдугаарт**, төв, орон нутгийн боловсролын байгууллагын удирдлагын чадавхийг жигд сайжруулах.

5.37. Бодлогын эдгээр зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах стратеги, арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

1. Аймаг, орон нутаг дахь боловсролын байгууллагууд болон төрийн захиргааны тав байгууллагын боловсролын асуудлуудтай холбогдох удирдлагын чадавхийг бэхжүүлнэ.
2. Сургууль завсардалтыг бууруулж, ерөнхий боловсролын хамрагдалтын түвшинг нэмэгдүүлж 2006 онд 90.5 хувьд хүргэнэ. Ерөнхий боловсролын болон дээд боловсролын жендерийн тэгш бус байдлыг арилгах зорилгоор аль ч хүйсийн хүүхдийн элсэлтийн түвшинг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнээс гадна боловсролын чадвар, үйлчилгээний чанар, боломжийг сайжруулахад багш нар, бусад ажилтнууд илүү их дадлагажих хэрэгтэй байна. Засгийн газар, улсын байгууллагууд болон аж ахуйн нэгж, иргэд, эцэг эхчүүд, багш нар сургуулиуд нэгдмэл байдлаар энэхүү үйл хэрэгт хүчин зүтгэх хэрэгтэй.
3. Багш нарын сургалтын системийг сайжруулахын тулд хөдөөгийн сургууль болон цэцэрлэгийн багш нарын мэргэжил, арга зүйн чадварыг дээшлүүлэх явдлыг оновчтой болгоно.
4. Цэцэрлэг, бүх шатны сургуулийн боловсролын агуулгыг сайжруулж сурагчдад мэргэжлийн болон ажил, амьдралын баримжаа олгох, 2005 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулийг 11-н жилийн сургалтанд шилжүүлнэ.
5. 2006 онд сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг 62 хувьд хүргэх, хөдөөгийн цэцэрлэгүүдийн сургалтын орчныг сайжруулах, малчин өрхийн хүүхдүүдийг сургуульд бэлтгэх үндэслэл сайтай арга, хэрэгслийг тодорхойлно.
6. Малчин болон ядуу өрхүүдийн хүүхдүүдийг, мөн тахир дутуу хүүхдүүдийн /хэлгүй, дүлий, биеэ авч явах чадваргүй г.м/ сургуульд бүрэн хамрагдах боломж, нөхцөлийг дээшлүүлж, дотуур байрны хангамж, үйлчилгээг сайжруулна.
7. Сургууль завсардсан хүүхэд, залуучууд болон иргэдэд бичиг үсгийн боловсрол нөхөн олгох, мэргэжил эзэмшүүлэх бүх арга хэлбэрийг дэмжин өргөжүүлнэ.
8. Зах зээлийн эрэлтэд нийцүүлэн боловсролын агуулга, материаллаг орчныг сайжруулснаар мэргэжлийн ажилчдыг сургах хүрээг өргөтгөн мөн ажилгүй залуучуудыг мэргэжлийн сургалтанд татан оруулна.
9. Дээд боловсрол олгох чанарыг олон улсын жишигт ойртуулж, дээд боловсролын магадлан итгэмжлэлийн чанарыг сайжруулна.
10. Ерөнхий боловсролын дунд сургуулийн сурах бичгийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, сурагчдыг ном, сурах бичгээр бүрэн хангана.
11. Сургууль цэцэрлэгийн барилга, дотуур байрыг шинээр барих, засварлах зэргээр сургалтын орчин сайжруулж, сургалтын материаллаг баазыг өргөтгөн, сургуулиудыг интернеттэй холбож, компьютержүүлнэ.

12. Ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчдын /сургалтын үр дүнг / сурлагыгүнэлэх, хянан шинжлэх, тэдгээрийн гүйцэтгэлд нөлөөлж байгаа үндсэн үзүүлэлтүүдийг судлах замаар мөн суурь боловсролын чанарыг сайжруулна.

5.38 Боловсролын салбарын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудын туслалцаа дэмжлэг чухал үүрэг хүлээнэ гэж үзэж байна.

Хүснэгт 5:1: Зардлын урьдчилсан тооцоо, мянган ам доллар

| Зүйл | 2003 | 2004 | 2005 | 2006 |
|--|------|------|------|------|
| 1. Цэцэрлэг, сургууль болон дотуур байрны барилгын шинэчлэн засвар | 5000 | 6500 | 7000 | 7500 |
| 2. Боловсролын агуулгыг шинэчлэх | 40 | 50 | 60 | 60 |
| 3. Багш нарыг бэлтгэх , мэргэжил ур чадварыг нь дээшлүүлэх | 250 | 250 | 280 | 280 |
| 4. Сурах бичгийн шинэчлэл | 200 | 220 | 230 | 240 |
| 5. Компьютерийн технологи, интернетийн холболт болон сүлжээний хангамж | 200 | 220 | 220 | 220 |
| 6. Сургуулиудын тоног төхөөрөмж болон техник хэрэгсэлүүд | 150 | 150 | 180 | 180 |
| 7.Зайны сургалт, албан бус сургалт | 50 | 50 | 60 | 60 |
| 8.Сургалтын үзүүлэлтийн мониторинг | 30 | 40 | 40 | 40 |
| Нийт дүн | 5920 | 7480 | 8070 | 8580 |
| Үүнээс: - гадаадын эх үүсвэрээр | 4950 | 6430 | 6870 | 7230 |
| - дотоодын эх үүсвэрээр | 970 | 1050 | 1200 | 1350 |

II. Эрүүл мэнд

5.39 *"Эмнэлгийн үйлчилгээ их муу байна. Эмч дутагдалтай, эмнэлгийн үйлчилгээ нэр төдий л байна. Эмнэлэгт хэвтвэл шаардлагатай эм, тариаг өөрсдөө л олох болдог. Нэгэнт бид тэр бүр Улаанбаатар явж чадахгүй болохоор эм, тариаг жижиг наймаачдаас авах болдог юм. Гэвч тэр нь чанар муутай, заримдаа хэрэглэх хугацаа нь хэтэрсэн байдаг. Хэрэглэх хугацаа нь хэтэрсэн эм хөдөөгийн хүмүүст зарж байгаа нь тэдний эрүүл мэндэд тун их аюултай гэж би боддог юмаа. Чанарын шалгалтаар худалдах зөвшөөрөл аваагүй бүтээгдэхүүн л орон нутагт зарагдаад байх шиг санагддаг"* гэж Өмнөговь аймгийн Сэврэй сумын Бүйлсэн багийн эмэгтэй ярьсан байна.

5.40 Шилжилтийн үе эхэлсэн 1990 оноос хойш эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд гарсан өөрчлөлт, бэрхшээл эрүүл мэндийн салбарыг ч тойроогүй юм. Тус салбарын ажилтнуудын тоо, тухайлбал, бага эмч, сувилагч, эмч нарын тоо 11-32 хувиар буурчээ. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа суларсан төдийгүй зарим нь (эхийн амрах байр г.м) бүр хаагдсан юм. Ийм хүнд нөхцөл байдалд эрүүл мэндийн салбарын ажилтнууд ажлынхаа төлөө бие сэтгэлээ зориулж, өөрсдийн нөөц бололцоог шавхан ажилласны хүчинд хүн амын эрүүл мэндийн байдал эрс доройтохоос сэргийлж чадсан юм. 1995 оноос эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа сэргэсэн нь цаашдын хөгжил дэвшлийн баттай суурь болсон.

5.41 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн байдлыг өмнөх хүснэгтэд үзүүлсэн бөгөөд зах зээлд шилжсэнээс хойш бага зэрэг буурсанаа 2001-2002 онуудад бага зэрэг өссөн нь харагдаж байна. Энэ нь төсвийн хүндрэл, дээр дурьдсан ажиллагчдын тооны бууралттай холбоотой. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь улсын төсөв, төлбөрт үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал гэсэн 3 эх үүсвэртэй байна. Тус салбарын төлбөрт үйлчилгээний орлогын санхүүжилт нь харьцангуй бага байдаг. 1990 онд эрүүл мэндийн

салбарын санхүүжилтийн 70.3 хувийг улсын төсөв, 29.7 хувийг эрүүл мэндийн даатгал хариуцаж байсан бол 2002 оны байдлаар 53.9 хувийг улсын төсөв, 41.8 хувийг эрүүл мэндийн даатгал, үлдсэн 4.3 хувийг төлбөрт үйлчилгээний орлого санхүүжүүлж байна.

5.42 Монгол улс дахь төрөлт сүүлийн хорин жилд байнга буурч байсан бөгөөд 1990 оноос хойш эрс буурсан байдаг. 1998 оны байдлаар төрөх насны нэг эмэгтэйд 3 хүүхэд ногдож байв. Төрөлтийн түвшин бүс нутаг болон боловсрол, амьдралын түвшингээс хамаарч ялгаатай байна. Тухайлбал, 1998 онд баруун бүсийн аймгуудын төрөх насны нэг эмэгтэйд 3.85 хүүхэд ногдож байсан бол Улаанбаатар хотод дөнгөж 2.17 хүүхэд ногдож байна.

5.43 Хүн амын дундаж наслалт 1980 онд 58 байснаа 2000 оны байдлаар 67 болж нэмэгдсэнээр орлогын түвшин ойролцоотой дэлхийн ихэнхи улс оронтой ойртож ирсэн юм. Гэхдээ эмэгтэйчүүдийн дундаж наслалт нь шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын үзүүлэлтийн дунджаас доогуур байна.

5.44 Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл байсан боловч нялхасын болон 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтыг бууруулах талаар Монгол улс сүүлийн 10 жилд зохих амжилтанд хүрсэн юм. Жишээ нь, нялхасын нас баралт 1992-2000 оны хооронд 63-аас 31 хүртэл 2 дахин буурчээ. Энэ үзүүлэлт нь орлогын түвшин ойролцоотой ихэнхи улс орнуудын үзүүлэлтээс доогуур байгаа боловч, шилжилтийн үеийн улс орнуудын дунджаас өндөр байна. Энэ нь Монгол улсын ядуурлын түвшин харьцангуй өндөр байгаатай зарим талаар холбоотой байна.

5.45 Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин хөдөө орон нутаг хотынхоос илүү байна. Жишээ нь, 1998 онд хийгдсэн судалгаагаар хөдөө орон нутаг дахь нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын түвшин хотынхоос 50 хувиар илүү байсан төдийгүй хамгийн өндөр үзүүлэлттэй Дорнод аймаг нь хамгийн бага үзүүлэлттэй Дундговь аймагас хоёр дахин их байв.

5.46 Боловсролын түвшин бага, ядуу гэр бүлд дээрхи үзүүлэлт өндөр байна. 1997 онд хийсэн судалгаанаас үзэхэд, чинээлэг гэр бүлтэй харьцуулахад ядуу гэр бүл дэх хүүхдүүдийн эндэх магадлал 16 дахин илүү байна. Ядуурлын түвшингээс гадна эцгийнх нь боловсролын түвшин, жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ дутмаг байсан, эмчийн зөвлөгөө авах боломжгүй байсан зэргээс шалтгаалан эндэгдлийн түвшин харьцангуй их хамааралтай байна. Хүүхдийн эндэгдлийн гол шалтгаан нь амьсгалын замын цочмог халдвар, тэжээлийн доройтолтой холбоотой үүсэж, шингэн алдалтаар хүндэрдэг ходоод гэдэсний замын халдварууд болон харьцангуй хялбархан урьдчилан сэргийлэх, эмчлэх боломжтой бусад төрлийн өвчнүүд байна.

5.47 1985-1990 оны хооронд эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд 120-175 хооронд хэлбэлзэж байжээ. 1990 оноос энэ үзүүлэлт огцом өсч, 1993 онд 240 буюу дээд хэмжээндээ хүрсэн байна. Тэр үеэс хойш уг үзүүлэлт аажмаар буурсан бөгөөд сүүлийн 5 жилд 100000 амьд төрөлтөнд ногдох эхийн нас баралт 160 орчимд тогтвортой байна. Монгол улсад 1990-ээд оноос хойш төрөлт буурсан хэдий ч төрөлтийн нийлбэр коэффициент шилжилтийн эдийн засагтай буюу бусад орныхоос өндөр байна. Мөн 1000 амьд төрөлт тутамд үр хөндөлтийн түвшин 230.8 байгаа нь нөхөн үржихүйн эрүүл мэнд, тэр дундаа охидын бэлгийн харьцаа, төрөлтөд муугаар нөлөөлж байна. Өнөөдрийн байдлаар 19-өөс доош насны охидын 9 хувь нь хүүхэд төрүүлсэн мэдээтэй байна. Жирэмсэлтээс хамгаалах хэрэгслийн хэрэглээний түвшин нийт эмэгтэйчүүдийн хувьд 33.4 хувь, гэр бүлтэй эмэгтэйчүүдийн хувьд 45.7 хувь байна.

5.48 2000 оны судалгаанаас харахад, бүх төрөлтийн дөнгөж 29 хувь нь малчин өрхөд ноогдож буй атлаа эхийн эндэгдлийн бараг тал нь энд гарч байна. Мөн эхийн эндэгдлийн ихээхэн хувь нь (28%) ажилгүй эмэгтэйчүүдэд тохиолдож байна. 2001 онд хийгдсэн судалгааны үр дүнд эхийн эндэгдлийн голлох шалтгаанууд нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар буурсан (36%), яаралтай үзүүлэх тусламж хоцорч удаан байгаа (28%),

эмнэлгийн байгууллагаас хол амьдардаг зэргээс болж байгааг тогтоожээ. Бэлгийн замын өвчин нь ихэвчлэн жирэмсний хүндрэлд хүргэдэг учраас эхийн эндэгдлийн нэг шалтгаан болж байна.

5.49 Хоол тэжээлийн дутагдал нь тус улсын насанд хүрэгчид болон хүүхдүүдэд тохиолдож буй нь бас нэг тулгамдсан асуудал юм. Тураал болон цус багадалт жирэмсэн эхчүүд болон хүүхдүүдэд их тохиолддог. Тухайлбал жирэмсэн эхчүүдэд дор хаяж 40 хувь нь архаг цус багадалттай байна. Хот суурин газартай (45 хувь) харьцуулахад харьцангуй ядуу өрхөд болон хөдөө орон нутагт (71 хувь) цус багадалт илүү тархалттай байна. Хөхөөр хооллохыг дэмжих үйл ажиллагааны үр дүнд нялхасын тураалын хувь багассан ч гэрийн нөхцөлд буруу хооллох нь 2-5 хүртэлх насны хүүхдүүдэд тэжээлийн доройтол үүсэхэд хүргэж байна. 2000 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдүүдийн 25 хувь нь өсөлтийн сааталтай, 13 хувь нь дутуу жинтэй байсан нь 1997 оны түвшингээс өндөр байна.

5.50 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшингээрээ ойролцоо бусад орнуудтай харьцуулахад Монгол улсад тураал нь түгээмэл биш юм. Гэхдээ ядуу болон хөдөөгийн хүн амын дунд тураал байна. Ядуу өрхийн хүүхдүүд уургийн дутлын гаралтай тураал, өсөлтийн саатал болон эрдэс бодисын дутагдалд илүү өртөж байна. 2000 онд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд нэн ядуу өрхийн гишүүдийн 39.3 хувь, ядуу өрхийн гишүүдийн 13.0 хувь, ядуу бус өрхийн гишүүдийн 5.0 хувь нь хоол хүнсний хомсдолд орсон байна. Судалгаанд оролцсон жин багатай хүүхдүүдийн 7.1 хувь нь хотод, 15.7 хувь нь аймгийн төвд, 19.4 хувь нь сумын төвд амьдарч байна. Бамбай зэрэг хүнс, тэжээлийн гаралтай өвчнийг бууруулах талаар зарим амжилт гарсан боловч цаашид их зүйл хийх хэрэгтэй байна. Тухайлбал, боловсрол багатай болон иоджуулсан давсыг олж авч чаддаггүй зэргээсээ болж ядуучууд бамбайд илүү өртөмтгий байна.

5.51 *Халдварт өвчинд* ядуу хүмүүс илүү өртөж байгаа бөгөөд дээр дурьдсанчлан амархан сэргийлэх боломжтой амьсгалын замын халдвар, гэдэс ходоодны өвчнүүдийн өвчлөл ч өндөр байна. Монгол улс сүрьеэгийн өвчлөл өндөртэй Ази номхон далайн бүсийн 7 орны нэг бөгөөд энэ үзүүлэлт 1991 онд 7,4 байснаа 2001 онд 14,1 болж өссөн байна. Сүрьеэтэй өвчтөнүүдийн ихэнхи нь ажилгүй, эсвэл ядуу буюу нэн ядуу хүмүүс байна. Эмчилгээний хөтөлбөрүүд харьцангуй үр дүнтэй байгаа боловч улам ихсэж буй нь ядууралтай холбоотой байна.

5.52 *Бэлгийн замын халдварт өвчин* болон ядуурал хоорондоо нягт холбоотой байна. 1989-1998 оны хооронд тэмбүү өвчний тохиолдол 66 хувь, заг хүйтэн өвчин 56 хувиар тус тус өсчээ. 2001 оны байдлаар 10.000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөлийн түвшин 7.1, заг хүйтнийх 23.0 байна. Халдвар авсан бүх хүмүүсийн бараг тал хувь нь ажилгүй буюу орон гэргүй ядуу хүмүүс байна.

5.53 Хүүхдийн дархлаажуулалтын тусламжтайгаар хөхүүл ханиалга, сахуу, татран, саа болон салхин цэцэг зэрэг өвчнүүдийг хянах хөтөлбөрүүд улс даяар үр дүнтэй хэрэгжиж байна. Гэхдээ хотын болон хөдөөгийн, ядуу болон ядуу бус хүүхдүүдийн хооронд байдал тэнцвэртэй биш байна. Жишээ нь, 2 хүртэлх насны хүүхдийн В хэлбэрийн гепатитын вакцинд хамрагдсан байдалд Эдстам нарын хийсэн судалгаагаар хагас нүүдлийн амьдралтай хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүдийн вакцинаа бүрэн хийлгэх боломж нь Улаанбаатар хотын хүүхдүүдээс хамаагүй бага болохыг тодорхойлжээ.

5.54 Сүүлийн 10 жилд *зүрх судасны өвчин, хавдар, гэмтэл* зэрэг халдварт бус өвчнүүд нь нас баралтын гол шалтгаан болж байна.

5.55 ***Амьдралын нөхцөл.*** Ядуурал болон эрүүл мэндийн дорой байдал нь амьдралын нөхцөл муу байхтай шууд холбоотой байна. Ядуу хүмүүс ихэвчлэн гэрт амьдардаг бөгөөд гэр нь зарим талаар эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, саяхан хийгдсэн судалгаагаар гэрийн халаалтын арга ба хүүхдийн амьсгалын замын халдварын хооронд шууд хамаарал байгааг тогтоожээ. Ядуу хүмүүс ихэвчлэн эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй, зохимжгүй аргаар гэрээ халаадаг. Энэ нь гэрт амьдардаг бие

султай өндөр настан төдийгүй өвчин эмгэгтэй аль ч насны хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна.

5.56 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртгийг багасгах талаар нилээд алхамууд хийгдэж байгаа хэдий ч ядуу хүмүүс эрүүл мэнддээ орлогын нэлээд их хэсгийг зарцуулж байна. Жишээ нь, 1998 онд хийгдсэн Амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар эм, эмнэлгийн тусламжинд ядуу өрхүүд нийт зардлын 3 хувь, ядуу бус өрхүүд 2 хувийг зарцуулдаг болохыг тогтоосон. Мөн энэ судалгаагаар ядууралд орохын хоёр дахь гол шалтгаан нь өвчлөх явдал байдаг гэсэн дүн гарчээ.

5.57 Жейнсийн судалгаанаас харахад (2000), судалгаанд хамрагдсан өрхүүдийн 15 хувь нь хүнд өвчин эмгэгээс болж ядуурсан буюу ядуурах нөхцөл бүрдээд байна гэсэн бол, 20 хувь нь санхүүгийн бэрхшээлээс болоод эмчийн зааврыг дагаж чадаагүй буюу оройтож биелүүлсэн гэжээ. Эдгээр бэрхшээлүүд нь хүн амын ядуу, эмзэг бүлгийнхэн дотор илүүтэй тохиолдож байна.

5.58 Эрүүл мэндийн тусламжийн хэрэглээ. Эрүүл мэндийн тусламжийн хэрэглээ тус оронд өндөр хэвээр байна. Вакцинжуулалтанд хүүхдүүд болон жирэмсэн эхчүүд бараг бүрэн хамрагддаг бөгөөд ихэнхи төрөлт мэргэжсэн эрүүл мэндийн ажилтны хяналтанд явагддаг. Жишээ нь, амьсгалын замын цочмог халдвартай хүүхдүүдийн 77 хувь, суулгалт өвчинтэй хүүхдүүдийн 67 хувь нь зөвлөлгөө авах буюу эмчилгээ хийлгэхээр эмнэлгийн байгууллагад хүргэгдсэн гэжээ. Үүний зэрэгцээ улсын эмнэлгүүдийн тайлангаас үзэхэд жилд нэг хүн дор хаяж 5 удаа амбулаториар үзүүлж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хэрэглээ өндөр байгаа хэдий ч өвчлөлийн түвшин өндөр байгаа нь цаашид тусламж, үйлчилгээний чанарыг үнэлэх шаардлагатай байгааг харуулж байна.

5.59 Эрүүл мэндийн тусламжийн хэрэглээнд ялгаа тод харагдаж байна. Чинээлэг хүмүүстэй харьцуулахад ядуу хүмүүсийн эрүүл мэндийн тусламжийн хэрэглээ нь нэн доогуур байна. Үүний зэрэгцээ ядуу хүмүүс нь ойр дөт байдаг бөгөөд өртөг багатай байдаг учраас өрхийн болон дүүргийн эмнэлэгт ихэвчлэн очдог бол орлого өндөртэй өрхүүд томоохон эмнэлгүүд, хувийн эмнэлэг ба аймгийн төвийн эмнэлгээр ихэвчлэн үйлчлүүлдэг байна.

5.60 Бэлэн мөнгөөр төлбөр хийх чадвар муутай учраас ядуу хүмүүс эмнэлгийн тусламж үйлчилгээг бага хүртэж байна. 1999 оны судалгааны дүнгээс харахад, ядуу хүмүүс бүх төрлийн эрүүл мэндийн тусламжийг бага хэрэглэсэн байна. Нэн ядуу өрхийн гишүүдийн эмнэлэгт хэвтэх тусламжийг ашигласан байдал нь чинээлэг өрхтэй харьцуулахад 2,5 дахин доогуур байна.

5.61 Харин 2001 онд хийгдсэн өрхийн эмнэлгийн үйлчилгээний талаархи судалгаанаас эерэг дүр төрх харагдаж байна. Ядуу гэж бүртгэгдсэн хүмүүс өрхийн эмнэлгийн тусламжийг ядуу бус хүмүүстэй бараг адил хүртжээ. Зарим эмзэг бүлгийнхний хувьд (өндөр настнууд, өрх толгойлсон эмэгтэй г.м) өрхийн эмнэлгийн тусламж нь эрүүл мэндийн тусламжийн хамгийн чухал эх үүсвэр болж байна.

5.62 Гэхдээ зарим тохиолдолд, өрхийн эмч нар үзүүлэх ёстой тусламжаа үзүүлж чаддаггүй бөгөөд ихэнхдээ дээд шатны эмнэлэг рүү илгээдэг гэж өвчтөнүүдийн нэлээд хэсэг нь гомдол гаргадаг. Үүнээс болж өвчтөнүүд илүү зардал гаргах (эмнэлгийн бус), үзүүлэх эмч нь байхгүй байх, эсвэл тухайн очсон эмнэлэг нь хүлээж авахгүй байх, удаан хүлээлгэх зэрэг бэрхшээлүүд гардаг байна.

5.63 2002 оны 9 сарын байдлаар Монгол улсын нийт хүн амын 56 хувийг үйлчилгээндээ хамруулсан 234 өрхийн эмнэлэг ажиллаж 940 их эмч ажиллаж байна. Дунджаар нэг өрхийн эмнэлэгт 5540 хүн 1250 өрх ногдож байна.

5.64 Сумын эмнэлгийн тусламж. Сумдын эмнэлгээс хөдөөгийн хүн амд үзүүлж байгаа нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах асуудал нь эрүүл мэндийн салбарын тулгуур зорилтуудын нэг юм.

5.65 Монгол улсын нийт эмнэлгийн орны 27.7 хувь, хэвтэн эмчлүүлэгчдийн 32.1 хувь нь тус тус сумын эмнэлэгт ногдож, нийт эхчүүдийн 39.4 хувь нь сумын эмнэлэгт хүүхдээ төрүүлж байна.

5.66 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх таван шалтгаант өвчин хөдөөгийн хүн амын дунд жил бүр нэмэгдэж, сүүлийн 3 жилд нас барсан эхчүүдийн 40.5 хувь нь сум, багт энджээ. Энэ нь сум, багийн түвшинд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна. Энэ байдалд дараах шалтгаан, хүчин зүйлүүд нөлөөлж байна.

5.67 Сумын эмнэлгийн барилга, дулаан, цахилгаан, усан хангамж эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй байна.

5.68 Сумын эмнэлгийн 370 орчим барилга байгууламжийн ашиглалтын байдалд холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас хийсэн үзлэгийн /2001 он/ дүнгээс үзэхэд ихэнх эмнэлгүүд чанар муутай баригдсан, засвар хийлгүй удсанаас эвдэрч, хуучирсан байранд, 109 эмнэлэг зориулалтын бус байранд тус тус үйл ажиллагаа явуулж байна. Сумдын эмнэлгийн 83.6 хувь нь гар хийцийн нам даралтат зуухаар эмнэлгийн барилгаа халааж, 80 хувь нь сумын дизель цахилгаан станцаас хязгаартай гэрэлтүүлэг авч, нийт эмнэлэг үйлчилгээндээ зөөврийн ус хэрэглэж, цэвэр, бохир усны нэгдсэн системгүй ажиллаж байна. Сумын эмнэлэг зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эм хэрэгслээр дутмаг байна.

5.69 Сүүлийн 10 жилд сумдын эмнэлгийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажил үндсэндээ орхигдож, өмнө нь хэрэглэгдэж байсан тоног төхөөрөмжүүд хуучирч ашиглагдах боломжгүй болсноос нийт сумдын эмнэлгийн 92.5 хувь нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай багаж, тоног, төхөөрөмжөөр дутагдаж байна. Харин энэ хугацаанд зарим гадаад орон, олон улсын байгууллагуудын тусламжтайгаар эх барихын иж бүрдэл, хүйтэн хэлхээний цахилгаан хэрэглэдэггүй тоног төхөөрөмжөөр ихэнх сумдын эмнэлгүүдийг хангах арга хэмжээ авсан юм. Сумын эмнэлгийн түвшний эмчилгээнд 174 нэр төрлийн нэн шаардлагатай эм хэрэглэгддэг бөгөөд эдгээрийн хангамж дунджаар 30-40 хувьтай байгаа бөгөөд эмийн сангийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд хүргэх тогтолцоо алдагдсан зэргээс шалтгаалан хөдөөгийн иргэдийг чанарын баталгаатай, боломжийн үнэтэй эмээр хүртээмжтэй хангах явдал тогтворжиж чадаагүй байна. Мөн шаардлагатай эм, тарианы үнийг орон нутгийн иргэд хувиасаа гаргах, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан ч хөнгөлттэй эмээр үйлчлүүлж чадахгүй байх явдал гарсаар байна.

5.70 Сумын эмнэлгийн боловсон хүчний хангамж хүрэлцээгүй, тэдний чадавхи нь сул байна.

5.71 Сумын эмнэлэгт эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний хангамж дутагдалтай хэвээр байна. Хөдөөгийн эмч, мэргэжилтнүүд төгсөлтийн дараахь сургалтад хамрагдах, шинэ мэдээлэл авах боломж хязгаарлагдмал, амьдралд нь хүрэлцэхүйц цалин хөлс, нийгмийн баталгаагаар хангагдаагүй байгаа нь тэдний тогтвор суурьшилтай ажиллах, хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны чанартай, хүртээмжтэй тусламж үзүүлэх үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байна.

5.72 Сумын эмнэлгийн санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй, төсөв хүрэлцэхгүй байх явдал гарсаар байна.

5.73 Сумын эмнэлгийн санхүүжилт хугацаандаа хийгдэхгүй, төсөв нь хүрэлцэхгүйн улмаас нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, өвчтөнийг стандартын дагуу эмчлэх, эмч, ажиллагсдын цалинг хугацаанд нь олгоход

байнга бэрхшээл учирч байгаа нь зарим тохиолдолд өвчтөний ар гэрээс эм тариа авчруулах, түргэн тусламжийн дуудлагын машины бензинийг ард иргэдээс гаргуулах зэрэг зохисгүй байдал даамжрах, эмнэлэг, эм хангамжийн байгууллагын хоорондын эмийн өр төлбөр нэмэгдэхэд хүргэж байна. Сумын нэг иргэнд ногдох нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нормативт зардлаар тооцсон санхүүжилт хугацаандаа бүрэн хийгдэхгүй байгаагаас сумын эмнэлгийн санхүүжилтэд улсын хэмжээгээр 2001 оны гүйцэтгэлээр 10.0 тэрбум төгрөг зарцуулсан нь эрүүл мэндийн салбарын нийт зардлын 21 хувийг эзэлж байна.

5.74 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, мэдээллийн удирдлагыг чадавхижуулах, орон нутгийн удирдах байгууллагын зохицуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр ч анхаарах асуудлууд байсаар байна.

5.75 **Эмч, эмнэлгийн ажилтнуудын хүртээмж, байршил.** 1990- 1995 оны хооронд бага эмч, сувилагч, их эмчийн тоо эрс багассан талаар өмнө дурьдсан. 1995-2000 оны хооронд сувилагч, бага эмч нарын тооны бууралт үргэлжилж, 5-20 хувь буурчээ. Үүний зэрэгцээ их эмчийн тоо 18 хувиар өссөн байна. 2000 оны байдлаар эмч нарын тоо сувилагч нарын тоотой бараг тэнцүү байна.

5.76 Эмч, эмнэлгийн ажилтнуудын газарзүйн байршлын асуудал нь анхаарал татаж байна. Улаанбаатарт нэг эмчид 206 хүн ноогдож буй бол Завханд 794 байна. Улаанбаатарт нэг сувилагчид 393 хүн ногдож байгаа бол Завханд 502 байна. Ийнхүү эмнэлгийн ажлын хүртээмж, байршил харилцан адилгүй, ялангуяа хөдөөд эмч нар цөөн байгаа нь иргэд, ядуучууд эмнэлгийн үйлчилгээг авах боломж бага болж байна. Алслагдсан зарим сум хүний их эмчгүй байх явдал байна.

5.77 **Сүүлийн үед хэрэгжүүлсэн бодлогын өөрчлөлтүүд.** 1990 оноос хойшхи эдийн засгийн хүндрэлийн улмаас эрүүл мэндийн салбарын төсөв эрс багасч, эрүүл мэндийн тусламжийн тоон болон чанарын үзүүлэлтүүд муудсан. 1995 оноос хойш зарим талаар байдал эргэж сэргэсэн боловч эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө 1990 онд ДНБ-ий 5.3 хувь байснаа 2001 онд 4.6 хувь болж буурсан байна.

5.78 1990 оноос хойш эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт тогтвортой биш, 2000 оны байдлаар нийгмийн салбарын зардлын дөнгөж 4 хувийг эзэлж байна.

5.79 Орлогын шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор 1994 онд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бий болгосон юм. Эмзэг бүлгийн хүмүүсийн даатгалын хураамжийг төрөөс хариуцдаг учраас даатгалын энэ тогтолцоо нь олонхи ядуу хүмүүсийг хамгаалж байгаа юм.

5.80 2003 оноос эхлэн өрхийн эмнэлгийн тусламж эрүүл мэндийн даатгалд хамрагдах болсон бөгөөд ядуучууд энэ тусламжийг хамгийн ихээр хүртэж байгаа учраас ядуучуудад ашигтай байна. Эмнэлэгт хэвтэхдээ хийх төлбөр нь одоо сумын эмнэлэгт 5 хувь, аймагт 10 хувь, гуравдагч шатлалын эмнэлэгт 15 хувь байна. Энэ нь шаардлагагүй үед гуравдагч шатлалын эмнэлгийн тусламжийг ашиглахыг багасгаж байгаа бодлогын арга хэмжээ юм. Нөгөө талаас, энэ нь 3-дагч шатлалын эмнэлгийн тусламжийг хамгийн бага хүртдэг хүмүүс болох ядуучуудын энэ шатлалын тусламжийг зохистой ашиглах боломжийг нь улам хааж болох талтай байна.

5.81 **Эрүүл мэндийн салбарын хувьчлал нь** ядуучуудад ашиггүй байх хандлагатай байна. Тухайлбал, улсын эмнэлгийн туршлагатай сайн эмч нарт хувиараа давхар ажиллах боломж олгож байгаагаас эдгээр эмч нарын үйлчилгээ нь ядуу бус хүмүүст ихэвчлэн чиглэх болж байна. Одоогоор хувьчилсан нэг эмнэлгийн туршлагаас харахад, энэ эмнэлэг төлбөр нэхээд ядуучуудад бараг үйлчлэхгүй болсон байна.

5.82 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээний гарцаар тооцсон санхүүжилт хийхээр бэлтгэж байгаа бөгөөд ингэснээр тусламж, үйлчилгээний зардлын үр ашгийг дээшлүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.

5.83 **Эхийн эндэгдлийг бууруулах стратеги** 2002 оноос хэрэгжиж байна. Эхийн эндэгдэл нь ядуу, эмзэг бүлгийн дотор өндөр байгаа учраас энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулна. Хүн амын ядуу эмзэг хэсгийн дотор халдварт өвчний өвчлөл өндөр байгаа учраас ядуу эмзэг бүлгийнхэнд энэ хөтөлбөр ихээхэн тустай болно. 2001 оны 11 сард Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого батлагдсан юм. Энэ нь ядуурлыг бууруулах болон эрүүл мэндийн салбарын үр дүнг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулах бололцоог бүрдүүлж байна. Түүнчлэн Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний хөтөлбөр нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд илүү үр дүнтэй, хүртээмжтэй хүргэхэд чиглэгдэж байна.

5.84 Хөдөөгийн ядуу, эмзэг бүлгийн хүн ам нь сумын түвшний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гол хэрэглэгчид учраас сумын эмнэлгийн хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн жигд, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх зорилт тавьж байна. Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийг 2001 онд байгуулсан бөгөөд энэ нь хот суурин болон орон нутаг дахь тусламж, үйлчилгээний ялгааг багасгахад чиглэгдсэн алхам болсон. Иодын дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн чиглэлээр олон чухал хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

5.85 *Эрүүл мэндийн салбарт 2000-2002 онд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, үр дүн.*

5.86 Хүн амын дийлэнх хэсгийг эрүүл мэндийн даатгалд хамруулах замаар тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчилсэн найруулгыг батлуулав. Ингэснээр хувь хүний даатгалын системээс өрхийн даатгалын системд шилжих боломж бүрдсэн. Ядуу амьдралтай олон хүмүүс үнэгүй буюу хямд өртөг бүхий эрүүл мэндийн үйлчилгээг авах бололцоо нээгдсэн. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын дунд өрсөлдөөн бий болж ажил, үйлчилгээгээ нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах боломж бий болсон.

5.87 *Засгийн Газраас эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийг идэвхтэй дэмжиж байна.* Хувьчлалыг нэг талаас эрүүл мэндийн байгууллагуудад байр сууц, материаллаг баазыг эзэмшүүлэх, нөгөөтэйгүүр санхүүжилтийн дийлэнхийг төрийн өмчийн бус салбарт хариуцуулах (сайн дурын даатгал буюу төлбөртэй үйлчилгээгээр дамжуулан) хэлбэрээр хийж байна.

5.88 *Эрүүл мэндийн анхдагч тусламжийн томоохон хэсгийг өрхийн эмнэлэгийн тогтолцоо хэмээн нэрлэгдэх шинэ арга замаар хүргэх ажлыг эрчимтэй хэрэгжүүлж байна.* Өрхийн эмнэлгийг бие даалган байгуулж, үйлчлэх хүн амынх нь дунд байршуулан ажиллуулж, нэг иргэнээр тооцсон зардлын нормативаар гэрээний үндсэн дээр санхүүжүүлж байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгад өрхийн эмнэлгийн тогтмол зардлыг төсвөөс, урсгал зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болов.

5.89 Монгол улс халдваргүйжүүлэх вакцинжуулалтыг олон жилийн турш, үр дүнтэй тууштай хийж, нилээд амжилтанд хүрлээ. Вакцинд хамруулалт, тухайлбал, сүрьеэ, салхин цэцэг, гепатит В вирусын халдварт шар, саагийн эсрэг вакцинжуулалт 90 гаруй хувьтай байна.

5.90 Гэвч эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй хүндрэл бэрхшээл байна. Эхийн эндэгдэл өндөр байгаа бөгөөд дорвитой буурахгүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээний анхан шатны тусламж, үйлчилгээ муу, эмзэг бүлгийнхэнд бүрэн хүрч чадахгүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу, санхүүгийн чадавхи хязгаарлагдмал байна. Эрүүл мэндийн салбарын үр өгөөж хангалтгүй байна. Хөдөөгийн оршин суугчид, ялагуяа

гэрийн эзэгтэй нарт радио, мэдээлэл, холбооны технологийг ашиглан мэдээлэл хүргэх, сургалт явуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

5.91 Урт болон дунд хугацаанд эрүүл мэндийн салбарт дараахь стратегийг хэрэгжүүлэх зорилт тавьж байна. Үүнд:

1. Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, Нөхөн үржихүйн Үндэсний хөтөлбөр, Хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлснээр эх, нялхсын эндэгдлийг бууруулж мянганы хөгжлийн зорилтод дэвшүүлсэн хэмжээг хангана.
2. Өрхийн эмнэлгийг бэхжүүлэх, Сумын эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангаж, боловсон хүчин, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлөөр хангах замаар нийт хүн ам, хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.
3. Иргэний эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлснээр нийгмийн ядуу, эмзэг бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх нөхцөл боломжийг сайжруулна.
4. Халдварт өвчнийг бууруулна.

5.92 Дээрхи урт хугацааны стратегийн хүрээнд дунд хугацаанд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Эхийн болон нялхсын эндэгдлийг бууруулах хүрээнд:

- Эрүүл мэндийн тухай хуульд оруулсан нэмэлтэд нийцүүлэн эх, хүүхдэд эмнэлгийн мэргэжлийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлэх журмыг шинэчлэн, мөрдүүлнэ.
- Архангай, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг, зарим сумдын эмнэлгийг эхэд ээлтэй эмнэлэг болгох ажлыг зохион байгуулна. Цаашид хамрах хүрээг нь нэмэгдүүлнэ.
- Ялангуяа айл өрх, бүлгийн хүрээнд жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх талаарх нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд Засгийн газар, иргэний нийгмийн оролцоог өргөтгөнө.
- Ховд, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Хөвсгөл аймаг Улаанбаатар хотын 2 дүүрэгт нөхөн үржихүйн эрүүл мэндийн бие даасан үйл ажиллагааг идэвхжүүлэн, орон нутгийн нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлж өргөжүүлнэ.

2. Ядуу, эмзэг бүлгийн болон алслагдсан хөдөө орон нутагт оршин сууж байгаа хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах хүрээнд:

- Өрхийн эмнэлгийн эмчилгээ болон бусад үйлчилгээнд олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- Сумдын эмнэлгийн чадавхийг сайжруулах, боловсон хүчнийг сургах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сайн дурын туслах ажилтан бэлтгэнэ. Хөдөөгийн болон өрхийн эмнэлгийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.
- Хүн амд эрүүл мэндийн байгууллага, эмч нарын үзүүлэх мэргэжлийн тусламж, чанарыг дээшлүүлнэ.
- Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэх ажлыг шинэ шатанд гаргана. Хувийн хэвшлийн эмнэлэг хөгжих бололцоог бүрдүүлж дэмжлэг үзүүлнэ.
- Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний чанарыг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Магадлан итгэмжлэгдсэн, зөвшөөрлийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургаж мэргэжлийг нь дээшлүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарын хувьчлалын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэнэ.

3. Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх хүрээнд:

- Шаардлагатай эм, эмчилгээний багаж хэрэгслээр хангах арга хэмжээг авна.
- Төрийн өмчит эмнэлгүүдийн оношлогооны чадварыг сайжруулна.
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр санхүүгийн нөөцийг зөв зохистой ашиглах хөшүүргийг бий болгоно.
- Эрүүл мэндийн зардлын бүртгэлийн шинэ тогтолцоог нэвтрүүлнэ.
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг зохицуулах шинэ заавар, журмыг боловсруулж мөрдөнө.
- Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулна.
- Хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай хүргэх бололцоог боловсронгуй болгоно. Хөдөөгийн түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах арга хэмжээ авна.

4. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд:

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар эх, хүүхдийн хоол, тэжээлийн аюулгүй байдал, хангамж, чанарыг сайжруулна.
- Халдварт өвчинтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар халдварт өвчин, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчнийг бууруулна.
- ДОХ-той тэмцэх арга хэмжээ авна.

5.93 Эрүүл мэндийн салбарт дэвшүүлж байгаа стратегийн зорилтыг хэрэгжүүлсэнээр Монгол улсын хүн амын эрүүл мэндийн баталгаа дээшилж, эрүүлжилтийн түвшин сайжирч, ядуу эмзэг бүлгийн хүн ам эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамрагдах нөхцөл бүрдэнэ. Эрүүл мэндийн салбарын стратегийг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой ашиглах, хандивлагчдын дэмжлэгийг авах шаардлага гарна.

Хүснэгт 5:3: Эрүүл мэндийн салбарт шаардагдах хөрөнгийн тойм тооцоо

| | 2003-2006 | 2007-2010 |
|---|-----------|-----------|
| 1. Өрхийн эмнэлэг, сум, аймаг, нийслэлийн эмнэлгийн барилгын засвар, өргөтгөл, шинэчлэл | 5190 | 5150 |
| 2. Эмнэлгийн бүх шатны байгууллагын тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хангалт | 1645 | 2950 |
| 3. Түргэн тусламжийн авто машины парк шинэчлэх | 1575 | 575 |
| 4. Эмнэлгийн ажилтаны давтан сургах, нарийн мэргэжлээр мэргэшүүлэх | 2262 | 250 |
| 5. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгө | 224.8 | 280 |
| Дүн | 7508.8 | 9205 |
| Үүнээс: -гадаад эх үүсвэр | 1280 | |
| -дотоод эх үүсвэр | 6258.8 | 9205 |

III. Хөдөлмөр эрхлэлт

"Үйлдвэрүүд дампуурч, төсвийн байгууллагууд цомхотголд орсон нь олон хүнийг ажилгүй болголоо. Сэргээлэн, овсгоотой нь өөр тийш нүүгээд тийм бус нь эндээ хоцорсон юм" гэж Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлсон байхад "Найман жилийн өмнө боломжийн амьдралтай байсан айлуудын амьдрал аажмаар доошлон ядуу, нэн ядуу бүлэг рүү орсоор байгаагийн шалтгаан нь өмч хувьчлалыг буруу явуулж, олон үйлдвэр, аж ахуйн газрууд хаагдаж, улмаар ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдсэнд оршино" гэж Өмнөговь аймгийн Даланзадгад хотын иргэд өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн уналтын байдлыг тодорхойлжээ.

5.94 Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын үндсэн зорилго нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, нийгмийн халамж, асрамж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэгдэж байна. Мянганы хөгжлийн зорилтод туйлын ядуурал, өлсгөлөнт байдлыг бууруулахаар заасан нь Монгол Улсын Засгийн газрын нийгмийн хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл болж байна.

5.95 Монгол Улсад ажилгүйдлийн түвшин нэлээд өндөр байгаа нь хүн амын орлогыг бууруулах, хоол, хүнс, хэрэгцээний дутагдал бий болж ядуурах үндэс болж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор 15 ба түүнээс дээш насны хүн амын 51 хувь нь ажил эрхэлж, бодит ажилгүйдлийн түвшин буюу ажил эрхлээгүй байгаа ажилгүйчүүд ажиллах хүчний 17.5 хувийг эзэлж байв. Нийт ажилгүйчүүдийн 54 хувийг эмэгтэйчүүд, 60 гаруй хувийг 16-35 хүртэлх насны залуучууд, талаас илүү хувийг мэргэжлийн боловсролгүй хүмүүс эзэлж байна. Мэргэжлийн сургалт хангалтгүй байгаа нь ажилгүйдлийг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна.

5.96 Хөдөлмөрийн насны хүн ам 2003 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 1402.8 мянга, ажиллагчид 832.6 мянгад хүрчээ. Ажиллах хүчний оролцооны түвшин 2002 оны эцэст 61.5 хувьтай байна. Хөдөлмөрийн зах зээлийн байдалд хийсэн судалгаагаар ажиллах хүчний урсгал хөдөлгөөн их, бүтээмж харьцангуй доогуур байна. Энэ нь Монголын ажиллах хүчийг хөгжүүлэх, чадавхийг нь нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

5.97 Хөдөөнөөс хот, суурин газар руу чиглэсэн иргэдийн шилжих хөдөлгөөн хөдөлмөр эрхлэлтэд том нөлөө үзүүлж байна. Энэ нөлөөлөл нь хот, суурин газарт хүн ам төвлөрч, албан бус хэвшил ергөжиж байгаагаар илэрч байна.

5.98 Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах, хөдөлмөрийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцоход нэгдсэн ойлголт, тодорхойлолтыг ОУХБ-аас гаргасан нэр, томъёотой нийцүүлэх зорилгоор Үндэсний статистикийн газрын дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 207/103 тоот тушаалаар хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолтыг баталж гаргасан. Энэхүү тодорхойлолтоор ажиллах хүчний тайлан, мэдээллийг гаргаж хэвшээд байгаа юм.

5.99 2002 оны эцсийн байдлаар хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйдлийн тоо 30.8 мянга, ажилгүйдлийн түвшин 3.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 1.1 пунктээр буурсан байна. НҮБХХ-ийн Бодлого, хөтөлбөр боловсруулах дэмжлэгийн хүрээнд ОУХБ-аас бэлтгэсэн Монголын эдийн засгийн хөгжилт, хөдөлмөр эрхлэлт ба сургалт тайланд ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхитэй хүн амын 10 орчим хувь байна (ОУХБ, 1999) гэж дүгнэсэн бөгөөд Монголын Засгийн газар үүнтэй санал нэг байгаа юм. Энэ тооцоонд албан бус хэвшлийнхэн /тэд өөрсдийгөө хөдөлмөр эрхлээгүй гэж бүртгэл, мэдээлэлд оруулах сонирхолтой байдаг/ бас орж байгаа юм. 1995 оноос ажилгүйдлийн даатгалын тогтолцоонд шилжсэн.

Хүснэгт 5:4: Хүн амын ажил эрхлэлт, жилийн эцэст 1995-2001, мянган хүнээр

| Үзүүлэлт | 1995 | 1996 | 1997 | 1998 | 1999 | 2000 | 2001 |
|---------------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| 1.Хөдөлмөрийн насны хүн ам | 1186.7 | 1212.8 | 1229.9 | 1256.8 | 1279.3 | 1347.4 | 1402.8 |
| үүнээс: эмэгтэй хүн ам | 590.4 | 599.5 | 612.3 | 625.8 | 637.0 | 676.5 | 719.9 |
| эзлэх хувь | 49.8 | 49.4 | 49.8 | 49.8 | 49.8 | 50.2 | 51.3 |
| 2.Эдийн засгийн идэвхтэй хүн ам | 812.7 | 825.0 | 828.8 | 842.4 | 853.4 | 847.6 | 872.6 |
| үүнээс: эмэгтэй | 384.2 | 393.1 | 396.4 | 404.4 | 408.3 | 412.8 | 429.7 |

| | | | | | | | |
|--|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| 2.1.Ажиллагчид (албан ёсны) | 767.6 | 769.6 | 765.1 | 792.6 | 813.6 | 809.0 | 832.3 |
| үүнээс: эмэгтэй | 360.6 | 365.0 | 363.8 | 378.4 | 386.7 | 392.1 | 407.8 |
| 2.2.Ажилгүйчүүд (бүртгэгдсэн) | 45.1 | 55.4 | 63.7 | 49.8 | 39.8 | 38.6 | 40.3 |
| үүнээс: эмэгтэй | 23.6 | 28.1 | 32.6 | 26.0 | 21.6 | 20.7 | 21.9 |
| 3.Ажилгүйдлийн түвшин (хувиар) | 5.5 | 6.7 | 7.7 | 5.9 | 4.7 | 4.6 | 4,6 |
| үүнээс: эмэгтэй (хувиар) | 6.1 | 7.1 | 8.2 | 6.4 | 5.3 | 5.0 | 5.1 |
| 4.Ажиллах хүчний оролцооны түвшин (хувиар) | 68.5 | 68.0 | 67.4 | 67.0 | 66.7 | 62.9 | 62.2 |
| Үүнээс: эмэгтэй (хувиар) | 65.1 | 65.6 | 64.7 | 64.6 | 64.1 | 61.0 | 59.7 |
| 5.Ажил эрхлэлтийн түвшин (хувиар) | 64.7 | 63.5 | 62.2 | 63.1 | 63.6 | 60.0 | 59.3 |
| үүнээс: эмэгтэй (хувиар) | 61.1 | 60.9 | 59.4 | 60.5 | 60.7 | 58.0 | 56.6 |

*Тайлбар: *Гадаадад ажиллаж буй хүмүүс хамаарахгүй
Эх сурвалж: Үндэсний статистикийн газар*

Ажил эрхлэлтийн тухайд эмэгтэйчүүд ядуурлаас сэргийлэх гол механизм болох ажил эрхлэлт, орлого олох боломжоор эрчүүдээс бага байгааг тэмдэглэх хэрэгтэй. Ажилд авахад нас, зүс царай болон хүүхэд төрүүлэх, асрах зэргээс болж эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдал байдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Түүнчлэн шилжилтийн үед хөдөлмөрийн албан ёсны зах зээлд бүтцийн өөрчлөлт явагдсанаас үүдэн эмэгтэйчүүд илүүтэй нэрвэгдсэн юм. Хөнгөн үйлдвэрүүд, үйлчилгээний салбарт ажиллаж байсан олон тооны эмэгтэйчүүд албан бус салбарт бараг бэлтгэлгүйгээр ороход хүрсэн. 1992-1995 онд явагдсан эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөс үүдэн эрэгтэйчүүдээс /37 хувь/ илүү эмэгтэйчүүд /63 хувь/ ажилгүй болсон байна /НХХЯ-ны явуулсан судалгаар/. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа, орлого болон хөдөлмөр эрхлэлт нь албан бус салбарт ихээхэн түшиглэдэг нь тэднийг төрийн нийгмийн хамгааллаас гадна үлдээж, эдийн засаг, эрүүл мэндийн эмзэг байдлыг нь улам даамжруулахад хүргэж байна.

5.100 Хөдөлмөрийн зах зээлийн байдалд хийсэн судалгаа, үнэлгээгээр ажиллах хүчний урсгал хөдөлгөөн их, бүтээмж бага, зах зээлд ерселдэх чадвар сул, хөрвөх чадвар хангалтгүй, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, ажилгүй байх хугацааны үргэлжлэл урт байна гэсэн дүгнэлт гаргасан байна.

5.101 Ажилгүйчүүдийн бараг 60 хувь нь огт мэргэжилгүй, 6 хувь нь бага боловсролтой байгааг харгалзан мэргэжлийн баримжаа олгох, шинэ мэргэжил эзэмшүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Мэргэжлийн сургалтын байгууллагын тогтолцоо шинэчлэгдээгүй, сургалтын хөтөлбөр, боловсролын уялдаа хангалтгүй, чанар сул хэвээр байна. Ажил олгогчийн захиалга, хэрэгцээнд тохирсон мэргэшилтэй, ур чадвартай ажиллах хүчин хомсдолтой байна.

5.102 Шилжилтийн эхэн үед буюу эдийн засаг, нийгмийн ихээхэн бэрхшээлтэй байсан тэр үеэс хувийн хэвшил нь хvн амын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхэд багагvй хувь нэмэр оруулж, албан бус хэвшил үүссэн юм. Албан бус хэвшил гэдэг ойлголтод “албан ёсны статистик, татварт бүрэн хамрагдаагүй, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд ороогүй, орлогыг нь тодорхойлох боломжгүй, орлого олох зорилгоор явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааг” ойлгож байгаа юм. Дэлхийн банкны тусламжтайгаар хийсэн судалгаанд “Албан бус хэвшил нь жижиг хэмжээтэй, гол төлөв өрхөд суурилсан эдийн засгийн үйл ажиллагаанаас бүрддэг ба үүнийг албан ёсны статистикт хамруулаагүй, албан ёсны аж ахуйн газруудтай нэгэн адил татвар болон бусад зохицуулалтад зохицуулагдаагүй байж болно.” (Дэлхийн банк, 1997) 1999 онд АОУХА-ийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг дэмжих

төслөөс хийсэн судалгаанд мөн ийм тодорхойлолтыг гаргасан байна. Албан бус эдийн засгийн хүрээнд ажиллагчид нь албан ёсны бүртгэлгүй, үйл ажиллагааны хүрээ бага, байнгын бус, хөдөлмөрийн зохион байгуулалт, нөхцөл муу, бүтээмж, орлого бага, ганц нэгээрээ буюу цөөн тооны хүмүүсээс бүрдсэн микро аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байна.

5.103 Албан бус хэвшлийн дотор 60 хувийг нь жижиглэн худалдаа эзэлж байна. Энд ажиллагчид нь гол төлөв эмэгтэйчүүд, дунд насныхан байна.

5.104 Албан бус эдийн засгийн үйл ажиллагаанаас харахад орлого, бүтээмж багатай ажилтны тоог нэмэгдүүлэх хандлага илэрч байна. Эд нарын ихэнхи нь төсвийн байгууллага, улсын үйлдвэрийн газраас цомхотголд орсон болон албан хэвшилд шинээр ажилд ороход хөгшинд тооцогдсон хүмүүс байна. Үлдсэн хэсэг нь сургууль төгсөөд албан хэвшилд ажилд орж чадаагүй, хөдөлмөрийн зах зээлд бүртгүүлсэн хүмүүс байна.

5.105 Судалгаагаар албан бусаар хөдөлмөр эрхлэгчид хөдөлмөрийн нөөцийн 10.2 хувь, эдийн засгийн бүтцэд 13 хувийг нь бүтээдэг гэсэн тооцоо байгаа бөгөөд энэ салбарын цаашдын хөгжлийн талаар төрөөс бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. Юуны өмнө ажиллагчдын эрх ашгийг хамгаалах, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллыг сайжруулах, албан хэвшилд шилжин ажиллах нөхцөл бололцоог бий болгох хэрэгтэй байна.

5.106 Хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлого, үйл ажиллагааны эрх зүй, эдийн засгийн орчин бий болгох асуудалд анхаарч, ажилгүйдлийн даатгалын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудийг УИХ-аас 1995-2001 онд баталж, Засгийн газраас 2002 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн албан бус эдийн засгийн талаар дунд болон урт хугацаанд төрөөс баримтлах бодлогын төсөл, Шилжих хөдөлгөөний талаарх төрийн бодлогын төслийг боловсруулаад байна.

5.107 Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ хууль эрхзүйн болон бусад таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч байна. Улсын Их Хурлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталж, 2001 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Энэ хуулийн гол агуулга нь сургалт, зөвлөгөө, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт, давтан сургалт явуулах, хувийн аж ахуй эрхлэлт, хоршоодыг дэмжих, ажил олгогч нарыг дэмжих, нийтийг хамарсан түр хугацааны хөдөлмөр эрхлэх ажлыг зохион байгуулах зэрэгт чиглэж байна.

5.108 Улсын болон орон нутгийн төсөв, дотоод, гадаадын байгууллагаас олгох зээл, тусламж, хандив, бусад эх үүсвэрүүдээс бүрдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг дээрх хуулийн дагуу байгуулан зарцуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн санд улсын төсвийн орлогоос 0.3 хувь хүртэлх хөрөнгийг оруулах ёстой бөгөөд 2001 онд 200.0 сая төгрөг, 2002 онд 800.0 сая төгрөгийг төсөвлөгдсөн бөгөөд 2003 онд 1200.0 сая төгрөгийг олгохоор улсын төсөвт тусгаад байна. Энэхүү санд Монголд ажиллаж байгаа гадаадын иргэдийн ажлын байрны хураамжийн мөнгө хуримтлагдаж байна. 2001 онд 400.0 сая, 2002 онд 600.0 сая төгрөгийг хуримтлуулсан бол 2003 онд 800.0 сая төгрөгийг хуримтлуулахаар тооцож байна.

5.109 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2002 онд 1850.9 сая төгрөг төвлөрүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна. Үүний дүнд 2002 онд 33.0 мянган хүнийг ажилд зуучлан оруулж, мэргэжлийн ба давтан сургалтад 15431 хүнийг тус тус хамруулсан байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын эрхзүйн таатай орчин бүрдэж эхэлсний үр дүн гэж үзэж болно.

5.110 Ойрын жилүүдэд Монгол Улсын хvн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувьд хадгалагдах төлөвтэй байна.

5.111 Терех хvvхдийн тоо буурах тодорхой хандлага байгаа хэдий ч хүн амын нас баралт насны бүлгүүдээр тогтворжих шинжийг үндэс болгон хүн ам, хөдөлмөрийн нөөцийн прогнозыг хийж байна. Тухайлбал, насны суварга/пирамид/-ын харьцуулалтаас үзэхэд бага насны хүүхдийн хувийн жин буурч байгаатай зэрэгцэн хөдөлмөрийн насны хүмүүсийн хувийн жин нэмэгдэж байгаа нь бүтээх хүчний үүднээс таатай хандлага юм.

5.112 Хүн амын есөлтөөс хөдөлмөрийн нөөцийн есөлт 15-20 пунктээр дээгүүр байгаагаас хөдөлмөрийн нөөц хэдэн зуун мянган залуусаар сэлбэгдэж, тэднийг ажлын байр, мэргэжилтэй болгох бэрх зорилт Монголын нийгмийн өмнө тулгарч байгааг харуулж байна.

5.113 Зөвхөн 2002 оны байдлаар ЕБС-ийн 10 дугаар анги төгссөн бvх хvvхдийн 64 хувь нь их, дээд сургууль, коллежид орсон байхад 2 гаруйхан хувь нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд элсэн орж, үлдэх 33 хувь нь хөдөлмөрийн зах зээлд шилжиж байна. Чухамхүү энэ сүүлчийн хоёр асуудал нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудалтай нягт холбоотой болно.

5.114 Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал, мэргэжлийн сургалтын тогтолцоо, ажилгүйдэл, албан бус хэвшлийн дүр төрхийн талаар ОУХБ болон доноруудаас хийсэн үнэлгээ, зөвлөмжийг харгалзан үзсэний үндсэн дээр хөдөлмөрийн зах зээлийн стратегийг тодорхойлсон болно.

5.115 Хөдөлмөр эрхлэлтийн талаар урт болон дунд хугацаанд баримтлах бодлогын хүрээнд дараах 2 чиглэлийг үндсэн зорилго болгож байна. Үүнд:

Нэгдүгээрт: эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдаатай хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн бодлого;

Хоёрдугаарт: ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг шуурхай зохицуулахад чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого.

5.116 Үүний тулд, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр дараах стратегийн зорилтууд, тэргүүлэх чиглэлүүдийг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

- Боловсруулах, олборлох аж үйлдвэр, хүн амын ахуйн үйлчилгээг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг түлхүү чиглүүлнэ;
- Мал аж ахуй, газар тариалан, хадлан, тэжээл бэлтгэлийн хоршоо, нөхөрлөл, худалдаа, ерхийн ба фермерийн аж ахуй хөгжүүлэх, аж ахуй эрхлэхэд эдийн засаг, эрх зүйн таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх замаар албан бус хэвшлийг хөгжүүлж, улмаар албан ёсны хэвшилд аажмаар хандуулна;
- Албан бус эдийн засгийн талаар дунд болон урт хугацаанд баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, тэдний хөдөлмөрийн чадавхийг бэхжүүлнэ;
- Хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлого, арга хэмжээг эрчимжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн залуучууд, ядуу болон эмзэг бүлгийн иргэдэд зориулсан мэргэжлийн болон ур чадварын /эрхийн бичгийн сургалт/ сургалтыг өргөжүүлж, сургалтын чанар, үр дүнг сайжруулна;
- Хөдөлмөрийн зах зээлийн төрөлжсөн судалгаа, мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэн иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ;

5.117 Эдгээр зорилт, тэргүүлэх чиглэлийн хүрээнд ойрын жилүүдэд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл холбооны технологийг нэвтрүүлэх зэрэг чиглэлээр тогтвортой ажлын байр бий болгох үндсийг бүрдүүлж бус нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, тухайн бvс нутгийн давуу тал зэргийг харгалзан жижиг, дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлнэ.

- Дэд бүтэц, хот, нийтийн аж ахуй болон нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламжийн тохижилт, үйлчилгээний зарим хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар нийтийг хамарсан түр байр бий болгох арга хэмжээ авна.
- Боломжит хөдөлмөр эрхлэх үзэл баримтлалд нийцүүлэн эрүүл ажлын байрыг дэмжих хөдөлгөөн өрнүүлнэ.

5.118 Эдгээр зорилтуудыг дунд хугацаанд дараах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

- “Мянганы зам” төслийн хүрээнд төв, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албаар зуучлуулан ажилгүйчүүдийг ажлын түр болон байнгын байраар хангах ажлыг зохион байгуулна.
- Сайн үүлдрийн болон нутгийн шилмэл омгийн мал сүргийг үржүүлэх, фермерийн аж ахуйг хөгжүүлэх, түүний үйл ажиллагааг дэмжих, энэхүү чиглэлээр эрдэм шинжилгээ-судалгааны түшиц газар бий болгоно.
- Экспортын бүтээгдэхүүн, түүхий эдийг хүлээн авч борлуулах бөөний худалдааны сүлжээ байгуулах, мал аж ахуйн гаралтай түүхий эдээ анхан шатны боловсруулалт хийх цэг байгуулах ажлыг дэмжих замаар иргэдийг түр болон байнгын ажлын байраар хангах арга хэмжээ авна.
- Албан бус эдийн засгийн талаар дунд болон урт хугацаанд төрөөс баримтлах бодлогын төслийг УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Ялангуяа уул уурхайн салбарт албан бусаар ажил эрхлэж байгаа иргэдийг албан хэвшилд шилжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Сум, багийн төвд халуун ус, үсчин, оёдол, гутал засварын чиглэлээр ахуйн үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах, явуулын үйлчилгээ бий болгох асуудлыг шийдвэрлэхэд нь туслах замаар хөдөө дэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Ойн нөөц, усны эх булаг, ховордсон ан амьтадыг хамгаалах, ой цэвэрлэх, худаг, булаг шандыг тохижуулах, ойг нөхөн сэргээхэд орон нутгийн иргэдийг өргөн хамруулж, түр болон байнгын ажлын байраар хангах, байгалийн баялаг ашиглах үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн зохион байгуулна.
- Говь хээр нутгийг цөлжилтөөс сэргийлэх, ойн зурвас байгуулах замаар газрын хөрс бэлчээрийг хамгаалах ажилд хөдөлмөр эрхлээгвй иргэдийг оролцуулах ажлыг зохион байгуулна.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан ажилгвй иргэн, ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн албаар дамжуулан зохион байгуулна.
- Ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулсан ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна.
- Бичил аж ахуйн нэгжийн чадавхийг хөгжүүлэх зорилгоор бизнес-инкубаторын төвийг аймгийн төв болон нийслэлийн дүүргүүдэд зохион байгуулна.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын материаллаг бааз, сурах орчин, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулна.

- Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд ертеж болзошгүй иргэд болон тухайн онд ЕБС-ийн 8,10 дугаар анги төгссөн ажил, сургуульгүй үлдсэн хүүхдүүдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил олгох болон мэргэшлийн ур чадварын сургалтад хамруулж, сургалтын үр дүнг сайжруулах арга хэмжээ авна.
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авна.
- Хөдөлмөр эрхлээгүй иргэд болон албан бус хэвшилд ажиллагчдыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, статистикийн тогтолцоог ОУХБ-ын аргачлалын дагуу бүрдүүлнэ.
- Төв, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албадын чадавхийг бэхжүүлэх, бvтэц зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгааг өргөтгөх, хяналт-үнэлгээ-шинжилгээний зохистой механизмыг бий болгоно.
- Албан хэвшлийн бизнесийн орчны судалгааг хийж, цаашид тодорхой хугацаанд тогтмол хийх журамд шилжинэ. Албан хэвшилд ажиллагчдын мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

5.119 Ийнхүү хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын байр бий болгох бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн орлого өсч, ядуурал буурах болно. Ядуурлыг бууруулах гол арга зам нь хөдөлмөр эрхлэх явдал юм.

5.120 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлж байгаа стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тойм тооцоог авч үзвэл:

Хүснэгт 5:5:

| 1 | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шаардагдах хөрөнгө /сая.ам.доллар/ | |
|-----------------|---|------------------------------------|-------------|
| | | 2003-2006 | 2006-2010 |
| 1. | Нийтийг хамарсан ажлын байрыг бий болгож ажлын түр болон байнгын байртай болгох | 10.0 | 10.0 |
| 2. | Албан бус хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 3.0 | 5.0 |
| 3. | Мэргэжлийн сургалт болон ур чадварыг дээшлүүлэх бааз суурийг сайжруулах | 5.0 | 5.0 |
| 4. | Хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлого, үйл ажиллагаа явуулах | 3.0 | 3.0 |
| 5. | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгааг өргөжүүлэх | 2.0 | 2.0 |
| Дүн | | 23.0 | 25.0 |
| Үүнээс: -дотоод | | 10.0 | 12.0 |
| -гадаад | | 13.0 | 13.0 |

IV. Нийгмийн хамгаалал

5.121 Амьжиргааны түвшингийн үзүүлэлтээр баяжуулсан өрхийн орлого, зарлагын судалгаа төслийг 2001 оны сүүлчээс эхлэн явуулахаар зохих бэлтгэлийг хийлээ. Энэ судалгааг 2002-2003 оныг дамжуулан сар бүр 11200 гаруй өрхийг хамруулан хийх юм. Өрхийн орлого, зарлагын энэ судалгаагаар өрхийн гишүүдийн нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал, өрхийн орлого, зарлага, хэрэглээний хэмжээ, орон сууцны нөхцөлийг судлах юм. Өрхийн орлого, зарлагын 2002 оны судалгаанаас үзэхэд нэг өрхийн сарын дундаж мөнгөн

орлого 141.0 мянган төгрөгт хүрч 2001 оныхоос 27.0 хувиар өссөн байна. Улсын дунджаар нийт мөнгөн орлогын бүтцэд цалин 24.6 хувь, өрхийн үйлдвэрлэл, арилжаа, наймааны орлого 44.3 хувийг эзэлж байна. Мөнгөн зарлагын 42.9 хувийг хүнсний зарлага, 26.8 хувийг хүнсний бус зарлага, 27.3 хувийг үйлчилгээний зарлага эзэлж байна. Өрхийн хадгаламж 2002 онд 2001 оныхоос 2.5 дахин өссөн байна. Өрхийн орлого зарлагын судалгаа нь хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох суурь болж байгаа бөгөөд амьжиргааны доод түвшинг тогтоох тухай хуулийн дагуу Үндэсний статистикийн газар өөрийн судалгаандаа үндэслэн амьжиргааны доод түвшинг зарлаж байна. 2002 онд амьжиргааны доод түвшинг Улаанбаатар хотод 24600 төгрөг, хөдөөгийн 5 бүсэд 19100-20200 төгрөг байдлаар Үндэсний статистикийн газар зарласан. Ойрын жилүүдэд амьжиргааны доод түвшинг тогтоож байгаа хэрэглээний сагсны бүтцийг боловсронгуй болгох арга хэмжээ авна. Ядуурлын түвшин амьжиргааны доод түвшинд үндэслэн тодорхойлж буй аргыг боловсронгуй болгож малын тоо толгой, автомашин, мотоцикл, орон сууц зэрэг үндсэн хөрөнгийг оруулж тооцох асуудлыг судалж үзнэ.

5.122 Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн шилжилтийн жилүүдэд хүн амын нийгмийн хамгааллын хэрэгцээ өсч, зардал нь 1996-2000 онд 4.4-7.3 хувь болон нийт төсвийн зардлын 17.7 хувьтай тэнцэж байна. Дээрх хугацаанд нийгмийн салбарт зарцуулах зардал ДНБ-ий 13 хувь байснаа 20 хувь болж өссөн байна. 1997-2000 онуудад нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах хөрөнгийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна. 1998 онд дундаж орлоготой өрхийн нийт орлогод нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь ердөө 0.75 хувь байсан ба энэ нь ядуу өрхийн хувьд 1.3 хувь, нэн ядуу өрхийн хувьд 3.6 хувь байжээ. Нийгмийн хамгааллын салбарын санхүүжилт нь улсын төсвийн санхүүгийн эх үүсвэрийн бүрдэлт, бэрхшээлээс шалтгаалан зарим талаар хүндрэх явдал байдаг.

5.123 **Нийгмийн даатгал.** Нийгмийн даатгал нь нийгмийн хамгааллын тогтолцоонд томоохон үүрэг гүйцэтгэж байна. Монгол улсад даатгуулагч, ажил олгогчоос шимтгэл төлөх замаар тэтгэврийн хуримтлал бий болгон түүнээс тэтгэвэр авагчдынхаа тэтгэврийг олгодог хуваарилалтын тогтолцоо үйлчилж байна.

5.124 Одоогийн байдлаар нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын 92.0 хувь нь заавал даатгалд, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 22.5 хувь нь сайн дурын даатгалд, нийт хүн амын 92.2 хувь нь эрүүл мэндийн даатгалд тус тус хамрагдаад байна. Нийт 262.8 мянган тэтгэвэр авагчдын нэг хүнд ногдох дундаж тэтгэвэр 2002 оны эцсийн байдлаар 25.7 мянган төгрөгт хүрээд байна.

5.125 2000 оны хvн ам, орон сууцны тооллогын дvнгээр Монгол улсад 60 ба түүнээс дээш насны хүн амын тоо нийт хүн амын 5,2 хувийг эзэлж байна. Ирэх 25 жилийн хугацаанд Монгол Улсын хүн ам 24 хувиар өсөх төлөвтэй байхад 65 ба түүнээс дээш настай хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин 2025 он гэхэд одоогийнхоос бараг 2 дахин буюу 2.4 хувиас 6.4 хувьд хүрч нэмэгдэх төлөвтэй байна.

5.126 Ийнхүү ахмад настны нийт хүн амд эзлэх хувийн жин өссөнөөр нэг даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэж, тэтгэврийн даатгалын сангийн эх үүсвэр дутагдах бэрхшээл гарч болзошгүй байна.

5.127 Түүнчлэн улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан тэтгэврийн тогтолцоонд хамрагдаж буй тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээ нь 1990 оноос хойшхи үнийн өсөлтөөс бараг 2 дахин хоцорч байгаа нь тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх улмаар тэтгэврийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага, нөгөө талаас бэрхшээл хүндрэлийг гаргаж байна.

5.128 Иймээс тэтгэврийн даатгалын “хуваарилалтын” тогтолцооноос “хагас хуримтлал”-ын тогтолцоонд шилжих нөхцөлийг хангах, тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар тэтгэврийн тогтолцоог боловсронгуй болгох явдал тулгамдсан зорилт болж байна.

5.129 Мөн нийгмийн даатгалд хамрагчдын тоо буурч, тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нэмэгдэж буй нь Монгол улсын нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэвэл зохих гол асуудлын нэг болж байна. Даатгуулагчдын тоо цаашид нэмэгдэхгүй бол өнөөгийн тэтгэврийн тогтолцоо нь төсөвт цаашид нэмэлт дарамт болохоор байна.

Хүснэгт 5:5. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр

(2003 оны 1 дүгээр сарын 01-ний байдлаар)

| Нийгмийн даатгалын тэтгэврийн төрөл | Өндөр насны | Тэжээгчээ алдсаны | Тахир дутуугийн | Цэргийн | ҮОМШӨ | Нийт |
|-------------------------------------|-------------|-------------------|-----------------|---------|-------|-------|
| Хүний тоо (мян.хүн) | 174.6 | 35.5 | 36.3 | 9.7 | 6.7 | 262.8 |
| Дундаж тэтгэвэр (мян.төг) | 25.1 | 18.0 | 18.5 | 36.8 | 30.5 | 25.7 |

Эх сурвалж: УНДЕГ

5.130 Нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоог шинэчлэн сайжруулах, даатгалын сангийн чадавхийг бэхжүүлэх хүрээнд дараахь тэргүүлэх зорилтуудыг урт болон дунд хугацаанд дэвшүүлж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын одоогийн хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих бэлтгэл, нөхцөлийг хангах, гарч болох сөрөг үр дагаврыг арилгах асуудлыг судалж шийдвэрлэнэ. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны сүлжээнд 1960 оноос хойш төрсөн даатгуулагчдыг бүрэн хамруулах, нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ, хүүг даатгуулагчдад шуурхай мэдээлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- Одоогоор тэтгэврийн насны доод хязгаар 50-60 нас байгаа нь нийгмийн даатгалын тогтолцоог зардал ихтэй болгож, цаашдаа нэрийн дансны сүлжээнд хамрагдсан иргэд болон одоогийн хуулиар тэтгэвэр, тэтгэмж авах даатгуулагчийн хооронд тэгш бус байдлыг бий болгож байна. Тэтгэврийн нас доогуур байх нь тэдний тэтгэврийн хэмжээ бага байна гэсэн үг. Энэ нь нөгөө талаар тэтгэврээс гадна нэмэлт орлого олох чадваргүй тэтгэврийн насныханд хүндээр тусаж, тэдний дунд ядуурлыг ихэсгэх талтай. Иймээс тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг оновчтой тогтоох, эрэгтэй ба эмэгтэйчүүдийн тэтгэврийн насны зөрүүг багасгах зэрэг асуудлаар судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Өнөөгийн нийгмийн даатгалын хуулийн дагуу Монгол улсын иргэн 60 настай тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч зөвхөн 25 хувь нь 60 нас хүрсний дараа тэтгэврээ тогтоолгодог гэсэн судалгааг олон улсын зөвлөхүүд гаргажээ. Ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, хүйс зэргээс хамаарч иргэд харилцан адилгүй наснаас тэтгэвэр тогтоолгож байна. Тухайлбал:
 - Хөдөлмөрийн хэвийн бус хүнд нөхцөлд ажилласан бол 45-50 наснаас,
 - 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэй 50 нас, бусад эмэгтэй 55 наснаас,
 - Цэргийн бага, дунд тушаалын албан хаагчид 20-25 жил ажилласан бол 40-45 наснаас бөгөөд Тэтгэврийн хуулийн /1990/ нэмэлт, өөрчлөлтөөр 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэй тэтгэврийн насанд хүрээгүй ч тэтгэвэрт гарах эрхээр хангагдсан. Энэ нь шилжилтийн үед эмэгтэйчүүд ажлаа алдах, ядууралд нэрвэгдэх зэргээр эмзэг байдлыг нь улам дордуулсан байна.

- Төрийн захиргааны албан хаагчид өөрөө хүсэж, дээд дарга нь зөвшөөрвөл эрэгтэй 65, эмэгтэй 60 наснаас тэтгэврээ тогтоолгож байна. Энэ асуудлыг нарийвчлан судалж шийдвэрлэх шаардлагатай байна.
- Албан бус хэвшилд ажиллагчид, малчдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, хөдөлмөрийн хэвийн бус хүнд нөхцөлд ажилладаг болон ажил, мэргэжлийн өвөрмөц онцлог бүхий ажиллагчдад зориулан салбарын даатгалын тогтолцооны тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Өнөөгийн байдлаар 300.0 мянга гаруй малчид, 100.0 мянга гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалд хамрагдахгүй байна. Эдгээр хүмүүс нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвр, тэтгэмж авах эрхгүй болж нийгмийн хамгаалалгүй үлдэх эрсдэлтэй байна. Цаашид нийгмийн даатгалын сангаас тэтгэвр авах эрх үүсэхгүй, тэтгэврийн насанд хүрсэн малчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Эдгээр иргэдэд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг бодвол арай бага хэмжээтэй байдаг нийгмийн халамжийн тэтгэвр авах эрх үүсэж болох ба энэ нөхцөлд улсын төсвийн ачаалал нэмэгдэнэ. Урьд нь тодорхой хугацаанд ажиллаж байсан буюу тэтгэврийн даатгалд сайн дураар даатгагдсан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд нийгмийн даатгалын сангаас доод хэмжээний тэтгэвр авах эрх үүсэж болох ба үүнд зарцуулах хөрөнгийн нэлээд хэсэг нь бусад даатгуулагчдын шимтгэлийн орлого, улсын төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхэд хүрч байна. Иймд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын тусгай санг байгуулах, уг сангийн анхны эх үүсвэрийг бий болгох асуудлыг судалж, шийдвэрлэх хэрэгтэй байна.
- Нийгмийн даатгалын тухай одоогийн хууль (DB) болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны шинэ хуулийн дагуу (NDC) тогтоогдох тэтгэврийн хэмжээ ихээхэн зөрүүтэй буюу одоогийн хуулиас шинэ хуульд огцом (ойролцоогоор 2021 оноос) шилжих тул 1960 оноос хойш төрсөн даатгуулагчдын өндөр насны тэтгэврийн хэмжээ эрс буурах тооцоо гарч байна. 2020 онд 60 нас хүрэх даатгуулагчдын (нэрийн дансны шинэ хууль) тэтгэвр өмнөх жил нь 60 нас хүрсэн даатгуулагчдын тэтгэврийн (нийгмийн даатгалын одоогийн хууль) дөнгөж хагастай тэнцэх төлөвтэй байна. Иймд ойролцоо насны бүлэгт багтах хүмүүсийн тэтгэвр тогтоолгохоос өмнөх цалинд тэтгэврийн эзлэх хувийг аажмаар бууруулах замаар 1960 оноос өмнө төрсөн даатгуулагчдын тэтгэврийг тооцох аргыг өөрчлөх шаардлага гарч байна. Уг зөрүүг бууруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх бодлогын саналууд, хүрэх үр дүнг тооцох, түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиар олгогдох тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээг мөн хуулиар олгогдох өндөр насны тэтгэвэртэй харьцуулан тооцох, эдгээр тэтгэврийг тогтоох аргачлалыг өөрчлөх, түүний үр дүнгийн талаар холбогдох тооцоо хийж судалж үзнэ.
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын байгууллагаас бүтээгдэхүүн ажил, үйлчилгээ худалдан авах хэлбэрээр Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг механизмыг бий болгоно.
- Нийгмийн даатгалын сангуудыг төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.
- Нийгмийн даатгалын байгууллагын чадавхийг бэхжүүлж, мэдээллийн сүлжээг сайжруулна.

5.131 Нийгмийн халамж. Нийгмийн хамгааллын салшгүй нэг хэсэг болох нийгмийн халамж нь нийгмийн эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх, нэн ядуу амьдралтай, бие даан амьдрах чадваргүй иргэдийг халамжлах, асрамжлах замаар тэдний амьдралын баталгааг хангах зорилт тавьж байна .

5.132 Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь үүсээгүй, бие даан амьдрах чадваргүй, тэтгэж туслах үр хүүхэд, ах дүү, төрөл садангүй ахмад настан, тахир дутуу хүмүүс зэрэг 30.0 гаруй мянган хүн нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр авч байна. Олон хүүхэдтэй, жирэмсэн ба амаржсаны амралттай, нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, өнчин хүүхдүүд зэрэг 200.0 гаруй мянган хүнд нийгмийн халамжийн сангаас тэтгэмж, тусламж олгож, нийгмийн эмзэг хэсгийн 400 гаруй мянган хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байна.

5.133 Нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоо нь хүн амд халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох замаар бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож, ядууралд улам түлхээс болсон, нэг хүнд ногдох үйлчилгээний хүртээмж харьцангуй бага, амьдралд үзүүлэх нөлөө муу боловч нэгдсэн дүнгээрээ ихээхэн зардал гаргадаг сул талтай тогтолцоо юм. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 1997 онд 7.0 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2001 онд 20.0 гаруй тэрбум болж, бараг 3 дахин өсчээ. Гэвч нэг хүнд ногдох орлого төдийлэн нэмэгдэж чадаагүй байна. Мөн халамжийн удирдлага нь босоо тогтолцоотой, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог бага тусгасан бүтэцтэй байгааг өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

5.134 Нийгмийн халамжийн одоогийн тогтолцоо нь дараахи 3 сул талтай байна.

5.135 Нэгдүгээрт, нийгмийн халамжийн тогтолцоонд зарцуулж буй хөрөнгийн алдагдлын хувь өндөр байна, өөрөөр хэлбэл, ядуу бус олон өрх халамжийн тэтгэвэр, тэтгэмж хүртэх явдал байна.

5.136 Хоёрдугаарт, халамжийн тогтолцооны хамрах хүрээ нь хангалтгүй, олон ядуу өрх халамжийн тэтгэмжийн гадна үлдэж байна.

5.137 Гуравдугаарт, халамжийн одоогийн тогтолцоо нь “ядуурлын урхи”-ийг бий болгох хандлагатай байна. Өөрөөр хэлбэл тэтгэмж авахын тулд ядуу, эмзэг бүлгийн гишүүн байх сонирхолтой хүний тоо өсөх хандлагатай байна.

5.138 Нийгмийн халамжийн шинэчлэл нь эдгээр 3 асуудлыг шийдэж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, нийгмийн тусламж хүртэх бүлгүүдийн тоог багасгаж, тэтгэмжийн дундаж хэмжээг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулахад илүү үр дүнд хүрэхээр өөрчлөх шаардлагатай байна.

5.139 Нийгмийн халамжийн тогтолцооны одоогийн бүтэц зохион байгуулалт нь иргэдэд зөвхөн тэтгэвэр, тэтгэмж олгох эсэхийг тодорхойлох төдий үйл ажиллагаагаар хязгаарлагдаж, нийгмийн халамжинд хамрагдаж байгаа иргэдийн аж байдлыг дээшлүүлэх, нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанарыг сайжруулах ажил дутагдаж байна.

5.140 Ирэх арван жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа Нийгмийн хамгааллын салбарын мастер төлөвлөгөөнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн шинэчлэлийн асуудлыг тусгах бөгөөд, энэ хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, нийгмийн тусламж хүртэх бүлгүүдийг зөв тодорхойлж, тэтгэмжийн дундаж хэмжээг нэмэгдүүлснээр ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэж төсөөлж байна.

5.141 *"Биднийг манай ахмадууд, тэтгэврийн хамаатнууд маань л тэжээж байна шүү дээ, тэгэхлээр бид ажил хиймээр байна"* гэж Төв аймгийн Баянцогт сумын залуучуудын бүлэг тодорхойлсон байхад *"Гэрлэх зардал өндөр учир ажилгүй, насанд хүрсэн маш олон залуучууд эцэг эхтэйгээ хамт аж төрж тэднийхээ тэтгэврээр амьдарч байна"* гэж Архангай аймгийн Тариат сумын эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэг ярьсан байна. Энэ бүгд нь дээр дурдсан нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах ёстойг харуулж байна.

5.142 Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, эзэнд нь очих хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлэхэд чиглүүлэх талаар дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, сум, хорооны түвшинд нийгмийн халамж, асрамж, үйлчилгээг зохион байгуулах, нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээг нэвтрүүлнэ. Өнөөгийн бүтэц нь аймгийн төв, дүүргүүдэд ажилладаг бөгөөд тэтгэвэр, тэтгэмж олгоход ихэнх ажлаа чиглүүлж, иргэдэд хүрч үйлчилж чадахгүй байгааг өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Гэвч энэ бүтцийг нарийвчлан судлах, турших, эерэг, сөрөг үр дагаврыг урьдчилан тооцоолох шаардлагатай байгаа юм.

- Нийгмийн халамжийн байгууллагуудын тэтгэвэр, тэтгэмж олгох төдий ажлаасаа, эмзэг бүлгийн хүмүүст үйлчилгээ үзүүлэх арга, хэлбэрт шилжих асуудлыг судалж шийдвэрлэнэ. Үүний тулд нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, байгууллагын чадавхийг сайжруулах, орон тоо зохион байгуулалтыг өөрчлөх зэрэг асуудлууд тавигдаж байна.

- Нийгмийн халамжийн хуулийн дагуу олгож байгаа жирэмсэн ба амаржсаны, хүүхэд асарсны, ихэр хүүхдийн, нярай хүүхдийн арчилгааны, бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авч өсгөсний, тахир дутуу хүүхдээ асарсны тэтгэмжүүдийг олгох шалгууруудыг оновчтой болгох, хүртээмжийг нь нэмэгдүүлэх, хамрах хүрээг зөв тогтоох зэрэг шинэчлэлийн чанартай асуудлуудыг нарийвчлан судалж оновчтой хувилбаруудыг сонгон хэрэгжүүлнэ. Нэгэнт хэрэгжиж байгаа хууль эрх зүйн харилцааг өөрчлөхдөө өнөөгийн хүрсэн түвшингээс ухрахгүй байх зарчим баримтална.

- Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хуулийн дагуу олгож байгаа тусламж, хөнгөлөлт үйлчилгээг өөрчилж шинээр өрхийн тэтгэмжийн төрөл бий болгох асуудлыг олон улсын байгууллагын дэмжлэг тусалцаатай судалж шийдвэрлэнэ.

-Тахир дутуу иргэдэд үзүүлэх мөнгөн бус хэлбэрийн тусламж дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэхдээ тэдний амьдралын чанар, онцлог байдлыг харгалзана. Өрх, нийгэм, хамт олонд нь тулгуурласан халамжийн тогтолцоог хөгжүүлэх чиглэл баримтална. Үүнтэй уялдуулан асрамжийн газрын төвлөрлийг сааруулах, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- Нийгмийн үйлчилгээний зориулалттай хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад олон нийтийн хяналт, оролцоо чухал үүрэгтэй. Энэ салбарын мониторинг хийхдээ иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутагт эрх мэдлийг төвлөрүүлж сонголт, хуваарилалт хийлгэх нь чухал ач холбогдолтой гэж үзнэ.

5.143 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэхэд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдах, Монгол орны онцлог, хүн амын мэргэжлийн түвшингээс хамаарч зарим зорилт биелэгдэхгүй байх эрсдэлтэй. Түүнчлэн Монгол улсын хөгжлийг дэмжигч орнууд, олон улсын байгууллагын оролцоо, тусалцаа ихээхэн шаардлагатай боловч одоогоор амлагдсан, эх үүсвэр нь батлагдсан төсөл, хөтөлбөрүүд харьцангуй цөөн байгаа нь эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

V. Жендэрийн тэгш байдал

5.144 Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын орлогч даргаар удирдуулсан, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлтэй Жендэрийн Үндэсний Зөвлөл ажиллаж байна. Монгол дахь Жендэрийн тэгш бус байдлыг дэлхийн бусад оронтой харьцуулахад нэлээд өвөрмөц гэж болно. Монгол Улсын эмэгтэйчүүдийн эрх эрэгтэйчүүдийнхтэй адил тэгш, боловсрол харьцангуй өндөр, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг үйлчилгээний салбарт эмэгтэйчүүд ихээхэн давамгайлж эрэгтэйчүүдийн оролцоо бага байдаг.

5.145 2000/2001 оны хичээлийн жилийн статистикийн тоо мэдээнээс үзэхэд цэцэрлэгт хүмүүжиж байгаа хөвгүүд (29.4), охидын (31.9) тоо харьцангуй ойролцоо байгаа бөгөөд цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 30.6 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Харин 8-11 насны хүүхдийн сургуульд хамрагдалт хүйсийн хувьд тэгш бус болж, 119 мянган охид, 117 мянган хөвгүүд сургуульд суралцаж байна. Хөдөө орон нутагт сургууль завсардсан 12-15 насны эрэгтэй хүүхдийн тоо 23.3 хувь, эмэгтэй хүүхдийн тоо 13.2 хувь байна. Анхан шатны болон дунд шатны боловсролын сургуульд 2000-2001 оны хичээлийн жилд суралцаж байсан хүүхдийн 52.3 хувь нь эмэгтэй байснаас 1-3 дугаар ангийн хүүхдийн 50.1 хувь, 4-7 дугаар ангийн хүүхдийн 53.4 хувь, 8-10 дугаар ангийн хүүхдийн 59.4 хувь нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл, хүйсийн тэнцвэр дунд сургуулиас эхлэн алдагдаж байна. Сургуулиа орхиж гарсан 8-15 насны хүүхдийн 61.7 хувийг хөвгүүд эзэлж байгаа нь сургууль завсардаж буй хүүхдийн дунд хүйсийн ялгаа их байгааг харуулж байна. Үүнээс шалтгаалаад их, дээд сургуульд элсэн суралцагчдын дийлэнх нь охидууд байна.

5.146 Эмэгтэйчүүдийн санхүү, зээлийн үйлчилгээг хүртэх хүртээмж, бизнэс эрхлэх боломжууд нь эрэгтэйчүүдийг бодвол хязгаарлагдмал байдаг. Өмч хөрөнгө гол төлөв өрхийн тэргүүн эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэгдсэн байдаг нь эмэгтэйчүүд хөрөнгө барьцаалан зээл авах, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарладаг байна. Засгийн газар банк санхүүгийн тогтолцооны бүтцийн өөрчлөлтийг хийхдээ эмэгтэйчүүдэд мөн ашиг хүртээх талаас нь судлаж үйл ажиллагаа, арга хэмжээ авах нь зүйтэй юм. Зээл авагчдынхаа тоог арилжааны банкууд хүйсээр ялган гаргадаг болох шаардлагатай байна.

5.147 Жендэрийн холбогдолтой хууль эрхийн актууд. Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн Пактаас гадна Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш шан олгох тухай конвенц зэрэг олон улсын гэрээ конвенциудад нэгдэн орж хүйсийн тэгш байдал, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн талаар олон арга хэмжээ авч байгаа ч гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл анхаарал татсан асуудлын нэг байсаар байна. Шүүхийн статистикаас үзэхэд сүүлийн хоёр жилд хүч хэрэглэсэн гэмт хэрэг нийт хэргийн 25.2 хувьд хүрсэн бөгөөд хохирогч нь голдуу эмэгтэйчүүд хүүхдүүд байна. Мөн өнгөрсөн 5 жилд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байранд 639 эмэгтэй 641 хүүхдийн хамт ирж байрласны 82.2 хувь нь бусдын дарамтад өртсөн, 28.9 хувь нь ямар нэг гэмтэлтэй байсан байна. Шилжилтийн үед батлагдаж гарсан зарим нэг хууль дүрмүүд эмэгтэйчүүдэд ээлгүй байлаа. Сүүлд батлагдсан Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар газрыг хувь хүмүүст биш өрхөд өгнө гэж заасан нь ганц бие эмэгтэй эрэгтэй хүмүүст таатай бус нөлөө үзүүлэхээр байна.

5.148 Бүтцийн өөрчлөлтийн бодлогын хэрэгжилтийн явцад эмэгтэй эрэгтэйчүүдэд адил ашиг хүртээх явдлыг баталгаажуулахын тулд эдгээр бодлого хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийж, ялангуяа газрын шинэчлэлийн бодлогод онцгой анхаарч, болзошгүй сөрөг үр дагаварыг гаргахгүй байх нь чухал юм. Боловсролын салбарт ажиллагчдын 80 гаруй хувь, улс орны хэмжээний нийт шүүгчдийн 90 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нийгэмд эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүрэг, хүлээж байгаа ачааллыг харуулж байна. Гэтэл улс төр, нийгэм, эдийн засгийн удирдлагын дээд түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь нэмэгдэхгүй байна.

5.149 Монгол Улсын парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл 1991-1992 онд 23 хувь байснаа 1992 оны сонгуулиар 3.9 хувь болж буурсан бөгөөд 1996 онд 10.5 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувь болжээ. Гэвч улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага байна. Сүүлийн жилүүдэд болсон сонгуулийн дүнгээс харахад сонгогчид хувь хүнд санал өгөхөөс илүүтэй намд нь саналаа өгдөг байдал ажиглагдаж байна. Иймд эмэгтэйчүүдийг улс төрийн шийдвэр гаргах түвшинд дэвшүүлэхийн тулд улс төрийн намуудтай ажиллан, намын бодлогын хүйсийн мэдрэмжит байдлыг хангах нь стратегийн нэг чухал чиглэл байж болох юм.

5.150 Сайн засаглалын хүрээнд жендэрийн асуудлыг авч үзэж эмэгтэйчүүдийн улс төрд оролцох оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн хүчирхийллийг устгах зорилт тавьж байна. 2002 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан Жэндэр ба Хөгжил сэдэвт үндэсний чуулганаар улс төрийн намуудын тухай хуульд “Улс төрийн намуудын шийдвэр гаргах бүх түвшинд болон сонгуульд нэр дэвшигчдийн аль нэг хүйс нь 40-өөс доошгүй хувь байх” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эмэгтэйчүүдийн удирдах болон шийдвэр гаргах түвшинд сонгогдох бололцоог бүрдүүлнэ гэсэн зөвлөмж гарсан юм. Энэ нь эмэгтэйчүүдийг удирдах болон шийдвэр гаргах түвшинд сонгогдох бололцоог бүрдүүлэх болно.

5.151 Засаглал, жендэрийн тэгш байдлыг сайжруулах бас нэг арга бол орон нутгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг илүү оролцуулах, мөн эрх зүйн (газар, ажил эрхлэлт, хувийн аюулгүй байдал зэрэг асуудлаар) мэдлэгийг таниулах ажлыг эмэгтэйчүүдийн дунд үр ашигтай зохион байгуулах явдал чухал юм. Дунд хугацаанд энэхүү стратегийн хүрээнд гэр бүлийн хөгжлийн талаархи төрөөс баримтлах бодлогыг батлуулах замаар гэр бүл дэх хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

5.152 Эдийн засгийн нөхцөл байдал болон гэр бүлийн хүчирхийллээс улбаатай бие мах бодийн болон сэтгэл санааны дарамт нийгэмд нэлээд түгээмэл байгааг арилгах зорилт тавьж байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Улаанбаатар хотын 6 дүүрэгт явуулсан судалгаанд оролцогчид гэр бүл дэх хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд ороход нь сөргөөр нөлөөлдөг гээд 30 хувь нь ажил хийх сонирхол буурдаг, хоёр хүн тутмын нэг нь өөртөө итгэх итгэл нь алдарч, нийгэмд эзлэх байр суурь мууддаг гэжээ.

5.153 Монгол Улсын Засгийн газраас хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, боловсрол эзэмших, шийдвэр гаргах түвшин, өмчийн харилцаанд жендэрийн зохистой тэгш байдлыг хангах, гэр бүлийн доторх хүчирхийллийг бууруулах бодлогыг боловсруулан улс орны эдийн засаг, нийгмийн бодлого, хөтөлбөрт тусгах үүднээс 2002 оны 12-р сард Жендэрийн тэгш байдлын талаарх үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрт жендэрийн тэгш байдлын стратегийн зорилтуудыг тусгасан юм. Гэр бүл болон үнэт зүйлсийг батжуулах, хүүхэд өсгөх, гэрийн ажилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, хууль журам боловсруулах, сурталчилгаа явуулах замаар гэр бүл дэх хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх, өрхийн өмчийг эзэмших, өмчлөх эрх, шийдвэр гаргах байдлыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авна. Жендэрийн мэдрэмжтэй макро эдийн засгийн бодлого, төсөв, статистикийн мэдээллийг боловсруулах, хөрөнгө эзэмших, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдах боломжоор хангах, өрхийн эдийн засагт жендэрийн тэгш байдлыг хангана. Хөдөөгийн хүүхдүүд, ялангуяа эрэгтэй хүүхдүүдэд сургуульд суралцах боломжийг сайжруулах, бүс нутгийн хөгжилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, эхийн болон нялхасын эндэгдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлт, жижиг бизнесийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангана. Засгийн газрын шийдвэр гаргах түвшин, улс төрийн болон төр, захиргааны албан тушаалд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлнэ. Жендэрийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хүрээг нь өргөтгөх, жендэрт тулгуурласан судалгаа явуулах, жендэрийн асуудлыг бодлого хөтөлбөр, төслүүдэд тусгах, жендэртэй холбоотой зорилт хөтөлбөрүүдийн хяналт үнэлгээг сайжруулах механизмыг бий болгоно. Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний зөвлөл болон жендэрийн асуудлаар ажиллах төр, засгийн байгууллагуудын ажилтны мэдлэг, чадавхийг сайжруулна.

БҮЛЭГ 6. СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТ

“Сумын захиргааныхан бидний ажилд маш их нөлөөтэй байх ёстой, гэвэл тэд хүнд хүрч ажиллахгүй байна.” гэж Төв аймгийн хөдөөгийн багийн иргэд хэлсэн байна.

I. Сайн засаглал

6.1 Иргэний нийгмийн оролцоог өргөтгөх. Иргэний нийгмийн оролцоо нь цаашдаа ЭЗӨДЯБС-т өөрчлөлт, зохицуулалт хийх, мөн түүний хэрэгжилтийг тогтвортой хангахад чухал үүрэгтэй. Ямар ч стратегийг хэрэгжүүлэх нь тухайн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт, дүн шинжилгээ хийх Засгийн газрын ерөнхий чадавхаас хамаардаг.

6.2 Тухайлбал, “доороос-дээш” нь гэсэн зарчмаар стратегийн талаар иргэний нийгэм болон бизнесийн нэгжүүд аймаг, сумын түвшинд үргэлж санал бодлыг цуглуулж авна. Стратегийн нөлөө болон үр дүнгийн талаархи ард нийтийн санаа, үзэл бодол нь ЭЗӨДЯБС-ийн цаашдын шинэчлэл зохицуулалт хийхэд чухал ач холбогдолтой. Эдгээр санал нь ЭЗӨДЯБС -ийн зохицуулалтын гол үндэс суурь нь болох бөгөөд мөн үүнийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ч үндэс суурь нь болно. ЭЗӨДЯБС-ийн хэрэгжилтэд төрийн бус байгууллагуудын оролцоог үндэсний, бүсийн, салбарын болон орон нутгийн бүх түвшинд хангах механизм, арга замыг тогтоох болно. Төвийн болон салбарын агентлаг, яамныхан, орон нутгийн удирдлагууд стратегийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд болон бизнесийн салбарынхан хэрхэн оролцох талаар үзэл баримтлалыг боловсруулна.

6.3 Нийгмийн нэлээд үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх тийм оролцооны хэлбэрт илүү анхаарал хандуулах болно. Засгийн газрын агентлагууд хуулийн хүрээнд өөрсдийн гүйцэтгэх боломжит үйлчилгээ, үйл ажиллагааны жагсаалтуудыг боловсруулах бөгөөд мөн гэрээ хэлэлцээр байгуулах арга замыг тодорхойлж Засгийн газраар батлуулна. ЭЗӨДЯБС-ийн хэрэгжүүлэхэд агентлагууд гүйцэтгэх ажил үүргээс үлдсэн хэсгийг иргэний нийгмийн хэсгүүдтэй хамтран гүйцэтгэнэ. Ийм үйл явц, жагсаалтыг боловсруулахад, яамдууд, агентлагууд төрийн бус байгууллагын хэсэгтэй зөвлөлдөж, тэдгээрийн сонирхол, чадавхид бүрэн нийцсэн, мөн янз бүрийн түвшинд нийгмийн үйлчилгээг хүрэгх төрийн бус байгууллагуудын хэтийн төлөв, чадавхийг харгалзана.

6.4 Энэхүү ТББ-ын яамд болон орон нутгийн түвшинд оролцох оролцоо нь Дэлхийн Банкны ЯБСББ-ийн Итгэлцлийн Сангаас дэмжлэг авах ба оролцоог болон иргэний нөлөөллийг дээшлүүлэх зорилготой. Үүгээрээ тогтвортой хөгжлийг хангахад зайлшгүй шаардлагатай нэгэн хүчин зүйл болох нийгмийн капиталыг хөдөлгөөнд оруулж болох зарчмыг Засгийн газраас баримтална.

6.5 Үүнийг үр дүнтэй хийхийн тулд, Засгийн газар, Засгийн газрын болон олон нийтийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах болно. ЯБСББ-ийн Итгэлцлийн Сангийн эх үүсвэрүүд нь ЭЗӨДЯБС-ийн зөвхөн хэрэгжилтийг хангах чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг өгөөд зогсохгүй үнэлгээ, хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

6.6 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах нь ЭЗӨДЯБС-ийн цаашдын боловсруулалтад иргэний нийгмийн оролцоог хангах талд дээр чухал үүрэг гүйцэтгэнэ. Стратегийн баримт бичгийн тухай болон боловсруулалт, хэрэгжилтийн явцын мэдээллийг нийтэд тараах, түгээх, түүний иргэний нийгэм, орон нутгийн байгууллагуудтай зөвлөлдөх мэдээллийг доороос цуглуулах, ЭЗӨДЯБС-ийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, стратегийн хэрэгжилтэнд төрийн болон орон нутгийн оролцооны талаархи ажлыг тайлагнах зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн түгээх юм.

6.7 Сайн засаглалыг бэхжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон ажиллана. Үүнд:

- Засгийн газрын байгууллага болон бизнесийн үйл явцын үр ашигтай байдлыг сайжруулах, гүйцэтгэх үйл ажиллагаа, санхүү, төлөвлөлт, тайлагналт, хариуцлагын тогтолцоо, ил тод байдлыг хангах, удирдлагын арга хэрэгслийг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нэр хүндийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

- Нийгмийн үйлчилгээний удирдлагын мэдээллийн тогтолцооны сүлжээг байгуулах, түүний найдвартай байдлыг орчин үеийн технологийг ашиглах үндсэн дээр хангах, гүйцэтгэх засаглалын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх арга хэрэгслийг боловсронгуй болгоно.

- Засгийн газрын байгууллагуудын дотоодын болон гадаад хяналт шинжилгээ, үнэлгээний зохих арга барилыг бүрдүүлж дээшлүүлнэ. .

- Хууль, шүүхийн байгууллагын эрх мэдэл, зохион байгууллалтын эрхзүйн үндсийг бэхжүүлэх, шүүхийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлэх, шүүхийн байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангах, түүний нэр хүндийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

- Хэвлэлийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, түүний хариуцлагын тогтолцоог сайжруулах замаар төрийн бодлогыг ард түмэнд ил тод хүргэх ажлыг сайжруулах, иргэдийн санаа бодлыг хэвлэлээр дамжуулан төр засагт хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.

- Нийгмийн үйлчилгээний хариуцлагын тогтолцоог сайжруулах, хээл хахууль, авилгал, гэмт хэрэгтэй тууштай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд дотоодын хүчирхийллийн эсрэг хууль, эрхзүйн орчинг бий болгоно.

- Олон нийттэй харилцах харилцааны удирдлагыг сайжруулах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төрийн бус байгууллагуудтай ажил хэргийн ойр дотно харилцаа холбоо тогтоох ажлыг бүх талаар дэмжих, төрийн бус байгууллагуудаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх явдлыг өргөжүүлнэ. Сайн засаглалыг төлөвшүүлснээр ядуурлыг тууштай бууруулах нөхцөл бүрдэнэ.

6.8 Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийг амжилттай хэрэгжүүлэх нэг үндэс бол хандивлагчдын үйл ажиллагааны зохицуулалт юм. Энэхүү зохицуулалтыг Засгийн газар хийх бөгөөд хандивлагчдын нэгдмэл үйл ажиллагаа, тэдний үзүүлж буй хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг аль болох оновчтой байршуулж, үр өгөөжтэй ашиглана. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд Засгийн газар тэргүүлэн манлайлахын зэрэгцээ шийдвэр боловсруулж гаргах, хэрэгжүүлэхэд бусад оролцогчдыг оролцоог дээшлүүлэх, түүний нээлтэй, ил тод байдлыг хангана.

II. Хэрэгжилт ба үйл ажиллагааны удирдлага.

6.9 Монгол улсын Засгийн газар Улсын хамгийн дээд гүйцэтгэх институцийн хувьд ЭЗӨДЯБС-г Монголд хэрэгжүүлэх ба хянах үүргийг хүлээнэ.

Одоогийн Монгол Улсын Засгийн газар нь доорхи салбар болон салбар хоорондын үүргийг гүйцэтгэдэг 11 яамнаас бүрддэг.

- Үндсэн хууль болоод бусад хуулийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулж, хангах;
- Эдийн засаг болон нийгмийн хөгжил, улсын төсөв, зээл болон санхүүгийн бодлого боловсруулж Улсын Их Хуралд оруулах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ;
- Салбарын болон салбар хоорондын, бүсийн хөгжилтэй холбогдсон арга хэмжээнүүдийг боловсруулж хэрэгжүүлэх ;
- Байгаль хамгааллын арга хэмжээг авах болон байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах, сэргээх ;

- Төрийн төв байгууллагын удирдлагын үр ашигтай байдлыг хангаж орон нутгийн удирдлагуудын үйл ажиллагааг чиглүүлэх ;
- Улсын батлан хамгаалах чадварыг сайжруулж, үндэсний аюулгүй байдлыг хангах ;
- Хүний эрх, эрх чөлөө, олон нийтийн дэг журмыг хэрэгжүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ;
- Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх;
- Улсын Их Хурлаас баталж хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ конвенциуд болон Засгийн газар хоорондын гэрээг байгуулж хэрэгжүүлэх .
- Засгийн газрын тодорхой эрх, бүтэц болон журмуудыг хуулиар тогтоох ;

Яамд болон Засгийн газрын бусад байгууллагууд хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. ЭЗӨДЯБС-г хэрэгжүүлэхийн тулд яам бүрийн бодлого, үйл ажиллагааг уг стратегид заасан зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглүүлэх ба бүх талын оролцоог хангасан механизмыг бүрдүүлсэн байх шаардлагатай.

6.10 ЭЗӨДЯБС -ын хэрэгжилт ба хяналтыг Санхүү Эдийн Засгийн Яам зохион байгуулна. Санхүү, Эдийн Засгийн яамны Ядуурлын Судалгааны Нэгж нь ЭЗӨДЯБС-ийн хэрэгжилт, хяналт ба тайланг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэнэ. Салбарын яамдууд зорилтуудад тусгагдсан тодорхой хөтөлбөрүүдийг заасан хугацаанд нь хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. Завсрын ЯБСББ тархаах үйл явцад байгуулагдсан орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн оролцоотой ажлын хэсгүүд оролцох болно. Яамд, агентлаг,ТББ нь ЭЗӨДЯБС-т тусгагдсан тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хянахад оролцох болно.


Ядуурлын Судалгааны Нэгж явцын тайлан нэгтгэх, дүгнэх, бэлтгэх, дээд шатны байгууллагууд болох Яамдууд, Улсын Их Хурлын гишүүд, Дэлхийн банк болон бусад холбогдох газруудад тайлагнана. Явцын тайланг жил бүр бэлтгэж стратегийг гурван жил тутам нэг удаа явцын тайлангийн хамт доноруудын хүрээний хөрөнгийг зохицуулах зорилгоор донорын хуралд танилцуулна

6.11 **Засгийн газрын бодлогын баримт бичгүүдийг нэгтгэх.** Засгийн газрын дунд хугацааны гол бодлогын баримт бичгүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл, салбарын баримт бичгүүд болон бусад бодлогын чанартай баримт бичгүүд, Олон Улсын агентлагуудтай байгуулсан гэрээнүүд болно.

Дээр дурьдсан баримт бичгүүдээс гадна олон улсын практикийн дагуу Монгол улс олон улсын чанартай баримт бичгүүд болох ЯБСББ-ийн үйл явц, Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх, Мянганы Сорилтын Данс зэрэг гадны туслалцааг зохицуулах, үндэсний оролцогч талуудын идэвхтэй оролцоотойгоор эдийн засгийн өсөлтийг дэмжин, ядуурлыг бууруулах үндэсний хөгжилд саад болж буй асуудлуудад чиглэгдсэн баримт бичгүүдэд идэвхтэй оролцоно. Санхүү, эдийн засгийн яам нь эдгээр хөтөлбөрүүдийг боловсруулах, батлах хэрэгжүүлэх ба хянахад гол үүргийг гүйцэтгэнэ.


Хөтөлбөрийн хэрэгжилт, үр ашигтай зохион байгуулалт, үйл явцын тайлан хоорондын уялдаа холбоог хангах ялангуяа хөгжилд чиглэсэн төсвийн үр ашигтай хувиарлалт нь салбарын болон макро эдийн засгийн удирдлагыг хангахад гол үүргийг гүйцэтгэнэ.

Бүдүүвч 6:1: Бодлого боловсруулах өнөөгийн үйл явц.



Бодлогын Зохион Байгуулалтыг сайжруулах үүднээс эцсийн шатанд жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл гол хяналтын баримт бичиг болох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, МХЗ-д болон ЯБСББ-ын үйл ажиллагааны тайлангийн суурь болж өгөх юм. Доорхи хүснэгт нь сайжруулсан бодлого боловсруулах үйл явцыг харуулж байна.

Бүдүүвч 6:2: Бодлого боловсруулалтын шинэчлэгдсэн явц



6.12 Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлтэй уялдах нь: ЭЗӨДЯБС-ийг хэрэгжүүлэх гол механизм нь жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхүндсэн чиглэл

юм. Энэхүү үндсэн чиглэлийг жил бүр УИХ-аас баталдаг бөгөөд Засгийн газрын яамд, агентлагуудаар дамжин хэрэгждэг. ЭЗӨДЯБС-д тусгагдсан бодлого, арга хэмжээ нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхүндсэн чиглэлд тусгагдан хэрэгжих бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийн тулд жил бүр УИХ-аас батлах шаардлагатай. Энэ үйл ажиллагаа нь 2004 оны Үндсэн чиглэлийг бэлтгэх үеэс эхлэн мөрдөгдөж эхлэх юм.

III. Оролцоог өргөтгөх нь

6.13 Завсрын ЯБСББ-ийн үнэлгээний үед Дэлхийн Банк болон Олон Улсын Валютын Сангаас эцсийн ЯБСББ-ийг боловсруулахад олон түмний оролцоог бүрэн хангахыг зөвлөмж болгосон. Тиймээс эцсийн ЭЗӨДЯБС-ийн Ажлын хэсэгт Нийгмийн Хөгжлийн Төв нь иргэний нийгмийн төлөөллөөр оролцсон. Нийгмийн Хөгжлийн Төв нь ЯБСББ-ийн оролцооны хуваарилалтыг бий болгохын тулд 12 төрийн бус байгууллагаас бүрдсэн салбар Ажлын хэсгийг байгуулсан юм. ЯБСББ-г боловсруулах эхний шатанд орон нутгийн хэмжээнд бүсчилсэн семинарыг зохион байгуулж, мөн энэхүү семинарт иргэний нийгмийн төлөөлөгчид өргөн оролцсон.

Хүснэгт 6:1: ЯБСЗББ-ийг танилцуулах семинар

| | Нийт оролцогчид | ҮүнээсТББ-н төлөөлөгчид % |
|---------------|-----------------|---------------------------|
| 1. Төв | 16.3 | 5.5 |
| 2. Дорноговь | 15.9 | 24.7 |
| 3. Дорнод | 13.3 | 25.7 |
| 4. Баянхонгор | 11.8 | 33.3 |
| 5. Хөвсгөл | 20.1 | 28.6 |
| 6. Завхан | 7.9 | 38.6 |
| 7. Ховд | 14.7 | 12.2 |
| Нийт | 100.0 | 22.8 |

6.14 Монгол Улсын Их Хурал нь жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлан хэрэгжүүлдэг. Тиймээс ЭЗӨДЯБС-д тусгагдсан бодлого, үйл ажиллагаа нь Улсын Их Хурлаас баталсан жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд онцгойлон тусгагдаж, хэрэгжих юм. Энэ ажил нь 2004 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулахаас эхэлнэ. Мөн ЭЗӨДЯБСББ-ийг боловсруулах явц, төслийн хувилбарыг танилцуулах зорилгоор төрийн бус байгууллагын ажлын хэсэгтэй хэд хэдэн уулзалтыг зохион байгуулж, тэдний саналыг ЭЗӨДЯБСББ-т тусгасан.ТББ-ын ажлын хэсэг нь мөн өөрсдийн саналыг бичгээр өгсөн. Мөн ТББ-ын төлөөлөгчид Дэлхийн банкнаас зохион байгуулсан Азийн бүсийн ядуурлын семинарт оролцсон. ТББ-ын төлөөлөгчид Дэлхийн Банкнаас зохион байгуулсан видео болон телефон бага хуралд байнга оролцож байв.

6.15 Тодорхой хэсэг хугацааны дараа ЭЗӨДЯБСББ –т нэмэлт өөрчлөлт оруулах болон хэрэгжилтийг тогтвортой хангах үйл явцад иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлнэ. Мөн аймаг, сумын түвшинд ЯБСББ-ийн хэрэгжилтийн үйл явцыг хянах болон эрчимжүүлэх зорилготой иргэний нийгмийн болон бизнесийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй ажлийн хэсэг байгуулж болно. Түүнээс гадна ЯБС-ийн үйл ажиллагааг хянах болон дүгнэхэд ТББ-ыг оролцуулна.

6.16 Стратегийн Боловсруулалт болон хэрэгжилтэнд ард иргэдийг идэвхтэйгээр татан оролцуулахын тулд стратегийн агуулга, чиг хандлага, төлөвлөсөн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилан, ард иргэдийн санаа бодол, дуу хоолойг сонсохын тулд хэвлэл мэдээллийн албаныхантай хамтран ажиллана. Оролцоог өргөтгөх ажлын анхны дэмжлэг болгож ЯБСББ-ийн Итгэлцлийн Сангийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх юм. Энэхүү сан нь чадавхийг сайжруулах, мэдээллийн технологи болон хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдээр дамжуулан мэдээллийг түгээх, зөвшилцөх үйл явцыг сайжруулах зорилготой.

IV. Дүн шинжилгээ ба үнэлгээ

6.17 *Хянан Шалгах ба Дүгнэх. ЭЗӨДЯБС-ийг* амжилтанд хүргэх урьдчилсан нөхцөл нь иргэний нийгэм, Засгийн газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөө бүхий хянан шалгах болон дүгнэх механизмыг бий болгох явдал юм. Ядуурлыг Бууруулах Стратегийг хэрэгжилтийг хянан шалгах, дүгнэлт хийхэд Засгийн газрын зүгээс амьжиргааны түвшинг харуулах статистикийн үзүүлэлтүүд болон шалгуур үзүүлэлтийн системийг боловсруулна. Энэхүү үзүүлэлтүүд нь Монгол улсын Мянганы Хөгжлийн зорилтууд дээр суурилсан байх бөгөөд үр дүнг тооцох тогтолцооны үзүүлэлтүүдийг тогтооход мэдээллийн боломж, хэмжүүр болон хамралтын хүрээ нь гол шалгуур болно. Мөн зарим үзүүлэлтүүдийг цаашид хэрэгтэй гэж үзсэний үндсэн дээр багтааж болох ба үүний нэг жишээ нь эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээний мэдээлэл байж болно. Хянан шалгах ба дүгнэх үйл ажиллагаанд ТББ, хувийн хэвшлийнхэн, парламентийн гишүүд, иргэд донорын төлөөлөгчид зэргийг багтаасан иргэний нийгэм нь олон төрлийн арга, хэлбэрээр оролцоно. Үүнд Засгийн газрын тэргүүлэх чиглэл нь хянан шалгах, үнэлгээ хийх чадвархийг бий болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал юм. Жишээ нь оролцоог албан ёсны болгох үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд, стратегийн тухай олон нийтэд мэдээлэх, иргэний мэдээллийн картыг хэрэглэх үйл ажиллагааг өргөтгөх, Цэнхэр гэр будах, Скоуп карт нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хянах үйл ажиллагаа болон хэрэгтэй мэдээллийг цуглуулах үйл ажиллагааны зохицуулалтыг Санхүү, эдийн засгийн яамын харьяа Ядуурлын Судалгааны Нэгж хийнэ. Ядуурлын Судалгааны Нэгжийн үүрэг нь судлаачид болон ТББ-дад ЯБС-ийн хэрэгжилтийн тодорхой хэсгүүдийн талаар дүгнэлтийн судалгааны ажил зохион байгуулахад нь туслалцаа дэмжлэг үзүүлнэ. Харин Үндэсний статистикийн Газар нь олон янзын судалгаа шинжилгээн дээр тулгуурлан амьжиргааны түвшиний тухай судалгаа явуулж ядууралтай холбоотой мэдээлэл, чанарын үзүүлэлтүүдийг баяжуулна. Өрхийн Зарлагын өргөтгөсөн судалгаа нь Ядуурлын мониторингийн гол эх үүсвэр болох бөгөөд эдгээр мэдээллүүд нь хэрэглэгчдэд нээлттэй байна.

6.18 ЭЗӨДЯБС –ийн мониторингийн үзүүлэлтүүд нь Мянганы Хөгжлийн Зорилтуудтай нягт уялдаатай байна. Статистикийн үзүүлэлтүүдийг тархахаас гадна ЭЗӨДЯБС-ийн зорилтуудын хэрэгжилтийн явцыг Мянганы Хөгжлийн Зорилтуудтай уялдуулан боловсруулсан шалгуур үзүүлэлтийн тогтолцооны дагуу хянан шалгаж, дүгнэнэ. Энэхүү шалгуур үзүүлэлтийн тогтолцоонд эдийн засгийн өсөлт, ажилгүйдлийн түвшин, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт, хүүхэд болон эхийн эндэгдэл, 5-аас доошхи насны хүүхдийн эндэгдэл, бага болон дунд сургуульд хамрагдалт болон вакцинжуулалт зэрэг үзүүлэлтүүд орох бөгөөд дунд хугацааны үр дүнг тооцох тогтолцоо нь ядууралыг бууруулсан түвшингээр тодорхойлогдоно (мониторингийн болон үнэлэх шалгуур үзүүлэлтийн тогтолцоо болон мониторингийн үзүүлэлтүүдтэй холбоотой бусад техникийн мэдээллүүдийг хавсаргав).

6.19 Дэлхий дахины шинэ санаачилга болох Мянганы Сорилтын Данс нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах болон ядуурлыг бууруулах үйл явцыг хянан шалгаж дүгнэх бас нэгэн арга юм. Гадаад Хэргийн Яам нь Засгийн газрын амлалт Мянганы Сорилтын Дансны зарчмууд, хамтын ажиллагааг бий болгох, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, хөрөнгийг удирдах чадавхийг бий болгох зэрэг дээр анхааран ажиллана.

6.20 НҮБХХ нь мониторингийн үйл ажиллагаа болон бусад шаардлагатай тайлан мэдээг бэлтгэдэг гол бүтэц болох Ядуурлын Судалгааны Нэгж бүрдүүлэн байгуулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Мөн зохих туршлагатай ТББ ЯБС-ийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр хувь нэмрээ оруулах юм.

6.21 Азийн орнуудад ашиглагддаг Иргэний Хяналтын Картын системийн үр дүнд тулгуурласан ЯБС-ийн хэрэгжилтийн явцыг хянан шалгах механизм нь иргэний нийгмийн оролцоог өргөтгөхөд чухал юм. Мөн ЮНИСЕФ-ийн төслийн хүрээнд боловсруулагдсан

олон нийтэд тулгуурласан Хяналтын системийг амьжиргааны түвшинг орон нутгийн хэмжээнд дүгнэхэд ашиглах зорилгоор өргөтгөнө.

6.22 Жэндрийн мэдрэмжийн мониторингийн ажлын зохицуулалтыг Ядуурлын Судалгааны Нэгж хийнэ. Статистикийн газраас тоон болон чанарын үнэлгээнд үндэслэсэн амьжиргааны түвшин болон ядуурлын тухай мэдээ, мэдээллийг тархаах явцыг сайжруулах бөгөөд эдгээр мэдээлэл нь нийтэд нээлттэй байна. Мөн ядуурлыг бууруулах болон бусад үндэсний зорилтуудтай холбоотой хүйсийн ялгаатай байдлын талаарх мэдээллийг цуглуулж жэндрийн мэдрэмжтэй мониторингийг болон үнэлгээний аргачлалыг боловсруулна.

6.23 Санхүүгийн хэрэгцээ. Эдийн Засгийн өсөлтийг дэмжиж Ядуурлыг бууруулах стратегийн хүрэн дэх бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд жил тутамд ДНБ-ий 40-45 хувьтай тэнцэх хэмжээний санхүүгийн нөөц шаардлагатай. Энэ тооцоог Дунд хугацааны төсвийн хүрээний тооцоонд орсон зорилтуудад үндэслэн хийсэн болно.

_____оо_____